

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-20
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	21-137
1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэх	22-37
2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	37-74
3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	74-129
4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нарын гишүүд 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	129-137

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
04 дүгээр сарын 13-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Батишугар, Б.Бейсен, Х.Болорчулуун, Г.Ганболд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;

Хоцорсон: С.Амарсайхан- 46 минут, Ц.Анандбазар- 22 минут, Д.Ганбат- 1 цаг 11 минут, Т.Доржханд- 32 минут, С.Одонтуяа- 35 минут, М.Оюунчимэг- 17 минут, Д.Өнөрболор- 11 минут, Ц.Сэргэлэн- 18 минут, Н.Учрал- 1 цаг 10 минут, Д.Цогтбаатар- 17 минут, Б.Чойжилсүрэн- 12 минут, Н.Энхболд- 11 минут, Ж.Эрдэнэбат- 2 цаг 36 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатараас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:08/

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэх**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их хурлын гишүүн А.Адьяасүрэн нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, С.Бямбацогт, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

*Байнгын хорооноос гаргасан санал тус бүрээр санал хураалт явуулав.*

**/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн  
82 дугаар зүйлийн 82.2.3-т заасны дагуу явуулах санал хураалт/**

**Г.Занданшатар:** 1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэж санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40  
Татгалзсан: 17  
Бүгд: 57  
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэж санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 15  
Бүгд: 58  
74.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

**Г.Занданшатар:** “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41  
Татгалзсан: 17  
Бүгд: 58  
70.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:09/

*Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Б.Идэрчулуун, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, мөн газрын ахлах шинжээч С.Сарангэрэл, Сургалт, судалгааны мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Л.Лхамжав, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Удирдлагын академийн Эрх зүй, хуулийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор А.Алтанзул, Монгол Улсын Их сургуулийн багш, дэд профессор Д.Оюунгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн, С.Чинзориг, Г.Дамдинням, Т.Энхтүвшин, Д.Батлут, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Б.Энх-Амгалан, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Удирдлагын академийн Эрх зүй, хуулийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор А.Алтанзул, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа нар хариулж, тайлбар хийв.

*Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Б.Энхбаяр, Н.Энхболд /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.Энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 19  
Бүгд: 47  
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Эрүүгийн хууль”, “Авлигын эсрэг хууль”, “Захиргааны ерөнхий хууль”, “Хөдөлмөрийн хууль,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 16  
Бүгд: 45  
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 17  
Бүгд: 45  
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 4.4 дэх хэсэг нэмэх:

“4.4.Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.7, 4.1.9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“төрийн албан хаагийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” гэж төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлагыг;

5.1.2.“төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.3.“төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага” гэж энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 18  
Бүгд: 46  
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийг “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 15  
Бүгд: 46  
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“6 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим**

6.1.Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална:

- 6.1.1.хүнлэг, энэрэнгүй байх;
- 6.1.2.үнэнч, шударга байх;
- 6.1.3.хариуцлагатай байх;
- 6.1.4.манлайлах;
- 6.1.5.хамтач байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 17  
Бүгд: 50  
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.8-7.1.11 дэх заалт, 7.2, 7.3 дахь хэсэг тус тус нэмэх:

“7.1.8.албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх;

7.1.9.байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

7.1.10.албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх;

7.1.11.багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах.

7.2.Төрийн албаны тухай хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.4, 4.1.7, 4.1.9-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтооно.

7.3.Төрийн албаны тухай хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 17

Бүгд: 49

65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“8 дугаар зүйл.Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага**

8.1.Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;

8.1.2.эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;

8.1.3.бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;

8.1.4.бусдын ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

8.1.5.бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх;

8.1.6.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

8.1.7.албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

8.2.Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах үйл ажиллагааг хориглоно:

8.2.1.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах;

8.2.2.удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих;

8.2.3.хүний эмзэг болон хувийн мэдээллийг бусдад дамжуулах, гутаах;

8.2.4.албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах;

8.2.5.үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох, үйлдэл хийх;

8.2.6.соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;

8.2.7.албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх;

8.2.8.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 11

Бүгд: 49

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар бүлэг нэмэх:

**“ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН  
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**9 дүгээр зүйл.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх,  
соён гэгээрүүлэх үйл ажиллагаа**

9.1.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10.1-д заасан эрх бүхий этгээд, албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

9.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

9.1.3.урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах;

9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах;

9.1.5.иргэд, байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10 дугаар зүйл болгох:

**“10 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал  
эрхлэх эрх бүхий этгээд**

10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

10.2.Засгийн газар нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлын талаар Ёс зүйн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.3.Ёс зүйн хороо /цаашид “Хороо” гэх/, Ёс зүйн дэд хороо /цаашид “Дэд хороо” гэх / нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллана.

10.4.Хороо, Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хороо хуралдааны дэгээ өөрөө тогтоож болно.

10.5.Хороо, Дэд хорооны шийдвэр дүгнэлт хэлбэртэй байна. Шийдвэрт хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 22

Бүгд: 48

54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11 дүгээр зүйл болгох:

**“11 дүгээр зүйл.Хороо, түүний бүрэн эрх**

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

11.1.Хороо нь Төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна.

11.2.Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

11.3.Хороо нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан орон тооны бус 4 гишүүнийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо томилж, чөлөөлнө.

11.5.Хорооны үйл ажиллагааны дүрэм, орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо батална.

11.6.Хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

11.6.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

11.6.2.хуульд өөрөөр заагаагүй бол Дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

11.6.3.төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах;

11.6.4.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

11.6.5.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

11.6.6.томилох эрх бүхий этгээдээс ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих;

11.6.7.Дэд хорооны ажиллах журмыг батлах;

11.6.8.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, түүнд хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж, мөрдүүлэх;

11.6.9.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

11.6.10.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг зөрчсөн талаар нэгдсэн тайлан гаргах;

11.6.11.хууль тогтоомжид заасан бусад.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

11.7.Энэ хуулийн 7.2, 7.3-т заасан ёс зүйн хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомж, дүрмийн төсөлд Хорооны саналыг авна.

11.8.Хорооны гишүүн хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгөө болон эхнэр, нөхөр, гэр бүл, садан төрлийн бусад гишүүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээс татгалзах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 18

Бүгд: 46

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12 дугаар зүйл болгох:

**“12 дугаар зүйл.Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх**

12.1.Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

12.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

12.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

12.1.3.Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

12.1.4.ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Хороо, Дэд хороонд гаргаж өгөх;

12.1.5.Дэд хорооны дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол хариуцлага хүлээлгэх;

12.1.6.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, Хороонд тайлагнах;

12.1.7.Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

12.1.8.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 19

Бүгд: 46

58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13 дугаар зүйл болгох:

**“13 дугаар зүйл.Дэд хорооны бүрэн эрх**

13.1.Дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно.

13.2.Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно.

13.3.Дэд хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

13.3.1.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

13.3.2.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

13.3.3.харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх;

13.3.4.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;

13.3.5.ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Хороонд хүргүүлэх;

13.3.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

13.3.7.хуульд заасан бусад.

13.4.Дэд хорооны гишүүн дараах баталгаагаар хангуулна:

13.4.1.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах;

13.4.2.хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх;

13.4.3.шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17

Бүгд: 44

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох:

**“14 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл гаргах**

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

14.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг энэ хуулийн 14.3-т заасан харьяаллын дагуу Хороо, эсхүл Дэд хороонд гаргана.

14.2.Гомдол, мэдээлэлд албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

14.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг дараах харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ:

14.3.1.Дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны;

14.3.2.Засгийн газар нь аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга, харьяалах дээд шатны Дэд хороогүй байгууллагын удирдах албан тушаалтан болон Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5, 4.1.9-д заасан этгээдийн;

14.3.3.Хороо нь төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтан болон энэ хуулийн 14.3.1, 14.3.2-т зааснаас бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, Авлигын эсрэг хуулийн 4.1.4-т заасан этгээдийн.

14.4.Хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хянан үзэж, шаардлагатай тохиолдолд санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18

Бүгд: 44

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15 дугаар зүйл болгох:

**“15 дугаар зүйл.Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх**

15.1.Энэ хуулийн 14.3-т заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгах ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:

15.1.1.гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр, эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тухайн албан хаагчийг дуудан ирүүлж, тодруулга мэдээлэл авах;

15.1.2.шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах;

15.1.3.шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

15.1.4.цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;

15.1.5.төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, үндэслэлийг тусгах.

15.2.Дүгнэлтийг дараах этгээдэд баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа, эсхүл биечлэн гардуулснаар дараах этгээдэд мэдэгдсэнд тооцно:

15.2.1.гомдол, мэдээлэл гаргасан этгээд;

15.2.2.зөрчилд холбогдсон төрийн албан хаагч;

15.2.3.томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллага.

15.3.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

15.4.Гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол 14 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

15.5.Иргэний гомдол, мэдээлэл гаргахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна.

15.6.Дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд, түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороо, Хороонд гомдол гаргаж болно.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан эрх бүхий этгээд гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.7.1.дүгнэлтийг хэвээр үлдээх;

15.7.2.дүгнэлтийг хүчингүй болгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 19

Бүгд: 44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16 дугаар зүйл болгох:

**“16 дугаар зүйл.Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх**

16.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Хороо, Дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна:

16.1.1.гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

- 16.1.2.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
- 16.1.3.байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;
- 16.1.4.төрийн албанаас халах.

16.2.Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

16.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасныг зөрчсөн бол тухайн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

16.4.Төрийн албан хаагчид энэ хуульд заасны дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.5.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

16.6.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 20  
Бүгд: 44  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17 дугаар зүйл болгох:

**“17 дугаар зүйл.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг  
сайн дураар хүлээх**

17.1.Хороо, Дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

17.2.Төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно:

17.2.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;

17.2.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 22  
Бүгд: 44  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 17  
Бүгд: 43  
60.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 19  
Бүгд: 43  
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19 дүгээр зүйл болгох:

**“19 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх**

19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр, үйл ажиллагааны тайланг дараа оны 01 дүгээр сард багтаан Хороонд хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.

19.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.

19.3.Хороо үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд хүргүүлнэ.

19.4.Хороо холбогдох байгууллагаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 18  
Бүгд: 42  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

21.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд шинээр бүлэг, хэсэг, зүйл, заалт нэмэгдэж, хасагдсантай холбогдуулан төслийн бүтэц, дугаарлалт, найруулгын холбогдох өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төрийн албан хаагчдад тавигдаж байгаа ёс зүйн хэм хэмжээ, шаардлага болон хариуцлагын асуудлууд тус тусынхаа холбогдох хуулиар тодорхой албан тушаалтнуудын тухай зохицуулж, ялгамжтай байдлаар хэрэглэх талаар хэлж, протоколд тэмдэглүүлэв.

*Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Нэг.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төсөл**

**Г.Занданшатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 19

Бүгд: 44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “37.1.12” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 19

Бүгд: 44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,  
ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төсөл**

**Г.Занданшатар:** Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

**Г.Занданшатар:** Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 21

Бүгд: 44

52.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Дөрөв.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

**Г.Занданшатар:** Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 19

Бүгд: 44

56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Тав.“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

**Г.Занданшатар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь дэд заалт нэмэх:

“2/Авлигын эсрэг хуульд хөрөнгө орлогын мэдүүлгээс гадна зарлагыг мэдүүлж байх талаар санал боловсруулж, холбогдох хуульд тусгах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Н.Энхболд, Ш.Адъяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 30

Бүгд: 42

28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 35 минут үргэлжилж, 13 цаг 40 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 24 минутад эхлэв.*

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хуралдааныг даргалав.*

**Гурав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнараран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Батлут, Ш.Раднаасэд, Ц.Мөнх-Оргил, Э.Бат-Амгалан, Ц.Даваасүрэн, О.Цогтгэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Х.Баделхан, Ж.Батжаргал, Ш.Адьяшаа, Т.Энхтүвшин, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ц.Мөнхцэцэг, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, Ц.Туваан, А.Адьяасүрэн нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Тогтохсүрэн, Т.Доржханд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнараран, мөн хорооны Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ц.Сэргэлэн, Ц.Мөнхцэцэг, С.Амарсайхан нар дэмжиж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Ганибал нар дэмжээгүй үг хэлэв.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар цаг сунгаж хуралдах талаар хэлэв.  
/18:08/*

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 11

Бүгд: 43

74.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их**

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

*Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нарын гишүүд 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

**Бусад.** “Бэрс финанс” банк бус санхүүгийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэл дэх салбарын захирлууд, “Шихихутуг” Хууль зүйн их сургуулийн Бизнесийн эрх зүйн ангийн 3 дугаар дамжааны оюутнууд, Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын “Хөгжил” цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн урилгаар Баянзүрх дүүргийн Социал демократ Монголын залуучуудын холбооны тэргүүлэгчид болон ерөнхий боловсролын “Ирээдүй” цогцолбор сургуулийн 8 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 а,б,в,г ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, П.Анужин, Б.Жаргалмаа, Н.Учрал, Э.Батшугар нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн Социал демократ Монголын залуучуудын холбооны гишүүдийн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Д.Сарангэрэл, Г.Амартүвшин нарын урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Л.Мөнхбаатар нарын урилгаар Хөвсгөл аймгийн Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн албан хаагчид болон ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Баделхан нарын урилгаар Баян-Өлгий аймгийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нар, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар “Хууль, эрх зүйн боловсролыг дээдлэгч хамт олон” уралдааны аварга “Монгени” цогцолбор сургуулийн 9г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 7 цаг 50 минут үргэлжилж, 73 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 89.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 39 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их Хуралдай” танхим  
10 цаг 05 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023  
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ  
ӨДӨР/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** УИХ-ын  
гишүүдийн ирц бүрдсэн байна.

УИХ-ын 2023 оны хаврын ээлжит  
чуулганы 4 дүгээр сарын 13-ны өдрийн  
нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар  
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улсын ҮХЦ-ийн  
2023 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.

2 дугаарт, төрийн албан хаагчийн  
ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт  
өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын  
төслүүдийг хэлэлцэнэ, зарчмын зөрөөтэй  
27 саналтай, энэ УИХ-ын гишүүн  
Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ нарын 4  
гишүүн өргөн мэдүүлсэн ийм хууль байгаа.  
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын  
хорооны дарга Баттөмөр гишүүн энэ  
хууль дээр ажлын хэсгийн ахлагчаар  
ажилласан, ажлын хэсгийн ахлагч.

3 дугаарт, Монгол УИХ-ын  
сонгуулийн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл  
болон хамт өргөн мэдүүлсэн УИХ-ын  
тогтоолын төсөл, УИХ-ын гишүүн  
Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн өргөн  
мэдүүлсэн.

4 дүгээрт, Монгол УИХ-ын  
сонгуулийн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн  
төслүүд, УИХ-ын гишүүн Цогтгэрэл,  
Дашдондогийн Ганбат нарын өргөн  
мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудлыг  
хэлэлцэнэ.

5 дугаарт, төрөөс олгох  
урамшууллаас нийгмийн даатгалын болон  
ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай  
хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг  
хийнэ. Зарчмын зөрөөтэй 2 саналтай,  
Туваан нарын гишүүдийн санаачилсан.

6 дугаарт, ЗГ-ын тусгай сангийн  
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг  
хийнэ.

7 дугаарт, дотоод орчны агаарын  
бохирдолтой холбоотой хууль  
тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах,  
хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах,  
сурах эрхийг хангах хүрээнд зохион  
байгуулсан хяналтын сонсголын тайланг  
сонсоно.

Монгол УИХ-ын чуулганы  
хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-д  
заасны дагуу хууль тогтоолын төслөө  
хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл  
хамааран хууль санаачлагч хууль,  
тогтоолын төслөө татан авах үндэслэл  
бүхий саналаа тусгасан албан бичгийг  
УИХ-д ирүүлэх бөгөөд үүнийг нэгдсэн  
хуралдаанд уншиж сонсгосноор  
танилцуулснаар хууль, тогтоолын  
төслийг татан авсанд тооцно гэж  
заасан. Энэ дагуу Жамбалын Ганбаатар  
гишүүнээс ирүүлсэн бичгийг уншиж  
танилцуулъя.

УИХ-ын дарга Занданшатар  
танаа. Миний бие ТХШТХ-ийн  
шинэчилсэн найруулгын төслийг  
санаачлан боловсруулж, УИХ-д өргөн  
мэдүүлсэн. ЗГ-ын шийдвэрээр МХЕГ-ыг  
татан буулгасантай холбоотойгоор  
миний өргөн мэдүүлсэн ТХШТХ-ийн  
шинэчилсэн найруулгын төслийн үзэл  
баримтлалд зармын өөрчлөлтүүд  
орохоор байгаа тул Монгол УИХ-ын



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тухай хуулийн дагуу хуулийн төслөө татан авах хүсэлтийг гаргаж байна. Холбогдох журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье. УИХ-ын гишүүн Жамбалын Ганбаатар гэсэн байна аа. Ингээд хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, горимын санал гаргах бол ирүүлнэ гэж заасны дагуу үндэслэл бүхий саналыг Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээс ирүүлсэн байна. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ ээ.

**Б.Пүрэвдорж:** Өнөөдөр УИХ-ын чуулганаар Сонгуулийн тухай хуулийг хэлэлцэх гэж байна. Хэдийгээр би улс эх орны хөгжил, дэвшилд хэрэгтэй чухал шаардлагатай мөн түүнчлэн сонгогчдын саналыг гэдэггүй, холимог тогтолцоог дэмждэг боловч энэ удаа энэ бодлоосоо 1 алхам ухрахаас өөр аргагүй болж байна. Энэ бол өнөөдрийн 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл төрийн эрхийг барьсан МАН-тай салиггүй холбоотой. Өнөөдөр энэ төсөв данхайсан, төсвөөс хулгай хийх нь хэтэрсэн, 2018 онд 9.6 их наядын төсвийн зарлагатай байсан Монгол Улс өнөөдөр 20.5 их наяд болж 1 дахин нэмэгдсэн. Эндээсээ төсвөөр дамжуулж маш их зардал гаргаж тэрнээсээ тендерээр зувчуулдаг. Тэгээд үүнийгээ бүгд бүрдүүлэхийн тулд ард түмэн, компани, ААН-үүдийг шулдаг.

2018 онд 6.2 их наядын татварын орлоготой байсан Монгол орон өнөөдөр 17 их наядын татварын орлоготой болж татвараар 3 дахин нэмэгдүүлсэн байна. Тэгээд энэ их зардлаа санхүүжүүлдэг. Тэгээд төсвөөс хулгайлдаг нь одоо багадаад Төрийн өмчийн компаниуд руу орсон. ЖДҮ, концесс, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, төмөр замын хулгай зэрэг ийм олон хулгай руу орсон. Зөвхөн Эрдэнэс таван толгой дээр ярихад 40 их наядын хохиролтой гэж ярьж байгаа. Тэр

компанийн ганцхан захирал нь 1 хувийн компанитай 19 их наядын буюу Монгол Улсын төсөвтэй тэнцэхүйц хэмжээний юу оптекийн гэрээ байгуулдаг. Ийм замбараагүй юм явж байна.

Тэгээд энэ их хулгайгаараа сонгогчдын саналыг худалдаж авдаг. Тэгээд өнөөдөр бүүр байтлаа жагсаалт оруулж ирж байгаад жагсаалтын ард намыгаа санхүүжүүлэх замаар энэ жагсаалтын ард нуугдах гэж байна. Би хөдөө орон нутгаар явсан. 7 сарын 15-наас хойш би 60 гаруй уулзалт би Ховд аймагтаа хийсэн. Дээрээс нь 4-5 аймаг руу явж би уулзалт хийсэн. Иргэд юу ярьж байна. Иргэд жагсаалтын ард нуугдахыг, хулгайч нар нуугдахыг эсэргүүцэж байгаа. Иргэд 152 гишүүнтэй болохыг эсэргүүцэж байгаа шүү дээ. Би бол энэ ард түмэнтэйгээ ойрхон байдаг, тэдний хүсэл сонирхол дээр би үгийг нь дамжуулдаг, ийм л хүн байгаа.

Гэтэл өнөөдөр энэ ард түмний хүслийг эсэргүүцээд, жагсаалтын ард баахан хулгайчдаа оруулж ирэх гээд, дээрээс нь гишүүдийн тоог үүнийхээ ард нэмэх гэж байгаа энэ Их Хурлын шийдвэр дээр ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ Их Хурлын сонгуулийн тухай хууль хэлэлцэх үед ярих сэдэв байна. Хаягаа андуурчихсан байна. Тэр үедээ ярья.

Одоо бол **Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 1 дүгээр дүгнэлтийг сонсоно, хэлэлцэнэ.**

ҮХЦ-ийн дүгнэлтийг ҮХЦ-ийн гишүүн Батсүхийн Буяндэлгэр танилцуулна. оруулж ирье.

Ер нь бол энэ 3, 4 дүгээр асуудал дээр Сонгуулийн тухай хууль ажлын хэсгээс оруулж ирсэн. 3, 4 дүгээр асуудал Сонгуулийн тухай хууль хэлэлцэх үед үүнийг ярих юм байна.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ҮХЦ-ийн дүгнэлтийг ҮХЦ-ийн гишүүн Батсүхийн Буяндэлгэр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Буяндэлгэр:** Монгол УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэнд Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийг уншиж сонсоё.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсгийн зарим заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн, эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

ҮХЦ-ийн хуралдааны танхим 11 цаг 40 минут. Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааныг ҮХЦ-ийн гишүүн Баясгалан даргалж, ҮХЦ-ийн гишүүн Солонго, Буяндэлгэр, илтгэгч Нанзаддорж, Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Баяржаргалыг оролцуулан ҮХЦ-ийн хуралдааны танхимд нээлтээ хийлээ.

ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Батмөнх оролцоо. Монгол УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Сүхбаатар 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 03/2740 дүгээр албан бичгээр ҮХЦ-д өмнө нь ирүүлсэн тайлбартаа нэмж гаргах тайлбар байхгүй тул маргааныг өөрийн эзгүйд шийдвэрлэхийг зөвшөөрч байгаагаа мэдэгдсэн болно. Энэхүү хуралдаанаар Монгол УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 3-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох

заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцлээ.

Үндэслэл 1. Монгол УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 1 дэх хэсэгт ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох хэд хэдэн үндэслэлийг хуульчилсан байх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан бол дээрх үндэслэлд хамаарахаар мөн зүйлийн 41-ийн 1-ийн 3 дахь заалтад тусгаж энэ тохиолдолд тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт заасны дагуу тухайн төлөөлөгчийг огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэн шийдвэрлэхээр заасан байна.

Дээрх үндэслэлээр иргэдийн Хурлын Төлөөлөгчийг огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэхэд тус хуулийн 39 дүгээр зүйлд заасан эрхийнхээ дагуу хурлын төлөөлөгчид асуулт асууж, хариулт авч, санал, дүгнэлт гарган санал хураалгаж болох бөгөөд уг асуудлыг ийнхүү хэлэлцэн шийдвэрлэхээр хуульчилсан нь гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон этгээдийн гэм буруугийн асуудлыг цаашилбал аливаа шүүхийн шийдвэрийг ИТХ-аар хэлэлцэж болох нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна.

3. ИТХ-ын төлөөлөгч нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нийтийн албан тушаалтан мөн болохын хувьд эрх хасах ял буюу нийтийн албанд ажиллах эрхийг хасах ялаар шийтгүүлсэн тохиолдолд дээрх хуулийн заалтаас шалтгаалж уг шүүхийн шийдвэр цаг хугацааны хувьд нэн даруй хэрэгжих боломжгүй болж нийтийн албанд ажиллах эрхээ хасуулсан иргэдийн Хурлын Төлөөлөгч бүрэн эрхээ цаашид

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэрэгжүүлэн ажиллах үр дагаврыг үүсгэж болзошгүй байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлд зааснаар ИТХ-ын ээлжит хуралдааныг улиралд 1 удаа, ээлжит бус хуралдааныг нийт төлөөлөгчдийн 3-ны 1-ээс доошгүйн саналаар, эсхүл хурлын зөвлөл, хурлын даргын санаачилгаар хуралдуулах бөгөөд хуралдааны дэгийн хүрээнд тус хуралдааныг хойшлуулах завсарлага авах боломжтой байна. Үүнээс үзэхэд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсгийн холбогдох зохицуулалт шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмыг хөндөж байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гэсэн заалт нь бүх шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр, бүх байгууллага, хуулийн этгээд заавал биелүүлэх агуулгыг илэрхийлж байна.

Иймд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 3-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын

Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 2, 1-ийн 4, 1-ийн 5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41-ийн 1-ийн 3, 41-ийн 1-ийн 1, 41-ийн 1-ийн 7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасны 41-ийн 1-ийн 3 гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Дээд Шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт 41-ийн 1-ийн 3 гэж заасныг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг УИХ-д уламжилсугай.

Даргалагч Баясгалан, гишүүд Солонго, Буяндэлгэр, Нанзаддорж, Гангабаатар.

**Г.Занданшатар:** Цэцийн дүгнэлтийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Э.Бат-Амгалан:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсгийн зарим заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 1 дүгээр дүгнэлтийг 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр УИХ-д ирүүлснийг ХЗБХ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

ХЗБХ-ны хуралдаанаар ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар дурдаад дүгнэлттэй холбогдуулан УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, хариулт авсан болно. УИХ-ын гишүүн Мөнхцэцэг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсгийн зарим заалт, Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн ҮХЦ-ийн дүгнэлт гарсан тул хүлээн авч хуулийн холбогдох заалтыг өөрчлөн найруулж, хууль хэрэглээний тал дээр маргаан үүсгэхгүй байх нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Мөнхбаатар уг хуулийн зохицуулалт, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хэлэлцэхтэй холбоотой асуудал биш, иргэдийн төлөөллийг хангах, нөхөн сонгууль явуулах боломжийг нээсэн зохицуулалт тул ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар, УИХ-ын гишүүн Адьяа иргэдийг төлөөлөх эрх бүхий этгээд гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор батлагдсан бол даруй шийдвэрлэх зохицуулалтыг хуульд

тусгаж, ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй талаар, УИХ-ын гишүүн Сэргэлэн хуулийн нэр томьёо хоёрдмол утга илэрхийлж байгаатай холбогдуулан ҮХЦ-ээс маргаан үүсгэсэн байх магадлалтай бөгөөд Үндсэн хуулийн суурь зарчмыг ямар ч тохиолдолд хэрэгжүүлдэг байх зохицуулалтыг тусгаж, холбогдох өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа талаар саналаа илэрхийлсэн болно.

Монгол УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 2, 41-ийн 1-ийн 4, 41-ийн 1-ийн 5-д заасан тохиолдолд 41-ийн 1-ийн 3, 41-ийн 1-ийн 6, 41-ийн 1-ийн 7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж гэж заасны 41-ийн 1-ийн 3 гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Дээд Шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Бат-Амгалан гишүүнд баярлалаа.

Одоо ТББХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Амгалангийн Адьяасүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**А.Адъяасүрэн:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсгийн зарим заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн, эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр УИХ-д ирүүлснийг ТББХ Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

ТББХ-ны хуралдаанаар ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн нар ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар дурдаад, дүгнэлттэй холбогдуулан УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж хариулт авсан болно.

Монгол УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 2, 41-ийн 1-ийн 4, 41-ийн 1-ийн 5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41-ийн 1-ийн 3, 41-ийн 1-ийн 6, 41-ийн 1-ийн 7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасныг 41-ийн 1-ийн 3 гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон

гишүүдийн дийлэнх олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу.

Содномын Чинзориг сайдаар тасаллаа. Өөрөөс нь асууж байж болъё. Хүний кноп дарж болохгүй Пүрэвдорж гишүүн. Лхагвын Мөнхбаатар УИХ-ын дэд дарга асуулт асууя.

**Л.Мөнхбаатар:** ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй байгаа юм аа. Энэ цэцийн дүгнэлт ямар агуулгатай вэ гэхээр иргэдийн Хурлын Төлөөлөгч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн буюу бүрэн эрх нь дуусгавар болох энэ асуудлыг шийдвэрлэнэ гэсэн энэ асуудлыг бол Үндсэн хуулийн зөрчсөн байна дүгээр гэсэн ийм агуулгатай шийдвэр гарчхаад байгаа юм. Энэ нь ямар учиртай вэ гэхээр ер нь засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль дээр ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болгох 8 үндэслэлийг зааж өгсөн. Энэ 8 дотор бол гэмт хэрэг үйлдэж шүүхийн шийдвэр гарсан бол уул нь огцруулна гэж байгаа юм. Энэ огцруулахдаа ИТХ-ын хэлэлцэж шийднэ. Энэ бол уул нь ямар агуулгатай гарсан бэ гэхээр хууль тогтоогчдын зүгээс ямар агуулгатайгаар үүнийг гаргасан бэ гэхээр шүүхийн шийдвэр хэлэлцэж байгаа асуудал биш юм. Шүүхийн шийдвэрийг зөв буруу гэдэг асуудлыг хэлэлцэхгүй мэдээж. Энэ бол эцсийн шийдвэр шүүхийн шийдвэр байна. Гэхдээ тухайн хүн сонгогдсон төлөөлөгчийнх нь хувьд бүрэн эрхийг нь дуусгавар болгох буюу огцруулах асуудлыг иргэдийн хурлаар шийдэх нь зүйтэй.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хэрвээ ингэж шийдэхгүй шүүхийн шийдвэр гараад орхичих юм бол дараагийн нөхөн сонгууль явах, тухайн төлөөллийг хүн амын төлөөллийг хангах энэ асуудал чинь орхигдоод үлдчих гээд байгаа учраас энэ заалтыг бол оруулсан байгаа юм, оруулсан. Ийм учраас энэ парламентаас баталсан энэ хууль маань бол Үндсэн хуульд нийцсэн хууль гэдгийг би хэлэх гээд байгаа юм.

Нөгөөтээгүүр энд бол огцруулах, эсэх асуудлыг шийдвэрлэнэ гээгүй байгаа шүү дээ. Огцруулах асуудлыг л шийдвэрлэнэ гэж байгаа юм. Агуулга нь бас тийм. Тийм учраас Иргэдийн хурлаараа хэлэлцэнэ, үүнийг огцруулна. Тэртээ тэргүй хуулийн үндэслэл нь байгаа, энэ юуны шүүхийн шийдвэрийг гарчихсан учраас чөлөөлье, огцруулъя гээд ингээд санал хураалтаа явуулах ийм л энгийн процесс байгаа байхгүй юу. Тэрнээс биш шүүхийн шийдвэрийг аваачаад зөв бурууг нь энд иргэдийн хурлаар ярих гээд байна гэсэн ийм ойлголтоор ерөөсөө яваад байх шиг байгаа юм. Энэ бол ийм юмгүй ээ гэдгийг хэлье. Тэгээд ийм учраас энэ цэцийн дүгнэлтийг бол хүлээж авах боломжгүй байгаа юм гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Санал хэлчихлээ, тийм ээ. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

**Ц.Даваасүрэн:** Та бүхний энэ өглөөний мэндийг эрье. Би ч гэсэн бас цэцийн шийдвэрийг хүлээж авах боломжгүй гэсэн талдаа байгаа юм. Ер нь аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч бол бас ард түмний төлөөлөл учраас энэ асуудалд бол бид нар шүүх хүчний байгууллага гэж ингэж шийдэхээс илүү бас тэр ард түмний төлөөллийн шийдвэрийг бас харах ёстой. Яагаад тэгдэг вэ гэвэл ер нь энэ төлөөллийн байгууллагууд бол ард түмний мандатыг авч ажиллаж байгаа, улс төрийн нөлөөлд өртөж болох боломжтой ийм этгээд байдаг юм. Ялангуяа нэг хоёрхон хүний зөрөөтэй байх юм бол үүнийг зүгээр

л ийм асуудлаар шийдэх боломжтой. Тийм учраас УИХ-ын гишүүн халдашгүй байдаг энэ төлөөллийг хэрэгжүүлж байгаа иргэдийн төлөөлөгч халдашгүй байдаг. 1 хүний зөрөөг шүүхээр шийдэж болохгүй, ийм л зүйл.

Тэгээд ер нь энэ ҮХЦ энэ Үндсэн хуулиас хамаарч байгааг хэзээ зогсоох юм бэ? Тэр Үндсэн хуулийн 2016 оны дүгнэлтээ эргэж харсан ийм зохисгүй юм хийсэн. Тэрнээс болоод өнөөдөр энэ сонгуулийн хуулийн асуудал орж ирж байна шүү дээ. Бид нар 19 онд Үндсэн хууль хэлэлцэхдээ холимог тогтолцоог дэмжээгүй юм. Холимог тогтолцоо унасан байдаг юм, санал хураалтаар. Тэгэхэд буцаагаад Их Хурал шийднэ ээ гэсэн ийм хачин дүгнэлт гаргасан. Тэгээд тэнд бол тэтгэврийн нас нь хэтэрчихсэн, хугацаа нь дуусчихсан ийм улсууд тэгээд Үндсэн хуулийн зөрчилтэй эсэх маргааныг шийднэ гээд ингээд сууж байдаг. Үүнийг болиулмаар байна, Их Хурлын дарга аа. Энэ явуулсан 3 байгууллага нь анхаар.

Ер нь Үндсэн хуулиасаа эхлээд, ҮХЦ-ээсээ эхлээд Монголын төр дампуурч байна. Энэ чинь хулгайтай ялгаа байхгүй, төрийн эсрэг гэмт хэрэг хийгээд сууж байна шүү дээ, тэнд. Үндсэн хуулийнхаа эсрэг гэмт хэрэг хийгээд сууж байна. Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг хийгээд сууж байна. Ард түмэн гишүүнээ сонгохдоо ямар нэг байгууллага дамжихгүй сонгоно гэж 16 онд дүгнэлт гаргачхаад одоо болох юм шиг яриад сууж байна шүү дээ. Зөнөчихсөн байна. Энэ ҮХЦ тэтгэвэртээ гараад зөнөчихсөн байна. Тийм учраас энэ зөнөчихсөн улсуудыг буцаад тат. Энэ хууль бус шийд гаргасан улсуудыг эрүүгийн хариуцлага хүлээлгэ. Төрийн эсрэг гэмт хэрэг хийсэн энэ улсуудыг Үндсэн хуулийн Үндсэн хуульд төрийн эсрэг гэмт хэрэг хийсэн улсуудыг ингээд суулгаад байж болохгүй. Энэ ингээд суугаад байх юм бол магадгүй ард түмний хөдөлгөөн болж, ард түмэн босох байдалд хүрнэ. Үндсэн хуулийн хямрал гэдэг бол энэ ард түмнийг босгодог. Тийм учраас ҮХЦ-ийн гишүүдийг сонгохдоо бид

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нар маш олон хэмжүүрээр сайн ярьж байж сонгохгүй бол болдоггүй. Үндсэн хууль гэдэг бол энэ улс оршин тогтнохын дээд эрх хязгаар. Гэтэл тэрийгээ нулимаад, тэрийгээ сүйтгээд сууж байгаа улсуудаар өнөөдөр бид нар ҮХЦ-ийн дүгнэлт хийлгээд байж байж болохгүй. Энэ асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага Их Хурал нэн даруй хэлэлцэх хэрэгтэй, Их Хурлын дарга аа. Тэр хугацаа нь хэтэрчихсэн улсуудаа, тэр тэтгэвэртээ гарчихсан улсуудаа аваад, тэгээд хуулийн байгууллагад нь өг. Тэр Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг хийсэн тэр зүйл заалтаар нь өг.

Ингээж Монголын төр цэвэршихгүй бол үгүй ээ хамгийн цэвэр ариун байх Цэц нь өөрөө ингээд сууж байхаар яаж энэ Монгол төр, энэ Монгол улс цэвэр ариун байх юм бэ? Тэр яригдаад байгаа хулгай, тэр нүүрс бай, тэр Хөгжлийн банкны хулгайгаас илүү юм чинь энэ байхгүй юу. Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг. Оюутолгой дээр эх орноо зарчихсан байхад хэн ч ял авахгүй байна шүү дээ. Эх орныхоо эрх ашгаас урвачихад яах ч үгүй байна. Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг хийгээд Цэцийнхэн сууж байхад Монголын төр таг суугаад л байж байна.

**Г.Занданшатар:** Ер нь энэ асуудалтай холбогдуулаад хэлэхэд Цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйл дээр Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоосон бол эргүүлэн татах асуудлыг тухайн томилсон байгууллагын саналыг үндэслэн УИХ эргүүлэн татаж болно гэж байгаа юм. Яг ажил логикоор бол энэ заалт ингээд бусад ижил төстэй бүх хуульд ийм агуулгатай заалтууд бий. Төрийн албаны тухай хуульд, Ерөнхийлөгч бас томилдог албан тушаалтнууд дээр, УИХ дээр томилдог албан тушаал, яг адил зохицуулалттай, татаж болно гэсэн. Тэгэх юм бол яг үүгээр ингээд энэ процессыг зохицуулсан заалтаар бүгд яг энэ стандартаар явна гэсэн үг болно. Шууд шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болох.

2 дугаарт, энэ чинь өөрөө ард түмний төлөөлөгчдийн байгууллагын бүрэн эрхийн баталгаа учраас Цэцийн гишүүний ч гэсэн бүрэн эрхийн баталгаа гэж байгаа учраас энэ бол ингээд Үндсэн хууль болон бусад хуультайгаа процесс заасан юман дээр энэ зөрчил үүсэх юм байна лээ.

2 дугаарт, нь Даваасүрэн гишүүний яриад байгаа зүйл бол Даваасүрэн гишүүн манай гишүүд бас яг хуулиа сайн үзээд, УИХ-аас томилдог байгууллагуудын дарга, цэрэг, гишүүдийг томилгоог чөлөөлөх, эргүүлэн татах, огцруулах асуудлыг тухайн Байнгын хороо санал, дүгнэлт гаргана гэж байгаа юм. Ер нь бол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулиар УИХ-ын дарга санал болгодог тийм дэг энэ тэр байхгүй болчихсон шүү дээ. УИХ-ын дарга бол ерөөсөө 76 гишүүний 1, тэгээд 1 гишүүний саналаар асуудал хэлэлцдэггүй. Тийм учраас хэрвээ тийм асуудлууд байх юм болбол зарим тэр хуулийн зохицуулалтууд алдчихсан бол тухайн Байнгын хороо санал, дүгнэлт гаргаад л, тэгээд энэ асуудлуудыг хэлэлцэх ийм дэгтэй.

Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

**Ц.Даваасүрэн:** Тийм. Тийм учраас би хуралдаан зохион байгуулагчийн хувьд танд хандаж хэлж байгаа юм. Би бол эд нарыг ингээд огцруулах саналыг Байнгын хороонд гаргасан шүү дээ. Тийм учраас миний тэр асуудлыг Байнгын хороогоор хэлэлцээд ингээд явах бүрэн боломжтой байсан. Би хэлээд байна шүү дээ. Энэ асуудал бол яг жишээлбэл төрт улс байх юм бол Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг байсан байхгүй юу. 16 оныхоо дүгнэлтийг эргэж хараад үгүйсгэж байна гэдэг бол Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг. Энэ бол үнэхээр бузар зүйл байхгүй юу даа. Тэгээд ийм юмыг бид нар ингээд мэдэхгүй царайлаад ингээд байж байна гэж болохгүй. Тэгэх ийм л байх юм бол Монголын төр хэзээ ч цэгцрэхгүй, хэзээ ч цэвэр ариун болохгүй.

*Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.*

**Ш.Адьяа:** Энэ Монгол Улсын ҮХЦ-ийн 23 оны 01 тоот дүгнэлтийг хүлээж авах нь өнөөдөр хууль дээдлэх зарчим, төрийн албаны ёс зүй, сахилгын хариуцлагын асуудлыг өнөөдөр 1 гартаа сахилга хариуцлага, шударга ёс, төрийн албаны ёс зүй гэж яриад өдөр бүхэн хуралдаад байгаа эрх баригчдын үнэнийг ярьж байна уу, нөгөө талдаа энэ хариуцлага, сахилга, ёс зүйг алдсан тэр хүмүүсийгээ хамгаалж байна уу гэдгийг харуулсан ийм асуудал болж байна.

Өчигдөр би ХЗБХ-ны хурал дээр энэ саналаа хэлсэн. Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийн байна гэдэг. Энэ шийдвэрийг тэр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний нэгж, түүний удирдлагын тухай хууль зөрчсөнийг, Монгол Улсын Үндсэн хууль хууль дээдлэх зарчмыг баримталж зөв шийдсэн байгаа. Гэтэл өнөөдөр энд манай Их Хурлын гишүүд бас 1 юмыг ойлгоорой. Гэмт хэрэг үйлдээд 3 шатны шүүхээр шийдэгдсэн шүүхийн шийдвэрийг энэ хуулийн чинь 41-ийн 2-т иргэдийн хурал хэлэлцэнэ ээ гэж байгаа юм. Үгүй ээ, энэ хаанаас ямар гарч ирсэн юм бэ? Өнөөдөр шүүхийн шийдвэрээр шийдэгдсэн хүн шууд явах ёстой шүү дээ. Хэлэлцэхгүйгээр шууд түүнийг огцуулна гэдэг заалтыг бүр оруулж ирэх хэрэгтэй. Өчигдөр энэ дээр ХЗБХ дээр олон УИХ-ын гишүүд, энэ иргэдийн төлөөлөл, ард түмний төлөөлөл гэдэг юм ярьж байна лээ. Ярих нь зөв байх л даа. Гэтэл өнөөдөр иргэд чинь энэ өөрийнх нь төлөөлөл болсон хүмүүс Монгол Улсын хууль зөрчиж, гэмт хэрэг үйлдэж, шүүхийн шийдвэр гарсан байхад түүнийг нь өнөөдөр ингээд хаацайлаад ингээд байх нь та нарын энэ явуулж байгаа энэ төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагад нийцэж байгаа юм уу, олонхын бүлгийн гишүүд ээ, Их Хурлын удирдлага аа.

Ингээд бид нар өнөөдөр 1 цэцийг ялладаг. Тэгээд тэнд Үндсэн хууль зөрчсөн

асуудлыг үнэн зөвөөр нь хуульд нийцүүлээд гаргаад ирэхээр бидний баталсан хууль зөв өө, өнөөдөр гэмт хэрэг үйлдсэн хүний тэр шүүхийн шийдвэрийг иргэдийн хурал хэлэлцэх нь зөв өө гэдэг ийм яриад сууж байгаа нь өнөөдөр ямар юм энд явагдаад байна. Бид нар өнөөдөр ингээд сахилга хариуцлага, ёс зүй, гэмт хэрэгтэй тэмцэнэ гээд энэ УИХ-ын удирдлага, ЗГ чинь өдөр шөнөгүй ярьж байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр гэмт хэрэг үйлдээд 3 шатны шүүхээр эцсийн шийдвэр гараад ирсэн нөхцөлд шууд энэ шүүхийн шийдвэр биелэгдээд явах ёстой байхгүй юу. Шүүхийн шийдвэрийг хэн ч шүүхгүй ээ гээд эцсийн байна гээд Монгол Улсын Үндсэн хууль дээр заачихсан байгаа шүү дээ. Гэтэл яахаараа өнөөдөр иргэдийн төлөөлөл болоод сонгогдчихоод гэмт хэрэг үйлдсэн хүний асуудлыг тэр шүүхийн шийдвэрийг яахаараа иргэдийн хурал хэлэлцдэг юм бэ. Энэ хууль чинь угаасаа л хэлэлцэхээсээ их мордохын хазгай байсан. Энэ хууль бол олон тийм зөрчил агуулсан одоог хүртэлх шүүмжлэл дагуулсан асуудлууд байгаа. Тэрний эхний хэлбэр нь энэ.

Ийм учраас энэ ард түмэн та бүгдийг харж байгаа, бид нарыг харж байгаа. Үнэхээр гэмт хэрэг үйлдээд шүүхийн шийдвэр гарсан эцсийн шийдвэр гарчихсан иргэдийн Хурлын төлөөллийн асуудлыг тухайн аймаг, дүүргийн иргэдийн хурал хэлэлцэнэ ээ гэдэг энэ Үндсэн хууль зөрчсөн асуудлыг та нар өнөөдөр эсэргүүцвэл тэр төрийн албаны ёс зүй, шударга ёсны тухай асуудал чинь зүгээр ... /минут дуусав/

### **Г.Занданшатар:**

Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн Байнгын хорооноос хариулъя. Хууль зүйн байнгын хороо. Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч хариулъя.

**Ж.Сүхбаатар:** Өнөөдрийн энэ ярьж байгаа цэцийн дүгнэлтийн асуудал бас үр дагавартай юм. Тийм учраас би бас 1 товч тайлбар хийчихье гэж бодож байна. Энэ бол иргэдийн төлөөлөгчийг

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

гэмт хэрэг үйлдсэн бол шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гарснаар тэр огцруулах асуудлыг нь ИТХ хэлэлцэж шийдвэрлэх болох уу эсвэл зүгээр шууд шүүхийн шийдвэрийн дагуу автоматаар тэр иргэдийн төлөөлөгчийг төлөөлөгч биш бол гэж үзээд явах уу гэдэг асуудал юм шиг ийм байдлаар ойлгоод байгаа юм. Тэгэхээр энэ асуудал дээр бол энэ түрүүн Даваасүрэн гишүүн бас их ойлгомжтой хэлж байгаа юм. Иргэдийн төлөөлөгч гэдэг бол яг ард түмний төлөөлөгч болсон Их Хурлын гишүүнтэй адилхан бас тодорхой хэмжээнд халдашгүй байдал эдэлдэг. Иргэдийг төлөөлж байгаа мандат гэдэг бол тэр бусад оронд бол маш чухал зүйлд тооцогддог. Хууль хүчний байгууллага, ЗГ-ын ямар нэгэн халдлагаас хамгаалагдсан байх энэ эмнүүдийг бол дэлхийн орнууд тогтоочихсон байдаг. Тийм учраас халдашгүй байдал гэдгийг ганцхан гишүүн дээр хүмүүс яриад байдаг. Тийм биш л дээ. Бусад албан тушаалтнууд дээр ч байгаа. Цэцийн гишүүн ч гэсэн тийм дархлаатай байдаг юм шүү дээ. Тэгэхээр Цэцийн гишүүд Монгол Улсад бол бүр хамгийн их том дархлааг эдэлчихсэн байдаг. Гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон байсан ч гэсэн Цэцийн гишүүнээс нь эргүүлэн татах тухай асуудлыг Цэц эхэлж шийдвэр гаргана гэж байгаа юм. Өөрийнх нь хууль дээр. Бүр анх илгээсэн байгууллагын саналыг нь үндэслэнэ гэж байгаа юм. Тэгээд Их Хуралд эргүүлэн татаж болно гэж байгаа юм бас эргүүлэн татна гэхгүй байгаа шүү. Бүр Их Хурлын гишүүдээсээ илүү хамгаалалт Цэцийн гишүүд энэ дээрээ Цэцийн тухай хуулиар авчихсан байдаг байхгүй юу. Хэрвээ энэ заалт жишээлбэл буруу гэвэл Их Хурлын гишүүдийн асуудлыг шууд шүүх гэмт хэрэг үйлдсэн гэвэл шууд гишүүний мандат дуусгавар болсонд тооцдог болох ёстой болно.

Дээр нь Цэцийн гишүүдийн өөрсдийнх нь Цэцийн хууль дээр байж байгаа энэ юм чинь бас буруу шүү дээ. Цэцийн гишүүд тэгэхэд сонгогддог хүмүүс биш шүү дээ. Тэгэхэд яг цэцийн

гишүүд Их Хурлын гишүүдээс илүү хамгаалалт эдэлдэг байхгүй юу. Тэгэхээр энэ логик нь юу юм бэ гэхээр зэрэг зарим I үед бол яах вэ, манай хууль дээр бол Их Хурлын гишүүдийг чинь харин ч бүүр айхтар хийчихсэн байдаг юм шүү дээ амархан. Одоо шүүхийн шийдвэр гарчихсан байвал эргүүлэн татна гээд шууд заачихсан байдаг байхгүй юу. Эргүүлэн татна гэж. Их Хурал бол хэлэлцэж шийдвэрлэнэ. Тэгэхдээ өөрсдөө яах вэ хэлэлцэн шийдвэрлээд дэмжчих юм бол тогтоол баталсанд тооцно гэж байгаа юм. Гэхдээ Үндсэн хууль дээр бол шууд эргүүлэн татна гэж заачихсан байгаа.

Бусад оронд бол яагаад үүнийг ингээд түрүүн тэр хэлдгээр тусдаа байдаг юм бэ гэхээр I суудлаар зөрөөтэй байгаа үед жишээлбэл шүүхийн оролцоотойгоор тэр улс төрийн эрх мэдлийн харьцааг тодорхойлж өөрчилчих боломжтой байхгүй юу. Би энд I зүйлийг хэлмээр байгаа юм. Онолын талаас нь зүгээр, Чимэд багшаар би хичээл заалгаж байсан хүний хувьд парламентын эрх зүй гэдэг хичээл Монголд анх удаа ороход би хичээлд аз болоход сууж байсан. Тэгэхэд Чимэд багш юу гэж хэлж байсан бэ гэхээр парламентын гишүүн төлөөлөгч хүний мандатыг шүүх хүртэл эвдэх эрхгүй, шоронгоос ч ажлаа явуулах боломжтой байдаг юм гэж. Одоо яг энэ Трамп дээр яригдаж байна шүү дээ. Арай өөр хэлбэрээр. Хэрвээ энэ Трамп энэ буруутгагдаж байгаад нэр дэвшихсэн явж байгаад ял эдлээд шоронд орчихвол нэр дэвших боломжтой юу гэхээр боломжтой гэж байгаа байхгүй юу. Америкийн хуульчид. Үндсэн хуулиар үүнийг хориглоогүй. Энэ бол тусдаа асуудал, сонгогдох эрхийн асуудал учраас сонгогдох эрхийг нь жишээлбэл тэр нөгөө юмаар нь хязгаарлаж болохгүй гээд зааж байгаа.

Яг түүнтэй адилхан энэ шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцэж байгаа биш байхгүй юу, Адьшаа гишүүн ээ. Гэм буруутайг нь ерөөсөө шүүх тогтоочхож



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байгаа болохоос биш чи төлөөлөгчөө хийж болохгүй гэдгийг нь яг шийдсэн гэсэн үг биш. Тэр ИТХ чинь өөрөө тэрийгээ цуцлаад, нөхөн сонгууль зарлах эсэх асуудлуудаа тогтоол гаргаж хэлэлцэж байж шийдэх байхгүй юу. Тэгэхээр энэ ганцхан тэр иргэдийн төлөөлөгчтэй холбоотой асуудал биш. Уг нь аягүй тийм ойлгомжтой энгийн асуудал дээр манай цэц маань яагаад ийм онол арга зүйн хувьд ийм алдаатай шийдвэр гаргачхав аа л гэж. Энэ чинь өөрөө эдний дүгнэлтээр явчихвал өөрсдийнх нь асуудал ч гэсэн Цэцийн хуулийг бид нар тэгвэл шинэчлэхдээ бүр хялбархан л болгочих нь шүү дээ. Шүүхийн юун дээр 1 торгох ял аваад л тэгээд л чи шууд тэр цэцийн гишүүнээсээ татагдах тийм л байдал үүснэ шүү дээ. Гэтэл цэцийн тухай хууль дээр чинь бүр Цэц гэмт хэрэг үйлдсэн байгаад байхад хүртэл тэгвэл Цэц өөрөө шийдвэр гаргана, анх илгээсэн байгууллага нь санал гаргана, тэрний дараа Их Хурал авч үзнэ гэдэг бүр заалт байгаа байхгүй юу. Тэгвэл тэр заалтаар чинь шүүхийн шийдвэрийг ч гэсэн тэгвэл Цэц ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя.

“Бэрс Финанс” ББСБ-ын удирдлага, аймаг, нийслэл дэх салбарын захирлууд УИХ-ын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Адьяаа гишүүн тодруулж асууна, 1 минут.

**Ш.Адьяаа:** Сүхбаатар гишүүн ээ, т жоохон андуураад байх шиг байна. Энэ хуулийн чинь 42-ын 2 дээр үүнийг хэлэлцэнэ гээд цагаан цаасан дээр хараад биччихсэн байна шүү дээ. Энэ юмыг өмгөөлж хамгаалж болно. Тэгэхдээ таны өргөн барьсан хууль чинь өнөөдөр хөндөгдсөн учраас та ийм юм ярьж байна гэж бодож байгаа. Та өнөөдөр сахилга хариуцлага ёс зүйг 1-д тавина гэж байгаа.

2 дугаарт, тэр шүүхийн шийдвэрийг хэлэлцэнэ л гэж байгаа шүү дээ. Тэр юун дээр чинь, тэгэхээр энд ямар асуудал яригдаад байна аа? Өчигдөр ХЗБХ-г Сүхбаатар гишүүн даргалах ёсгүй байсан. Яагаад гэвэл энэ ашиг сонирхлын зөрчилтэй, энэ хуулийг өргөн барьсан хүн. Тэгээд ийм байдлаар тайлбарлаад ёс зүй, сахилга, хариуцлага, гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхийн шийдвэрийг ингээд бид хэлэлцээд байх нь ер нь ямар жишгийг тогтоох гээд байгаа юм бэ? Ийм учраас энд тайлбар авъя, Сүхбаатар гишүүнээс.

### **Г.Занданшатар:**

Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн тайлбар авъя гэнэ ээ, сайн тайлбарлаж өг.

**Ж.Сүхбаатар:** Би товчхон зүгээр түрүүн хэлсэн, шүүхийн шийдвэрийг хэлэлцээгүй гэдгийг манай Их Хурлын гишүүд угаасаа мэдэж байгаа. Би энэ дээрээ хэн нэгэн миний хэлсэн хууль бол биш ээ. Энэ хуулиуд Их Хурлын тухай хууль, цэцийн хуулиуд чинь аль өмнө нь Цэцийн хууль бол 93 ондоо ингээд гарчихсан хууль байгаа байх. Энэ Их Хурлын хууль чинь надаас өмнө ингээд батлагдаад явж байсан хуулиуд аа. Одоо ч гэсэн Их Хурлын тухай хууль дээр шүүхийн шийдвэр гарсан ч гэсэн ТББХ-оор ороод л санал, дүгнэлтийг нь хэлэлцээд л, тэгээд гишүүдийг олонхоор эргүүлэн татах асуудлыг нь дэмжсэн бол тогтоол батлагдсанд тооцдог шүү дээ.

Энэ иргэдийн төлөөлөгч чинь мөн адилхан ИТХ-ын бүрэн эрхийн чинь иргэдийн хурал нь хүлээн зөвшөөрөөд тогтоол гаргачихсан байдаг. Тэр нь шүүхийн шийдвэр гарангуут тэр хүн гэм буруутай гээд өөр ямар нэгэн гэмт хэргээр гэм буруутайд тооцогдож байгаа болохоос биш тэр төлөөлөгчийг нь түүнтэй холбогдуулаад бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно гэхээр тухайн иргэдийн хурал чинь хэлэлцээд тогтоол гаргаж таарна. Тэр гарсны үндсэн дээр нөхөн сонгууль зарлагдана ч гэдэг юм уу ингээд олон үр

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дагавар үргэлжилдэг байхгүй юу даа. Тэгэхээр ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Адъяаа гишүүн энэ цэцийн тухай хууль, прокурорын тухай хууль, Их Хурлын тухай хууль, төрийн албаны тухай хууль, Шүүхийн тухай хуулийг сайн унш. Энэ чинь процесс зааж байгаа болохоос биш ингээд хувь асуудал руу дайраад хүн рүү дайраад байх асуудал биш. Ашиг сонирхлын зөрчлийн асуудал биш. Үгүй ээ, ашиг сонирхлын зөрчлийн асуудал биш. Энэ чинь хууль. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон, өргөн барьсан хүн чинь харин итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр очсон бол итгэмжлэгдсэн төлөөлөгч хариулах ёстой. Та түүнийг ойлго. Яагаад гэхээр энэ процесс зааж байна шүү дээ.

Ингээд жишээлбэл Адъяаа гишүүн, хэн нэгэн гишүүн торгуулийн ял авчээ. Замын хөдөлгөөний дүрэм зөрчөөд юм уу хууль зөрчөөд шүүхийн хүчин төгөлдөр тушаалд торгуулийн ял авчээ. Орных нь нөхөн сонгуулийг зарлах болно. Гэнэт өдөр ажилдаа ирэхээ больчихгүй, тэрний чинь процесс явна шүү дээ. Энэ ард түмний төлөөлөгч учраас цаана нь тэр хувь гишүүний асуудал биш, ард түмний төлөөлөгч учраас тэр ард түмний төлөөллийг хангахын тулд чөлөөлөөд, оронд нь хэлэлцээд, чөлөөлөөд орных нь нөхөн сонгууль томилох энэ процесс явах заалтыг хэлж байна шүү дээ. Түүнээс шүүхийн шийдвэрийг авч хэлэлцэнэ гэсэн асуудал биш. Сахилга хариуцлагаас шүүхийг авч хэлэлцэх тийм хууль байхгүй, угаасаа. Шүүхийн шийдвэрийг зөв бурууг иргэдийн хурал шийдэхгүй, харин тэр хүнийг огцруулаад торгуулийн ял авчихжээ, огцрууллаа, орных нь хүнийг нөхөн сонгууль зарлана, процесс явна шүү дээ. Тэр чинь зүгээр шүүхийн шийдвэр гарангуут маргааш нь ажилдаа хэлчхээж болохгүй шүү дээ. Энэ Цэцийн тухай хуульд ч тийм байна. Яг адил төстэй хууль Цэцийн тухай хуульд байна гээд танд хэлж байна шүү дээ.

5 дугаар зүйл Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон бол түүнийг Цэцийн гишүүнээс эргүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн УИХ эргүүлэн татаж болно гэж байна. Эргүүлэн татаж биш. Ингээд Цэцийн хуульд ийм заалттай. Прокурорын тухай хуульд бас ийм заалттай. Их Хурлын тухай хуульд ийм заалттай, Төрийн байгуулалтын байнгын саналыг үндэслээд. Төрийн албаны тухай хуульд бас ийм заалт. Энэ процесс явж байгаа байхгүй юу.

Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ Батмөнх гээд залуу хуульч энэ асуудлаар ҮХЦ-д хандсан байгаа. Тэгэхээр 2016 онд Батмөнх бас 1 асуудлаар ҮХЦ дээр өргөдөл гаргаад түүн дээрээ би яг УИХ-аас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр очоод Их Хурал ялж байсан.

Тэгээд 2 дахь өргөдлөө сая өгөөд энэ дээрээ Цэцийн дүгнэлтийг эергээр гаргуулсан байна. Тэгэхээр яах вэ, Батмөнхийн талаас 1 зүйлийг ярихад бол энэ шүүхээр гэм буруутай нь тогтоогдоод гэмт хэрэгт нотлогдоод шүүхийн ял авчихсан хүнийг чөлөөлж өгнө үү гэсэн ийм хүсэлтийг Булган аймгийн Баян-Агт сум руу явуулахад Баян-Агт сумын Иргэдийн хурал нь шүүхийн шийдвэрийг хүлээж авах боломжгүй тул дахин яана уу гэсэн 1 тийм бичиг явуулж байсан байгаа юм. Гэмт хэрэгт нотлогдчихсон хүнийг. Тэгээд энэ яасан гэх дээр 11, 10-ын зөрөөтэй л байсан юм аа даа янз нь. Тэгээд нөгөөдхөө хадгалж хамгаалж үзэж байгаа, цаг авч байгаа царай нь л тэр юм шиг байгаа юм. Тийм байх аа. АН-ынх байж магадгүй. Би тэрийг ер нь жишээ авч ярьж байгаа юм. Тэгэхээр ер нь бол Батмөнхийн зүгээс харахад бол энэ шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрдөггүй, иргэдийн хурал дээрээ хэлэлцдэггүй, удаадаг, түүнээсээ болоод юу яадаг юм, тэр нөгөө нэг 2

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

намын хоорондын харьцаанаас шалтгаалсан ийм асуудлууд гардаг учраас үүнийг шууд шүүхийн шийдвэрийн дагуу шийдэх ийм л зүйлийг хандаж хэлсэн юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ дээр нь бол яг энэ талаас нь бол яах вэ практик дээр асуудлууд гардаг учраас бас энэ өргөдөл өгсөн. Тэр асуудлыг нь бол дэмжиж байгаа.

Үүний цаана бол 1 асуудал нуугдаж байна. Өөрөөр хэлбэл үүний цаана бол ард иргэдийн сонгох эрхэд халдсан, тэр өөрсдийнхөө төлөөлөл болгож явуулж байгаа тэр иргэдийн хурлын төлөөлөгчөөрөө дамжуулж өөрсдийнхөө баг, хорооныхоо асуудлыг шийдвэрлэдэг, мөн түүнчлэн эрхээ хангуулдаг энэ зүйл дээр нь эсрэг болоод байгаа юм. Үүний ард бас 1 нууц юу юм байж байгаа нь бол хууль хяналтын байгууллагынхан ер нь бол эхний ээлжид иргэдийн хурлаараа дамжуулаад энэ иргэдийн хурлын төлөөлөгчийг гэмт хэрэгт шийтгэгдсэн бол шууд татах энэ хуулийн төслийн энэ Цэцийн дүгнэлтийн ард бол Их Хурал руу мярааж байгаа. Өөрөөр хэлбэл Их Хурлын бүрэн эрх рүү, Их Хурлын гишүүд рүү, өөрөөр хэлбэл 1 шүүгчийн шийдвэрээр тэр хүний нийт Монголын ард түмний сонголтыг үгүйсгэх ийм хандлага руу явж байгаад нь би бас эсэргүүцэж байгаа.

Тийм учраас энэ Цэцийн дүгнэлтийг ерөнхий агуулгаар нь бол эсэргүүцэж байгаа гэдгийг хэлье. Яг энэ нөгөө иргэдийн хурлыг татах, гишүүнийг татах тэр 2 заалт байгаа л даа. Түүн дээр нь би бол эсэргүүцэж санал өгнө. 2 дахь ач холбогдолгүй асуудал дээр нь иргэн Батмөнхийг сайн хуульч болоорой, сайн улс төрч болоорой гэж дэмжиж санал өгнө өө. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Энхбаяр дарга хариулах уу? Санал гээд ярьчихъя. Ер нь Даваасүрэн гишүүн ч гэсэн энэ санал, дүгнэлт орох юм бол өмнө бол шууд эргүүлэн татна уу гэсэн энэ тэр тийм бичиг гарчхаад байгаа байхгүй юу. Яг Байнгын хороондоо санал, дүгнэлтээ,

үндэслэлээ тогтоолын төслөө өгөөд л хэлэлцүүлэх юм байна лээ. Тэр тийм, Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцүүлээд л өгчихнө.

Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

**С.Бямбацогт:** Саналаа уул нь, өөрийнхөө санал хэлэх гэсэн тэгээд манай тойргоос хамт сонгогдсон Адьшаа гишүүн, Пүрэвдорж гишүүн 2 маань 2 эсрэг байр суурьтай байна аа, тэгээд. Тийм болохоор бас 1 талд нь орсон харагдах гээд байгаа учраас саналаа хэлэхээ больё.

Харин дараа Сонгуулийн хууль дээр Пүрэвдорж гишүүн, Адьшаа гишүүн ээ тэгээд 1 байр суурьтай байцгаана шүү. Дандаа битгий 2 талд яваад байгаарай. Тэгээд 1 байр суурьтай байцгаая. Үндсэндээ тойргоос энэ сонгогдох төлөөлөл чинь багасах гэж байгаа шүү. Ганцхан болох гэж байгаа. Энэ ганц болж болохгүй шүү. Энэ дээр 1 байр суурьтай байхыг та ерөөсөө хүсье ээ. Тэгээд үг хэлэхээ болилоо.

**Г.Занданшатар:** Бямбацогт гишүүн бас санал хэлчихлээ, тийм ээ. Хариулах юм уу? Баттөмөрийн Энхбаяр.

1 гишүүний асуултын дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаж санал хураалт бэлдэнэ үү. Асуулт хариултын цаг дуусаж байна. Энэ хооронд Баттөмөрийн Энхбаяр ХЗБХ-ны дарга Байнгын хороогоор хэлэлцсэн асуудлын талаар хэлье.

**Б.Энхбаяр:** Тэгэхээр ҮХЦ-ийн дүгнэлтийг бол ХЗБХ хүлээж авах боломжгүй ээ гэдэг ийм шийдвэр гаргасан. Яагаад ингэж шийдэж байгаа, шийдвэр гаргасан бэ гэхээр шүүхийн шийдвэрийг иргэдийн хурлууд хэлэлцэж, өөрчлөх тухай асуудал ерөөсөө байхгүй. Шүүхийн шийдвэр бол эцсийн шийдвэр.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгэхдээ, нөгөө талдаа ИТХ-тай адилхан ард түмний сонголт бол бас эцсийн шийдвэр байгаа. Сонгуульт албан тушаалтнууд байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчид гэсэн ард түмний сонголтоор гарч ирсэн, ард түмний мандаттай ийм албан тушаалтнууд байгаа. Энэ хүмүүсийг илгээж байгаа сонгогдох тэр эцсийн шийдвэрийг бол Монголын ард түмэн гаргасан. Тийм учраас ард түмний сонголт бол мөн өөрөө эцсийн дээд шийдвэр байдаг. Энэ шийдвэрт сая хэлсэнчлэн улс төрийн зорилгоор 1 саналын зөрөөтэй ийм ойролцоо байх үед тэр ЗГ-ыг авах, Засаг даргыг авах энэ улс төрийн шийдвэрт 1 шүүгч халдах, ард түмний сонголтыг засварлах боломжийг олгохтой холбоотой процессыг хуульчилсан байгаа юм. Тийм учраас тэр гэм буруугийн асуудлыг нь бол иргэдийн хурал шийдэхгүй, шүүхийн шийдвэр эцсийн явдгаараа явна.

Энэ шүүхийн шийдвэр гарсантай холбоотой ард түмний мандатыг хүчингүйд тооцох буюу ард түмний сонголтыг цуцлах гэсэн үг. Энэ шийдвэрийг бол тухайн ард түмний төлөөллийнх нь байгууллага нь өөрөө гаргадаг. Цаад утгаараа ард түмэн нь гаргадаг байх Үндсэн хуулийн утга өөрөө Үндсэн хуульд бас шингэчихсэн байгаа юм. Тухайлбал, аймаг, нийслэлийн хурал дээр ч тэр, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд дээр ч тэр шүүхийн шийдвэртэй гарсантай холбоотойгоор тухайн мандатыг цуцалж огцруулах, чөлөөлөх эцсийн шийдвэрүүдийг УИХ гаргахаар хуульчлагдсан байгаа. Үндсэн хуульд өөрт нь байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө Үндсэн хуулийн эх сурвалжтай тайлбартай ийм зүйл байгаа юм.

Тийм учраас ҮХЦ-ийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх боломжгүй ээ гэсэн ХЗБХ-ны болон ТББХ-ны саналыг дэмжиж өгөхийг гишүүдээсээ хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн. Энэ асуулт хариултын дараа асуулт хариултын цаг дуусаж, санал хураалт явуулах тул гишүүд чуулганы танхимд цуглана уу. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** Монгол Улсын шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр шийдвэр тогтоол хэрэгждэг эсэх тухай энд 1 ийм хуулийн маргаан явагдаад байна л даа. Гэтэл яг энэ тохиолдолд иргэдийн мандат авсан төлөөлөгч байдаг, төлөөлөгч гэдэгт УИХ-ын гишүүн ч бас орно. Тэгэхээр энэ асуудалд ер нь цааш цаашидаа яаж хандах, энэ дээр 1 тийм хуулийн гарц гаргалгаа энд өөрөө их чухал болчхоод байх шиг байгаа юм. Энэ чинь жирийн 1 иргэн биш иргэдийг төлөөлж байгаа. Тэгэхээр Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Сүхбаатар гишүүнээс, Сүхбаатар гишүүнээс 1 зүйл асуучихъя.

Сая Их Хурал дээр ч гэсэн зарим гишүүдийн бүрэн эрхийн асуудал бас ингээд яригдлаа. Тэгэхээр үүн дээр цааш цаашидаа ямар гарц гаргалгаа байх ёстой юм бэ? Тэр Их Хурлын шүүхийн тогтоол шийдвэр хэрэгжих ёстой 1 талаасаа, нөгөө талаасаа тэр иргэдийг төлөөлөх эрх, тэр маань яг давхартаа ингээд байхгүй болчхоод байгааг үүн дээр хууль зүйн хувьд бид нар ямар гарц гаргалгаа байж болох юм. Магадгүй шүүхийн шийдвэр хэрэгжээд биелээд тэгэхдээ тухайн хүн тэр хуралдаан чуулгандаа оролцоод шийдвэрээ гаргаад явдаг энэ эрх зүйн орчин манайд энэ хууль дүрмийн, одоогийн хууль дүрмийн хүрээнд байж болохгүй юу аль эсвэл ийм болгохын тулд ямарваа нэгэн өөрчлөлт хийх хэрэгтэй. Энэ өөрөө иргэдийн хуралд ч, Их Хурлын гишүүнд ч хамаатай байх гэж. Сая гэхэд 2, 3 гишүүн, аймаг, дүүргийн төлөөлөл үндсэндээ ингээд төлөөлөх эрхүүд нь цаашаагаа төрийн бодлого шийдвэрт оролцох эрхүүд нь давхартаа цуцлагдаад явчхаад байдаг.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Нөгөө талаасаа шүүхийн шийдвэр биелэх ёстой. Тэгэхээр шүүхийн шийдвэр биелэнгээ тухайн гишүүнийг хуралдаан, чуулган олон зүйлдээ оролцдог энэ нөхцөл бололцоог ямар хууль, хэрвээ байх ийм боломжтой гэж үзвэл ямар хууль, ямар өөрчлөлт үүний цаана хүлээгдэж байгаа вэ? Үүн дээр 1 тайлбар өгөөч?

Тэрнээс шүүхийн шийдвэр биелэх ёстой, ёсгүй гэдгийг бид нар Их Хурлын чуулганы хуралдаанд бүгдээрээ тойрч сууж байгаад дэлхий хавтгай гэж шийддэг шиг яг ийм маргаан бол үндсэндээ бас утга учиргүй шүү дээ. Шүүхийн шийдвэр биелдэг л байх ёстой шүү дээ. Энэ Цэцийн шийдвэр бол зөв гэж бодож байгаа.

Гэтэл нөгөө талд нь бас гарц гаргалгаа харагдаад байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Монгол УИХ-ын гишүүн Энхтайваны Бат-Амгалангийн урилгаар БЗД-ийн Социал демократ МЗХ-ны Тэргүүлэгчдийн болон ерөнхий боловсролын “ирээдүй” цогцолбор сургуулийн 8 дугаар ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан та бүхэнтэй уулзахаар гарсан байна аа.

Хэн хариулах вэ? Итгэмжлэгдсэн төлөөлөгч Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн, сайд асуултад хариулна.

**Ж.Сүхбаатар:** Тэгэхээр энэ зүгээр би бол яагаад сая зүгээр тэр асуудлыг гүнзгийрүүлж нөгөө үр дагавар талаас нь үргэлжлүүлж ярьсан болохоос яг иргэдийн төлөөлөгчдийн асуудал байгаа юм. Тэгээд Цогтгэрэл гишүүн ээ, ийм байгаа юм, ер нь бол зүгээр ингээд цаашдаа ямар асуудалтай юм? Бид нар хүний эрхийн талаас гэмт хэрэг үйлдсэн л бол бүх юм нь дуусах ёстой гээд ингээд яг

үзчихэж бас болох уу, үгүй юү гэдэг нь яг онол. Би өөрөө энэ чиглэлийн бас мэргэжлийн чиглэлээр ажиллаж байсан хүний хувьд зүгээр хууль зүйн маргаан учраас онолын юмыг нь бас хэлж байгаа юм. Тухайлбал гэмт хэрэг үйлдэхдээ хүн санаатай биш бас болгоомжгүйгээр бас гэмт хэрэг үйлддэг байхгүй юу. Торгох ял авдаг, зорчих эрхийг нь хязгаарлуулах ял авдаг тэр тохиолдолд төлөөллийн мандат шууд дуусгавар болж болохгүй гэдэг юм бас яригддаг байхгүй юу. Зүгээр Монголд бол яригддаггүй юм.

Хүн болгоомжгүй байж байгаад ямар нэгэн байдлаар зам тээврийн осол гаргаад ингээд явчихад тодорхой хэмжээнд тийм ээ, заавал шоронд орохгүй шүү дээ. Тэр чинь заавал. Тэгээд явахад төлөөллийн мандат шууд дуусгавар болж болохгүй гэдэг юм ер нь бол Үндсэн хуулийн эрх зүйн юман дээр сонгох, сонгогдох эрхийг тийм амархан хязгаарлаж болдоггүй гэдэг юм явдаг байхгүй юу. Тэр үүднээс нь би зүгээр сонирхолтой жишээ гэдэг жишээлбэл Трампын сонгогдох эрхийг шоронд орсон ч гэсэн хязгаарлаж болохгүй гэдэг юм яригдаж байх жишээтэй байгаа байхгүй юу. Манайд бол хязгаарладаг л даа, тэгээд гол нь энэ бол иргэдийн төлөөлөгчдийн асуудал гээд яригдаж байгаа нь би энэ иргэдийн төлөөлөгчдийн юмыг Цэцийн дүгнэлт зөвөө гэгчихвэл Цэцийн өөрийнх нь гишүүдийн хувьд ч гэсэн үүссэн хамгаалалт нь бас буруу байхгүй юу. Цэц цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдчихвэл Цэц шийдвэр гаргана гэж байгаа байхгүй юу. Үүнийг эргүүлэн татах уу, үгүй юү гэж. Тэгээд бас дээр нь нэмээд анх илгээсэн байгууллагын саналыг нь авна гэж байгаа юм. Тэгээд дахиад Их Хурал нь эргүүлж татах шийдвэр гаргаж болох уу, үгүй юү гэдэг ийм байдлаар хуульчлагдсан байдаг байхгүй юу. Тэгэхээр жишээлбэл энэ чинь иргэдийн төлөөлөгч чинь бол бүр сонгуульд иргэдийг төлөөлөх мандат авчихсан хүмүүс байгаа байхгүй юу. Цэцийн гишүүдийг бодвол. Тэгэхээр Цэцийн гарч байгаа шийдвэр чинь өөрөө эргээд өөрсдийнх нь хуультынх нь юмтай

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ч агуулгатай нь өөрсдөдөө ч статусын хувьд зөрчилдөхөөр байгаа ч энэ чинь энгийн асуудал байхгүй юу.

Шүүхийн шийдвэр бол гарахдаа юу гэж гарсан бэ гэхээр иргэдийн төлөөлөгчийг бүрэн эрхийг нь дуусгавар болго гэж ерөөсөө шүүхийн шийдвэр гарахгүй байхгүй юу даа. Чи тийм гэмт хэрэг үйлдсэн байна, тийм ял онолоо гэж. Тэр төлөөлөгчийн бүрэн эрх гэдэг чинь тусдаа асуудал байхгүй юу даа, 2 өөр асуудал. Тэгэхээр цэцийн дүгнэлт юу гэсэн бэ гэхээр зэрэг цэцийн шийдвэр биелэгдэхгүй байх боломжтой байна гэж, биш ээ Шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр биелэгдэхгүй байх боломж үүсгэчихсэн байна гэж, үгүй шүү дээ. Тэр шоронд хийдэг бол тэр чинь шийдвэр гүйцэтгэлээ очоод шорондоо л хийчихнэ шүү дээ. Тэр иргэдийн хурал чинь тэр мандатыг нь хэзээ дуусгавар болгох эсэхээ өөрөө шийдэх л асуудал байхгүй юу. Цаад утгаараа. Түрүүний хэлдгээр яг амьдрал дээр юу гарч орох вэ гэхээр 1 төлөөлөгчийн суудлаар юм уу, Их Хурал дээр ч юм уу бусад газар 1 хүний саналаар шийдэгдэх газар байлаа гэхэд тэрийг чинь аваачаад шууд автоматаар шүүхийн шийдвэрээр дуусгачихаар чинь шууд улс төрийн үр дагавар бүх юм чинь өөрчлөлт ороод явчих байхгүй юу. Тэрийг чинь бусад улс орнууд салгадаг байхгүй юу. Сонгогдох эрх гэдэг чинь тусдаа, төлөөлөх эрх чинь тусдаа. Тэр гэмт хэрэг бөгөөд ял авах чинь тусдаа асуудал байхгүй юу. Энэ ял эдлэхийг нь зогсоож байгаа асуудал биш. Ял эдэлдэг чинь автоматаар ялыг нь эдлүүлээд л явчихна. Тэгэхээр шүүхийн шийдвэрийг шүүж байгаа асуудал ерөөсөө биш л гэж хэлээд байгаа юм.

**Г.Занданшатар:** Тэгэхдээ энэ Цогтгэрэл гишүүн ээ. Санал хураалт явуулъя. Тэр Үндсэн хуулийн тайлбар номд болон Чимэд гишүүн хэлснээр бүрэн эрх гэдэг бол олон улсын ч ойлголтоороо эрх, үүргийн цогц нэгдэл гэж байгаа юм. 1 талаасаа хууль батлах, хууль тогтоох үүрэгтэй гэж гэж байгаа байхгүй юу, ард түмнийг төлөөлж байгаа учраас. Тийм

учраас өөрөө татгалзаж болдоггүй, өөрийнх нь эрх биш тэр бол хувь хүнийх биш ард түмнийг төлөөлж байгаа эрх учраас. Тийм учраас тэр эрх, үүргийг хязгаарлах, солих асуудал чинь тухайн тогтолцооны эрх, үүрэг болж хувирч байгаа юм л даа. Тэгээд ингээд торгох ч байдаг юм уу, хорих ч байдаг юм уу ял эдэлчихлээ энэ бол тусдаа гэмт хэргийн зүйл анги, шүүхийг авч хэлэлцэхгүй, ардчиллын эх сурвалжийг бол өөрчилж болохгүй гэж байгаа юм.

Ингээд Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураана.

Монгол УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 2, 41-ийн 1-ийн 4, 41-ийн 1-ийн 5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41-ийн 1-ийн 3, 41-ийн 1-ийн 6, 41-ийн 1-ийн 7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасны 41-ийн 1-ийн 3 гэж заасан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт, санал хураалт.

40 гишүүн дэмжиж, 70.2%-ийн саналаар энэ санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал дэмжигдлээ

2. Монгол УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 2, 41-ийн 1-ийн 4, 41-ийн 1-ийн 5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41-ийн 1-ийн 3, 41-ийн 1-ийн 6, 41-ийн 1-ийн 7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасны 41-ийн 1-ийн 3 гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

74.1%-ийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолыг уншиж танилцуулъя. ҮХЦ-ийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82-ын 3 дахь заалтыг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 2 дахь хэсэгт хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41-ийн 1-ийн 2, 41-ийн 1-ийн 4, 41-ийн 1-ийн 5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41-ийн 1-ийн 3, 41-ийн 1-ийн 6, 41-ийн 1-ийн 7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ гэж заасны 41-ийн 1-ийн 3 гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Дээд Шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн

2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Тогтоолыг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

70.7%-ийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоол батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулсан. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо^

11.10 цаг

Дараагийн асуудалд орно.

**Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баттөмөр:** УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол УИХ-ын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Балжиннямын Баярсайхан нарын 4 гишүүний 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Монгол УИХ-ын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд ишилжүүлсэн.

УИХ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 193 дугаар

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хороонд болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэн хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Баттөмөр, бүрэлдэхүүнд нь УИХ-ын гишүүн Мөнхцэцэг, Сандаг-Очир, Туваан, Энхбаяр, Энхболд нар болон бусад албаны хүмүүс ажиллалаа.

Хуулийн төслийг Ди парламент цэг мн цахим хуудсанд байршуулан олон нийтийн саналыг авч, орон нутагт болон Төрийн ордонд зохион байгуулсан хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэгт оролцогчид болон төрийн албан хаагчдаас нийт 277 санал ирүүлснийг ажлын хэсэг 1 бүрчлэн авч судалж үзэж хэлэлцсэн.

Ёс зүй, сахилгын хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39-ийн 10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр авч хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Баделхан, Баярсайхан нар хуулийн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг 1 бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1 дүгээрт нь, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль нь анхдагч хууль бөгөөд төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг

тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн үйлчлэлд хамрах хүрээг өргөтгөх, төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуульд заасан зарчмуудаас гадна хүнлэг энэрэнгүй байх, үнэнч шударга байх, хариуцлагатай байх, манлайлах, хамтач байх зарчмыг баримтлахаар тусгаж байна.

Эрх зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдөх түүнийг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтаас гадна энэ хуулиар тогтоосон үйл ажиллагааг хориглох, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар хуулийн төсөлд шинээр зохицуулалтыг нэмж тусгалаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар Ёс зүйн хороо, дэд хорооны бүрэн эрхийг хуульчилж, бие даасан, хараат бус зарчмаар ажиллахаар тусгалаа. Ёс зүйн хороо орон тооны 5, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллана. Ёс зүйн хороо нь төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны, ЗГ нь хэрэг эрхлэх асуудлынхаа хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны, дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах доод шатын байгууллагыг нь томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн асуудлаас гаргасан



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд Ёс зүйн хороо болон Ёс зүйн дэд хорооны холбогдох дүгнэлтийг үндэслэсэн нь зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэн эсэхийг харгалзан гомдол гаргагчид эсхүл олон нийтийн уучлалт гуйхыг үүрэг болгох, өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах, төрийн албанаас халах хүртэл арга хэмжээг хуулийн төсөлд тусгалаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрөөтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баттөмөр гишүүнд баярлалаа.

Одоо зочид танилцуулъя. УИХ-ын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор, Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЕБС-ийн 9-ийн А, Б ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд, эрхэм хүүхдүүддээ, хүндэт сурагчдадаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн сурицаагаарай.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу. Сэргэлэн

гишүүнээр, Батлут гишүүнээр тасалъя. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, тасаллаа. Энэ чинь бүгдээрээ асуух нь, Жамбын Батсуурь, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Бямбасүрэнгийн Энх-Амгалан тасаллаа.

Ингээд Цэдэвийн Сэргэлэн гишүүн асуулт асууна.

**Ц.Сэргэлэн:** Баярлалаа. Гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе ээ. Энэ маш чухал хууль аа, дэмжиж байгаа. Тэгээд энэ төрийн албаны ялангуяа сахилга хариуцлагыг дээшлүүлэх, чангатгах энэ хамгийн том агуулгуудыг энд суулгаж өгсөн ийм хууль. Тэгээд энэ дээр би 1 хэдэн зүйл хэлье гэж бодож байна.

Төрийн албаны мөрдөж байгаа тухай хууль дээр төрийн албанаас чөлөөлөх үндэслэлүүд маш тодорхой заагаад өгчихсөн байгаа. Энэ үндэслэлүүд дотор заахдаа тодорхой хугацаанд төрийн албанд эргэж орох боломжгүйгээр халдаг, 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр, 2 жилийн хугацаанд, 3 жилийн хугацаанд гээд. Нөгөөдөх нь бүр төрийн албанаас нэгмөсөн чөлөөлөх ийм заалтууд бий. Энэ бол маш чухал сахилгын шийтгэлүүд бөгөөд төрийн албан хаагчдыг алдаагаа ухамсарлах ийм боломжийг олгосон. Ийм сахилгын шийтгэлийн төрлүүд Төрийн албаны тухай хууль дээр суучихсан байгаа. Би энэ Төрийн албаны тухай хуулийн сахилгын энэ заалтуудтай уялдуулж энэ ёс зүйн асуудлыг ярих гээд байгаа юм. Юу вэ гэхээр 1 үндсэн зарчим бол төрийн албан хаагчид албан үүрэг гүйцэтгэж байх үедээ архидан согтуурах, мансуурах төрлийн ямар нэгэн үйлдэл гаргахыг ерөөсөө хуулиар нэгэнт хориглочихсон. Энэ бол Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар ч хориглочихсон, бусад төрлийн хуулиар ч хориглочихсон эд. Тэгвэл хориглочихсон энэ үйлдлийг төрийн албан хаагч гаргавал

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

яха вэ гэдэг асуудал одоогоор 1 мөр хуульчлагдаагүй явж байгаа юм. Тийм учраас ёс зүйн асуудал дээр нь сахилгын шийтгэл хүлээлгэдэг энэ төрөлдөө оруулж төрийн албан хаагч албан үүрэг гүйцэтгэж байхдаа архидан согтуурвал 1 дүгээрт, тодорхой хугацаанд төрийн албанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас чөлөөлдөг, 2 дугаарт, нэгмөсөн чөлөөлдөг ийм 2 хувилбарыг ямар нэгэн байдлаар энэ хуульд суулгах шаардлагатай гэдгийг л би хэлэх гээд байгаа юм. Энэ байр суурин дээр манай ажлын хэсгийн гишүүд, ТАЗ-ийн гишүүд маань ямар саналтай байдаг юм.

Хуульд 1 мөр суулгах боломжгүй байдаг юм бол төрийн байгууллагууд өөр, өөрийн гэсэн хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй, үүнийгээ дагаад өөрийн гэсэн онцлогтой. Тийм учраас төрийн албан хаагчдын сахилгын дүрэм, ёс зүйн дүрэм гэх мэтчилэн олон асуудлууд гарах ёстой. Үүнийг дагаж ЗГ-ын тогтоолууд ч гарах болов уу гэж би бодож байна. Энэ олон эрх зүйн баримт бичгүүд дотор төрийн албанд архийг эгнэгт халах тухай асуудлыг л шийдэх хэрэгтэй байна гэж би хэлээд байна. Энэ бол амьдрал дээр олон удаа харагдсан эд шүү дээ. Ялангуяа өдөр тутам зэвсэг тусгай хэрэгсэлтэй харьцаж байдаг төрийн тусгай байгууллагуудын хувьд болбол энэ маш хэцүү асуудал. Хажууд нь зэвсэг тусгай хэрэгсэл байж байдаг. Архидан согтуураад мансуурчихсан хүн юу ч хийж болдог. Тийм учраас энэ асуудлыг ялангуяа төрийн тусгай албад дээр бол өөр өөрсдийнхөө онцлогт тохирсон байдлаар хуульчлах ёстой.

Нийтлэг бол ер нь төрийн албан дээр архидан согтуурсан тохиолдолд ямар ч тохиолдолд халдаг, халахдаа миний хэлсэн саяын 2 ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн асуултад хариулна.

**Б.Баттөмөр:** Сэргэлэн гишүүн маш чухал асуудлыг хөндөж тавьж

байна. Ер нь бол төрийн албанд алба үүрэг гүйцэтгэж байхдаа архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэнэ гэдэг нь бол үнэхээр тэр ажлын дэг журам, тэр ажлын бүтээл бүх зүйлд сөрөг нөлөөтэй. Зүгээр холбогдох хуулиудад бол тэр архи уухтай холбоотой, ажлын байранд архи уухгүй байх талаар тодорхой заалтууд байгаа. Энд бол бид нар энэ төрийн албаны ёс зүйн хуульд бол энэ 8 дугаар зүйл гэж байгаа л даа. 8 дугаар зүйл нь бол юу гэхээр энэ төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага гэж байгаа юм. Нийтлэг шаардлагын 8-ын 2-ын 8-д, 8-ын 2-ын 8-д албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг зөрчих гэсэн энэ заалтыг энд оруулж өгч байгаа юм. Тийм, энд энэ ингээд оруулчихсан явж байгаа. Тийм учраас энэ дээр бол бид нар ер нь нэлээн их судалгаа хийсэн. Олон газруудын энэ ёс зүйн дүрэм дээр бол байдаг юм байна лээ. Японых, Сингапурынх, Хятадынх гээд маш олон газруудынхыг судалсан. Тэгэхээр энэ заалтыг бол бусад хуулиудад хэрвээ байдаг ч гэсэн Ёс зүйн хуульдаа бол байдаггүй учраас үүнийг энд оруулж өгч ингэж хуулийн төсөл тусгаад явж байгаа.

**Г.Занданшатар:** Баатарзориг дарга тодруулаад хэл, дараа нь тодруулж асууя. Баатарзориг дарга төрийн албаны зөвлөлийн тайланд тусгагдсан ажлын байран дээр согтуурах зөрчил хэд гарсан, яаж буурч байгаа, тэр талаар та өөрөө танилцуулах ёстой

**Б.Баатарзориг:** Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Эхний ажлын дэд хэсгээс хариулж байгаа хариулт учраас нийтлэг байдлаар бас эхлээд хэлье. Санхүүжилт шаардахгүйгээр, хөрөнгө оруулалт шаардахгүйгээр, хугацаа шаардахгүйгээр ажлын үр дүнд хүргэдэг механизм зохицуулалт бол ёс зүйн харилцааг зохицуулж байгаа энэ хууль байгаа юм.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Үүнтэй холбоотойгоор тодорхой асуулт асуулаа. Албан үүргээ гүйцэтгэж явахдаа ажлын байран дээрээ архиан согтуурсан энэ үзэгдэл дээр бол ТАЗ эвлэрэхгүй байгаа. 2019 онд 98 зөрчил илэрсэн, 2020 онд 37 зөрчил яг энэ үйлдлээр, 2021 онд 75 зөрчил, 2022 онд 153 зөрчил илэрсэн. Эд нар бол зөрчлийн нөхцөл байдлаас шалтгаалаад албан үүргээс нь халах хүртэл, төрийн албанаас чөлөөлөх хүртэл үйл ажиллагааг бол явуулж байгаа болно. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Архи хориглох асуудлууд гарсан, ерөөсөө тийм юм ярихгүй юм.

Эхлээд зочид танилцуулъя. Тэгээд Сэргэлэн гишүүн тодруулж асууна.

УИХ-ын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор, Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЕБС-ийн 9-ийн В, Г ангийн багш, сурагчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Цэдэвийн Сэргэлэн гишүүн тодруулж асууна.

**Ц.Сэргэлэн:** Тэгэхээр энэ тавигдах шаардлага дээр бол зүгээр хориглоно л гэж байгаа юм. Энэ хориглосон заалтуудыг зөрчвөл яах юм гэдэг асуудал чинь сахилгын шийтгэлтэй холбоотой юм. Зөрчсөн хүнийг яах юм. Хална гэдэг хуульчлагдаж өгөх ёстой юм. Зүгээр толгойг нь илээд 1 удаа загнаад, 2 дахь удаадаа цалинг нь хасаад ингээд ингээд өнгөрөөгөөд амьдрал дээр яваад байгаа, халах тухай асуудал тухайн байгууллагын даргын үзэмжийн тухай асуудал болчихоод байгаа юм. Тийм учраас үүнийг хуульчилж өгөх ёстой.

Ер нь мансуурсан төрийн албан хаагчийн өмнө Монгол Улсын иргэн очоод асуудлаа шийдүүлнэ гэж хэзээ ч байхгүй. Хэлээ хазсан, далжганасан юмны өмнө

очоод. Тийм учраас шууд халдаг болох хэрэгтэй. Тэгэхдээ ганцхан энэрэнгүй гэдэг юм уу үйлдлээ ухамсарлах боломжийг нь олгохын тулд 1 жилийн хугацаатай эргэж орох эрхгүйгээр халаад тэгээд архинаас гараад эргээд орж болдог. Эсвэл бүр ноцтой гэж үзэх юм бол шууд халдаг л байх хэрэгтэй.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн ажлын хэсгийн ахлагч, Ёс зүй сахилгын хариуцлагын байнгын хорооны дарга хариулна.

**Б.Баттөмөр:** Төслийн 16 дугаар зүйлд төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх гэж байгаа. Энд бол 16-гийн 1-ийн 1-д нь гомдол гаргагчид олны өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох, ганцаарчилсан хэлбэрээр сануулах, байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах, 16-гийн 1-ийн 4-д төрийн албанаас халах гэж байгаа юм. Энэ зүйлчлэлд бол архитай холбоотой.

Сэргэлэн гишүүнтэй бол үнэхээр санал 1 байна. Монголын ард иргэд, төрийн албан хаагч, согтуу төрийн албан хаагчийн урд талд очиж үйлчлүүлнэ гэж бол байхгүй. Хэрвээ ингэх юм бол дампуурна. Энэ утгаар энэ төрийн албанаас халах хүртэл арга хэмжээг энэ дээр зааж өгсөн юм аа. Энэ дотор бол архи ууж согтуурахаас гадна мөн ёс зүйн олон зөрчлийг гаргасан, давтаж гаргасан, төрийн албанд тэнцэхгүй гэдэг олон шаардлагууд байгаа учраас үүнийг бол төрийн албанаас халах гэдэг ийм зүйлчлэлээр нь 16-гийн 1-ийн 4-д ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** Баатарзориг даргаас 1 ганц 2 асуулт тодруулах юм байх юм. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулаад төрийн үйлчилгээний албан хаагчийг төрийн захиргааны албан хаагчтай дүйцүүлэн тооцогдох ийм хуулийн заалт хэрэгжсэн, батлагдсан.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ингээд танайх төрийн үйлчилгээний албыг төрийн захиргаатай дүйцүүлэх энэ журмаа баталсан байна. Үүнийг та бүхэн яагаад ингээд. Би бол арай жаахан эргэж харах шаардлагатай юу, үгүй юү гэж бодоод байх юм. Арай л төрийн үйлчилгээний албан хаагчийг төрийн захиргаатай адилтгахдаа ангилал, зэрэглэлийг нь арай доогуур л тогтоочихсон юм шиг байх юм. Та бүхэн маань. Одоо яамны сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж байгаа эмнэлгийн дарга ч юм уу, дээд сургуулийн захирал эд нарыг зөвхөн төрийн захиргааны албан хаагчтай адилтгахдаа зөвхөн ахлах түшмэлтэй адилтгачихсан байх жишээ. Тэгэхээр бид нар чинь энэ адилтгадгийн чинь гол давуу тал нь төрийн захиргаанд бас төрийн үйлчилгээнд ажиллаж байгаа өндөр боловсрол, мэдлэг, дадлага туршилагатай хүнийг төрийн захиргааны албан тушаалд дүйцүүлэн авъя гэхээр та бүхэн энэ ангилал, зэрэглэлийг нь их доогуур тогтоочихсон учраас бидний энэ нөгөө хүсэл биелэх сонирхол бол бас хангагдахад жаахан хүндрэлтэй болчихоод байна л даа. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж байгаа эмнэлгийн даргыг төрийн захиргааны албан тушаалтантай адилтгахдаа зөвхөн та бүхэн ахлах түшмэлтэй адилтгаад ингээд журам гаргачхаж. Тэгэхээр ахлах түшмэлтэй адилтгачихлаар чинь эрхэлсэн түшмэл буюу яамны газрын даргаар л 1 дүйцүүлж 1 хүн авбал авахаар л ийм л хязгаарлагдмал. Цаана нь нөгөө тэргүүн түшмэл буюу 1 агентлагийн дарга, төрийн нарийн эд нарт бол тэр харьяа газарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдаас хүн тэр мэргэжил, боловсрол, дадлага туршилагаар нь харгалзаад, дүйцүүлэн тооцож энэ тэргүүн түшмэлд хүн авах боломжгүй болчихоод байна л даа. Үүнийг яагаад дарга нар, ТАЗ ингээд их 1 их доогуур ахлах түшмэлтэй адилтгачхав аа? Үүнийгээ та бүхэн болж байна гэж үзэж байгаа юм уу? Хэрвээ шаардлагатай бол цаашид бас үүнийгээ

бас жаахан эргэж харах тийм боломж байх уу, үгүй юү гэдэг 1 асуудал.

2 дахь асуудал нь, ковидын хууль хүчингүй болсон, ковидын хууль хүчингүй болсонтой холбоотойгоор ковидын хуулиар томилогдсон асар олон хүн чөлөөлөгдөж байна. Тэгээд орыг нь ТАЗ-д тодорхойлолт, ажлын байрны захиалга өгөөд, сонгон шалгаруулалт явуулж л байх шиг байна. Гэхдээ танайд хуулиар олгосон эрх байна уу, үгүй юү? Хараад байхад та бүхэн маань төрийн албан хаагчийн ажлын байрны сонгон шалгалт зарлачхаад, тэгээд хугацааг юугүй сонгон шалгаруулалтаа хойшлуулаад байх юм. Зарим тохиолдолд нь бүр төстийнхээ шалгалтыг авчихсан атлаа хойшлуулчихаад эд нар байгаад байх юм. Энэ хойшлуулж байгаа чинь түр хойшлуулаад байгаа асуудал байна уу. Үгүй бол энэ сонгон шалгаруулалтаа хүчингүй болгоод байгаа юм уу.

Тэгээд төрийн албаны хуулиар та бүхэнд энэ сонгон шалгаруулалтыг зарласан бол бүр шалгалтаа аваад эхэлчихсэн бол хойшлуулдаг, хүчингүй болгодог эрх байгаа юм уу? Яагаад ингээд үзэмжээрээ юм шиг ингээд энэ төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтын асуудалд ТАЗ хандаад байгаа юм бэ? Ийм та бүхэнд хуулийн олгосон эрх байгаа юм уу, үгүй юм уу? Энэ дээр 1 тодорхой хариулт өгөөч. Тэгээд ингээд хойшлуулаад байгаа чинь хойшлуулаад байгаа юм уу? Тэр бүртгэлээ цуцалж, хүчингүй болгож байгаа юм уу? Төстийнхээ шалгалтыг авчихсан атлаа өчигдөр 2, 3 газрыг бас хойшлуулчихсан байна лээ шүү дээ. Энэ чинь хойшлуулж байгаа юм уу, бүр хүчингүй болгож байгаа юм уу? Ийм боломж хууль, эрх зүйн боломж та бүхэнд байгаа юм уу, үгүй юм уу? Яагаад ийм асуудлууд явагдаад байгаа юм бэ?

**Г.Занданшатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй ч гэсэн дуустал асуулгалаа. Тэгээд ТАЗ энэ асуултаар жич тодорхой хариултыг



өгчихье. Энэ ёс зүйн хэлэлцээж байгаа хуультай шууд холбоогүй юм байна.

Үгүй ээ, энэ Ёс зүйн хуулийн талаар биш өөр хуулийн хэрэгжилтийн талаар, ТАЗ-ийн тайлан хэлэлцэхэд та үүнийг асуух ёстой байж. Тэр үед та оролцсонгүй. Тэгээд үүнийгээ сайн тодорхой яг нөгөө салбарынхаа төв энэ тэртэй холбоотой асуудлыг ТАЗ-тэй жич сайн ярилц, тийм ээ.

Гонгорын Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой хууль зайлиггүй хэрэгтэй болчихоод байгаа юм. Төрийн албаны манай төрийн албаны хуульд гай ч үгүй, гавьяа ч үгүй олон жил болсон нь давуу тал болчихоод, тэр давуу талаараа өөрийнхөө эргэн тойрон, удирдлагадаа байгаа хүмүүсийг эрхшээлдээ оруулдаг 1 ийм бохир заваан нөхцөл байдал үүсчхээд байгаа юм. Тэгээд ямар ч гомдол гаргасан хууль зөрчөөгүй учраас тэр хүмүүст хариуцлага тооцож болдоггүй. Тэгээд би зүгээр захын жишээ хэлэхэд ямар ч байгууллагад шинэ удирдлага очлоо гэхэд доор нь 1 хор хутгаад л бужигнуулаад л, хов зөөж нааш нь цааш нь явуулаад л өөрсдөд нь үйлчлээгүй өөрсдийнх нь эрхшээлээр байгаагүй хүмүүсийн зэрэг дэвийн нэмэгдэл, цалин урамшууллын боломж, амралт гээд ер нь бүх юман дээр нь байж болох нөхцөл боломжоор дарамталж хяхаж боодог 1 ийм бүлэглэл бий болчихоод байгаа юм. Бүлэглэл гэдэг үг нь ч хаашаа ч юм, энэ намд, энэ төрийн албан дотор бол битүү. Ялангуяа энэ үйлчилгээний салбарт. Тэгээд л энэ боловсролын салбар бол, би боловсролын хуулийн ажлын хэсгийг ахалж байна. Хэлэлцүүлэг хийгээд явж байхад бол аймаг орон нутагт бол ялангуяа бүр ерөөсөө энэ засаг замбараагаа алдчихжээ. Энэ дээр энэ хуулийн зохицуулалт ер нь яаж орж ирж байгаа юм.

Сүүлдээ бүр давраад хуулийн бүрэн хамгаалалттай байгаа учраас доороо

удирдлагадаа ажилладаг хүмүүсээ ч хөдөлгөхгүй, дээшээ өгсөөд аймгийн дарга, газрын дарга, бүр Их Хурлын гишүүд рүүгээ янз бүрээр заналхийлсэн мессеж хүртэл бичдэг ийм даварсан төрийн албатай болчихоод байна л даа. Энэ ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой асуудал дээр энэ хууль шийдэл гаргах уу? Миний сонгогдсон тойргоос гэхэд багш нараас маш их гомдол ирдэг. Энэ салбарт ажиллаж байгаа зарим хүмүүсийн ааш авир, засаг замбараагүй байдал бол бүр хэрээс хэтэрчихсэн. Хуулийн асуудал ярихаар ямар ч боломжгүй, хариуцлага тооцох ямар ч боломжгүй. Тэгэхээр энэ сахилга, хариуцлагатай холбоотой зохицуулалт зайлиггүй шаардлагатай байгаа. Энэ дээр 1 хариулт өгөөч.

**Г.Занданшатар:** 80. Удирдлагын академийн багш, ажлын хэсгийн Алтанзул.

Энэ өдрийн мэндийг хүргэе. Удирдлагын академийн багш Алтанзул. Таны саналыг таны асуултад байгаа зохицуулалт манай энэ төрийн албан хаагчийн ёс зүйн хуульд яг орж ирсэн. Энэ төслийн 7 дугаар зүйлд бол байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, аливаа харшил үйлдэл гаргахгүй байх гэсэн хэм хэмжээ болгоод энэ хэм хэмжээгээ үүрэг болгосон зохицуулалт, 8-ын 1-ийн 5-д бусдыг өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх гээд үүргээр, 8-ын 1-ийн 2-ын 4 дээр албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатай нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйлчилгээнд саад учруулах гэсэн хориглох зүйлээр орсон. Тэгээд энэ үүрэг, хориглох зүйлийг зөрчсөн бол 16 дугаар зүйлд заасан ёс зүйн хариуцлага, үүнийг давтан үйлдвэл бол сахилгын шийтгэл оногдуулахаар заасан. Яах аргагүй энэ асуудал бүх ёс зүйн төрийн байгууллагын дотоод ёс зүйн асуудал дээр гардаг. Тэгэхээр манай хуульдаа саяын

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зохицуулалтаар нарийвчилсан  
зохицуулсан байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Энэ асуудалтай холбогдуулаад бас нийт энэ төрийн албан хаагчид руу бас хэтэрхий хүнд дарамт учруулж байгаа юм шиг зарим хүмүүс ойлгоод байж магадгүй. Төрийн албан хаагчдыг харин хамгаалж байгаа хууль байгаа юм шүү. Одоо удирдлагуудын зүгээс төрийн албан хаагчдад шахалт шаардлага тавих асуудал байлгүй яах вэ. Тэгэхдээ эрх хэмжээгээ хэтрүүлж, хүний мөн чанар луу халдаж, тэр ёс зүйн хэм хэмжээг давж болохгүй. Өөрөөр хэлбэл шахааж шаардлага тавихдаа хүнийг нас хүйс, яс үндэс, биеийн хэлбэр галбираар доромжлох, нөгөө загнаж байгаа нь энэ гээд хүнд сэтгэл санааны дарамт учруулах, тэгээд бэлгийн хүчирхийлэл дарамт гээд янз бүрийн асуудлууд гардаг. Ийм зүйлүүд гарахгүй байхад энэ хуулийн бас 1 зохицуулалт, нэн ялангуяа төрийн албаны удирдлагын түвшинд, газар, хэлтсүүдийн даргын түвшинд ч гэсэн ийм зөрчлүүд байгааг бас таслан зогсоож байгаа гэж ойлгож болно.

Ингээд зочид танилцуулъя. УИХ-ын гишүүн Хишгээгийн Нямбаатар, Пүрэв-Очирын Анужин, Бадарчийн Жаргалмаа, Ням-Осорын Учрал, Энхбаярын Батшугар нарын урилгаар СХД-ийн Социал демократ МЗХ-ны гишүүдийн төлөөлөл УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ, залуучууддаа ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Та бүхний зүрх сэтгэлд Монгол эх орны маргаашийн хувь заяа зураастай байгаа гэж бодож байна.

Дамдинням гишүүн тодруулж асууна. 1 минут.

**Г.Дамдинням:** Тийм. Тэгэхээр саяын зохицуулалт орж байгаа нь их сайн байна. Тэгэхдээ бас нөгөө талд нь бас харж үзээрэй. Юу вэ гэхээр бас гүтгэдэг, хэлмэгдүүлдэг асуудлууд бас гарах байх шүү. Тэгээд энэ талаас нь бас бодолцож

үзээрэй. Их Хурлын даргатай бас санал 1 байна. Ер нь төрийн албанд бол олон мянган сайн хүн бий. Дийлэнх нь олуулаа, тэр дотор цөөхөн хэсэг бол энэ төрийн албаны хуулийн сайн бодолтойгоор хийсэн зохицуулалтуудыг хувьдаа буруугаар ашигласан бүлэг байдаг шүү. Энд л гол энэ зохицуулалтыг оруулах талаас нь анхаарч энэ зохицуулалтыг ажлын хэсэг дээрээ ярилцаж хийгээрэй л гэж хүсье.

**Г.Занданшатар:** Зөв маш чухал.

Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг дэмжиж байгаа. Тэгээд энэ хууль бол бас цаг үеэ олсон зайлиггүй гарах ёстой хууль. Ялангуяа энэ хуулиар энэ ёс зүйн нийтлэг хэм хэмжээг бас тодорхой болгож өгсөн. Тэгээд төрийн албан хаагчдын бас нэр хүнд бас цаашидаа бас нэмэгдэх болов уу гэж бодож байна.

Би 7-гийн 1-ийн 1 дээр 1 асуулт асуух гээд байгаа юм. Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх гэсэн ийм заалт орж ирсэн байна. Чин сэтгэлээсээ гэдгийг ер нь хэрхэн хэмжиж тайлбарлах вэ? Чин сэтгэлээсээ үйлчилсэнгүй ээ гээд гомдол гарвал яаж шалгах юм үүнийг. Ямар шалгуур үзүүлэлт байх ёстой юм? Тийм учраас энэ чин сэтгэлээсээ энэ шалгуурыг бол шалган тогтоох бололцоо боломж бол байхгүй л дээ. Тийм учраас үүнийг юу гэдэг юм, шударга, мэргэжлийн түвшинд ажиллах ч гэдэг юм уу, ийм үг үсгээр тайлбарлавал яасан юм бэ? Бичиж бол.

2 дахь асуудал бол энэ 9-ийн 2-т байж байна. Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлийн энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хараат бус байна гээд ингээд. Үүнийг бас жоохон тодорхой болгоод энэ Ёс зүйн хороо ямар нэгэн алдаатай шийдвэр гаргах юм бол хариуцлага хүлээх үү, ямар нэгэн хөндлөнгийн нөлөөнд автал яах вэ гэдэг

энэ асуудлыг бас тодорхой болгож оруулж өгвөл зүгээр байна. Ялангуяа юу гэдэг юм гаргасан шийдвэрийнх нь төлөө хариуцлага хүлээдэггүй ч юм уу, ямар нэгэн хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй ч гэдэг юм уу. Ийм заалтуудыг оруулж ирэхгүй бол бас энэ нэлээн бүрхэгдүү бас ийм заалт орж ирсэн байна гэж бас бодож байна.

Ер нь төрийн албан хаагчийн хүнд суртал юунаас эхтэй вэ гэх юм бол та бүхэн мэдэж байгаа шүү дээ, ерөөсөө л энэ цалин тариа, төрийн албаа шударгаар явуулах энэ нийгмийн нөхцөл байдал, ажиллах нөхцөл байдал ийм дутагдалтай байгаагаас болж л юу гэдэг юм энэ хүнд суртал, энэ төрийн албан хаагчдын авлига, ёс суртахууны асуудал хөндөгдөж байгаа. Тийм учраас энэ хууль дээрээ ч тэгсэн юу гэдэг юм төрийн албан хаагчдыг шударга ажиллуулах, зарчимтай ажиллуулахын тулд тэр ажлын нөхцөл бололцоог хангаж өгсөн тодорхой тийм заалтуудыг бол бас хэлж өгөөч ээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 80, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Алтанзул хариулна.

Удирдлагын академийн багш Алтанзул хариулъя. Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж гэдэг өөрөөр хэлбэл 7-гийн 1-д заасан зохицуулалт бол энэ шууд нийтлэг тавигдах хэм хэмжээ байгаа. Энэ хэм хэмжээгээ сахихын тулд 8 дугаар зүйлд заасан үүрэг хориглох зүйлээр нарийвчлан зааж байгаа. Өөрөөр хэлбэл үйлдэл болгож байгаа. Тэгэхээр энэ 7-гийн 1-ийг 7 дугаар зүйлд заасан энэ хэм хэмжээнүүдийг зөрчсөнтэй холбоотой хариуцлагын санкц үйлчлэхгүй. Өөрөөр хэлбэл, энэ эерэг нөлөөлөл бүхий тухайн төрийн албан хаагч баримталбал зохих тэр нийтлэг эерэг хэм хэмжээг нь зохицуулж өгч байгаа.

Хэрвээ энэ хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд 8-ын 1-д заасан тэр үүрэг хориглох зүйл гэдэг маань

жишээлбэл чин сэтгэлээсээ зүтгээгүй байна гэдэг маань одоо иргэдэд би үйлчилгээ үзүүлэхдээ тийм ээ, анхааралтай хандаагүй, мөн нийтийн хуульд заасан чиг үүргээ биелүүлээгүй байх гэсэн энэ зохицуулалтаараа уяж, тайлбарлаж байгаа.

2 дахь асуултын хувьд бол Ёс зүйн хороо дэд хорооны асуудлыг хараат бус байхаар зохицуулсан. Хараат бус байх хүрээнд бол ялангуяа дэд хорооны түвшинд энэ хуульд маань дэд хорооны зохицуулалтыг нарийвчлан зааж өгсөн. Дэд хороонд ажиллаж байгаа хүмүүсийг хэрвээ шийдвэр гаргахтай нь холбоотойгоор тийм ээ, дарамтлах, аливаа нөлөөлөх үйлдэл үзүүлсэн албан тушаалтанд бол тухайн хуулийнхаа үйлчлэлтэй холбоотойгоор хариуцлага тооцохоор ингээд зохицуулсан байгаа.

Ерөнхий ёс зүйн хорооны хараат бус байдлын асуудал дээр ч гэсэн бид нар хорооны ёс зүйн бүрэн эрхийг зохицуулсан зүйл дээр бол оруулж өгсөн байгаа.

**Г.Занданшатар:** Дамбын Батлут гишүүн.

**Д.Батлут:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой, хариуцлагатай холбоотой асуудлыг одоогийн байдлаар 60 орчим хуулиар зохицуулж байна. ЗГ-ын тогтоолын дагуу агентлагийн дарга нар байгууллагад мөрдөгдөх ёс зүйн дүрмээ баталдаг гээд ингээд харахаар маш их тийм олон ёс зүйн асуудлыг зохицуулсан хууль тогтоомжууд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ хууль тогтоомжид заасан заалтаараа бол хариуцлагын тал дээрээ бол харилцан адилгүй зохицуулалтууд хийгээд өгчихсөн заалтуудтай, 1 ёсондоо 1 чиглэлийн асуудал дээр харилцан адилгүй тийм хариуцлага тооцдог, бүр эсвэл зарим 1 дээр нь бүүр байхгүй, хариуцлага тооцох тогтолоцоо ч зүйл заалт ч байхгүй байх ийм нөхцөл байдлууд байна.

Тэгэхээр энэ хуулийг баталснаараа бид харин энэ төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагатай холбоотой асуудлыг 1 мөр болгож цэгцлэх ёстой гэж харж байгаа. Тэгэхээр энэ цаашилаад энэ 60 орчим хууль энэ тогтоомжууд дээр өөрчлөлт оруулах шаардлага гарах байх. Тэгээд ийм боломжууд байгаа юу? Үүнийг та бүхэн юу гэж үзэж байгаа юм бэ?

2 дугаарт, нь твиттер, фэйсбүүк зэрэг нийтийн сүлжээнд идэвхтэй байдаг төрийн албан хаагчид олон бий. Тэд маань бас төрийн албаны талаар сөрөг зүйл иэйрлэх, мөн үр дүнгүй бодлогын талаар өөрийн сэтгэгдлээ бичих зэрэг зүйлүүд гаргадаг нь зарим 1 талаараа дарга удирдлагуудад таалагддаггүй, тэрийгээ устга, ямар нэгэн байдлаар ийм үйлдэл хийхийг нь хориглодог ийм нөхцөл тохиолдлууд зөндөө байдаг талаар яригддаг. Тэгэхээр дээрх үйлдлийг гаргасан төрийн албан хаагч хуулийн төслийн 8-ын 1-ийн 1-ийн 2-т заасан төрийн албаны үйл ажиллагаанд итгэл алдах, хардахад хүргэх, аливаа үйлдэл эс үйлдэл хийсэн гэж үзэх үү. Ёс суртахууны зөрчил гаргасан гэж үзэх үү, үүнийг. Хэрвээ тийм бол иргэн хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх хүний эрхийн асуудал зөрчигдөж байгаа юм шиг л харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ тал дээр та бүхэн 1 хариулт өгөөч ээ гэж хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 84 Чандагийн Бат-Эрдэнэ.

ТАЗ-ийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ Батлут гишүүний асуултад хариулъя. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйл дээр энэ төрийн албаны тодорхой ангиллуудад хамаарах албан тушаалын, албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг ямар субъект тогтоох талаар маш тодорхой зохицуулж, хуулийн төсөлдөө тусгасан байгаа. Жишээлэхэд хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7-гийн 2 дахь хэсэгт төрийн албаны тухай хуулийн 10-ын 1, 10-ын 1-ийн 3 буюу төрийн улс

төрийн албан тушаалтан, мөн төрийн тусгай албан тушаалтантай холбоотой энэ мөн Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 4, 4-ийн 1-ийн 7, 4-ийн 1-ийн 9 дэх заасан энэ албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтоохоор зохицуулсан.

Мөн 7-гийн 3 дахь заалтаар төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтан, мөн Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 3, 4-ийн 1-ийн 5-д заасан этгээдийн ёс зүйн хэмжээг хуульд нийцүүлэн ЗГ тогтоохоор ингэж төсөлдөө тусгаж өгсөн байгаа. Энэ зохицуулалт маань өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлээр бас зохицуулагдсан байдаг аа.

Хуулийн төсөл батлагдан гарахтай холбоотойгоор бид бүхэн УИХ-ын тогтоолын төслийг хамт энэ хуулийн төсөлтэй боловсруулж оруулж ирсэн байгаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай гэсэн тогтоол байгаа. Энэ тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт маш тодорхой заасан. Энэ дээр бол Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ёс зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа боловсруулан УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүргийг бас ЗГ-т болон төрийн албаны төв байгууллагад хариуцуулсан ийм төсөл бол энэ дээр зохицуулагдаад ингээд явж байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

2 дахь асуултад хэн хариулах юм? 80. Асуулт хариултын цаг тэнцүү байх ёстой уул нь.

Удирдлагын академийн багш Алтанзул хариулъя. Нийгмийн сүлжээнд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, үүнтэй



холбоотой хориглолт, хязгаарлалт бол Төрийн албаны тухай хуулийн 37, 39-д бол заасан байгаа. Энэ хүрээнд бол нэгэнт хуульд зохицуулчихсан харилцаа байгаа учраас бид нар Ёс зүйн хуульдаа дурдаад өгчихсөн байгаа. Өөрөөр хэлбэл Төрийн алба 8 дугаар зүйл төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасан хэм хэмжээг зөрчвөл энэ хуульд нэн адил үйлчилнэ. Хариуцлагын тогтолцоо нь бол бид нар төрийн албаны хуулиараа байгаа. Одоо ч гэсэн бид нар зарим байгууллагуудад бас энэ хууль хэрэглээний зүйлийг тайлбарлахдаа өөрийн үзэл бодлоо илрэх, төр бодлогын шийдвэртэй холбоотой асуудалд хандахдаа энэ хуулийн зохицуулалтаар явна шүү гэж тайлбарлаж байгаа.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Бид нар төрийн алба данхайсан гэдэг ойлголт бол бүр хүн бүрд бүр суучихсан. Тийм учраас төрийн албыг цомхотгоё, чадварлаг болгоё гээд л яриад байдаг. Өнөөдөр яг ингээд бодит байдал дээр очоод үзэхэд иргэдэд үйлчилж байгаа төрийн алба маань харин хүний нөөц нь дутмаг болчихсон, бүр ачаалалдаа дарагдчихсан, тэр хэмжээгээрээ ажиллах нөхцөл, авч байгаа цалин нь, гүйцэтгэл, үр дүнгээсээ хамаагүй хойно хоцорчихсон. Ийм учраас төрийн албанаас маш олноороо хүмүүс чинь гарч байна л даа. Тэгэхээр бид нар өнөөдөр энэ хууль гаргаад энэ нь өөрөө бас Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хууль гээд ёс суртахуунтай холбоотой л хууль гэж ойлгож байна л даа. Энэ түрүүн Их Хурлын даргын хэлдгээр энэ өөрөө төрийн албан хаагчийг хамгаалах хууль гээд энэ нь 1 талаасаа яах вэ хамгаалах байгаа шүү дээ. Нөгөө талаасаа ихэнх нь хариуцлага хүлээлгэх, уучлалт гуйх ч гэдэг юм уу тэр талын заалтууд нь их байна л даа.

Сая Шүгэл үлээгчийн хуулийн ажлын хэсэг АТГ-ын олон нийттэй

харилцах төвд ажиллахад тэнд ирж байгаа гомдлуудын дотроос тэр төрийн албан хаагч ч гэдэг юм уу тэр над руу муухай хараад байна, муухай харсан заавал арга хэмжээ авч өг гэдэг ч юм уу тийм гомдлууд хүртэл их ирдэг, тэгээд үүнийг ингээд хариу нь ингээд нэхдэг ч гэдэг юм уу тийм зүйлүүд хүртэл их байсан. Энэ дээрээс бас олон нийтээс ирсэн гомдол нөгөө талаасаа хамт олноос нь хэрвээ гомдол, өргөдөл гарвал энэ тэр гэсэн заалтууд энэ хуулийн заалт дээр байна л даа. Тэгэхээр энэ дээр бас АТГ-ын олон нийттэй харилцах хэлтсийн дарга байх тийм ээ, Дуламсүрэн дарга сууж байна. Ер нь энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн энэ хууль дээр анхаарч энэ хэлэлцүүлгийн явцад бас тусгаж анхаарах зүйлийг юу нь илүү гэж өөрөө бодож байна? Яагаад гэвэл төрийн алба өөрөө бас иргэддээ үйлчилдэг. Өнөөдөр хүссэн хүсээгүй ачаалал ихтэй байгаад байдаг. Данхайсан гэдэг нь юу юм байна гэхээр нөгөө эмч нар, багш нар гээд тэр төрийг бүхэлд нь оруулчихаар төрийн алба маш том данхайсан юм шиг харагдаад байдаг. Тэгээд бас төрийн албан хаагчдынхаа цалин хөлсийг хангалттай өгч чадахгүй. Яагаад гэвэл нөгөө хүн ам, мөнгө төгрөг, төсөв хөрөнгө нь ямар байгаа билээ гээд асуудлууд их байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энэ хэлэлцүүлгийн явцад бас энэ хууль хэрэгжихийн тулд энэ заалтуудыг нь бас тодорхой тусгаж анхааруулж өгөх нь их зөв болов уу гэж би 1 дүгээрт бодож байна.

2-т нь, өнөөдөр төрийн байгууллага бүхэн дотоод журамтай. Яг тэр тухайн албан хаагчтай гэрээ байгуулахдаа бас эрх үүрэг гээд яг энэ шиг тийм зөрчил гаргавал ингэнэ, ийм эрхтэй, ийм үүрэгтэй гээд дотоод тийм байгууллагын удирдлагууд албан хаагчдын хооронд журам гарчихсан байдаг. Тэгэхээр тухайн байгууллага тэр журмаа эхэлж мөрдөх үү, эсвэл энэ төрийн албан хаагчийн ёс зүйн тухай энэ хууль хэрвээ гарчихвал үүнийг нэгдүгээрх нь гэж мөрдөх үү? Энэ зүйлүүд чинь өөрөө нь маш тодорхой болохгүй бол ингээд сая

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэлж байна шүү дээ. Бараг 60 гаруй төрийн албан хаагчийн ёс зүй, энэ ёс суртахуун эрх үүрэгтэй холбоотой хууль дүрмүүд байгаад байдаг. Тэгээд дахиад 1-ээр нэмэгдэх гэж байна. Ёс зүйтэй холбоотой гээд. Энэ олон дотор тухайн байгууллагын удирдлагууд үзэмжээрээ хандвал алийг нь эхэлж барих вэ. Ингэсэн үзэмжээрээ хандсан тохиолдолд хариуцлага тооцох бол аль хуулиа барьж хариуцлага тооцох вэ гэдэг асуудлуудыг тодорхой болгомоор байна л даа. Энд хариулт өгнө үү? Баярлалаа.

**Г.Занданшатар:** Дуламсүрэн дарга 83.

**Д.Дуламсүрэн:** Та бүхний өглөөний амар амгаланг айлтгая. Тэгэхээр энэ төрийн албан хаагчийн ёс зүйтэй, ёс суртахуунтай холбоотой асуудал бол цаашид үр дагавар нь мэдээж төрийн өөрийнх нь тогтвортой хөгжил, улсын хөгжилтэй шууд холбоотой учраас энэ бусад хуулиудтай ч гэсэн яг нягт холбоотой байгаад байгаа л даа. Төрийн албаны тухай хуульд заачихсан байгаа төрийн албан хаагчид хүлээлгэж байгаа үүргүүд, мөн төрийн албаны өөрийнх нь үйл ажиллагааны үндсэн зарчим, Үндсэн хуульд заасан бас төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудад байгаа тэр зарчмуудыг бол бүгд л дагаж мөрдөх ёстой байгаа. Энэ зарчмуудыг бүрэн гүйцэд дагаж мөрдөж чадахгүй, өргөсөн тангаргаасаа тийм ээ няцаж хазайж байгаа ийм асуудлууд л эргээд нөгөө ёс зүй, ёс зүй, цаашилаад ашиг сонирхлын зөрчил гээд авлигын асуудлыг болон бусад гэмт хэргийн асуудлуудыг бол өдөөж байгаа. Тийм учраас энэ өдөөгдөхгүйн тулд хүрсээр болсон зүйл бол бид нар тэдэнд тавигдаж байгаа ёс зүйн шаардлага, хэм хэмжээг бол маш нарийн зохицуулж өгөх ёстой. Тийм учраас зөвхөн энэ Оюунчимэг гишүүний саяын дурдсанаар хариуцлага хүлээлгэх гэхээсээ илүү хамгаалах ийм тэнцвэрийг хадгалах ийм асуудлыг үзсэний үндсэн дээр бид нар заавал шийтгэл хүлээлгэх гэж байгаагаа гэдгээсээ илүүтэйгээр мөн тухайн албан

хаагчид өөрсдөө тийм ээ, төрийн албаны нэр төр өндөрт өргөхтэй холбоотой асуудлыг нь тусгайлан авч үзээд энэ хууль дотор оруулж авч ирсэн байгаа юм л даа.

Өөрөөр хэлбэл хэмжиж болох, болохгүй гэдэг дээр ажлын хэсэг бас төвлөрч ажилласан байгаа. Хэмжиж болохгүй зүйлүүд нь юу байх юм. Хэмжиж болохгүй тийм үйлдэл эс үйлдэл үлдэхгүй байвал бид нар яаж үзэх юм бэ. Үүний цаана бас л эргээд нөгөө хүний эрх, цаашилаад иргэдийн эрх ашиг бас хөндөгдөх асуудал учраас энэ дээр бол тэнцвэрийг хадгалах гэдэг байр суурийг бол ажлын хэсэг сайн баримталж ажилласан байгаа гэдгийг бас дурдъя.

**Г.Занданшатар:** 80, Алтанзул доктор, профессор.

**А.Алтанзул:** Оюунчимэг гишүүний 2 дахь асуултад хариулъя. Энэ хууль маань нөгөө анхдагч суурь хууль байгаа, анхдагч суурь хуулиа дагаад түрүүн дурдсан 60 гаруй хууль, 30 орчим төрийн байгууллагуудын нийтлэг зохицуулалттай хууль дүрмүүд өөрчлөгдөнө өө. Тэгэхээр төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан нийтлэг хэм хэмжээний хүрээнд хууль нийтлэг хэмжээнд хууль дүрмүүдээ өөрчлөх ёстой. Өөрчлөхийн тулд түрүүн ярьсан ёс зүйн хорооны дүгнэлт саналыг авсан байх ёстой. Одоо байгаа хууль хүчин төгөлдөр үйлчлээд эхлэх юм бол хуулийн 1 дүгээр эрэмбээр энэ хуулиа баримтална. Түүнээс дур дурын байгууллага юм уу, салбарын гаргасан нийтлэг хэмжээгээрээ төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг болон түүнд хүлээлгэх хариуцлагатай холбоотой шийдвэр гаргахгүй ээ гэж ойлгоно. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Оюунчимэг гишүүн тодруулж асууя, 1 минут.

**М.Оюунчимэг:** Энэ хуулийг бол дэмжиж байгаа учраас гаргах нь зөв байх. Гэхдээ хамгийн гол нь миний хэлээд

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байгаа төрийн албаа хүчтэй дээрээс нь бас хийснээрээ цалингаа авдаг тийм ээ, цалин урамишууллаа авчихдаг байлгах нь өөрөө чухал байна шүү дээ. Өчигдөр ингээд ЧД-ийн энэ бүх сувилагч нартай уулзахад ажлын ачаалал бүр дэндүү болчихсон, дээрээс нь хагас сайн бүтэн сайнд олон нийтийн зохион байгуулалттай арга хэмжээ гээд ар гэрээ бүр хаяхад хүрдэг. Авч байгаа цалин үүнийхээ талд ч хүрэхгүй нь өөрөө сэтгэл зовнил нөгөө стресс гэдэг шиг сэтгэл гутралд автах юм уу. Энэ нь өөрөө бухимдал ийм үүсгэдэг. Тэгээд энэ нь эргээд нөгөө иргэнтэй харьцахад энэ ажилд нь нөлөөлөөд явчихдаг талаар байр суурь, сэтгэгдлээ илэрхийлж байсан л даа саналууд. Сая ч гэсэн энэ ковидын дараа судалгаанууд хийхэд төрийн үйлчилгээний албан дээр хамгийн их тэр сэтгэл стресс, сэтгэл гутрал, сэтгэл хямралын шинж тэмдгүүд өндөр гарсан шүү дээ. Энэ нь өөрөө саяын энэ ёс зүйн хариуцлага хүлээх хүмүүс тэнд олноороо л байх болж байна гэсэн үг болж байгаа юм. Тэгэхээр энэ хуультай зэрэгцээд яг тэр төрийн албыг саяынх шиг чадавхжуулах үнэлэмжийг нь дээшил ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэгэхээр энэ хуулийн хүмүүс шал өөр асуудал л даа. 80, Алтанзул доктор, профессор хариулъя.

**А.Алтанзул:** Оюунчимэг гишүүний саналтай бол нийлж байна. Тэгэхээр энэ хуульд маань бид нар төрийн албан хаагчийг зөвхөн хариуцлага тооцдог хууль гэж бас ойлгож болохгүй. Энэ хууль маань бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зохицуулалтыг оруулсан. Ялангуяа төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаал дэвшүүлэх, шагнал урамишуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн зөрчил гаргаагүй, ёс зүйн аливаа асуудал гаргаагүй бол энэ саяын дурдсан шийдвэр гаргахад харгалзан үзнэ ээ гэдэг маань бас

тэр төрийн албан хаагчийгаа хамгаалж байгаа ийм процесс.

2 дугаарт, төрийн албан хаагчийн энэ ачаалалтай холбоотойгоор гомдол гаргахад тухайн иргэн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар нотлогдохуйц хэмжээний нотлох баримтыг өөрөө гаргах үүрэг хүлээлгэсэн байгаа. Тэгэхээр юу юугүй л намайг гүтгэсэн, намайг доромжилсон гэх нотлох баримтгүй зүйлүүдийг бол бид нар ёс зүйн зөрчлийн кэйс болгож үгүйсгэхгүй ээ л гэдэг зохицуулалтыг бас энэ хуульдаа уяж өгсөн байгаа. Тэгэхээр харилцан тэнцвэртэй байх ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн алга байна, хаслаа. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн алга байна, хаслаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн алга байна, хаслаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна, хаслаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн алга байна, хаслаа. Жамбын Батсуурь гишүүн, Жамбын Батсуурь гишүүн. Энэ чинь тэгээд дуусчихлаа шүү дээ.

Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Адьшаа гишүүн ороод ирсэн байна. Адьшаа, больчихсон уу? Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

**Д.Өнөрболор:** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Монгол Улсад 4232 төрийн байгууллага, үүнээс 567 байгууллага бол дэргэдээ Ёс зүйн зөвлөлтэй ажиллаж байгаа юм байна. Сая хэд хоногийн өмнө хийсэн энэ ТАЗ-ийн даргын тайлангаас харахад 225000 албан хаагчдаас тайлант хугацаанд 415 албан хаагчид бол ёс зүйн зөрчил гаргаж энэ хариуцлагыг бол хүлээлгэсэн гэсэн ийм тайлан сонссон. Тэгэхээр энэ 415 албан хаагчид энэ ёс зүйн хариуцлага тооцсоноор, энэ тоо нэмэгдсэнээр энэ иргэдийн бухимдал арилах уу. Энэ хариуцлагын үр дүнд төрд итгэх итгэл нэмэгдэх үү гэдэг асуудал байгаа юм.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгэхээр би бол бодохдоо энэ жинхэнэ ажил хийж байгаа энэ төрийн албан хаагчдад бүгдийг нялзаагаад энэ төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын асуудал гэж ярихаасаа илүүтэйгээр бид нар өнөөдөр яагаад энэ төрийн нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээ, сахилга хариуцлага, энэ асуудал маань өөрөө өнөөдөр ингэтлээ доройтсон бэ гэдгийг бол үндсээр нь авч үзэх шаардлагатай гэж бол ийм цаг ирсэн байна гэж бол үзэж байна.

Өнөөдөр олон нийтийн бухимдал, энэ төрийн нэр хүнд, энэ төрд итгэх итгэл буурч ирсэн энэ үндсэн шалтгаан бол энэ бодлого боловсруулагчид, мэдээлэлд ойр шийдвэр гаргагчдын буруутай үйл ажиллагаанаас бол шууд хамааралтай. Өнөөдөр энэ өнгөрсөн хугацаанд мэдээлэлд ойр нөлөө бүхий өндөр албан тушаалтнууд энэ боломжийг бол илүү их хүртэж ирсэн гэдэг нь сая нээлттэй сонсголоос бас маш тодорхой харагдсан. Энэ Хөгжлийн банк, ЖДҮ-ийн хөгжлийн сан, нүүрсний гээд энэ ард түмний өмч, баялгийг тийм ээ, өөдтэй өнгөтэй бүхнийг цөлмөсөн энэ бүх асуудлуудтай улс төрд нөлөө бүхий этгээд холбогдож байгаа нь ер нь ёс зүйгээс хальсан. Ингэж хальж гэмт хэргийн бүлэг дээрмийн шинжтэй болж байгааг ер нь хатуухан хэлэх юм бол энэ улсаараа дүүрэн алдаа, завхрал, авлигад идэгдсэн ийм л дүр зурагтай бид нар сууж байна. Тэгэхээр ер нь төрийн албан хаагчдын энэ ёс зүйн тусгал нь УИХ-ын гишүүд, сайд, дарга нар өөрсдөө. Тэгэхээр бид өөрсдөөсөө үлгэрлэж, манлайлах ёстой гэж бол би үзэж байна. Ер нь энэ хуулийн үндсэн үзэл санаа ч энэ байх ёстой. Ингэж байж л бид бас энэ хуулийн төслийн зорилгод байгаа үр дүн гарах тийм ээ, ийм итгэл үнэмшил бий болно гэж бол би үзэж байгаа юм. Тэгээд үүнийг энэ үзлээ баримталъя ч гэсэн бас баталж байгаа 1 судалгаа бол энэ манай УИХ-аас явуулсан ард иргэдийн дунд явуулсан байж байгаа энэ зөвлөлдөх санал асуулгад оролцогчдын 87.9% нь мэргэшсэн төрийн албан хаагчид, мэдлэг чадвар дээр

суурилсан улс төрөөс ангид байх асуудлыг бол хөндөж ингэж судалгаанд оролцсон байж байгаа. Үүн дээр бол бид нар бол үнэхээр дүгнэлт хийх, нийтээрээ дүгнэлт ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

**Б.Баттөмөр:** Өнөрболор гишүүн бас маш чухал асуудлыг хөндөж гаргаж ирж тавьж байна аа. Энэ бол үнэхээр анхаарах ёстой асуудал. Үүнийг УИХ-ын дарга энэ асуудлыг анх судалж гаргаж гаргаж тавьсан юм. Тэгээд захирамж гаргаад 4 гишүүнтэй бүрэлдэхүүнтэй ийм ажлын хэсэг томилсон юм. Томилоод Их Хуралд өргөн барьсан, ажлын хэсгийг надаар ахлуулж байгуулсан. Бидний ажилд бол байнга тусалж ярьж дэмжиж эрдэмтдийн багийг энд бас цуглуулж, ярьж дэд ажлын хэсэг 15 удаа хуралдсан. Энэ дээр бол яг сая Өнөрболор гишүүний хэлж байгаа энэ асуудлыг гаргаж ирж тавьсан юм. Тэгэхээр энд бол их олон талаас нь бид нар бол авч үзсэн. Ер нь бол энэ эрдэмтдийн гаргасан судалгаа байна л даа. Тэгээд энэ судалгаан дээр юу гэж гарч ирж байна гэхээр энэ энэ хуулийн амин сүнс нь бол ёс суртахуун ерөөсөө аливаа хуулиудын. Ёс суртахуунд бол ямар юм хамаарч байна гэхээр зэрэг энэ ёс суртахуунтай хүн гэдэг чинь юу гэхээр эелдэг байдаг, шударга байдаг, эр зоригтой байдаг, тэгээд цаашаага элдэв бусын үүрэг хариуцлагатай байдаг, жудагтай, нинжин сэтгэлтэй, нийтэч, тусархаг, тэвчээртэй, өгөөмөр сэтгэлтэй гээд ингээд гол нь юугаар энэ эрдэмтэд тодорхойлсон байгаа юм. Энэ дээр ухамсрын доройтол гэдэг юм бол бидэнд бол байгаа юм л даа. Тэгээд бүдүүлэг зан гардаг, шударга бус байдаг, шуналтай, эрээ цээргүй, ирээдүйдээ итгэх итгэлээ алдчихсан, хариуцлагагүй, харгис хэрцгий болох итгэл эвддэг, хууран мэхэлдэг, хувиа хичээдэг, нэр хүндээ алддаг, 2 нүүртэй, тэсвэргүй хагарал үүсгэдэг, болно болохгүй гэсэн сонголтыг нь буруу хийдэг энэ сонголтуудыг ийм юм



бол манайд үнэхээр байгаа шүү дээ, төрийн албанд.

Ер нь Монгол даяар бол байж байгаа. Үүнийг бол нөгөө шатыг дээрээс нь цэвэрлэдэг гэгчээр төрийн албанаасаа эхэлжээ ээ, энэ жишигийг тогтооё. Энэ жишиг маань бол Монголын бүх алба хашиж байгаа, хувийн гэлтгүй ТББ бүх юм жишиг болох ёстой гэж УИХ-ын гишүүд төрийн өндөр албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлага хүртэл энд ингээд ороод орчихсон л явж байгаа юм л даа. Тэгээд ингэж хийсэн юм. Тэгээд энэ дээр бол бид нар их ажилласан. Энэ яг өөрийн чинь хэлж байгаатай бид нар санал 1 байгаа. Энэ олон улсын туршилагуудыг судалсан. Сингапурын туршилага, Өмнөд Солонгос, тэгээд Хятадын туршилага байна, тэгээд юу байгаа Европын холбооны улсуудын туршилага, Америкийн туршилага гээд маш их олон туршилагуудыг судалж ингэж гаргаж ирсэн юм. Тэгээд ер нь бол энэ дээр бас тодорхой өөрчлөлтүүд гарна гэж ингэж ойлгож байгаа, өөрийн чинь ярьж байгаа хэлж байгаа юутай бол санал 1 байгаа юм. Ер нь бол тодорхой үр дүн гарна л гэж ойлгож байгаа, товч хэлэхэд. Манай ажлын хэсгийн гишүүдээс бас ярьж болно.

**Г.Занданшатар:** 80, Алтанзул доктор хариулъя.

**А.Алтанзул:** Оюунболор гишүүний асуултад харуулъя. Өнөрболор гишүүний уучлаарай. Яах аргагүй төрийн улс төрийн албан хаагч УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн юу, сайдууд, ҮХЦ-ийн гишүүд гээд төрийн өндөр албан тушаал түүнтэй адилтгах албан тушаалтнуудын асуудал орхигдлоо гээд иргэд бас бусад төрийн албан хаагч шүүмжилдэг. Тэгэхээр манай хуулийн үйлчлэлд саяын дурдсан албан хаагчид албан тушаалтнууд орно оо. Тэгээд энэ төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой ёс зүйн асуудал нь бид нарын хараат бус бие даасан ажиллах Ёс зүйн хороо нь энэ албан хаагчтай холбоотой ёс

зүйн зөрчлүүдийг дүгнэлт гаргахаар байгаа. Тэгэхээр энэ хуулийн үйлчлэл дээр саяын дурдсан бүх субъектүүд ороод тэгээд энэ Ёс зүйн хороо энэ эдгээр албан хаагчдын ёс зүйн дүгнэлт хийгээд Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд дүгнэлтээ ирүүлээд тэгээд томилох эрх бүхий албан тушаалтан буюу УИХ-д саналаа хүргүүлэхээр ингээд процессын хувьд яг бас нарийвчилсан зохицуулсан байгаа. Тэгэхээр энэ хуулийн үйлчлэлд бол хамаарна.

**Г.Занданшатар:** Баатарзориг дарга та юу хариулах гэсэн юм. Дараагийн хүн товч тодорхой хариулахгүй тэгээд. Баатарзориг дарга хариулчихъя, 82, товч тодорхой хариулаарай.

**Б.Баатарзориг:** Өнөрболор гишүүн асуусан, 565 Ёс зүйн зөвлөл байгуулагджээ гээд энэ өмнөх тайлан дээр ч ингэж хэлээд байсан. Энэ бас ойлголтын зөрөө байгаа. 567 бол дүрмээр 25 хүнээс доошоо байгуулж болохгүй ээ. Ёс зүйн зөвлөл гэдгийг. Санаачилгаараа байгуулсан ийм санаачилга гаргасан учраас 567 шинээр байгуулагдсан, 25-аас дээш хүнтэй төрийн байгууллагуудад 250 Ёс зүйн зөвлөл байгуулагдсан юм. Ингээд одоогоор бол 2961 ёс зүйн зөвлөл улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа. Шинэ хууль батлагдахаар ажилтны тооноос үл хамаараад 4232 төрийн байгууллагад тус тусдаа Ёс зүйн дэд хороо байгуулагдаад ажиллана. Ингээд хийдэгдэл гарахгүй ээ, давхар ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тийм. Ер нь 2691 ёс зүйн зөвлөл ажиллаж байгаа, энэ хуулиараа байгуулагдах ёстой. Үүнийг нь институтчилж нэгдсэн удирдлагаар хангаж энэ Ёс зүйн дэд хороо байна, төрийн албаны ёс зүйн хороо байна. Энэ систем болгож байж энэ төрийн албанд байгаа жишээлбэл төрийн албан хаагчдыг хамгаална, хариуцлага их байна гэж буруу ойлгоод байгаа юм л даа. Ёс

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зүйн зөвлөл чинь удирдлагуудыг нь ч байдаг юм уу улс төрийн ч байдаг юм уу, дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны хүчирхийлэл, ажлын байрны дарамт энэ бүх юм чинь Ёс зүйн зөвлөлдөө гомдлоо гаргадаг байхгүй юу. Тэгтэл Ёс зүйн зөвлөл нь ажилладаг биш дарга нь 1 хүн томилчихдог, энэ юмнуудыг чинь тодорхой болгож байгаа юм. Ингээд улсын хэмжээнд 4292 төрийн байгууллага ажиллаж байгаа юм. Энэ 4292 байгууллага дээр 20-оос дээш дээр нь Ёс зүйн зөвлөл ажиллана гэж байгаа боловч бүх байгууллага дээр энэ ёс зүйн хэм хэмжээг хянаж байх ёстой юм. Ер нь эрх зүйт төр шударга бол ямар ч хууль эс гаргасан ч гэсэн ард нийтээрээ дагана. Эрх зүйт төр шударга бус бол мянган хууль гаргаад ч ард түмэн дагаж мөрдөхгүй ээ гэсэн ийм эртний Чингис хааны сургаал байна. Ийм учраас энэ чинь ёс зүй бол хуулийн амин сүнс ээ гэж. Энэ хууль дээр ажилласан Нарангэрэл академич энэ хуулийг боловсруулсан. Энэ манай энэ Анхзул доктор, Японы төрийн албаны ёс зүйн хууль, Германы төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын хууль, Азийн орнууд бол бүгд энэ ёс зүйг ингээж хуульчилж, дэлгэрүүлж, тогтоож байгаа. Энэ зарчмуудыг судалж байж ингээж энэ хуулийг үндсэндээ 3 жил боловсруулж, 2018 оноос хойш ажиллаж өнөөдөр анхны хэлэлцүүлгийг нь манай Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн Байнгын хорооны дарга байхдаа хэлэлцүүлж, манай Баагаагийн Баттөмөр гишүүд үүнийг боловсруулж энэ ийм чухал хууль гаргаж байгаа. Энэ чинь ямарваа нэгэн гэмт хэрэг ч бай ёс зүйн зөрчил гарахад заавал төрийн албан дотроос шүгэл үлээх, мэдээлэх, мэдэгдэхээс авхуулаад бүгд хоорондоо уялдаж байгаа. Ийм учраас энэ чинь 1 талаас төрийн албан хаагчдаа ч хамгаалж байна. Нөгөө талаас энэ төрд итгэх итгэлийг сэргээж байгаа. Японы төрийн албаны ёс зүйн тухай хуульд төрийн албан хаагч бол төрийн ард түмэнд үйлчлэгч учраас тэдний үйл ажиллагаа, ёс зүйн хэм хэмжээгээс төрд итгэх ард түмний итгэл хамаарна гэж

тодорхойлж байгаа. Тийм учраас энэ төрд итгэх ард түмний итгэлтэй ч холбоотой. Энэ тулд улс төрийн албан тушаалтнуудынх шатыг дээрээс нь эхлээд шүүрдэх учраас энэ төрийн албаны энэ УИХ-ын гишүүний ёс зүйн кодикс гэж дүрэм батлагдсан. Үүнийг мөрдүүлэхээс энэ цаашаа мөрдөгдөж эхэлж байгаа шүү дээ.

Ингээд гишүүд асуулт. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Дашдондогийн Ганбат, Цагаанхүүгийн Идэрбат нарыг хаслаа. Ингээд Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна. Энэ асуултын дараа санал хураалт явуулах учраас УИХ-ын гишүүд чуулганы танхимд цугларна уу. Зарчмын зөрөөтэй 27 санал байгаа. Энэ анхны хэлэлцүүлэг. Хэлэлцэх эсэх биш учраас нөгөө үг хэлэхгүй. Саналууд дээр зарчмын зөрөөтэй, саналыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлчхэж болно. Энэ нөгөө анхны хэлэлцүүлэг учраас хэлэлцэх эсэхээ шийдчихсэн шүү дээ, энэ хуулийн чинь.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууна.

**Б.Энх-Амгалан:** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг дэмжиж байгаа. Энэ бол цаг үеэ олсон ийм хууль. Би 1, 2 зүйл тодруулах гээд байгаа юм. ТАЗ маань ингээд 1 шүдгүй харсан шиг боллоо. Энэ Говь-Алтай аймагт ингээд 180 гаруй төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас нь халчихсан. Танай ТАЗ-ийн шийдвэр гараад 120 гаруй албан хаагчийг нь буцааж ав гэдэг шийдвэр гарсан. Одоо 1-ийг нь ч аваагүй ээ. Зарим нь шүүхдээд 3 шатны шүүхээр ингээд яваад шүүхийн шийдвэр нь гарчихсан. Шүүхийн шийдвэрээ биелүүлдэггүй ээ, ажилд нь авдаггүй ээ. Төсвийн хэмнэлтийн тухай хуулийнхаа дагуу ингээд хэмнэлт гарга аа, орлогч нараа чөлөөл өө, зөвлөхүүдээ чөлөөл өө гэхээр чөлөөлдөггүй ээ, төсвийн мөнгөөр цалинжуулаад яваад байдаг. Төсвийн мөнгөөр гараа угаадаг төрийн

болон орон нутгийн өмчийг үнэгүйдүүлж, хувьчилж хувьдаа авдаг ийм юмнууд гаарлаа. Говь-Алтай аймагт. Тэгээд үүнийг шийдэхгүй юу. Ингээд л 1 дүгнэлт гаргачхаад л суугаад байх уу эсвэл тэгээд цаашаа үргэлжлэхийг нь хүлээгээд байх уу? Энэ дээр ямар арга хэмжээ авах юм? Яг маш тодорхой надад 1 хариулт өгөөч.

Энэ төрийн албаны ёс зүйтэй холбоо, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудал мөн биз. Ийм зүйл бол 1 бус удаа гарсан, одоо аудитын дүгнэлтээр 49 хуудас ийм материал гарч ирсэн. Төрийн болон орон нутгийн өмчийг үнэгүйдүүлж хувьчилсан, төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулсан ийм алдаа дутагдлууд гарч ирсэн. Ингээд байгаад байх уу? Энэ хүнийг.

2 дахь нь, гадаад харилцаатай холбоотой асар том алдаатай бодлого гаргасан. 1 ёсондоо энэ чинь бол аймгийн Засаг дарга буюу Монгол улсын ЗГ-ын бодлогыг Говь-Алтай аймагт бол орон нутагт хэрэгжүүлэх ёстой хүн шүү дээ. Тэгээд аваачаад Халимагууд аа, Тува нар аа, Буриад ахан дүүс ээ, Якутууд аа манайд хүрээд ир, манай аймагт амьдар гэсэн утгатай мэдээлэл хийсэн. Ингээд хөршийн харилцаанд стратегийн иж бүрэн түншлэлтэй 2 улсын харилцаанд сэв суулгах ийм мэдээгдэл, мэдээллүүд хийсэн. 1 ёсондоо гаднын улсын дотоод хэрэгт оролцсон. Тэгээд энэ хүн ингээд л ажлаа хийгээд л зүгээр л байгаад байх уу? Энэ дээр манай ТАЗ шийдвэртэй арга хэмжээ авах уу, авахгүй юу, эсвэл ингээд өөшүүлээд яваад байх уу? Энэ асуудлаар надад 1 маш тодорхой хариултууд өгөөч.

Ланд круизер машиныг сая төгрөгөөр зарчихлаа гээд л зөндөө мэдээлэл гарсан. Шилэн дохио тэнд нь жиргээд одоо өө, саяар зарж байгаа юм бол би 2 саяар үнэ цохиж авъя гээд сууж байна лээ шүү дээ. Ийм нөхцөл байдлууд цаашид яваад байх уу? Үүнийг 1 надад 1 тодорхой хариулаадхаач.

**Г.Занданшатар:** 85. Идэрчулуун гишүүн, Бадамцогийн Идэрчулуун ТАЗ-ийн гишүүн.

Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Энх-Амгалан гишүүний асуултад ТАЗ-ийн гишүүн Идэрчулуун хариулж байна. Говь-Алтайд болоод байгаа хууль бус томилгоо, энэ гомдлуудыг бол бид нар мэдэж байгаа. Тэгээд мэдээд зүгээр суугаад байгаа юм биш. Төрийн албаны тухай хуульд 7 сарын 5-нд өөрчлөлт ороод 8 сараас мөрдөж эхэлсэн. Энэ хуулийн хүрээнд хууль бусаар томилсон хүмүүс энэ дотор орж байгаа, ковидын хуулиар томилоод төрийн албаны тухай хуульд тавьсан шаардлагыг хангахгүй хүмүүсийг томилсныг хууль хүчингүй болж 12 сарын 31-нээр дуусгавар болсон. Үүнтэй холбогдуулж 11 сарын 22-нд байх аа, манайх мэдээгдэл гаргаж энэ хуулийн үйлчлэл дуусаж байгаатай холбогдуулаад энэ хууль бусаар томилсон улсуудаа чөлөөл өө гэдэг мэдээгдэл хүргүүлсэн. Энэ хооронд бол таны хэлдгээр 1 хэсэг хүмүүс нь шүүхэд хандсан. Шүүхийн процесс удаан явдаг учраас бас үүн дээр цаг хугацаа авч байгаа юм байгаа. ТАЗ энэ хяналтаа огт сулруулаагүй. Одоо бид нар ер нь энэ томилгоо дээр хууль бусаар хандаад байгаа асуудал бол ард нь ашиг сонирхол байна гээд АТГ-т шилжүүлэх хүмүүсийн нэрсийг ганцхан Говь-Алтай гэхгүй бид нар судалгаа аваад материал бүрдүүлээд явж байна. Дээр нь энэ хууль бус томилгоотой холбоотойгоор төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажил нэлээн эрчимтэй явагдаж байгаа. Тийм учраас магадгүй зүгээр хөндлөнгөөс ажиглаж байгаа хүнд энэ анзаарахгүй орхиод, удаан яваад байгаа юм шиг санагдаж магадгүй. Яг бид нар бол үүнийг анхааралдаа аваад үүний ардаас хөөцөлдөөд ажиллаж байгаа.

Ер нь яг энэ багц ажлынхаа хүрээнд бид нар ТАЗ-ийн тогтоолыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ ээ гэсэн Төрийн албаны тухай хуулийн 65-ын 6 дахь заалтыг биелүүлэхгүй байгаа хүмүүсийг бид нар

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нэр дараалан АТГ-т үүний ард ашиг сонирхол байна гэдгээр шилжүүлэхээр ингээд бэлдээд ажиллаж байгаа. Эрх бүхий байгууллагад нь энэ хууль зөрчсөн үйлдлийг нь таслан зогсоолгох, энэ огцруулах энэ мэдэгдлийг хүргүүлэх энэ ажил хамт хийгдээд явагдаж байгаа.

**Г.Занданшатар:** Гадаад харилцааны алдаатай бодлогыг чинь ТАЗ хариулах юм уу? 80, доктор профессор Алтанзул. Удирдлагын академийн тэнхимийн багш.

**А.Алтанзул:** Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө тийм, манай энэ төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал дээр өөрөөр хэлбэл зөвхөн энэ хуулиас гадна бас нарийвчилсан зохицуулалттай хуулиуд бол байгаа. Тэгэхээр нарийвчилсан зохицуулалттай хуулийн хэм хэмжээг бид нар бас энэ хуульдаа эшлэл татаад бол оруулж ирсэн. Саяын ярьсан захирах, захирагдах ёсыг зөрчсөн өөрөөр хэлбэл дээд шатны байгууллагын шийдвэрээс давж гарсан шийдвэр гаргаж байгаа бол тухайн нарийвчилсан хууль болон төрийн албаны хуулийн 7-гийн 1-д заасан зарчмын дагуу 37, 39-өөр хориглосон байгаа. Хэрвээ энэ хориглосон үйлдлийг гаргасан байвал эрх бүхий албан тушаалтан буюу томилдог албан тушаалтан сахилгын арга хэмжээ авахаар хуульчилсан. Тэгээд нэгэнт хуульчилсан хуулиас гадна манай хууль дээр ямар зохицуулалт бас нарийвчилж орсон гэхээр гадаад томилолтын хувьд ёс зүйн талаас нь гадаад томилолтын гадаад томилолт болон түүнтэй холбоотой чиг үүргээ хэрэгжүүлэхэд дипломат ёс жаягийг зөрчих, аливаа нөгөө улсын болон төрийн байгууллагын нэр хүндэд харш аливаа үйлдэл гаргахыг хориглосон байдлаар зохицуулалт орсон байгаа.

**Г.Занданшатар:** Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн 1 минут.

**Б.Энх-Амгалан:** Би маш тодорхой ганцхан асуулт асууя. Та хэд маань энэ

төрийн албаны хуулиараа болохгүй байгаа энэ ковидын хууль хэрэгжээд дуусчихсан. Тэгээд бид нар 1 мэдэгдэл хүргэсэн. Энэ хориглосон заалт хуульд байгаа. Тийм учраас томилсон албан тушаалтанд нь ингээд сахилгын арга хэмжээ авахаар хэлэх ёстой, материалууд бүгд бүрдүүлж байгаа, АТГ өгч байгаа гээд 1 ийм юм яриад суугаад байдаг. Хариуцлага тооцохгүй юм уу, ганцхан л юм асууя, хариуцлага тооцохгүй юм уу. Томилсон дээд шатных нь албан тушаалтанд сахилгын арга хэмжээ авч өгөөч ээ гэдэг бичиг явуулахгүй юм уу. Ингээд давруулаад байгаад байх юм уу. Тэгээд хугацаа авдаг юм аа, яах вэ, ингээд мэдэгдлээ өгчихсөн тэгчихсэн, ингэчихсэн гээд. Энэ чинь 4 жилийн процесс явагдлаа шүү дээ. Энэ дээр 1 маш тодорхой хариулт өгөөдхөөч. Дээд шатных нь даргад та нар бичиг явуулах уу, хариуцлага тооцох тухай юм явуулах уу, үгүй юу гээд надад өгөөдхөөч.

**Г.Занданшатар:** 85. Энэ хуультай шууд холбоотой.

**Б.Идэрчулуун:** Би түрүүн тайлбарласан, энэ процессын ажиллагаа яалт ч үгүй ингээд хуульчилсан заалтуудтай учраас эхлээд өөрсдөд нь залруулах боломж олгож мэдэгдэл хүргүүлээд, үүнийгээ хэрэв мөрдөхгүй байвал тэр томилгоотой холбоотой хууль бус тушаалуудыг ТАЗ татаж хүчингүй болгоод, тэгээд энэ томилгоотой холбоотой энэ чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байх юм бол харьяалах дээд шатны байгууллагад нь албан тушаалаас нь халах, огцруулах ийм санал хүргүүлэх хуулийн заалттай. Энэ процессоороо явж байгаа, үүнийг бол бид нар хойш нь тавиад ингээд хүлээгээд байхгүй хүргүүлнэ ээ.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя.

УИХ-ын гишүүн Тогмидын Доржханд, Даваажанцангийн Сарангэрэл, Ганибалын Амартүвшин



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нарын урилгаар Хан-Уул дүүргийн иргэдийн төлөөлөл УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе өө, гишүүдийн нэрийн өмнөөс.

Одоо I гишүүний, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний асуултын дараа санал хураалт эхлэх тул асуулт хариултын цаг дуусах тул гишүүд чуулганы танхимд цуглана уу.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Энэ хуулийн төсөл дээр бол бид нэлээн ажилласан. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороог ахалж ингэж ажиллаж байхдаа бид ажилласан. Улс орон даяар нэлээн дорвитой сайн хэлэлцүүлэг зохион байгуулсан, олон улсын байгууллагуудтай хамтарч сургалт, семинар зохион байгуулсан. Орон нутагт явж ажилласан, энэ төвийн яам, агентлаг, газрууд дээр бид нар ажилласан. Тэгээд ер нь НҮБ-ын гаргасан дүрэм, тогтоол, шийдвэрээс өгсүүлээд энэ бусад улс орнуудын Төрийн албаны төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг нэлээн чамбай үзэж судалсан. Ингээд манай УИХ-ын гишүүдийн зүгээс ч энэ дээр тусгайлан ажилласан олон гишүүд байдаг. Тухайлах юм бол Их Хурлын дарга Занданшатар байна. Их Хурлын гишүүн байхаасаа, ЗГХЭГ-ын дарга байхаасаа эхлээд энэ асуудал дээр нэлээн ач холбогдол өгч ингэж ажиллаж байсан. Тэгээд бидний нэр бүхий гишүүд энэ Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийг төсөл боловсруулаад, Их Хуралд өргөн бариад, УИХ хэлэлцэх эсэхийг нь шийдээд, ингээд үүний дараа бас ажлын хэсэг гараад өнөөдөр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баттөмөр дарга энэ хуулийг ахлаад, энд сууж байгаа манай ажлын хэсгийн хүмүүс байна. Нарангэрэл академич, Алтанзул доктор, манай ТАЗ, энэ холбогдох хүмүүс нэлээн сайн ер нь

чамбай ажиллажээ гэж би ингэж үзэж байна.

Бидний анх энэ хуулийг боловсруулах үндэслэл шаардлага, бид юу гэж үзэж байсан юм гэхээр зэрэг энэ хүний хөгжлийн талаасаа бид онцгойлон анхаарал тавьсан юм. Энэ чиглэлийнх нь асуудал хэр тусгагдсан бэ гэдгийг би Баттөмөр даргаас тодруулж асуух гэж байна. Бид хэлэлцүүлэг хийгээд ингээд явахаар зэрэг улсын хэмжээнд бид 1100 бараг 1200-аад албан байгууллагуудад ёс зүйн зөвлөлийг байгуулж, нэлээн ёс зүйн зөвлөлийн ажлыг бол жигсдүүлж, ингэж манай Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо ажиллаж чадсан гэж дүгнэдэг. ТАЗ-ийн тайлан мэдээнд ч энэ талаар тодорхой дурдагдсан байдаг. Тэгтэл бол тэнд бусад байгууллагуудад яагаад Ёс зүйн зөвлөлүүд байгуулагдаж чадахгүй байна гэхээр зэрэг 25 албан хаагчаас дээш албан хаагчидтай, ажилчидтай ийм байгууллагууд гээд I заачихсан босго байсан. Үүнийг яаж авч үзэж байгаа вэ гэж.

Нөгөө талынх нь юм бол бид энэ хууль дээр Ёс зүйн хороо байгуулна. Ёс зүйн хороог бол ТАЗ-д нэмэгдэл орон тоо, элдвийн төсөв, зардал шаардахгүйгээр байгуулъя, тэгэхдээ ажиллах бололцоо нөхцөлийг нь хангая. Тэнд үнэхээр итгэл заасан, шударга ийм зарчмаар ханддаг энэ ёс зүйн хороог байгуулж ажиллуулъя гэж байсан. Энэ зарчим маань хэвээрээ байна уу. Эсвэл дунд нь хуваарилаад нааш цааш нь болгочихсон ийм зүйлүүд байна уу. Энэ дээр тодорхой I хариулт өгөөч ээ гэж ийм асуултууд байна.

Сүүлд нь би 40 секундэд багтаагаад хэлэхэд ер нь бол Монголчууд 90 он, 92 онд ардчилсан Үндсэн хуулиа баталсан, түүндээ тунхаглаад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон бүтээнэ ээ гээд. Гэтэл бол энэ хүмүүнлэг талаасаа их алдагдсан. Боловсролын систем тэр чигээрээ энэ хүмүүжил, хүний хөгжлийн асуудал, төлөвшилтэй холбоотой юмыг огт анхаарч үзэхгүйгээр

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үндсэндээ 30 жил явлаа. Энэ суурь шалтгаан чинь өнөөдрийн үр дагавар бий болж гарч ирээд байгаа юмны суурь шалтгаан шүү. Тийм учраас бол ингээд талын үер шиг ингээд нэлэнхийдээ ингээд суларчихсан үер авчихсан юм шиг ороод ирсэн үед бол бид бүх түвшинд нь ажиллах хэрэгтэй байгаа юм. Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хууль, Их Хурал ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн хариулъя. 2691 байхаа, Ёс зүйн зөвлөл ажиллаж байгаа.

**Б.Баттөмөр:** Сая Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулахад бол тийм ээ, тийм. Занданшатар даргын хувьд бол үүнийг бол удирдаж бол үндсэндээ хийсэн, чиглүүлсэн. Энэ дээр бол их олон саналуудыг гаргаж ирсэн. Энэ ингээд их олон өөрчлөлтүүд анхны өргөн барьсан төсөл дээр бол нэмэгдсэн. Ийм ажлууд хийгдсэн.

Таны ярьж байгаа ер нь бол хөгжил гэдэг бол хүний хөгжил гэдэгтэй санал 1 байгаа. Хөгжил ингээд яриад ирэхээр зэрэг хүний ёс зүйн асуудал, хүний ёс суртахууны асуудал ингээд яригдаад явж байгаа юм л даа. Сингапурын Ерөнхийлөгч Сингапурын шинэчлэн удирдагч Ли Хуаны 1 хэлсэн үг байгаа шүү дээ. Сингапурыг орчин үеийн энэ Сингапурыг бид нар байгуулахад бол амаргүй замыг туулсан, эдийн засгийг нь сэргээж чадсан, гэхдээ одоог хүртэл бас 1 шийдэж чадаагүй асуудал энэ хүний ухамсрын доройтлыг бид хүртэл шийдэж чадаагүй байна гээд. Энэ бол өнөөдөр Сингапурын хөгжилд өнөөдөр саад болж байна гэж ингэж ярьсан. Тэгэхээр бид бол өнгөрсөн энэ 30 жилийн хугацаанд ерөөсөө хүний ёс зүй, ёс суртахууны холбогдолтой асуудал дээр ерөөсөө тийм дорвитой тийм эрх зүйн баримт бичгээ бол гаргаагүй байдаг юм л даа. Тэгээд энэ бол энэ хууль маань Төрийн албаны хууль, Авлигатай тэмцэх хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах хууль гээд энэ хуулиудтайгаа

уялдаад ингээд цаашидаа хэрэгжээд ингээд явах ийм хууль болох юм гэдгийг бол хэлэхийг хүсэж байна аа.

Энэ ТАЗ дээр бол тэр хороог нь байгуулахаар шийдэж байгаа юм. Үүнийг байгуулсан нь энэ ТАЗ дээр байгуулах учир шалтгаан юу байна гэхээр зэрэг төрийн албаныхаа хуультай бол энэ ёс зүйн хууль маань бол нягт уялдаж явах ёстой гэдэг утгаар 1 дүгээрт, 2 дугаарт, ТАЗ-ийн гишүүд маань энэ Ёс зүйн хорооны гишүүн байна гэж. Ингэснээрээ бол ажлын уялдаа холбоо сайжирна, 1 дүгээрт, 2 дугаарт, зардал хэмнэгдэнэ. 3 дугаарт, төрийн албаны хуулийн хүрээнд хийдэг тэр статистик мэдээллүүд бол энэ ёс зүйн хуультайгаа уялдаж ингэж гарна гэсэн утгаар ингэж бид нар хийсэн юм гэдгийг хэлэхийг хүсэж байгаа юм.

Манай ажлын хэсгийн гишүүдээс бас нэмж хариулж болно.

**Г.Занданшатар:** 80 Алтанзул доктор, профессор хариулъя.

**А.Алтанзул:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тэр 25-аас доош албан хаагчтай байгууллага бол өмнө нь бол Ёс зүйн зөвлөл, Ёс зүйн хороо, дэд хороо байгуулах боломжгүй байсан. Одоо манай энэ хуулиар тухайн байгууллага төрийн байгууллага байгаа бол 25-наас доош байна уу, дээш байна уу үл хамааран бид нар Ёс зүйн дэд хороо байгуулахыг нь энэ хуулиар дэмжиж байгаа. Тэгэхээр бид нар энэ хуулийн гол зорилго маань нөгөө ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх институцийг бий болгож байгаа учраас тэр байгууллагын дотор тэр албан хаагчдынхаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд заавал нэгж зохицуулалт байх ёстой гэж үзсэн. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Энэ Баатарзориг дарга тэр тоог ахиад 1 хэлчих. 1000 гаруй ёс зүйн зөвлөл ажиллаж байсан, одоо 2691 билүү болсон, 567 сайн дураар.

82 *Баатарзоригт. Тэгээд Ба Бат-Эрдэнэ дарга гишүүн, сайд.*

**Б.Баатарзориг:** Хоёрдмол утгагүйгээр шууд хэлье ээ. Яг өнгөрсөн 23 оны 01 сарын 01-ний байдлаар 4232 төрийн байгууллагад 2961 Ёс зүйн хороо ажиллаж байгаа. 25-аас дээш ажилтантай байгууллагад 250 ёс зүйн зөвлөл буюу дэд хороо шинээр байгуулагдсан. Саяын яриад байгаа 25-аас доош төрийн албан хаагчтай байгууллагад байгуулагдах хязгаарлалт байсан боловч мэргэжил сонирхлынхоо байгууллагын онцлогтой хамаараад 567 байгууллага шинээр байгуулсан. Ийм учраас энэ харилцаа байгаа учраас ёс зүй сахилга хариуцлагын энэ хуулиар ер нь бүх 4232 төрийн байгууллагад тухайлсан тухайлсан Ёс зүйн дэд хороо ажиллах нь зүйтэй юм байна. Мэргэжил, мэргэжлийн онцлогтой ийм харилцааг зохицуулж байгаа учраас хөндлөнгөөс тухайн байдал дээр тохирсон зүйлийг хөндлөнгийн хүмүүс шийдвэрлэх нь учир дутагдалтай байна.

1 сум дээр гэхэд эмнэлгийн асуудлыг сургуулийн захиралтай нийлсэн хороо шийдчих гээд байдаг, нөхцөл байдал өөр байдаг. Ийм учраас мэргэжлийн холбоотой нь уялдуулж энэ ажил явагдаж байгаа. Ер нь өнгөрсөн жил бол 21 онд 2177 ёс зүйн хороотойгоор ажиллаж байсан, яг одоо 2961 дэд хороо ажиллаж байгаа, одоо 4232 болгоно. Ийм байна.

**Г.Занданшатар:** 4232 төрийн байгууллага байгаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулж асууна.

**Б.Бат-Эрдэнэ:** Би түрүүн цаг багтаагүй учраас би үргэлжлүүлээд хэлье. Тэгэхээр зэрэг хүний хөгжлийн суурь гэдэг талаас нь л их анхаарч үзэх хэрэгтэй. Сая Баттөмөр дарга их тодорхой хэллээ шүү дээ. Сингапурын жишээн дээр. Эдийн засгийн асуудлыг бол шийдэж болдог юм байна. Хүний

хөгжлийн асуудал, хүний үзэл ухамсар, хандлагыг өөрчилнө гэдэг бол хамгийн том асуудал байна гэж. Үүнийг нь харамсалтай нь сүүлийн 30 жил бол зүгээр тэр чигт нь хаячихсан. Тийм учраас бид нар энэ батлах гэж байгаа энэ анхдагч суурь хуулийг батална. Үүнтэй зэрэгцүүлээд бид нар хүмүүнлэг боловсролын хуулийг бид нар санаачлаад өргөн барьчихсан, хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн. Энэ хууль дээрээ онцгой анхаарах хэрэгтэй.

Манай боловсролын байгууллага бол ингээд хүмүүнлэг боловсролын асуудлыг бол манай яам хариуцдаг гэсэн болов чиг яг л тунхаглалын шинж чанартай 30 жил явсан. Ингээд энэ үр дагавар нь ямар гарч ирж байна вэ гэхээр зэрэг өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа энэ хүндэрсэн, тулгамдсан асуудал болоод байгаа шүү.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Алтанзул доктор чинь бас тэр Хүмүүнлэгийн боловсролын хууль дээр ажилла уу? Үгүй, Нарангэрэл академич ажилласан. Ер нь Удирдлагын академи дээр ийм сургалтын хөтөлбөр гаргах хэрэгтэй юм байна лээ. Тэгээд хүмүүнлэгийн боловсролын хууль, насан туршийн боловсрол гээд тэндээ оруулаад төрийн албан хаагчдыг ажил мэргэжлийн ёс зүйнүүдийг заадаг тийм.

89. Туулын Сувдмаа ЗГХЭГ-ын хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч. Тэгээд төрийн албанд тавих шаардлагаа тэндээ дурдаж болно. Тэгэхдээ зарим нь бол яах вэ төрийн албаны хуульд байгаа юмыг ийшээ төрийн албаны хууль дээр нийтлэг шаардлага тавина уу гэхээс биш түүнийгээ яах вэ дурдчих л даа. Сувдмаа хариул.

**Т.Сувдмаа:** Дэлхий нийтэд болохоор энэ ёс суртахууны хүмүүжил, төлөвшил бол гэр бүл, боловсрол, хамт олон тэгээд нийгмийн түвшинд ингээд явагдаж байгаа. Үндсэндээ нэг 2 хандлага байгаа. 1 нь бол нөгөө соён гэгээрүүлэх

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

чиглэлийн үйл ажиллагаанууд. Энэ бол зөөлөн хандлага нь. Хатуу хандлага нь болохоор энэ хяналт шалгалтын ийм арга хэмжээнүүд бол 2 чиглэлээр явагдаж байгаа. Тэгээд Бат-Эрдэнэ даргын хэлж байгаа нь бол энэ 6-гийн 1-ийн 1 гээд энэ нөгөө хүнлэг, энэрэнгүй байх гэсэн энэ философийн гол зарчим байдаг. Энэ бол ёс суртахуунд тавигддаг гол зарчим байгаа. Тэгээд хамгийн гол нь энэ ер нь бол энэ дэд хороо, хороонд бол заавал төрийн албан хаагч гэхээсээ энэ мэргэ ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** 89. Сувдмаа гүйцээж хариулъя.

**Т.Сувдмаа:** Тэгээд энэ Ёс зүйн хорооноос бол бас яг эрхлэх хүрээнийх нь асуудлын хүрээнд болохоор энэ ёс суртахууныг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэхээр энэ хуулийн төслийн 9 дээр заасан байгаа, 9 дүгээр зүйлд заасан байгаа. Тэр нөгөө хүмүүнлэг иргэний боловсролыг олгох чиглэлээр бол нэлээн их үйл ажиллагаануудыг хийж байж одоо төрийн албан хаагчийг ч гэсэн цаашид нь насан туршидаа мэргэжил боловсролоо дээшлүүлдэг ийм тогтолцоог бол бүрдүүлэх шаардлагатай байгаа.

**Г.Занданшатар:** Сувдмаа энэ ёс суртахуун гэдэг 2 үг ёс суртахуун гэдэг бол мораль, ёс зүй гэдэг бол этик шүү дээ, тийм ээ. Этик бол мэргэжлийн ёс зүй төрийн албаны ёс зүй, эмчийн ёс зүй, багшийн ёс зүй, инженерийн ёс зүй гээд ингээд ийм тусдаа сабжект субьектүүд байгаа юм. Тэгэхээр энэ ёс суртахуун гэж бас ярихаараа мораль бол арай өөр болоод явчихна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо дэмжсэн, Төрийн байгууллагын хороо дэмжсэн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 2-ын 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 2-ын 1 Энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Санал гаргасан УИХ-ын гишүүн Баагаагийн Баттөмөр, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Баттөмөрийн Энхбаяр, Нямаагийн Энхболд цаашидаа ажлын хэсэг гэж тодорхойлно. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад гишүүд бэлэн байна уу. Бэлэн байдлаа хангаад санал хураалт явуулъя.

28 гишүүн дэмжиж, 59.6%-ийн саналаар санал дэмжигдлээ.

2. төслийн 3 дугаар зүйлийн 3-ын 1 дэх хэсэгт Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн хууль гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Өөр гишүүн байна уу. Алга байна.

Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Яг энэ асуудлаар биш, нөгөө яг өнөөдөр ТАЗ дээр шалгаруулалттай холбоотой асуудлаар 1 үг хэлэх гэсэн юм. Тэгэхээр ...

**Г.Занданшатар:** Үгүй ээ, үгүй энэ асуудлыг дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ шүү дээ тэгээд.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр төрийн албанд ажилд орсон залуучууд хар



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

багаасаа яг тэр төрийн албандаа мэргэшиээд, тэгээд түүнчлэн өөрийгөө илүү боловсруулахын тулд Удирдлагын Академид 4 жилээр сурч төгсөөд, магистраа хамгаалаад, тэгээд тэр салбартаа мерит зарчмаар өсөж дэвшихийн тулд өөрийгөө хөгжүүлээд ингээд явдаг. Тэгээд үүнийг хөгжүүлээд өөрөө бас ингээд 1 мэргэжилтэн байж байгаад ахлах мэргэжилтэн, тэгээд хэлтсийн дарга, дараа нь газрын дарга больё гээд ингээд явж байгаа тэр хүмүүсийн өмнүүр ямар журам гаргаж ирж, цүнх баригч нарыг урдуур нь довтолгоож байна гэхээр ТАЗ-ийн байна уу, энэ ЗГ-ын 1 журмаар заавал төрийн албаны шалгалтад ороход нь тэр 3 сарын курст суусан байх ёстой гэдэг шаардлага тавиад. Тэгээд түүгээрээ нөгөө 1 эрх баригчдын цүнх баригчдыг урдуураа оруулдаг. Гэтэл бүхэл бүтэн 4 жил сураад магистрыг нь хамгаалчихсан хүнийг болох дээр заавал дахиад тэр нөгөө нэг 3 сарын курст сурга гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? Тэр мерит зарчмаар өсөж байгаа тэр хүмүүсийг бүхэл бүтэн 4 жил сурчихсан тэр мэдлэгийг нь үгүйсгэж байгаа юм уу. 3 сарын тэр курс чинь нэр төдий зүйл шүү дээ. Зүгээр л өнөөдрийн юу байдаг юм, 1 сонгуульд явсан, аль эсвэл хамаатан садан олонтой, тэр хүнийгээ төрийн албанд оруулахын тулд 3 сарын курст суулгасан болоод л тэгээд л тэр олон жил тэр өөрийнхөө тэр хийж байгаа мэргэжил, ажил дээрээ амжилт гаргаж байгаа тэр хүн ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулъя, санал хураалт явуулъя. Чи хэлэлцэх асуудал яриагүй, сонгуулийн хуультай холбоотой үгийг чи хэлэх ёстой байсан юм.

64.4%-ийн саналаар санал. Чамайг Сонгуулийн хууль дээрээ наад үгээ ярь аа гэсэн. Чи Сонгуулийн хуулийн талаар ярьсан. Сонгуулийн хууль өнөөдөр 2-уулаа хэлэлцэгдэхээр байгаа. 2 хууль байгаа. Түүн дээр нь үгээ хэлнэ ээ.

3. төслийн 4 дүгээр зүйлийн 4-ийн 2, 4-ийн 3 дахь хэсгийг хасах санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт, санал хураалт.

62.2%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Ер нь ёс зүйн зөрчилд байна шүү дээ согтуугаар машин жолоодох ч гэсэн хамаарна шүү. Бүр гэмт хэргийн шинж чанартайб

4 дүгээр заалт. Төсөлд доор дурдсан агуулгатай 4-ийн 4 дэх хэсэг нэмэх. 4-ийн 4 Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 3, 4-ийн 1-ийн 4, 4-ийн 1-ийн 5, 4-ийн 1-ийн 7, 4-ийн 1-ийн 9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Пүрэвдорж гишүүн ээ, чуулган үймүүлэхгүй байхыг хүсье ээ.

29 гишүүн дэмжиж, 63%-ийн саналаар санал дэмжигдлээ.

5. төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. 5-ын 1-ийн 1 Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ гэж төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлагыг, 5-ын 1-ийн 2 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг, 5-ын 1-ийн 3 төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага гэж энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Манай Пүрэвдорж гишүүн сайхан дуулдаг юм. Дуулсан дуундаа өөрөө уяраад гэдэг шиг өөр лүүгээ мессеж явуулчаад тэгээд.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

6. төслийн 2 дугаар бүлгийн гарчгийг төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Одоо 20 байна. Тийм, энэ чинь 29 саналтай байсан 7 нь явж байна шүү дээ.

67.4%-ийн саналаар санал дэмжигдлээ.

7. Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах 6 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим. 6-гийн 1 төрийн албан хаагч нь төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7-гийн 1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална. 6-гийн 1-ийн 1 Хүнлэг энэрэнгүй байх, 6-гийн 1-ийн 2 Үнэнч шударга байх, 6-гийн 1-ийн 3 Хариуцлагатай байх, 6-гийн 1-ийн 4 Манлайлах, 6-гийн 1-ийн 5 хамтач байх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63%-ийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төслийн 7 дугаар зүйлийн 7-гийн 1-ийн 6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 7-гийн 1-ийн 6-г хасах дээр Содномын Чинзориг гишүүн үг хэллээ. Үг хэлнэ.

**С.Чинзориг:** Би саяын уг нь тэр 7 дугаар 7 дахь зарчмын зөрөөтэй санал буюу тэр 6 дугаар зүйл дээр уг нь үг авъя гэсэн, дарга үг өгсөнгүй. Тэр ёс зүйн зарчмыг баримтална гээд 5 зарчим бичсэн байх юм. Ажлын хэсэг. Цаашидаа анхаарах ёстой юм. Тэр 6-гийн 1-ийн 5 дээр хамтач байх зарчим гээд ороод ирчихсэн байна л даа. Өмнө нь бол хууль дээр ийм хамтач байх зарчим гэж 1 их яригддаггүй л байсан юм. Хамтач байх зарчим гэдгийг юу гэж бол ойлгох юм. Би бол ойлгохдоо харин төрийн албан хаагч бол багаар ажиллах чадавхтай байх асуудлыг л уг нь

яримаар байгаа юм. Тэгээд уг нь бол энэ хамтач байх гэдэг нь ямар оновчтой вэ гэвэл би миний би бол хэрвээ боломжтой бол цаашидаа үүнийг анхаарах, эсвэл тэгэхдээ хамтач байх биш багаар ажиллах чадавхтай байх гэдэг асуудал байвал уг нь илүү л оновчтой юм шиг санагдаад байгаа юм бэ дээ. Үүнийг бас ажлын хэсэг бас 1 анхаараач гэсэн ийм санал.

**Г.Занданшатар:** Тийм, шинэ нэр томъёо гарсан юм уу? Дэмжиж, 95. Тодорхой хариулъя.

Сайн байцаана уу. Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. МУИС-ийн багш Оюунгэрэл хариулъя. Энэ

**Г.Занданшатар:** Хариулт биш ээ, зүгээр чи тодотгол хэлчих, тайлбар хэлчих.

**Д.Оюунгэрэл:** Тодотгол. Тэгэхээр энэ ёс суртахууны мэдлэг боловсрол энэ хэм хэмжээ зарчмууд бол үеийн харилцааг зохицуулахаас гадна ирээдүй үеийн харилцааг зохицуулж байдаг. Тэгэхээр ...

**Г.Занданшатар:** үгүй ээ, үгүй хамтач байх гэдгийг л тодорхой хариулчих

**Д.Оюунгэрэл:** Хамтач байх зарчим гэдэг бол тэр Чинзориг гишүүний хэлээд байгаа тэр багаар ажиллах гэсэн санааг бол агуулж байгаа, агуулж байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бол нөгөө философийн нэр томъёонд багаар ажиллах гэдэг нэр томъёо бол хамтач байх гэдэг агуулгаар томъёологдож ирсэн байдаг учраас бид нар яг тэр онолын хэллэгт томъёологддог тэр нэр томъёогоор нь оруулсан байгаа юм.

**Г.Занданшатар:** Хууль ойлгомжтой байх ёстой л доо. Хэрэглэсэн тэгээд энэ найруулга дээр тэр багаар ажиллах чадвар гэнэ үү, нэр томъёо дээрээ эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай гээд. Чинзориг гишүүн.

*Ингээд санал хураалт явъя.*

8. төслийн 7 дугаар зүйл нь 7-гийн 1-ийн 6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэг бол доор нь тайлбар хийх хэрэгтэй.

9. Төслийн 7 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 7-гийн 1-ийн 8-аас 7-гийн 1-ийн 11 дэх заалт, 7-гийн 2, 7-гийн 3 дахь хэсгийг тус тус нэмэх. 7-гийн 1-ийн 8 Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, 7-гийн 1-ийн 9 Байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих. Улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй олон нийтэд үлгэр жишээ манлайлал үзүүлэх, 7-гийн 1-ийн 10 Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх, 7-гийн 1-ийн 11 багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах, 7-гийн 2 төрийн албаны тухай хуулийн 10-ын 1-ийн 1, 10-ын 1-ийн 3-д заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 4, 4-ийн 1-ийн 7, 4-ийн 1-ийн 9-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтооно. 7-гийн 3 төрийн албаны тухай хуулийн 10-ын 1-ийн 2, 10-ын 1-ийн 4-д заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 3, 4-ийн 1-ийн 5-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн ЗГ тогтооно. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

65.3%-ийн саналаар санал дэмжигдлээ.

10. Төслийн 8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: 8 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага. 8-ын 1 Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7-гийн 1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8-ын 1, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ. 8-ын 1-ийн 1 иргэний хүсэлтэд анхааралтай хандаж хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх, 8-ын 1-ийн 2 эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах, 8-ын 1-ийн 3 Бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх. Хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй, ёс бус үг хэллэг хэрэглэхгүй байх, 8-ын 1-ийн 4 Бусдын ажил хэргийн санал бодлыг үл хүндэтгэх, мушгин гуйвуулахгүй байх худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх, 8-ын 1-ийн 5 бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх, 8-ын 1-ийн 6 албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, 8-ын 1-ийн 7 албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, 8-ын 2 төрийн албан хаагчид энэ хуулийн 7-гийн 1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дүгээр зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан хориглолт хязгаарлалтаас гадна дараах үйл ажиллагааг хориглоно. 8-ын 2-ын 1 төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг үйлдлээрээ эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах, 8-ын 2-ын 2 удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ажиллагаанд татан оролцуулах оролцох санал тавих, 8-ын 2-ын 3 Хүний эмзэг болон хувийн мэдээллийг бусдад дамжуулах, гутаах, 8-ын 2-ын 4 Албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах, 8-ын 2-ын 5 Үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох үйлдэл хийх, 8-ын 2-ын 6 соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах, 8-ын 2-ын 7 Албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх, 8-ын 2-ын 8 албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Ням-Осорын Учрал гишүүнээр тасаллаа.

**Н.Учрал:** Энэ анхны энэ хуулийн төслийн хэлэлцүүлэг хийж байхад би бас саналаа хэлж байсан. Ер нь хаана явахаа тодорхой болгохгүйгээр, яаж явахаа ярих нь өөрөө зохимжгүй л дээ. Тэгэхээр өнөөдөр бол төрийн албаны ер нь энэ реинженеринг яаж хийх вэ гэдгийг ийм цаг үе байна шүү дээ. Гэтэл энэ төрийн албаныхаа үндсэн концепц хуулийг өөрчлөхгүйгээр ингээд 1 төрийн албан хаагчийн ёс зүйг хуульчлаад эхлэхээр цаашидаа ер нь хаашаа очих вэ. Нийтлэг баахан шалгуур тавьчихлаа. Одоо энэ төрийн албан хаагчид нийтлэг шаардлага тавьчихсан. Тэгээд ийм аливаа зүйл ингээд ерөнхий байгаад эхлэхээр үүний чинь цаана хэлмэгдүүлэлт болдог л доо. Түрүүн энэ Чинзориг сайдын хэлээд байгаа бас үнэн шүү дээ. Тэр хамтач байдал, чи хамтач биш байна аа, ганцаараа явж байна гэж хэлээд цаана нь хүн хэлмэгдээд байгаа байхгүй юу. Тэгээд ерөнхий байх тусам ажил хийх боломжгүй болно.

Нийтлэг шаардлагууд ингэх тавих тусам ТАЗ ажил хийх боломж болоцоо байхгүй болно шүү. Тийм учраас наад 8 дугаар зүйл дээр чинь жишээ нь бусдын

ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэнэ гэж ер нь юу гэсэн үг юм? Чи үл хүндэтгэсэн гэж хэлээд л шаардлага зөрчлөө гээд л эхлэх үү? Бусдын өөрийгөө хөгжүүлэх мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд хясан боогдуулсан гэж энэ чинь хуулийн үг мөн юм уу? Тэгэхээр ингээд 1 хууль биш 1 ийм тангаргийн ёс зүйн уриалгын шинжтэй юмыг хуульчилчихдаг. Үүний чинь цаана зарим хүнийг хэлмэгдүүлнэ ээ. Өнөөдөр төрд ажиллах хүнгүй боллоо шүү дээ. Төрд ажиллах, 1 ийм олон нийтлэг шаардлага, ёс зүй хэрэггүй шүү дээ. Авч байгаа цалин нийгмийн баталгаа ийм. Тэгээд хэсэг бүлэг нөгөө ашиг сонирхлын зөрчилтэй зарим тэр нөхдөөс болоод төрийн алба бүхэлдээ хулгайч юм шиг ойлгогдчихсон. Энэ чинь төрийн төлөө өдөр шөнөгүй бас зүтгэж байгаа энгийн төрийн албан хаагч залуучууд зөндөө байна шүү дээ. Тэгэхээр нийтлэгээр нь ингээд нийгэм даяараа төрийн албан хаагч нар бүгдээрээ болохоо больчихсон юм шиг ойлгуулчихна лээ. Тэгээд реинженеринг хийх асуудлыг ярих байтал дахиад хувцас хунартаа анхаар гээд. Эрх бүхий байгууллагаас юу гэлээ, эрх бүхий байгууллагаас олгосон хувцсыг өмсөнө ч гэх шиг. Ингээд сүүлдээ энэ чинь төрд ер нь хэн ажиллах вэ? Төрийн байгууллага болгон эрх бүхий байгууллага гээд 1 хувцас хунар хүртэл заагаад, тэгээд сүүлдээ авч байгаа цалин нь ямар билээ. Тэгээд 1 тангаргаа өргөөд угаасаа л төрд тангаргаа өргөж байгаа шүү дээ, наадах чинь тангаргаараа л зохицоод л явчих асуудал байна шүү дээ.

Тэгээд ёс зүйг, нийтлэг шаардлагыг ингээд 1 хуульчилчихсан. Тэгээд төрийн албаны шалгалт дээрээ л тэр орчин үед яригдаад тэр тэр компьютер, цогц чадамжийн шалгалтыг нь аваад л төслийг нь боловсруулаад л авчих л даа. Тэгээд өнөөдөр тэр мэдлэг чадвар хандлагын үнэлдэг тогтолцоонд дэлхий нийт шилжсэн тэр хандлагыг мэдлэг чадварыг үнэлээд л цогц чадамжтай хүн эсэхийг нь шалгалтаараа л аваад л ингээд л явчих л асуудал шүү дээ.

Бид нар цаг алдаад л өнөөдөр энд 1 ийм ёс зүй хуульчлаад л тэгээд энд чинь бүгдээрээ 1 их ёс зүйтэй хүн ч хэд нь байгаа юм, мэдэхгүй л юм байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулна. Тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараад. Тэгэхдээ Учрал гишүүн түрүүн хэлэлцүүлгийн үед байхгүй, асуулт хариултаар энэ асуудал яригдаад үүнийг чинь Ёс зүйн зөвлөл байгууллагын удирдлага биш, Ёс зүйн зөвлөл ажилтнууд өөрсдийгөө хамгаалах зорилгоор тавих энэ тэр гээд ярьсан л даа. Тэр эрх бүхий байгууллагын хувцаслалтын стандарт гэдэг бол хувцасны код гэдэг бол тэр ажлын байрны хувцасны контакт тухайн байгууллага гарах юм бол түүнийгээ мөрдөнө л гэсэн утгатай юм байна.

Ингээд санал хураалт явъя. 57.1%-ийн саналаар санал дэмжигдлээ.

11. Төсөл дор дурдсан агуулгатай 3 дугаар бүлэг нэмэх: 3 дугаар бүлэг. төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа. 9 дүгээр зүйл. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа. 9-ийн 1 Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10-ын 1-д заасан эрх бүхий этгээд албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. 9-ийн 1-ийн 1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн учир шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах, 9-ийн 1-ийн 2 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх, 9-ийн 1-ийн 3 Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах, 9-ийн 1-ийн 4 Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаал дэвшүүлэх, шагнал урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах, 9-ийн 1-ийн 5 иргэд байгууллага олон нийтийг мэдээллээр хангах арга зүйн зөвлөгөө өгөх.

Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

58.3%-ийн саналаар санал дэмжигдлээ.

12. төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 10 дугаар зүйл болгох. 10 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий этгээд. 10-ын 1 төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ. 10-ын 2 ЗГ нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлаар Ёс зүйн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ, 10-ын 3 Ёс зүйн хороо /цаашид хороо гэх/, Ёс зүйн дэд хороо /цаашид дэд хороо гэх/ хороо нь бие даасан хараат бус зарчмаар ажиллана, 10-ын 4 хороо дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хороо хуралдааны дэгээ өөрөө тогтоож болно. 10-ын 5 хороо, дэд хорооны шийдвэр дүгнэлт хэлбэртэй байна. Шийдвэрт хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга нарын гарын үсгийг зурснаар хүчин төгөлдөр болно. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болголоо. Санал хураалт. Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ. Тэгээд дараа нь санал хураалт хүчингүй, санал хураалт. Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ.

**С.Чинзориг:** Үгүй ээ, тэгээд ЗГ-ын гишүүн үг хэлж энэ дээр л хэлэх үү? Өөр газар хэлж болно, энэ 1 сонин заалт ороод ирчихсэн байх юм даа. Гишүүд юу гэж үзэх юм, энэ ажлын хэсэг. Энэ санал хурааж байгаа 12 дахь заалт байна шүү дээ. Ёс зүйн дэд хороотой холбоотой асуудал. Тэгээд ЗГ чинь өөрөө Ёс зүйн дэд хорооны үүрэг гүйцэтгэх гэж байгаа юм



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

уу, ингэж болохгүй шүү дээ. 10-ын 2 дээр ЗГ нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах ажилтны албан тушаалтны ёс зүйн асуудлын талаар Ёс зүйн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ ээ гээд. ЗГ чинь өөрөө Ёс зүйн дэд хорооны үүрэг гүйцэтгэнэ гэж юу байх юм бэ. Энэ ямар юм заалт ийм юм ороод ирж байгаа юм. Ингэж байж болохгүй байх. Ёс зүйн дэд хороо гэж байвал улсын хэмжээний 1 Ёс зүйн дэд хороотой болох гэж байгаа юм уу. Би бол Ёс зүйн дэд хороо байвал салбар салбар дээрээ л Ёс зүйн дэд хороо байх ёстой л байх. Үгүй бол ТАЗ-ийн дэргэд тийм Ёс зүйн хороо байдаг юм уу. Тэгээд энэ дараагийн 12 дахь заалтыг чинь харахаар энэ Ёс зүйн дэд хороо чинь төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд гээд ингээд ороод ирсэн байх юм. Наад 10-ынхаа 2-ыг та нар хар л даа. ЗГ өөрөө ёс зүйн дэд хорооны чиг үүргийг гүйцэтгэхээр ороод ирлээ шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ. Энэ юу руу яваад байгаа юм. Тэгээд энэ Ёс зүйн дэд хороо чинь ТАЗ-ийн төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллана гээд ингэж болохгүй шүү дээ. Тэр Ёс зүйн дэд хороонууд байх юм бол тэр салбар салбартаа байдаг л юм байгаа биз. Улсын хэмжээний 1 ёс зүйн дэд хороо болох гэж байгаа юм уу. Наад заалтаа та бүхэн сайн хар даа, юу гэж ойлгодог юм, би лав ойлгохгүй байна.

ЗГ нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлаар талаар Ёс зүйн дэд хорооны чиг үүрэг гүйцэтгэнэ ээ гээд. Одоо тухайлбал томилж байгаа албан тушаалтнууд байх юм уу? Төрийн нарийн агентлагийн дарга нарын ёстой холбоотой ёс зүйтэй холбоотой асуудлыг ЗГ хариуцахаар тэгээд дараагийн асуудлыг чинь дараагийн асуудлыг чинь болохоор төрийн албаны энэ ёс зүйн дэд хороо чинь төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллана гээд ингэж болохгүй ээ. ЗГ Өөрөө Ёс зүйн дэд хорооны үүргийг гүйцэтгэнэ гэж ийм юм болохгүй шүү дээ. Ийм зарчим байж болохгүй шүү дээ. Тэрийг нь тэр өөр

хариуцдаг юм уу, тэр ТАЗ нь хариуцдаг юм уу, түүнээс ЗГ өөрөө ийм ёс зүйн дэд хорооны чиг үүрэг гүйцэтгээд ингээд оруулж болохгүй.

**Г.Занданшатар:** Дэд хороо дараагийн 12 чинь ерөнхий ёс зүйн хороо нь ТАЗ-ийн дэргэд ажиллана. Ёс зүй сахилга хариуцлагын хорооноос 4 орон тооны бус гишүүний томилолт гээд дараагийнхаа бүгдээр дээр байгаа тэгээд. Тэгээд эцсийн хэлэлцүүлэг ...

Ингээд санал хураана. Баттөмөр гишүүнээс сайн асуучих. Хамт сууж байгаа юм чинь.

54.2%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн заалт. 13. төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 11 дүгээр зүйл болгох. 11 дүгээр зүйл. Хороо түүний бүрэн эрх. 11-ийн 1 хороо нь төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна. 11-ийн 2 хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. 11-ийн 3 хороо нь ТАЗ-ийн гишүүд орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. 11-ийн 4 Энэ хуулийн 11-ийн 3-д заасан орон тооны бус 4 гишүүнийг УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо томилж чөлөөлнө. Нээлттэй сонсголоор гэж байна шүү гэж нэммээр юм байна. Энэ чинь одоо хорооны үйл ажиллагааны дүрэм, орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг УИХ-ын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороо батална. 11-ийн 6 хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй: 11-ийн 6-гийн 1 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих. 11-ийн 6-гийн 2 хуульд өөрөөр заагаагүй бол дэд хороо томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх



арга зүйн удирдлагаар хангах. 11-ийн 6-гийн 3 төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга хөдөлмөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийцсэн удирдлагаар хангах, зохион байгуулах. 11-ийн 6-гийн 4 Энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах. 11-ийн 6-гийн 5 Энэ хуулийн 15-ын 1-ийн 5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх. 11-ийн 6-гийн 6 томилох эрх бүхий этгээдээс ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих. 11-ийн 6-гийн 7 дэд хорооны ажиллах журмыг батлах. 11-ийн 6-гийн 8 төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил түүнд хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж мөрдүүлэх. 11-ийн 6-гийн 9 бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага аж ахуйн нэгж албан тушаалтнаас гаргуулан авах. 11-ийн 6-гийн 10 Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг зөрчсөн талаар нэгдсэн тайлан гаргах. 11-ийн 6-гийн 11 Хууль тогтоомжид заасан бусад. 11-ийн 7 Энэ хуулийн 7-гийн 2, 7-гийн 3-д заасан Ёс зүйн хэм хэмжээг тогтоосон хууль, тогтоомж, дүрмийн төсөлд хорооны саналыг авна. 11-ийн 8 хорооны гишүүн хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр, байгууллага ААН иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгөө болон эхнэр, нөхөр, гэр бүл, садан төрлийн бусад гишүүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээс татгалзах үүрэгтэй. Санал гаргасан ажлын хэсэг, санал гаргасан ажлын хэсэг. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлэн тасаллаа.

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхээр ийм байгаа юм дарга аа. Энэ дээр санал нийлэхгүй байгаа юм. Энэ Ёс зүйн хороо байх ёстой гэдэг санал 1 байна. Гэхдээ Ёс зүйн хороо ТАЗ-ийн дэргэд хэрхэвч байж болохгүй. ТАЗ чинь 2 чиг үүрэгтэй байгууллага байхгүй юу.

1 дүгээрт нь, төрийн албаны хуулийнхаа хэрэгжилтийг хянах, тэрний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага байхгүй юу. Өөрөөр хэлбэл хууль бус томилгоо ч юм уу.

2 дахь чиг үүрэг нь бүх сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэгтэй байхгүй юу. Ийм л 2 чиг үүрэгтэй байгууллага. Ёс зүйн хариуцлагын асуудал чинь ажил олгогч буюу ЗГ-ын чиг үүрэг байхгүй юу. Өөрөөр хэлбэл, ажилд томилох, гүйцэтгэлд нь хяналт тавих, сайн ажиллуулах менежментийн асуудлууд, ёс зүй, сахилга хариуцлагын асуудал чинь энэ дотроо багтаж явах ёстой байхгүй юу. Тийм учраас энэ зөвлөл чинь ЗГ-ын хэрэг эрхлэх дээр байх ёстой. Би өргөөгүй.

Яамдын сайд нар бүгдээрээ дэргэдээ Ёс зүйн зөвлөлтэй байх ёстой. Тэгээд тэд нар нь нэгдэж нөгөө энэ менежер, хүний нөөцийн менежер буюу ЗГ дээр байх ёстой байхгүй юу. Хүний нөөцийн менежерийн үүргийг ТАЗ гүйцэтгэхгүй байх байхгүй юу. Тэгээд манайх энэ хүний албаны, төрийн албаны хүний нөөцийн менежер чинь ЗГ байхгүй юу. ТАЗ-ийн чиг үүргээ би сая тодорхой хэлж байлаа 2 чиг үүрэгтэй, хөндлөнгийн агуулгатай байгууллага байхгүй юу наадах чинь. Өөрөөр хэлбэл ЗГ-ын сонгон шалгаруулалтын ажлыг хөндлөнгөөс нь зохион байгуулж байгаа байгууллага байхгүй юу. Тэгээд энэ 2-ын чиг үүрэг нэгдэж болохгүй учраас би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Ёс зүй сахилгын хариуцлагын энэ хороо чинь ЗГ дээр байх ёстой шүү. Хүний нөөцийн менежментийн асуудал ЗГ дээр байх ёстой. Тийм учраас үүнийг хэрэг эрхлэх дээр юм уу ЗГ-ын чиг үүрэг дээр хийж

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

өгөх ёстой гэдэг ийм саналтай байгаа юм. Үүнийг дараагийн хэлэлцүүлэг дээр манай ажлын хэсэг эцсийн хэлэлцүүлэг дээр үүнийг яриарай.

Чиг үүргийн хувьд бол болж байна, бүрэн эрх, чиг үүргийн хувьд нь бол. Харьяаллын хувьд нь бол 1 ийм саналтай байна.

**Г.Занданшатар:** Хариулт байхгүй байна. Дараагийн хэлэлцүүлэгт эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай. Тэгэхдээ Тогтохсүрэн дарга аа, таны ажлын хэсгээр ахалсан нөгөө төрийн албаны тухай хууль дээр чинь ТАЗ-ийн дэргэд байна гээд хуульчилчихсан шүү дээ. Энэ чинь процессжуулж л байгаа болохоос биш Үндсэн хууль нь ТАЗ дээр байгаа биз дээ тийм ээ. Ёс зүйн хороо чинь. Төрийн албаны хуулиараа.

Санал хураалт явуулъя. Санал хураалт.

60.9%-ийн саналаар санал дэмжигдлээ.

14. Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 12 дугаар зүйл болгох. 12 дугаар зүйл. Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх. 12-ын 1 Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй. 12-ын 1-ийн 1 Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. 12-ын 1-ийн 2 хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах. 12-ын 1-ийн 3 Дэд хорооны үйл ажиллагаа гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх. 12-ын 1-ийн 4 Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Хороо, дэд хороонд гаргаж өгөх. 12-ын 1-ийн 5 дэд хорооны дүгнэлтэд үндэслэж зөрчил гаргасан

этгээдэд зөрчлийн шинж байдал нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол хариуцлага хүлээлгэх. 12-ын 1-ийн 6 ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж Хороонд тайлагнах. 12-ын 1-ийн 7 дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах. 12-ын 1-ийн 8 хуульд заасан бусад. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

58.7%-ийн саналаар санал дэмжигдлээ.

15. төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 13 дугаар зүйл болгох. 13 дугаар зүйл. Дэд хорооны бүрэн эрх. 13-ын 1 дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно. 13-ын 2 Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг дэд хорооны гишүүнээр 5 жилийн хугацаагаар сонгоно. 13-ын 3 Дэд хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй. 13-ын 3-ын 1 Энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах. 13-ын 3-ын 2 Энэ хуулийн 15-ын 1-ийн 5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх. 13-ын 3-ын 3 харьяа байгууллага бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх. 13-ын 3-ын 4 хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах. 13-ын 3-ын 5 ёс зүйн зөрчил ажлын тайлан мэдээг гаргаж, хороонд хүргүүлэх. 13-ын 3-ын 6 бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага ААН, албан тушаалтнаас гаргуулан авах. 13-ын 7 хуульд заасан бусад. 13-ын 4 дэд хорооны гишүүн дараах баталгаагаар хангуулна. 13-ын 4-ийн 1 гишүүнээр

ажилласны төлөө урамшуулал авах. 13-ын 4-ийн 2 хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх. 13-ын 4-ийн 3 шийдвэрийн улмаас бусдын дарамт шахалтад өртөхөөс хамгаалуулах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

61.4%-ийн саналаар санал дэмжигдлээ.

16. төслийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 14 дүгээр зүйл болгох. 14 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол мэдээлэл гаргах. 14-ийн 1 хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол мэдээллийг энэ хуулийн 14-ийн 3-д заасан харьяаллын дагуу хороо эсхүл дэд хороонд гаргана. 14-ийн 2 гомдол мэдээлэлд албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна. 14-ийн 3 төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гарсан гомдол, мэдээллийг дараах харьяаллын дагуу шалгаж шийдвэрлэнэ. 14-ийн 3-ын 1 дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьяалах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны, 14-ийн 3-ын 2 ЗГ нь аймаг НЗД-аас бусад бүх шатны Засаг дарга эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан болон Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 3, 4-ийн 1-ийн 5, 4-ийн 1-ийн 9-д заасан этгээдийн. 14-ийн 3-ын 3 хороо нь төрийн өндөр түүнтэй адилтгах албан тушаалтан болон энэ хуулийн 14-ийн 3-ын 1, 14-ийн 3-ын 2-т зааснаас бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан Авлигын эсрэг хуулийн 4-ийн 1-ийн 4-д заасан этгээдийн, 14-ийн 4 хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хянан үзэж шаардлагатай тохиолдолд санал,

дүгнэлтээ УИХ-д танилцуулна. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

59.1%-ийн саналаар санал дэмжигдлээ.

17. төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 15 дугаар зүйл болгох. 15 дугаар зүйл. Гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх. 15-ын 1 Энэ хуулийн 14-ийн 3-д заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгах ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ. 15-ын 1-ийн 1 гомдол мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр эсхүл цахим шуудангаар тайлбар авах. Шаардлагатай тохиолдолд тухайн албан хаагчийг дуудан ирүүлж, тодруулга, мэдээлэл авах. 15-ын 1-ийн 2 Шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар тодруулга түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтнаас мэдээ баримтыг гаргуулан авах. 15-ын 1-ийн 3 шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах. 15-ын 1-ийн 4 цугларсан мэдээ баримтад дүн шинжилгээ хийх. 15-ын 1-ийн 5 Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг тогтоон дүгнэлт гаргах үндэслэлийг тусгах. 15-ын 2 дүгнэлтийг дараах этгээдэд баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа эсвэл биечлэн гардуулснаар дараах этгээдэд мэдэгдсэнд тооцно. 15-ын 2-ын 1 Гомдол мэдээлэл гаргасан этгээд. 15-ын 2-ын 2 зөрчилд холбогдсон төрийн албан хаагч. 15-ын 2-ын 3 Томилох эрх бүхий албан тушаалтан байгууллага. 15-ын 3 ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага эрх бүхий албан тушаалтанд илжжүүлнэ. 15-ын 4 гомдол мэдээллийг хүлээн авснаас хойш 30

хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол 14 хүртэл хоногоор 1 удаа сунгаж болно. 15-ын 5 иргэний гомдол мэдээлэл гаргахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна. 15-ын 6 дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол мэдээлэл гаргасан этгээд түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын дэд хороонд гомдол гаргаж болно. 15-ын 7 Энэ хуулийн 15-ын 6-д заасан эрх бүхий этгээд гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж дараах шийдвэрийн аль 1-ийг гаргана. 15-ын 7-гийн 1 дүгнэлтийг хэвээр үлдээх. 15-ын 7-гийн 2 дүгнэлтийг хүчингүй болгох. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56.8%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Өчигдөр та 2 чинь хэрэлдээд л байсан, өнөөдөр учиргүй сүжрээд л явж байгаа. ЗГ-ын хуралдаан дээр би сонсож байсан.

18. төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16 дугаар зүйл болгох. 16 дугаар зүйл. Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх. 16-гийн 1 хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8-ын 1, 8-ын 2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хороо, дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль 1-ийг ноогдуулна. 16-гийн 1-ийн 1 Гомдол гаргагчид эс үгүй бол олон нийтийн өмнө уучлал гуйхыг үүрэг болгох. 16-гийн 1-ийн 2 Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах. 16-гийн 1-ийн 3 Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах. 16-гийн 1-ийн 4 Төрийн албанаас халах. 16-гийн 2 Төрийн өндөр түүнтэй адилтгах албан

тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эргүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ. 16-гийн 3 Энэ хуулийн 8-ын 1, 8-ын 2-т заасан төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, 8-ын 1 дэх хэсэг, 10 дугаар зүйл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасныг зөрчсөн бол тухайн хуульд заасан хариуцлага хүлээнэ. 16-гийн 4 төрийн албан хаагчид энэ хуульд заасны дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. 16-гийн 5 ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй. 16-гийн 6 төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш 1 жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно. Санал гаргасан ажлын хэсэг.

Учрал гишүүн.

**Н.Учрал:** Энэ төрийн албан хаагч нар ёс зүйтэй байх, энэ нийтлэг хариуцлагыг оновчтой болгоё гэдэг энэ санаачилгыг бол бас дэмжиж байгаа. Гэхдээ ийм ерөнхий шаардлагууд чинь өөрөө ийм хэлмэгдүүлэлт үүсгэх гээд байдаг. Өнөөдөр төрд сайн мэргэжилтэн олж авч ажиллуулах үнэхээр хүнд болсон. Тэгээд төрд ажиллах сонирхол багассан. Ингээд л нэмээд л ийм нийтлэг шаардлагууд тавиад л байх юм бол төрд ер нь хүн олдох уу даа, цаашидаа. Бид нар сая хүрэхгүй цалин өгчхөөд л, тэгээд бас энэ төрийн төлөө өглөөнөөс үдшийн бүрий хүртэл зүтгэж байгаа хэдэн залуучуудыг, хэдэн мэргэжилтнүүдийгээ яаж энэ улс орныхоо төлөө зүтгээч гэж авч үлдэх юм гэдэг бол маш их чухал болчихоод байна шүү дээ. Тэгэхээр жишээ нь би өмнө нь саналаа бас хэлэх гээд байсан. Тэр 14 дүгээр зүйл дээр, тэр 15



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дугаар зүйл гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх.

Тэгээд одоо хар л даа, шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулна гэж байгаа юм. Шаардлагатай тохиолдолд шинжээч томилно гэж байгаа юм. Эсэхийг нь төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг нь тогтоож дүгнэлт гаргана гэж байгаа юм. Ингээд ёс зүйн хариуцлага хүлээлгэх асуудал дээр 4 тийм хариуцлага байгаа юм байна л даа. Энд олон нийтийн өмнө уучлалт гуй гэж байгаа юм. Юу гэсэн үг юм. Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануул гэж байгаа юм. Үгүй ээ, юу гэсэн үг юм? Байгууллага албан хаагчдын өмнө нээлттэй сануул, энэ тэр гээд ийм хариуцлагууд явчихаар чинь нөгөө түрүүний заасан байгаа 15 нийтлэг шаардлагыг чинь зөрчсөн хүн болгоныг ингээд сануулаад эхлэх юм уу? Тэгээд чи хамтач биш байсан байна, олон нийтийн өмнө уучлах уу? Хүн чинь дотроо тэр интернэл, экстернэл гээд 2 төрлийн хүн байна шүү дээ. Хамтач биш ээ чи гэж үзэх юм уу? Чи хувцас хунараа муухай өмсчихсөн байна. Эрх бүхий албан тушаалтны тавьсан хувцсыг өмссөнгүй ээ чи гэх юм уу. Тэгээд хясан боогдууллаа чи гэх юм уу? Ингээд чи олон нийтийн өмнө уучлал гуй гээд, ийм хариуцлага тооцоод сууж байх юм уу. Энэ чинь ТАЗ чинь хийх ажилгүй болох нь байна шүү дээ, сүүлдээ. Өдөр тутам хэдэн мянган гомдол ирээд л, тэгээд л 1 дэд хороо нь хуралдаад л, тэгээд л чи уучлал гуйгаарай, чи тэгээрэй гээд л ингээд л байж байдаг болох юм уу? Ажил үүргээ ер нь цаашидаа энэ чинь авч явж чадах юм уу? Ийм их, энэ чинь 1 хүн нөгөө хүндээ субъектив байдлаар дургүй байгаа тохиолдолд л гомдол өгнө. Та нар гомдлыг хянан шийдвэрлээд л сууна. Тэгээд л сүүлдээ наад гомдлын чинь ихэнх хариуцлага нь олон нийтийн өмнө уучлал гуй. Тэгээд 1, 1-ээр нь уулзаад сануулах юм уу, чи дахиж ингэхгүй шүү гээд. Тэгэхээр ёс зүй бол мэдээж чухал аа. Хэн ч үгүйсгээгүй. Гэхдээ ёс зүйн хариуцлагын асуудал бол тэр Солонгост ч гэсэн тэр хүний нөөцийн бодлого бол боловсролын салбарт анхан

шатнаас сурч байхад нь тэр ёс зүйн хариуцлагыг зүрх сэтгэлд нь шингээж өгдөг болохоос биш нэгэнт биш нэгэнт ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Баттөмөр гишүүнээс бас тайлбар сонсоорой. Тэгэхдээ энэ манайхан бас 1 одоо байгаа процессоо сайн мэддэггүй юм шиг байна. Төрийн албанд ажиллаж байгаагүй бид нар болохоор. Одоо ТАЗ төрийн албаны ёс зүйн зөвлөл энэ тэр ажиллаад 567 ёс зүйн зөрчил гаргаад энэ сахилга, хариуцлага, шийдвэр гаргадаг одоо явж байгаа процесс шүү дээ. Үүнийг л нарийвчилж ингэж хуульчилж байгаа болохоос биш ёс зүйн зөвлөлүүд 2691 ёс зүйн зөвлөл ажиллаад, архидан согтуурсан ажлын байран дээр гэсэн тэр тодорхой ёс зүйн зөрчлүүдийг гаргаад. Хамтач байх энэ тэр гэдэг чинь нөгөө нийтлэг шаардлага болохоос биш энэ ёс зүйн зөрчил биш шүү дээ. Ёс зүйн зөрчил биш. Тэгээд үүнийгээ хольж ойлгоод байх шиг байна.

Санал хураалт явуулъя. 54.5%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Ер нь бол энэ ТАЗ-ийн тайланг өнгөрсөн 7 хоногт хэлэлцэхэд анхаарсан бол 567 ч билүү ёс зүйн зөрчлийг сахилгын болон янз бүрийн шийтгэлүүд оногдуулаад, түүнээс архидан согтуурахтай холбоотой 151 ажлын байран дээрээ архидан согтуурсан зөрчил тэгээд ажлын байран дээрээ архидан согтуурснаас шалтгаалаад ямар гэмт хэрэг зөрчил гарч байсныг та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ёс зүй чинь гэмт хэргийн учир шалтгаан болдог гээд энэ доктор, профессор Алтанзул хэлсэн бөлгөө түрүүн.

Ингээд 54.5%-ийн саналаар санал дэмжигдсэн.

19 дэх санал. Төслийн 16 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17 дугаар зүйл болгох. 17 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагыг сайн дураар хүлээх.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээх. 17-гийн 1 хороо, дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно. 17-гийн 2 төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно. 17-гийн 2-ын 1 хамт олноос гомдол мэдээлэл гаргагчаас эс үгүй бол олон нийтийн өмнө уучлалт гуйх. 17-гийн 2-ын 2 ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Энэ санал тэнцчихсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Их Хурлын дарга аа, миний кноп битгий тасгаж юу микрофон битгий тасалж байгаарай. Тэгээд би сая буруу кноп дарчихлаа. Тэгээд дахин санал хураалгаж өгөхийг хүсье.

**Г.Занданшатар:** Би ерөөсөө микрофон таслаагүй. Ингээд үүнийг үл харгалзан Бөхчулууны Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар, та бол санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулж өгөөч ээ, буруу гарчихлаа гэж байна шүү дээ, тийм ээ. Ингээд энэ горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

60.5%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд уг саналыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахин явуулъя.

55.8%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ ТАЗ-ийн тайлангаас харахад энэ ингээд ажлын байрны бэлгийн дарамт

үзүүлсэн ч гэдэг юм уу тэгээд уучлалт гуйгаад хүнээс өөрөөс нь уучлалт гуйгаад өнгөрдөг энэ тэр гээд их олон л кэйсүүд байдаг юм гэж ярьж бичдэг.

Ингээд 20. төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19 дүгээр зүйл болгох. 19 дүгээр зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах олон нийтэд мэдээлэх. 19-ийн 1 хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан, төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр үйл ажиллагааны тайланг дараа оны 01 дүгээр сард багтаан хороонд хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна. 19-ийн 2 төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.

Хөөе Чойжилсүрэн гишүүн байж байгаарай.

19-ийн 3 хороо үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд хүргүүлнэ. 19-ийн 4 хороо холбогдох байгууллагаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

57.1%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Дэг сахиулагчид баярлалаа.

21. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд шинээр бүлэг, хэсэг, зүйл, заалт нэмэгдэж, хасагдсантай холбогдуулан төслийн бүтэц, дугаарлалт, найруулгын холбогдох өөрчлөлт оруулах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Энэ протоколд тэмдэглэх юмыг дараа нь яйчъя.

58.1%-ийн саналаар санал дэмжигдлээ.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн энэ санал хураалтууд дууссантай холбоотой протоколд тэмдэглэх санал хэлэх гэж байна. Тийм ээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ХЗБХ-ны дарга үг хэлнэ.

**Б.Энхбаяр:** Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулиар санал хурааж дуусаж байна. Тэгэхээр энэ маань бол суурь ёс зүйн шаардлагуудыг тавьсан нийтлэг харилцааг зохицуулсан ийм хууль болж байгаа. Тухай тухайн тодорхой төрийн албан хаагчдын тавигдаж байгаа ёс зүйн шаардлага болон хариуцлагын асуудал бол бас тус тусынхаа хуулиар нэн тодорхой байдлаар зохицуулагдана.

Тэгэхээр хуульд өөрөөр заагаагүй бол гэдэг нөхцөлүүд нь тодорхой албан тушаалтнуудын тухайд бол нарийвчилж зохицуулсан хуулиа барина шүү гэдгийг бас тэмдэглэж хэлэх гэж байгаа юм.

Тухайлбал шүүгчид хариуцлага ноогдуулах асуудал зөвхөн шүүхийн хуульд заасан үндэслэлээр л хариуцлага тооцогдоно гэдгийг шүүхийн хуульд нь хэлчихсэн байгаа. Зөвхөн шүүгчид нээлттэй болон хаалттай сануулах, цалинг нь хасах, огцруулах шийтгэлийг ямар ямар зөрчлүүд дээр ялгамжтай хэрэглэх вэ гэдэг үндэслэлийг бол тэр шүүхийн хуульд нь зааж өгсөн байгаа.

Тийм учраас ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө өөрөө хүлээн зөвшөөрч байгаа учраас чөлөөлөгдөх гэдэг. Жишээлбэл энэ хуульд тогтоогдож байгаа хэм хэмжээ бол шүүхийн хууль дээр очихоороо тэгж ялгамжтай байдлаар хэрэгжих учиртай. Тэгэхгүйгээр шүүгчийг өөрөө өргөдлөө өгөө. Өөрөө чөлөөлөгдөх хүсэлтээ гарга аа гэдэг ийм шахалтууд жишээлбэл байж энэ хуулийг хэрэглэж Шүүхийн сахилгын хорооноос бол гарч болохгүй. Ийм бол

онцлогууд байгаа гэдгийг хууль хэрэглээний явцад анхаарах учиртай.

Мөн энэ шаардлагууд тодорхой албан тушаалтнуудын хувьд бол онцлог, онцлог байдлаар хэрэглэгдэх учиртай шүү. Жишээлбэл, төрийн улс төрийн албан тушаалтны хувьд буюу сонгуульт албан тушаалтны хувьд бол тэр Үндсэн хуульд заасан тэр үндэслэлээр л хариуцлага нь яригдана. Төрийн захиргааны болон тусгай албан хаагчийн хувьд бол төрийн албанд заасан хуульд заасан тэр хүрээнд саяын өөрийн хүсэлтээрээ ажлаас чөлөөлөгдөх гэдэг шаардлага хэрэглэгдэх учиртай. Тэгэхгүй сонгуульт албан тушаалтны тухайд ийм үндэслэлээр хуулийн хариуцлага ноогдуулах асуудал бол ялгамжтай байдлаар бас хэрэглэх учиртай шүү гэдгийг бас протоколд тэмдэглүүлж байна.

**Г.Занданшатар:** 16 дугаар зүйл дээр хүлээлгэх ёс зүйн хариуцлагын асуудал дээр нөгөө холбогдох хуулиудаар зохицуулах, төрийн өндөр албан тушаалтан Төрийн албаны хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албаны ашиг сонирхлын хууль, нөгөө холбогдох хууль, Шүүхийн хууль энэ тэрээ тусдаа зохицуулагдахаар заасан. Ер нь энэ нөгөө бас энэ хууль дээрээ эцсийн хэлэлцүүлэгтээ анхаарах юм нь Баттөмөр гишүүн ээ. Энэ нөгөө эмчийн ёс зүй гээд байдаг, нөгөө эрүүл мэндийн мэс заслаас авхуулаад тусдаа хуульчийн ёс зүй, шүүгчийн ёс зүй, багшийн ёс зүй гээд тусдаа нөгөө мэргэжлийн ёс зүйгээр зохицуулагддаг асуудлуудыг бол сая хэллээ шүү дээ. Тийм ээ. Тэгээд шүүгчийн ёс зүй байна. Тэр хуулиудыг нь тодотгоод бас дурдчихвал зүгээр юм байна.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар санал хураалт явуулна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ажлын хэсгээс гаргасан санал хураалт. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо дэмжсэн санал.

1. төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 1 төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56.8%-ийн саналаар.

Ер нь Шүүхийн ёс зүйн хороо гэж байгаад тусдаа зохицуулагддаг байсан. Үүнийг нөгөө Шүүхийн сахилгын хороо гэж байгуулаад тусдаа зохицуулалттай болчихсон юм байна.

2. төслийн 3 дугаар зүйлийн 37-гийн 1-ийн 12 гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 1 төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

54.5%-ийн саналаар санал дэмжигдлээ.

3. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 1. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

52.3%-ийн саналаар санал дэмжигдлээ.

4. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 1. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

56.8%-ийн саналаар санал дэмжигдлээ.

5. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төсөл

1. Төсөлд дор дурдсан агуулгатай 2 дахь дэд заалт нэмэх. 2. Авлигын эсрэг хуульд ХОМ-ээс гадна зарлагыг мэдүүлж байх талаар санал боловсруулж холбогдох хуульд тусгах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан УИХ-д өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт явуулна.

Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Би түрүүн саналаа хэлсэн. Энэ ЗГ-аас энэ авлигатай тэмцэх жил болгож зарлаад шилэн ажиллагааг бас хариуцаж байгаа. Тэгэхээр төрийн үйл ажиллагаа өөрөө энэ 24/7 алган дээр тавьсан юм шиг нээлттэй байгаа юм бол хэн ч нийгэмд хардалт сэрдэлт сургаар асуудалд хандахгүй байхгүй юу. Бүгдийг нь л ил болгочихъё. Тэгэхээр сургаар биш судалгаатай, хардаж биш харж асуудлыг шийддэг болгохын тулд өнөөдөр энэ мэдээллүүдийг ил тод болгоё л гээд байгаа юм. Тэгэхээр түрүүний тэр энэ авлигын хуультай холбогдуулаад өмнөх бас 19 дүгээр зүйл дээр би бас саналаа хэлмээр байсан юм.

Энэ Ёс зүйн зөвлөл, Ёс зүйн дэд хороо шийдвэр гаргахдаа Ёс зүйн хорооны гишүүд юу гэж тухайн хүнийг үнэлсэн бэ гэдэг протоколыг ил болгох ёстой. Тэгэхгүй цаана үүний цаана дандаа ашиг сонирхол яваад байгаа. Үүний цаана дандаа хэлмэгдүүлэлт яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүний цаана хэн нэгэн дарга нь, өөрийнхөө доор ажиллаж байгаа ямар нэгэн албан тушаалтанд дургүй, нөгөө хясан боогдуулсан гээд нөгөө 1 нийтлэг шаардлагуудаар чинь хэн нэгнийг хэлмэгдүүлчихвэл тэр Ёс зүйн хороо нь тухайн Ёс зүйн хорооны гишүүн юу гэж хэлсэн бэ гэдэг протоколыг ил болгох ёстой юм. Тийм учраас түрүүний

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тэр 19 дүгээр зүйл дээр үүнийг бас ажлын хэсэг анхаараач.

2-т, энэ Авлигын хууль дээрээ Авлигын эсрэг хуульд ХОМ-ээс гадна зарлагыг мэдүүлж байх талаар санал боловсруулах дээрээ ч юм уу, энэ ёс зүйн зөвлөлийн гишүүдийн протоколыг ил болгохыг үүрэг болгожчооч ээ.

2-т, энэ АТГ чинь ерөнхийдөө ТАЗ-ийн ажлыг давхар шахуу бас хийдэг болчихлоо гээд хүмүүс шүүмжлээд байна шүү дээ. Тухайн хүн ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг биш тухайн хүн тухайн албан тушаалд нийцэж байгаа эсэхийг АТГ шийдээд байна, 2 ТАЗ-тэй юм шиг байна гээд төрийн албан хаагч нар юм яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг ямар албан тушаалтан энэ орлого, зарлагынхаа мэдээллийг дуулгах юм бэ гэдгийг нь тодорхой зааж өгөхгүй бол ингээд л бүхэлдээд бараг л ахлахаас авхуулаад хэн хэн байдаг юм? Тэгээд бүгдээрээ орлого, зарлагаа мэдүүлээд эхлэх юм бол наадах чинь бүр төрд ер нь ч дээ ажиллах хүн олдох уу даа? Байгаа хэдийгээ яаж авч үлдэх вэ? Одоо бол нөгөө цалин хөлс, нийгмийн баталгаа нь бага учраас дээрээс нь хэсэг бүлэг нөхдөөс болоод бүгдийг нь хулгайч, дээрэмчин болгочоод байгаа учраас хулгай хийгээгүй төрийн төлөө зүтгэж байгаа хүмүүс хэлмэгдээд, нөгөө 1 төрийн албан хаагч нар чинь бид нарт шаардлага, дарамт хангалттай байна. Бид нарыг яаж дэмжих юм бэ гээд байна шүү дээ. Тэгэхээр цомхон чадварлаг төрийн албатай болохын тулд нөгөө байгаа хэдийгээ яаж хэдүүлээ бас авч үлдэх вэ, байгаа хэдийгээ яаж дэмжих вэ гэдэг бодлого руугаа ороод энэ реинженеринг рүүгээ, төрийн албаны шинэчлэл рүүгээ хурдан оръё. Ёс зүй хуулиас зэрэгцүүлээд тэр төрийн албаны хуулиа оруулж ирээч ээ.

**Г.Занданшатар:** Санал хураалтаа явуулъя. Одоо 1:30 болж байна.

Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ шүү дээ, тийм ээ. Сая дэмжээгүй үг хэллээ. Дэмжсэн үг 1 хэлж болно. Ингээд Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

**Н.Энхболд:** Тэгээд энэ бол хэлэлцэх явцад дагалдаж гарч болох хуулиуд, тогтоолын төслийн талаар бас ажлын хэсэг дээр нэлээд их ярилцсан юм. Жишээ нь Энхбаяр гишүүн санал гаргаж байсан, бид нар ажлын хэсэг дээрээ ярьж байгаа үүнийг бол яг энэ хуультай хамт биш бусад яг холбогдох хуультай нь хамт гаргасан нь зөв байна гээд орхиж байсан. Яг энэ заалт дээр ч гэсэн бас тийм байгаа. Уг нь энэ ёс зүй гэхээсээ илүү нөгөө орлого, зарлагатай холбоотой, тийм ээ, илүү тийм бараг гэмт хэрэгтэй холбоотой тийм байхгүй юу. Зарлагаа мэдүүлэхгүй байх эсэх тухай асуудал бол яг ёс зүйтэй цэвэр холбогдолтой ч асуудал биш л дээ. Тэгэхээр энэ хуулийг дагуулаад яг ийм заалт оруулах дээр нэлээн эргэлзэж, эргэлзэж л бид нар ямар ч байсан тогтоолын хэсэг дээр нь оруулчихъя. Шууд оруулж байгаа юм биш, хугацаатай үүрэг гэсэн маягаар оруулчихсан юм.

Түүрүүн ярьж байсан зарчмуудаа бариад аливаа хуулийг хэлэлцэхэд дагалдаж орох өөрчлөлтүүд, бусад хууль, тогтоолд орох өөрчлөлтүүд үндсэн тэр яригдаж байгаа хуулийнхаа үзэл баримтлалын хэмжээнд байх нь зүйтэй гэдэг агуулгаар хэд хэдэн зүйлийг тухай тухайн үед нь ярина гээд орхисон. Түүнтэй адилхан л зүйл энд байгаа юм. Тэгээд манай гишүүд мэднэ биз дээ. Би уг нь өөрөө ажлын хэсэгт орчихсон мөртөө яг ийм хэлээд сууж байгаа нь 1 их зохимжтой биш байна. Тэгэхдээ яг ажлын хэсэг дээр яригдаж байсан. Нэлээн эргэлзээтэй байсан зүйл шүү. Аль асуудлыг дагуулж, юу оруулах вэ гэдэг дээр бид нар цаашидаа 1 зарчим юм барьж явж байхгүй бол болохгүй байна гэсэн ийм. Тэгэхгүй бол шүүмжлэл гарч байсан. Одоо ЗГ-аас юм уу, УИХ-ын гишүүдээс ямар нэгэн хууль оруулахдаа тэрийг дагуулаад бараг анзаарагдахгүй шахуу



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

заримтай тийм зүйлүүдийг, тэгэхдээ зарчмын нэлээд том ач холбогдолтой зүйлүүдийг яг үзэл баримтлалаасаа гажууд юмнууд оруулж ирэх асуудлууд сүүлийн үед гараад байна гэсэн ийм шүүмжлэлүүд байсан учраас би үүнийг өнөөдөр зүгээр хэлж байгаа юм. Тэгээд гишүүд өөрснөө мэднэ биз дээ?

Ер нь хэрэгтэй. Зарлагын тухай асуудал бол байнга яригдаж байгаа. Тэгэхдээ үүнийг дагаж орох нь зөв үү, буруу юу гэдэг дээр л асуудал байгаа.

**Г.Занданшатар:** Адьшаа гишүүн. Дэмжсэн дэмжээгүй 2 үг хэлчихлээ. Та дэмжсэн дэмжээгүйгээ л хэлнэ. Энэ заалт дээр.

**Ш.Адьяа:** Энэ төрийн албаны ёс зүйн асуудал, энэ хөрөнгө орлоготой тухай асуудал ер нь энэ төрийн албаны ёс зүйн тухай хуулийг бол би дэмжиж байгаа юм. Гэхдээ энэ арай хэтэрч байна. Энэ чинь өөрөө дээр үед бид нар кинон дээр зохиол дээр гардаг шиг юм болж байна шүү дээ. Орлогоо мэдүүлж болно, орлого бол. Үгүй ээ энэ зарлагаа яахаараа мэдүүлдэг юм. Нэг таваг хоол идсэн гэх юм уу, таксигаар явсан гэх юм уу ийм хууль та нар боль оо. Энэ чинь арай хэтэрч байна шүү дээ. Нөгөө 1 хувьсгалын жилүүдийн юм шиг л ийм юм ярьж байна шүү дээ. Ийм юмаа өнөөдөр оруулж ирээд, энэ төрийн эрх барих дээд байгууллагад ийм юмыг ярьж байгаа нь бид нар ямар ухамсар байна. Юу бодоод байна аа? Хэнд зориулаад ийм юм яриад байна. Энэ чинь хуультай шүү дээ. Үгүй ээ бид нар өнөөдөр юмаа зарахын тулд, хоол идэх, таксигаар явах, онгоцоор явахын тулд энэ хаанаас зөвшөөрөл авах юм, ТАЗ-өөс авах юм уу, УИХ-аас авах юм уу? Ийм дэндсэн юмаа орж ирж олны доог тохуу болохоо больё. Үүнийг бол би дэмжиж байгаа, төрийн албаны ёс зүйн тухай хуулийн, сахилга хариуцлага. Өнөөдөр энэ Монголын нийгэм замбараагүй байдалд орсон, ёс суртахуунгүй болсон, төрийн алба чинь өнөөдөр төрлийн алба болсон, сахилга

гэж байхгүй, төрийн ажил гэж байхгүй, үүнтэй бид хууль гаргаж ярих ёстой. Үгүй ээ энэ чинь арай л дэндээд байна. Энэ асуудлаа оруулсан хүмүүс татаж ав аа. Бат-Эрдэнэ аварга аа. Тийм, энэ чинь арай болмооргүй байна.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Тэгэхдээ ер нь энэ албан тушаалтнуудын орлогыг хянахаас гадна зарлага хэрэглээг хянах шаардлагатай байна гэсэн ийм саналыг төрийн бус байгууллагуудаас, АТГ-аас зохион байгуулсан энэ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн болон бусад хэлэлцүүлгийн үеэр төрийн бус байгууллагуудаас их тавьсан. Үүнийг төрийн бус байгууллагууд, манай гишүүд ч тавьж санал асуулгад оруулж хэлэлцүүлээд дэмжлэг авсан ийм заалт юм байна лээ. Тэгэхээр нөгөө зарлага хэрэглээг хянах шаардлагатай байна гэсэн ийм агуулгаар. Тэгээд мэдээж тэр нь ингээд хоол идсэн уусан ч гэдэг зарлага хянахгүй байх л даа. Одоо байр, байшин авсан юу гэдэг юм, тэр зарлага чинь нэгдсэн дүнгээрээ л хянагдах. Хуульд тэгж тусгая гэсэн тийм агуулгаар ийм санал гарсан юм байна гэж ойлгож байгаа.

Ингээд санал хураалт явуулъя. Тэгэхдээ яг энэ тийм утгатай заалт байна шүү дээ үүнийг оруулж ир ээ гэсэн заалт. Авлигын эсрэг хуульд хөрөнгө орлогыг мэдүүлэхээс гадна зарлагыг мэдүүлж байх талаар санал боловсруулж, холбогдох хуульд тусгах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-ын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан УИХ-д өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Ажлын хэсэг саналаа тайлбарлачихсан.

Адьяа гишүүн ээ, санал хураалт явуулна шүү. Санал хураалт.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Энэ санал дэмжигдсэнгүй. Горимын санал гаргах хүн байна уу? Ирц байна л даа. 42 гишүүн. Яах вэ, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэлэлцэх үе дээр үүнийг бас ахиж хэлэлцэнэ, дэлгэрэнгүй хэлэлцэнэ.

Ингээд энэ санал дэмжигдсэнгүй.

Ингээд зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Үдээс өмнөх хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул ингээд үдийн завсарлага. 14 цагаас.

Ингээд зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга харцуцлагын байнгын хороонд шилжүүлж байна.

13.40 цаг

## **ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.**

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших хуралдаан эхэлж байна. Ингээд дараагийн асуудалдаа оръё, хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Н.Энхболд:** Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Доржханд, Мөнхбаатар, Тогтохсүрэн

болон миний бие Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 оны 04 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Энэ урт хугацааны хөгжлийн бодлогын эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана гэсэн зорилт 5.1-ийн хүрээнд 1 дүгээр үе шат буюу 2021-2030 оны хооронд төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлэх, тодруулбал Улсын Их Хурлын сонгуулийг холимог системээр явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх нэн тодорхой зорилт дэвшүүлсэн байгаа.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д нам, Үндсэн хуулийн 16-дугаар зүйлийн 10-д заасны дагуу байгуулагдаж улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж намын бодлого, үйл ажиллагааны үндсэн хүрээг тодорхойлсон. Энэхүү үндсэн хэмжээний хувьд улс төрийн нам улсын хэмжээний бодлого, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дэвшүүлж сонгуульд өрсөлдөх, сонгуулийн тойрог дагасан улсын төсвийн нэгдмэл бус байдлыг арилгах боломжтой сонгуулийн тогтолцооны хувилбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх үндэс болж байгаа юм.

Ийм учраас сонгуулийн тогтолцооноос үүдэн гарсан Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг арилгах, төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлэх, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог мажоритар болон пропорциональ хосолсон тогтолцоогоор явуулах эрх зүйн үндсийг

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, түүнчлэн Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах зэргээр Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг эргэн харж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай байна гэж үзсэн болно.

Төслийг боловсруулахдаа Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас 2020, 2021 оны сонгуулиудыг ажиглаад өгсөн зарим зөвлөмж, Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын саналыг мөн авсан. Хуулийн төслийг Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны суурь өөрчлөлт, хуулиар зохицуулах харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлах, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагад үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд:

1 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас тус тус сонгох сонгуулийн хосолсон тогтолцоо байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, саналын хуудсыг хэвлүүлэх, сонгогч санал өгөх, түүнийг тоолох, дүн гаргах, суудал хуваарилах, гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй байх, боломжтой байх. Улс төрийн намын бүртгэл өөрчлөлттэй холбоотойгоор нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх, үйл

ажиллагаатай холбоотойгоор гардаг хүндрэл, эрх зүйн тодорхой байдлуудыг арилгах, Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, уг үйл ажиллагаа нь төрийн байгууллага болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг харилцааг нарийвчилсан зохицуулалтуудыг,

2 дугаарт, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын байнгын төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулах, байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын бүтэц, бүрэн эрх, ажиллах журам, гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох харьцааг нарийвчилсан зохицуулалтуудыг,

3 дугаарт, улс төрийн намын бүртгэл өөрчлөлттэй холбоотойгоор нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх, үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг хүндрэл, эрх зүйн тодорхой байдлуудыг арилгах талаарх нарийвчилсан зохицуулалтуудыг,

4-т, сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх. Уг үйл ажиллагаа нь төрийн байгууллага болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээрх зохицуулалтуудыг,

5-д, санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжоор бүрэн хангагдаж чаддаггүй сонгогчид болох оюутан, ээлжийн ажил хийдэг зэрэг сонгогчдын сонгох эрхийг хангах

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

шаардлагад үндэслэн урьдчилсан санал авах ажиллагааны талаарх зохицуулалт болон бусад зохицуулалтуудыг тусгалаа.

Энэ хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хуралд суудалтай 3 намын төлөөлөл, тэдний зүгээс гарсан саналууд, ажлын хэсгийн саналууд, хуралдааны дүгнэлтүүд, мөн хууль боловсруулахаас өмнө олон шатанд явагдсан эрдэмтэд, судлаачид, улс төрчид, тэдний санал бодол, мөн сүүлийн хоёр, гурван Улсын Их Хурал дамжин гарч байгаа ялангуяа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор яригдаж байсан асуудлуудын дунд сонгуулийн тогтолцоог хөндөх, өөрчлөх, боловсронгуй болгох шаардлагатай байгаа талаар гарч байсан саналуудыг бас тодорхой хэмжээгээр тусгасан.

Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 4 гишүүн 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч одоогийн сонгуулийн тогтолцооноос үүдэлтэй улс төр, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг арилгах, төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог мажоритар болон пропорциональ хосолсон тогтолцоогоор явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, түүнчлэн сонгуулийг зохион байгуулан явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай гэж үзэж уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд Улсын Их Хурлын 38 гишүүнийг хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас тус тус сонгох сонгуулийн хосолсон тогтолцоо байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, саналын хуудсыг хэвлүүлэх, сонгогч санал өгөх, түүнийг тоолох, дүн гаргах, саналын хуудсыг хуваарилах, суудал хуваарилах, гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй байх. Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1-ийг харьцах 1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлэх. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар. Улс төрийн намын бүртгэл өөрчлөлттэй холбоотойгоор нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх, үйл ажиллагаатай холбоотой хүндрэл, эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах, сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, уг үйл ажиллагаанд төрийн байгууллага болон сонгуульд оролцогч

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

талуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын Бямбацогт Улсын Их Хурлын 38 гишүүнийг сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгох зохицуулалт нь оновчтой эсэх, нутаг дэвсгэрийн зарчмыг харгалзан үзсэн эсэх, орон нутгийн төлөөлөл хангалтгүй байгааг хэрхэн хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг Улсын Их Хуралд нийгмийн бүлгүүдийн төлөөллийн оролцоог хангах, гишүүдийн тоо, тойргийн асуудлыг хэрхэн тогтоох, сонгуулийн зардлыг бууруулах зохицуулалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн Улсын Их Хурлын 2022 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх төлөөллийг нэмэгдүүлэх, сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулах асуудлыг судлах ажлын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Занданшатар Сонгуулийн хуулийн тогтвортой байдлыг цаашид хэрхэн хангах, төлөөллийн ардчиллын үндсэн зарчмуудыг хэрхэн хангаж буй талаар, нийгмийн бүлгүүдийн төлөөллийг сонгох, сонгогдох эрхийг хангахад анхаарах, хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтийг тусгасан эсэх, сонгогчдын боловсролыг хэрхэн нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нэр дэвшигчдээс гарах сонгуулийн зардлыг бодитоор бууруулах зохицуулалтыг тусгасан эсэх, ухуулагчийг сайн дураар ажиллуулах, сурталчилгааны материалыг нэгдсэн байдлаар хэвлэх,

түгээх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь хуулийн төслийг боловсруулахдаа улс төрийн намуудын саналыг хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулиар Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулахад тулгамдаж байгаа ямар асуудал байгаа талаар, намын жагсаалтын эрэмбийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулах гишүүдийн тоог нэмэгдүүлэх зохицуулалтыг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн барих эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Баатарбилэг Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог тогтвортой, тодорхой байлгахад анхаарч, ээлжит сонгууль бүрийн өмнө хуулиа өөрчилдөг буруу жишигийг халах, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь Улсын Их Хурлын 38 гишүүнийг сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгох зохицуулалтыг эргэн харах, нутаг дэвсгэрийн төлөөллийн зарчмыг хангах хүрээнд тойргоос сонгогдох гишүүдийн тоог нэмэгдүүлэх, нийгмийн зөвшилцлийг хангах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа улс эх орны эрх ашгийг хангахын тулд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог мажоритар болон пропорциональ хосолсон тогтолцоогоор явуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Занданшатар Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үед сонгуулийн хууль тогтолцооны тогтвортой байдлыг хангах, сонгуулийн зардлыг бууруулах, улс төрийн санхүүжилтийг ил тод болгох, Сонгуулийн ерөнхий хорооны хараат бус байдлыг хангах, төрийн албан хаагчдын эрх зүйн байдал, сонгох, сонгогдох эрхийн баталгааг хангахад ажлын хэсэг анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

гишүүн Доржханд эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх болон бусад нөхцөл байдлын хувьд ч сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлага байгаа тул хуулийн төслийг боловсруулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг намын жагсаалтад хуулийн ямар шаардлага хангасан нэр дэвшигч орох, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зохицуулалтыг нарийвчлан тусгах талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Сарангэрэл гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Пүрвээгийн Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга

Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Сүүлийн хүн нь хэн байна. Адьшаа гишүүнийг оруулаарай. Адьясүрэн гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

**С.Чинзориг:** Сонгуулийн хуультай холбоотой асуудал дээр хоёр, гурван асуулт байна. Энэ илтгэл, хууль санаачлагч Энхболд даргаас. Нэгдүгээрт, бид чинь энэ Үндсэн хуулиараа иргэд өөрийнхөө төлөөллийг шууд сонгоно гэсэн Үндсэн хуулийн заалттай. Тэгэхээр одоо энэ холимог тогтолцоо оруулж ирэхээр энэ иргэдийн Үндсэн хуулиараа төрийн эрх барих онцгой эрхээ төлөөллийн зарчмаа хэрэгжүүлэх энэ төлөөллөө шууд сонгоно гэсэн Үндсэн хуулийн энэ зохицуулалт зөрчигдөх үү, үгүй юу? Та бүхэн үүнийг юу гэж хараад байгаа юм?

Манай хөдөөгийн иргэдтэй уулзахаар манай ялангуяа манай малчид эд нар ярьдаг шүү дээ. Үгүй ээ, бид чинь яадаг юм ядаж нэг дэлгүүрт ороод дээлийн өнгө авахдаа хүртэл нэлээн гараараа барьж үзэж байж, имэрч үзэж байж сонгодог шүү дээ. Тэгээд энэ өөрийгөө төр барих энэ эрхээ төлөөлөгч хүний нэг халуун гарыг нь барьж нэг дотоод сэтгэлийг нь сэтгэл рүү нь өнгийж үзэж байж сонгомоор байна шүү дээ гэдэг юмыг ярьдаг шүү дээ. Тэгээд үүнтэй одоо иргэдийн энэ хүсэлттэй Үндсэн хуулийг шууд сонгоно гэдэг энэ заалттай энэ холимог болгосноороо зөрчилдөхгүй юу гэдэг асуудал.

2 дахь асуудал. Үндсэн хуульд ч ер нь сонгуулийн тогтолцооны асуудал байхгүй л дээ. Шууд сонгоно гэдгийг л бид нар ойлгохдоо пропорциональ, мажоритар гэж ойлгоод л байдаг. Хэрвээ одоо ингээд сонгуулийн тогтолцоог холимог болгох асуудал болж байгаа бол ер нь Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

юм уу эсвэл энэ нээлттэй гэдгийг болгож байгаа учраас болж байгаа гэж ойлгоод байгаа юм уу гэж нэг асуудал.

2 дугаар асуудал энэ мандатын асуудлыг өөрчилж хөж байгаа юм байна. 76-г чинь 38 нь тойргоос, 38 нь жагсаалтаар гээд. Тэгээд Монгол Улсын чинь нэг онцлог байна Энхболд дарга аа. Асар том газар нутагтай, асар олон засаг захиргааны нэгжтэй, 1 метр квадрат метр талбайд оногдох иргэдийн маань нягтрал маш бага, сийрэг. Тэгэхээр тэр зайлиггүй энэ онцлогийг чинь харгалзаад тэр мандатын тоо би бол илүү байх ёстой л гэж боддог. Тэгээд та бүхэн ямар үндэслэлээр ингээд мандатыг 50 нь пропорциональ, 50 нь мажоритарууд оруулаад ирж байгаа юм? Би бодохдоо мажоритар холимог болголоо ч гэсэн энэ пропорциональ тогтолцооны сонгогдох хувь нь арай бага, ядаж нэг 30 хувиас хэтрэхгүй байх ёстой л гэж өөрөө ийм бол итгэл үнэмшилтэй байдаг юм. Үүнийг одоо та бүхэн яаж бодож байна?

3 дахь асуудал нь, иргэдтэй уулзахаар энэ жагсаалтад чинь иргэд их эргэлздэг л дээ. Ямар нөхөр орох нь вэ? Намуудад сонгох, нэр дэвшүүлэх эрх нь байгаа жагсаалтад тэгээд ямар шалгуураар энэ жагсаалтад орох нэр дэвшигчдийг жагсаах вэ гэдэг асуудал тодорхойгүйгээс болоод иргэдийн дунд маш их тийм эргэлзээ бол байгаад байгаа юм. Тэгэхээр үүнийг тэгээд Улс төрийн намын тухай хуулиар тогтоох юм уу эсвэл Сонгуулийн хуулиар оруулах юм уу, ямар шалгуур нөхцөл хангасан хүн энэ намын жагсаалтад орох вэ гэдгийг нэлээн тодорхой болгох тийм боломж байна уу, үгүй юү?

4 дэх асуудал, энэ Сонгуулийн ерөнхий хороо чинь одоо ингээд 10 нам орлоо гэхэд 38 гэдэг чинь 10 нам орлоо гэхэд 380 хүн жагсаалтад бичигдэх нь л дээ. Тэгэхээр энэ чинь нөгөө тийм техникийн нөхцөл боломж нь байгаа юм уу, үгүй юм уу? Хоёрдугаарт, нэг өдөртөө энэ чинь сонгууль маань багтах уу, үгүй

юү гээд бас асар их ийм асуудлууд байна шүү дээ. Энэ бүхнийг та бүхэн яаж тооцсон юм?

Төгсгөлд нь нэг асуудал байнга яригддаг, энэ цахимтай холбоотой асуудал. Цахимаар чинь нэр дэвшигчдийг маш их харлуулдаг, гүтгэдэг, доромжилдог, харлуулдаг. Тэгээд бид нар 2020 оны сонгуульдаа нэлээн өөрчлөлт оруулсан, хариуцлага тооцно л гээд байсан ямар ч үр дүн гараагүй шүү дээ. Фэйсбүүк компанид мэдэгдсэн л гэдэг, Азийн бүсэд мэдэгдсэн л гэдэг, хариу ирээгүй байна гэдэг. Тэгээд хууль хяналтын байгууллагууд нэг нэр дэвшигч нар нөгөө өргөдөл, гомдол гаргадаг, энэ нь одоо тэгээд шийдэгддэггүй хууль хяналтын байгууллагуудад. Тэгэхээр үүнтэй холбоотой асуудал бол энэ удаагийн хуулийн төслөөр хөндөгдөөгүй байна. Цаашидаа үүнийг ер нь та бүхэн яаж шийдье гэж бол бодож байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Хариулт өгсний дараа та тодруулаарай.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн, Л.Энх-Амгалан, Мөнхбаатар нарын урилгаар Хөвсгөл аймгийн Рашаант сумын эрүүл мэндийн төвийн ажилтан, албан хаагчид чуулганы үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Чинзориг гишүүний асуултад хэн хариулах вэ? Хуулийн төсөл санаачлагч Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

**Н.Энхболд:** Хууль хамтарч санаачилсан хүмүүс бас нэмэх зүйлүүд байвал нэмээрэй. Би товчхон хариулаад явъя. Их олон хүн асууж байгаа юм байна. Үндсэн хуульд шууд гэж заасан тэр нь зөвхөн мажоритар тогтолцоогоор байна гэдэг нэг ойлголт, олонхын пропорциональ аль аль нь байж болно гэсэн нэг ойлголт олон жил яригдаж ирсэн. Цэцийн зүгээс хоёр, гурван удаа нааш цаашаа болсон

шийдвэрүүд гарч байсан. Холимог тогтолцоогоор урьд нь 2012 онд сонгууль явсан. Тэр Үндсэн хуулийг бүрэн эрх хэрэгжүүлэх үндэс байна. Хууль ёсны сонгогдсон Их Хурал гэж үзээд үйл ажиллагаагаа явуулсан. Тэр хооронд төрийн зүгээс гарсан бодлогууд бүгдээрээ албан ёсны болоод ингээд явж байгаа. Тэгэхээр энэ маргаантай байсан асуудлууд хамгийн сүүлд гарсан Цэцийн дүгнэлтээр холимог юм уу, пропорциональ тогтолцоогоор сонгууль явуулах нь Үндсэн хууль зөрчсөн зүйл болохгүй ээ гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа. Түүхт хамгийн сүүлийн шийдвэрээр товч дурдахад үүний дагуу ийм хагас нь олонхынхоор, хагас нь хувь тэнцүүлсэн тогтолцоогоор явж байхаар хуулийн төслийг барьсан, 1 дүгээрт.

2 дугаарт, өчигдөр Байнгын хороон дээр гарсан бас олон асуудлуудын нэг нь ерөөсөө газар нутгийн, орон нутгийн төлөөлөл 38 байх нь эрх ашгийг нь хангах хэмжээний хүрэлцээтэй тоо биш ээ гэсэн ийм саналууд гарч байна лээ. Энэ бид нарынх бол яах вэ, үндсэндээ төрийн нэгдсэн том бодлого, газар нутаг, орон нутагтай холбоотой бодлого хормой нь тэнцүү хэмжээтэй явж байж, улс орны хөгжил дэвшил, аюулгүй байдлыг хангах тал дээр бас зохистой харьцаах юм байх юм байна гэж үзэж ийм тоо оруулж байгаа. Хэлэлцүүлгийн явцад гишүүдээс ямар санал гарах юм байгаа, түүний дагуу ярьж байгаа олонхоороо шийдэх байх. Тухайлбал АН-ын бүлгийн зүгээс өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд 28, 48 гэсэн тоо явж байгаа. Энэ хуулийг хэлэлцсэний дараа нь АН-ын өргөн мэдүүлсэн хуулийг бас хэлэлцэнэ. Түүн дээр энэ харьцааны асуудал бас яригдана гэж бодож байгаа.

Жагсаалтын шалгууруудын хувьд бол Сонгуулийн хууль дээр намууд тийм, тийм хүн дэвшүүлнэ гэж бичих нь урьд өмнө ч байгаагүй, одоо ч ер нь зохистой бас асуудал болов уу гэж ингэж үзэж байгаа. Улс төрийн намууд өөрсдийнхөө үүрэг хариуцлага, Үндсэн хуульд бичсэн

тодорхойлолтууд, түүний дагуу хүлээж байгаа үүрэг, нийгэмд ямар хүн дэвшүүлбэл бодлогыг нь хэрэгжүүлэх боломжтой вэ гэдэг талын судалгаа гээд маш олон зүйлүүдийг харгалзаж үзэж байгаад хүмүүсээ дэвшүүлдэг. Энэ эрх нь намын зүгээс байх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа. Түүнээс сонгуулийн хуулиар үүнийг дэвшүүлнэ, тэрийг дэвшүүлнэ, үүнийг болохгүй, тэрийг болохгүй гэж заах нь бүр том утгаараа яривал иргэдийн эвлэлдэн нэгдээд, өөрсдийнхөө саналуудыг чөлөөтэй илэрхийлэх байгууллагынх нь эрхэд халдсан ийм хэрэг болох болов уу. Ер нь ч тийм байдлаар явж ирсэн гэж ингэж үзэж байгаа.

Сонгуулийн ерөнхий хороо тэр сүүлийн 2 асуултад нь хариулчихъя. Дэлгэрнаран дарга амжих уу, их олон хүн болох юм байна, хэдэн өдөр явах вэ, юу гэж тооцож байгаа юм бэ гэдэг дээр.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулъя. 83 дугаар микрофон. Сонгуулийн ерөнхий хорооны дарга хариулъя.

**П.Дэлгэрнаран:** Чинзориг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нар одоо өргөн баригдсан төслөөр одоо манайд бүртгэлтэй 37 нам тэгээд бүгдээрээ хоорондоо эвсэхгүйгээр 37 нам бүгдээрээ бие дааж оролцоод тэгээд бүгдээрээ жагсаалтаар ч бүрэн нэр дэвшүүлээд, мажоритарын мандатад ч бүрэн нэр дэвшүүлээд ингэсэн нөхцөлд ер нь саналын хуудас маань хэр зэрэг том болох нь вэ гэдэг байдлыг бид нар макет хийж үзсэн. Одоо манайд ашиглагдаж байгаа энэ санал тоолох төхөөрөмж хамгийн дээд талын урт нь 22 инч буюу 56 сантиметрийн ийм урттай саналын хуудсыг унших хүчин чадалтай. Тэгэхдээ 2 талаар нь уншиж бас болно. Хуучин бид нар дан мажоритар системээр сонгууль явуулдаг байхдаа нэг талаар нь дандаа уншуулаад сурсан. Ер нь бол өмнөх сонгуулиудад саналын хуудсыг 2 талаар нь уншуулж байсан тохиолдол бол

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байхгүй. Тэгэхээр энэ удаа яг энэ өргөн баригдсан төслийн дагуу тэгээд бүх юунуудыг бол бүх дээд нөхцөлөөр нь дэвшиүүлж байгаа бүх хэмжээг дээд нөхцөлөөр нь ингээд аваад үзэхэд бол ийм 4 нүүр буюу 56 сантиметрийн урттай 2 саналын хуудас бол болж байгаа. Ингээд 38 тойрогт зарим тойрогт 2 нэр дэвшигч, заримд нь 1 болох байх. Тэгээд 38, 38 жагсаалттай ингээд хийхэд ийм 2 талаараа уншигдахаар ийм 2 саналын хуудас бий болж байгаа. Тэгэхдээ яах вэ, техникийн маань үйлдвэрлэгчийн өгсөн хүчин чадал уг нь бол байгаа. Тэгэхдээ энэ урьд нь манайд яг ингэж уншигдаж байсан тохиолдол бол байхгүй. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Нэмж асуух юм уу? Дэлгэрнараран дарга юу яачихъя, гүйцээгээд хариулчихъя. 83 дугаар микрофон өгье.

**П.Дэлгэрнараран:** Санал яг үндсэн санал хураах өдөр бол эх орондоо оршин суугаа иргэдийнх бол 1 өдөр. Гэхдээ урьдчилсан санал авахаар хуулийн төсөлд урьдчилсан одоо ингээд 5 хоногийн хугацаатайгаар бол санал авах өдөртэйгөө нийлээд 5 хоногийн хугацаанд урьдчилсан санал авахаар ингэж хуулийн төсөлд орж ирж байгаа. Гадаадад байгаа иргэдийн саналыг 4 хүртэлх өдөр, 4 хүртэл өдөр ингэж зохион байгуулж авахаар ингээд хугацаагаа илүү сунгаж байгаа. Энэ нь улирлын чанартай ажилчид, тэгээд бас одоо энэ саналын хуудсыг бол унших бас энэ хугацааны зарцуулалт бол бас өндөр болно. Ийм учраас бол бид нар өдрүүдээ арай илүүхэн тавьж өгч байгаа ийм төсөл явж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Чинзориг гишүүн тодруулж асууя.

**С.Чинзориг:** Яах вэ, Энхболд гишүүн Цэцийн дүгнэлт гарчихсан гээд байна л даа. Цэц чинь өөрөө их эргэлзээтэй байгаа шүү дээ. Нэг болохоор Үндсэн хууль зөрчиж байна гээд л, нэг болохоор Үндсэн хууль зөрчөөгүй гээд л. Цэц өөрөө их эргэлзээтэй байгаа учраас

би бол Үндсэн хууль зөрчөөгүй гэж зөрчихгүй гэж үзэхэд бол маш их эргэлзээтэй байгаа нэлээн асуудлууд дагуулна.

2 дахь асуудал нь сая Дэлгэрнараран даргын ярьж байгаагаар 10 нам нэр дэвшиүүлээ гэхэд 380 хүн жагсаалтад бичнэ л дээ. Тэгээд одоо техникийн нөхцөл байхгүй л юм байна шүү дээ. 50 сантиметр урттайг уншина гэдэг чинь ерөөсөө л үндсэндээ 2 бичгийн цаас л байхгүй юу, 2 бичгийн цаастай чинь ар өвөргүй 38 хүн бичлээ гэхэд дөрөвхөн намынх нь нэр дэвшигчийг багтаах л, бичих л тийм л хүчин чадал байгаа юм гэж би бол тэгж л ойлголоо шүү дээ. Тэгэхээр тэр 380 хүн таны хэлж байгаагаар тэр 30 хэдэн нам бүгдээрээ нэр дэвшвэл наадах чинь мянга гаруй, мянгаад хүн болох юм байна шүү дээ. Тэгэхээр бол техникийн нөхцөл байхгүй юм уу гэж ойлгоод л, зардал мөнгөтэй холбоотой, зардал мөнгө бууруулах чиглэлээр тусаж байгаа юм байна уу, Нямаа Энхболд гишүүн ээ.

**Л.Мөнхбаатар:** Чинзориг гишүүний асуултад Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

**Н.Энхболд:** Бат-Эрдэнэ дарга юугаа, нөгөө яг зардалтай холбоотой юмнуудаа ингээд хэлчхээрэй. Маш тодорхой хэлчхээрэй. Би түрүүн нэг юм бас тодруулъя гэж хариулт дээрээ нэмж хэлье гэж бодсон юм. Одоо хүмүүс яг шууд сонгохын тулд хүнээ мэддэг байх ёстой, хүнээ л сонгох ёстой, нэрээр нь сонгох ёстой гэж шаардлага тавьдаг аа гэж. Тийм, тэр үнэн. Тэгэхээр энэ удаа орж байгаа хэрэв жагсаалтад орсон ч гэсэн хүний нэр нь давхар явж байгаа, хүнийх нь нэрээр сонголт хийж болно, хүнээ сонгож болно, намаа сонгож болно, ерөнхийдөө намын мөрийн хөтөлбөрийг харъя даа. Ямар мөрийн хөтөлбөртэй, ямар зорилт тавьж байгаа юм гэдэг талаас нь хараад сонголтлоо хийнэ гэвэл шууд намд саналаа өгч болно. Үгүй ээ, би хүнээ заавал өөрөө таньж байж, мэдэж

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байж хэн гэдэг хүн Улсын Их Хуралд очих гээд байгаа юм, ямар түүх намтартай юм, болзол шаардлага хангаж байгаа юм уу гэдэг энэ талаас нь илүү харвал хүнээ сонгох боломжтой ийм л сонголттой жагсаалтад нэрээ оруулна. Дээр нь намууд ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгээс нэмж хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ хариулъя. 85 дугаар микрофон өгөөрэй.

**Д.Бат-Эрдэнэ:** Чинзориг гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийг боловсруулахдаа сонгуульд оролцож байгаа нэр дэвшигч нам, эвслээс гаргаж байгаа сонгуульд гаргаж байгаа энэ зардлыг бууруулах чиглэл дээр анхаарч ажилласан байгаа. Тэр дундаа сонгуулийн сурталчилгааны үндсэн хэлбэрүүд болох тээврийн хэрэгсэл, сонгуулийн сурталчилгааны хэвлэл материал, ухуулах хуудас, зурагт самбар зэрэг эд нарын төрөл хэмжээнүүдийг 30-70 хувь багасгаж оруулсан байгаа. Тухайлах юм бол сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийг бол 50 хувь бууруулах, сонгуулийн сурталчилгаанд ашиглах хэвлэл материалыг 30 хувь бууруулж оруулсан, мөн ухуулах хуудсыг бол 50 хувь бууруулах, сонгуулийн сурталчилгаанд ашиглаж байгаа зурагт самбарыг бол бүр 60 хувь бууруулах байдлаар төсөл дээр тусгасан байж байгаа. Энэ дүнгүүдийг дундажлаад аваад үзэх юм бол нийтдээ сонгуулийн сурталчилгаанд зарцуулах энэ зардал маань 48 хувь буурах нь ээ гэсэн ийм урьдчилсан тооцоотой байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс, Дэлгэрнарэн дарга хариулъя.

**П.Дэлгэрнарэн:** Би бол сая энэ хуулийн төсөлд заагдсан бүх зүйлүүдийг бүгдийг нь дээд хязгаараар нь авч, туршиж үзсэнийг хэлсэн. Тэгэхээр энэ бүх зүйлийг бол дээд хязгаараар нь аваад

үзэхэд манай техникийн хүчин чадал уг нь хурч байгаа юм, техникийн үзүүлэлтээр хурч байгаа. Тийм намын жагсаалт дээр ч гэсэн тийм бүгдийг нь оруулаад. Одоо бид нар 37 намыг 38, 38 хүн нэр дэвшүүлнэ гээд 56 инчийн 4 нүүр ийм хуудас гарахад яг одоогийн манайд хэрэглэж байгаа төхөөрөмжийн техникийн үзүүлэлт бол уг нь хурч байгаа. 56 сантиметр байгаа. Тийм яах вэ, урт нь тэрийг манай төхөөрөмж бол уншиж чадна.

**Л.Мөнхбаатар:** Техникийн боломжтой гэдгийг тодорхой хэлж байна.

Дамбын Батлут гишүүн асуултаа асууя.

**Д.Батлут:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сонгуулийн холимог тогтолцооны асуудлыг Үндсэн хуулийн Цэц хуульд нийцэж байгаа, хуульд нийцэхгүй гээд 2 шийдвэр гаргачаад байна л даа. Тэгээд энэ нь их л эргэлзээтэй санагдаад байгаа юм. Бид иргэдийн төлөөллийн зарчмыг ярихдаа төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх ёстой юм аа гэж ярьдаг байсан. Одоогийн байдлаар бол нэг 38 холимог системд орох юм бол 38 гишүүнийг иргэд тойргоос шууд сонгох, 38 жагсаалтад орж ирэхээр болж байх шиг. Тэгэхээр энэ өөрөө тэр төлөөллийнх зарчмаа сайжруулж байгаа үр дүн мөн юм уу? Миний бодлоор бол харин эсрэгээрээ юм шиг санагдаад байгаа юм.

Тэгээд Үндсэн хуулийн Цэц маань эхлээд хууль зөрчихгүй байна гэж холимог системийн хууль зөрчиж байна гэххэд одоо хууль зөрчихгүй нийцэж байна гэж гаргаж байгаа нь ямар учиртай юм бол? Энэ тал дээр нэг тодорхой тайлбар хэлж өгөөч ээ гэж хүсье.

2 дугаарт нь, энэ хуулийн төслийн 71.11-д байна. Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчид өгсөн саналыг жагсаалтаар дэвшигчид өгсөн саналыг тухайн нам, эвсэлд авсан санал дээр нэмж тооцно гэхихсэн байгаа. Тэгээд намын



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

санал дээр жагсаалтад нэр дэвшсэн хүмүүсийн авсан саналыг нэмээд тооцох юм байна л даа. Гэтэл 38 хүн жагсаалтаар дэвшдэг, 35 дахь хүн нь маш өндөр санал авбал яах вэ. Нэг юм уу, хоёрт бичигдсэн хүн нь маш бага санал авбал яах вэ? Энэ дээр намынхаа жагсаалтыг баримтлаад явах уу? Энэ зохицуулалтуудыг яаж хийх гэж байгаа юм бэ. Энэ дээр нэг хариулт авъя.

3 дугаарт нь, энэ нь хуулийн төслийн 74.3.2, 74.3.3. Тэгэхээр энэ шаардлага хангаагүй нам, нэр дэвшигчдэд өгсөн саналыг шаардлага хангасан нам, нэр дэвшигчдийн авсан санал дээр тэнцүү хувааж тооцно гэгчихсэн байгаа юм. Үгүй ээ, шаардлага хангаагүй хэдий ч гэсэн нам, иргэдэд иргэд өөрсдөө санал сонголт хийж саналаа өгсөн шүү дээ. Энэ чинь тэгээд иргэдийн сонголтыг ингэж болох уу? Иргэдийн сонголтыг үл хүндэтгэсэн хэлбэр гарч байгаа юм биш үү, энэ чинь. Энэ дээрээ дахиад өргөөч ээ.

Тэгээд үүнийгээ бид нар төлөөллийн зарчимд тулгуурлаж нийцүүлж байна гэж үзэж байгаа юу. Арай л боломгүй санагдаад байгаа юм. Иргэд сонголт хийчхээд байдаг, тэр авсан саналыг нь шаардлага хангаагүй гээд шаардлага хангасан нам, иргэдийн авсан санал дээр нэмж тооцно гэсэн чинь юу гэж ойлгох юм бэ? Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Батлут гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

**Н.Энхболд:** Дараагийн гишүүд бас манай ажлын хэсгийнхэн санаачлагчид нэмбэл нэмээрэй. Би тэр Цэцтэй холбоотой юман дээр бас нэг юм хэлчихье. Хамгийн сүүлд Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцээс гарсан тогтоол дээр Үндсэн хуульд Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна, ард түмэн өөрийн үйл хэрэгт шууд оролцож мөн сонгож байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа уламжилж энэ эрхээ эдэлнэ, Улсын Их Хурлын сонгуулийн

журмыг хуулиар тогтооно гэж заасан нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах сонгуулийн зарчмын хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, түүний хувилбарыг сонгуулийг зохион байгуулах журмыг хуульчлах бүрэн эрх хууль тогтоогчид олгосон байна гээд заачихсан байгаа. Үүний дагуу явж байгаа 1 дүгээр хариулт нь түрүүчийнх дээр тодотгоход.

Эрэмбийн хувьд яах вэ, одоогийн бид нарын өргөн мэдүүлчихсэн хуваарь дээр намууд эрэмбэлээд оруулна, санал аваад нам нь хэдэн хувийн санал авах нь вэ тэр хэмжээгээр эрэмбийнхээ эрэмбэлсэн дарааллаараа хүмүүсээ хуваарилаад явна гэсэн ийм агуулгатай орсон байгаа.

АН-ын өргөн мэдүүлсэн хувилбар дээр намууд эрэмбэлчхээд, дараа нь иргэдээс авсан саналаар нь дахиж эрэмбэлээд, тэрнийхээ дагуу дээрээсээ хэдэн хүн орсон байна түүгээрээ сонгогдсонд тооцно гэсэн ийм санал байж байгаа. Аль аль нь байж болох хувилбар гэж бодож байна. Гишүүд тэгээд ярьж байгаад, хамтатгаад хэлэлцэх үедээ олонхоороо шийдээ гаргана. Ер нь зүгээр бид энэ саналаа оруулахдаа намууд ч гэсэн сонгуульд орохдоо аль болохоор л одоо хамгийн сонгогдох бололцоотой хүмүүсээ, дарга, цэргийн найз нөхөд, ойрхон гэхээсээ илүү сонгогдох шанстай хүмүүсээ л тэндээ зоох ёстой шүү дээ. Чадахгүй байгаа нам нь тэгээд сонгууль авах шанс нь боломж нь багадна л гэсэн үг. Ийм логикийн үндсэн дээр энэ жагсаалтаа гаргана гэж оруулсан байгаа.

Төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхийн хувьд цэвэр механик талаас нь яривал чөлөөлөх чадварыг сайжруулахын тулд тоог нэмэгдүүлэх тухай л асуудал байгаа юм. Ямар ч хэмжээний тоог энэ бол хангалтгүй байна гэж хэлж болно. Одоо байгаа 76-г ч гэсэн 1992 онд Үндсэн хууль батлагдаж байсан үеийн хүн амтай харьцуулаад үзэхэд энэ төлөөлөх чадвар



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нь буурчхаад байна, хэтэрхий олон хүнийг нэг хүн төлөөлж байна гэсэн ийм шүүмж хүртэл гардаг. Тэгээд энэ хэлэлцүүлгийн явцад бас энэ дээр асуудлууд гарвал бас л олонхоороо шийдээд явах зүйл гэж би харж байна.

Хамгийн сүүлийн асуултын хувьд бол ийм байгаа юм, Батлут гишүүн ээ. Шаардлага хангаагүй гэдэг нь нөгөө 3 хувийн босгоо ярьж байгаа юм. 3 хувийн босго даваагүй, үгүй ээ тэгээд орхигдчихоор тэнд чинь бас тодорхой хэмжээний хүмүүс саналаа өгсөн байгаа шүү дээ. Тэгэхдээ нам нь 3 хувьд хүрээгүй. Тэгээд тэрийг нь тэнцүү хуваагаад өгчихье л гэж байгаа юм. Суудал авсан намуудад. Авсан пропорцоор нь хуваагаад өгье гэсэн санал гарвал бас түүгээр нь хийж болно. Яах вэ, зарим хүнд буруу байна гэж санагдаж байж магадгүй. Тэгвэл яагаад 50 хувийн санал нь гадаа үлдчихсэн байхад тэрэнд санаа зовохгүй байгаа юм бид нар, тиймээ. 50 хувийн саналыг нь авчхаад тэгээд суудлын 80 хувийг авчихсан байгаа нь шударга мөн үү гэсэн ийм асуулт маш олон давтамжтай гарч байгаа шүү дээ. Ийм гарч байгаа, тиймээ. Тэгэхээр түүнээс бол хамаагүй сайжирсан хувь л гэж үзэж байгаа юм. 50 хувь нь орхигдчихсон байхад бид нар юм ярихгүй байгаа мөртөө 3 хувь нь орхигдчихоор тэгээд тэрийг нь ядаж тэнцүү хуваагаад өгчихье, санал гараад авсан тоогоор нь пропорционалиад өгчихье гэдэг л хүн орхигдож байгаа юм шиг бол тэгвэл пропорциональ систем цаагуураа гарцаагүй зөв юм ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Батлут гишүүн тодруулах юм уу, та. Батлут гишүүн тодруулж асууя.

**Д.Батлут:** Ер нь тэр Үндсэн хуулийн Цэцийн тэр гаргаж байгаа дүгнэлтүүд чинь тэгээд хэр бодитой вэ гэдэг асуудал их чухал байгаа юм даа. Нэг бол болохоор болж байна, нийцэж байна гээд байдаг. Дараа нь болохоор болохгүй, нийцэхгүй байна аа, ингэх хэрэгтэй гэдэг.

Тэгээд оруулж ирж байгаа төслүүдээ харангуут ингээд иргэдийн сонгох эрхэд халдаад явчихсан ийм заалтууд ороод ирчихсэн байх юм. Мэдээж энэ хэлэлцүүлгийн явцад засварлаад л явах байх. Бид урьд нь ярьж байсан зүйлүүдээсээ ухраад баймааргүй байгаа юм л даа. Төлөөлөх чадварыг нэмэгдүүлье гэж баахан ярьцаасан. Гэтэл өнөөдөр бүр 76-гаагаа 2 хуваагаад 38 нь шууд тойргуудаас сонгогдох, 38 нь жагсаалтаар орно гээд бүр эсрэгээрээ, магадгүй миний бодож байгаагаар бол төлөөлөх чадвар бүр буурах, багасах хэмжээний ийм төлөвлөлт хийгээд ороод ирж байх жишээтэй. Энд иргэдийн сонголтын улс төрийн боловсролын сонголт ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Энэ дээр юу яая. Хуулийн төсөл санаачлагчид бас нэмж хариулж болно. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн тодруулж, хариульа тодруулгад хариульа.

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхээр Батлут гишүүн ээ, ингэсэн. Үндсэн хуулийн Цэцийн эцсийн шийдвэр гарсан юм, эцсийн шийдвэр шүү, эцсийн шийдвэр гэдэг чинь тогтоол байхгүй юу. Та сая хэллээ. 2012 онд Үндсэн хуулийн Цэц болно гэж шийдвэр гаргасан юм. Пропорционалийг. 2016 онд болохгүй гэж шийдвэр гаргасан юм. Энэ 2 нь 2-уулаа дунд суудлын хуралдааны шийдвэрүүд байсан.

Сая 2022 оны 6 сарын 22-нд Үндсэн хуулийн Цэц яах вэ, Даваасүрэн гишүүн ээ, эхлээд бид яриадахъя. 2022 оны 6 сарын 22-нд Үндсэн хуулийн Цэц өмнөх энэ шийдвэрүүдээ бүгдийг нь авч үзээд, эцсийн тогтоол гарсан юм. Эцсийн тогтоолоороо пропорционалийн элемент орох нь нээлттэй гэдэг шийдвэр гаргасан юм. Нээлттэй гэдэг шийдвэр. Өмнө нь гулсахыг хориглосон шийдвэрээ гулсаж болно гэдэг тэр шийдвэрийг хүчингүй болгосон юм. Ингээд эцсийн тогтоол буюу нөгөө хөх тэнгэр дээр нь байдаг шийдвэрийг Үндсэн хуулийн Цэц ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Яах юм, гүйцээж хариулах юм уу? Тогтохсүрэн гишүүн гүйцээгээд хариулчихъя.

**Д.Тогтохсүрэн:** 2 дахь нь, түрүүн хэлж байна лээ. Пропорционалийн элементээр санал өгч байхад иргэн хүн нэг бол намд өгнө, нэг бол намаас нэр дэвшигчдийн жагсаалтад байгаа хэн нэгэн нэр дэвшигчид санал өгнө. Энэ ер нь нэгэнд нь л өгнө, нэгэнд нь л өгнө. Намд сонголт хийхгүй гэвэл нэр дэвшигчдийн сонголт хийх бололцоог нь гаргаж өгч байгаа юм. 2012 онд энэ элементийг явсан. Гэтэл юу гэсэн гэхээр намын нэрийн ард хэн нэгэн нуугдаж байна гэдэг асуудал гараад байгаа учраас нэр дэвшигчийг тодорхой болгож байгаа юм. Тэгэхээр хэн нэгэн нэр дэвшигчид өгч болно.

Тэр эх үлдэгдлийн зарчим буюу таны яриад байгаа 3-аас доош хувийн санал авсан намуудын үлдэж байгаа саналыг санал авсан намуудад нь хуваадаг олон улсын зарчим юм байна лээ. Үүнийг эх үлдэгдлийн зарчим гээд байгаа юм. Энэ эх үлдэгдлийн зарчмынх нь дагуу 3 хувиас доош санал үлдсэн саналуудыг хаягдахгүй гээгдэхгүйн тулд нөгөө санал авсан намуудад олгож байгаа юм, тэрийг орхичхож болно, тэр бол бага санал, тэрийг орхичхож болно. Сая Энхболд гишүүн хэллээ шүү дээ. Тийм.

Нөгөө талаар ер нь бол Монгол Улс бол цаашидаа олон намын тогтолцоотой парламентыг бий болгох, улс орныхоо эрх ашгийг өндөрт тавьдаг тийм тогтолцоог бий болгох, улс төрийн намуудаа чадавхжуулах ийм тогтолцоог бий болгох үүднээс сонгуулийн холимог тогтолцоо байх хэрэгтэй юм аа гэж ингэж үзэж л Улсын Их Хурлын гишүүд бид нар хууль санаачилж орж ирсэн. Энэ хуулийг хэлэлцэх явахад Их Хурлын гишүүн та бүхэн Сонгуулийн хуультай холбоотой саналаа хэлээд, санал хураалгаад шийдүүлээд явах нь тэр эрх бол та бүхэнд нээлттэй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Аубакир, Баделхан нарын урилгаар Баян-Өлгий аймгийн сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүгдийн ажил амьдралд сайн сайхан бүгдийг хүсье.

Одоо Шатарбалын Раднаасэд гишүүн асуултаа асууя.

**Ш.Раднаасэд:** 12-16 онд хэрэглэсэн зарчим л даа. Энд алдаа ч байгаа, оноо ч байгаа. Тэгээд үндэсний эрх ашгаа бодох юм бол пропорциональ элемент заавал сонгуульд байх ёстой, хэрхэн яаж байх вэ гэдэгт л байгаа юм. Одоо бол энэ төсвийн хөрөнгө оруулалт, хуваарилалт энэ юм орон нутаг руу чиглэсэн, тойрог дагасан энэ чинь буруу байна. Тийм учраас энэ орон нутгийн эрх ашгаас давсан үндэсний эрх ашгаа түлхүү явуулъя гэдэг энэ дээр би бол санал нийлдэг юм.

Хэд хэдэн асуулт байна. Энэ уул нь энэ Алтанхуяг гишүүн л үүний зовлон жаргалыг сайн хэлэх ёстой. Нэгдүгээрт, үүнийг улс төрийн намууд ярих ёстой юу, эсвэл энэ чиглэл болгож байгаа тогтоол дотроо бид нар хийх ёстой юу. Алтанхуягийн Засгийн газар 12-16 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан. Байгуулагдахад 50 хувь нь дандаа жагсаалтынхан орж ирсэн. Тэр бөөн хэрүүлтэй. Би сайд болно, тэр сайд болно, дандаа жагсаалтынхан нь үймүүлдэг. Дараа нь Засгийн газар нь унахад бас жагсаалтынхан нь унагаасан. Яагаад гэвэл түүн дотор нөлөөлөл, мөнгө нь явдаг. Тэгээд Засгийн газрын гишүүн өөрөө болоогүй бол өөрийнх нь фракцын хүмүүсээс олон хүн болоогүй бол унагаасан ийм л хувилбар.

Тэгээд миний хэлэх гээд байгаа санал бол энэ намууд бас бодох ёстой байх. Жагсаалтад нэр дэвшиж байгаа

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хүмүүсийг Засгийн газрын гишүүнээр давхар ажиллуулахгүй ээ гэдэг энэ зарчим дээр оччих юм бол энэ жагсаалт руу тэгээд би оръё, чи оръё гээд ингээд яваад байх хүмүүс чинь цөөрчихнө. Энэ рүү барьж мөнгөө гүйгээд байх хүмүүс ч байхгүй болно, бизнесийн бүлэглэлүүд чинь. Үүнийг бид нар хуульдаа хийх ёстой юу.

Дараагийн нэг зүйл, энэ сонгуулийн зардлыг бид нар бууруулах гэж ер нь сурталчилгааны хоногийг нь цөөлж үзсэн, хэвлэх материал, телевиз бусад юмыг нь буулгаж үзсэн, үнэгүй болгож ч үзсэн, ерөөсөө явдаггүй юм байна лээ л дээ. Тэгээд үүнийг яаж буулгах юм гэвэл энэ сонгуульд нэр дэвшиж байгаа хүмүүс тойргууд дээр бүх намууд хамтарсан сурталчилгаа хэвлээд, тэр мэтгэлцээд л явъя л даа. Сум сумдаа очоод, тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүс, дүүрэг дээр бол нэгдсэн уулзалтууд дээрээ л мэтгэлц. Энд сонин хэвлэл янз янзын юм самбар хадахаас гадна энэ бол явж байгаа 2 талын сайн ач холбогдолтой. Нэгдүгээрт зардлыг нь хэмнэнэ. Нөгөө талдаа энэ хэн нь хэн бэ гэдэг ус, тосыг нь ард түмэн ялгаад өгнө өө. Тэгэхгүй болохоор нэг нэгнийхээ араар тойрч худлаа ярьдаг, түрүүн Чинзориг гишүүний хэлдэг энэ сошиалын юм чинь бас бүр замбараагаа алдана. Тэр гүтгэлэг янз янзын юмнууд чинь ч үүгээр бас хаагдчих болов уу гэж бодоод байгаа юм. Нүүр нүүрээ харж байгаад үнэн худлаа, үнэн зөвөө яриад явдаг, үүнийг бид нар хийчхээж энэ хууль дотор хийчих юм бол үр дүнтэй юм болов уу гэж.

Энэ санал хуваарилах асуудал дээр би худлаа санаагүй бол яг энэ 12 оны энэ хууль дээр Үндсэн хуулийн Цэц дээр Б.Цогтгэрэл санал гаргаад энэ их үлдэгдэж байгаа хаягдаж байгаа саналыг хуваарилдаг дээр Цэцийн дүгнэлт гарсан юм байдаг юм шүү. Үүнийгээ харж байж хийхгүй бол 12 оны яг сонгуулийн өмнөхөн энэ дээр бас А, Б жагсаалт гээд нөгөө үлдэгдлийг нь хуваарилахдаа хууль зөрчсөн байна гээд дүгнэлт гараад тэгээд

хам хум хууль зассан болоод орсон нэг ийм зүйл байдаг юм. Үүнийгээ харж байж бид нар энэ юмнуудыг хийхгүй бол бас дахиад зөрчсөн юм хийчих вий. Энэ 6 сард гарсан Цэцийн дүгнэлт ер нь давхар дээл өмсөе гэж байгаа бол пропорциональ системээ энэ гишүүдийн тооны асуудлыг давхар яриагч ээ гэдэг юмыг л оруулж ирсэн шүү дээ. Цэцийн дүгнэлт үндэслэл хэсэг дээр бол. Тэгээд түүн дээр бол бид нар энд гадна дотнынхоо бүх намуудыг оруулж суулгаж байгаад л энэ дээр ярих ёстой байх. Намын жагсаалтын ард хүмүүс нуугдаж ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Нямаагийн Энхболд гишүүн хариулах уу? Бусад бас хамт хамтран санаачилсан гишүүд бас нэмж хариулж болно.

**Н.Энхболд:** Саналууд голдуу хэллээ. Тэгэхдээ жишээ нь чухам аль хууль дээр орж болох юм үнэхээр одоо тийм хардлага сэрдлэг бас бус зүй бус үйл явдлууд гардаг гэж гишүүдийн олонх үзэж байгаа бол тухайлбал жагсаалтад орсон хүн сайд болохгүй ээ гэдэг юм оруулчих юм, энэ бид нарын улс төрийн бодлогын л асуудал гэж бодож байна. Тийм нам дотроо ярих сонгуулийн хуулиар чухам тэгж их өгөх юм уу, үгүй юм уу, эсвэл намын дотоод журам, дүрэм юмаараа зохицуулах юм уу, зарчмыг нь би яах вэ энэ нөгөө гардаг болгоомжлол талаас нь бодоод орчихсон байхад болохгүй зүйл огт байхгүй л гэж бодож байна. Шийдлийн л асуудал гэхэд олонх нь.

Зардалтай холбоотой тэр мэтгэлцээний тухай байгаа. Энэ дээр тойрог шинэ хуулийн төсөл дээр жишээ нь олон нийтийн радио, телевиз, сурталчилгааны мэтгэлцээний нэвтрүүлэг гэдгийг заавал байхаар тэгээд түүнийхээ хуваарь цагийн тэнцүү хэмжээнд тогтоож байхаар гэсэн заалтууд нэмж орсон байгаа. Үүнийг жишээ нь орон нутгийн хэмжээнд юм уу тойрог дээр хийхдээ оруулъя гээд гишүүдийн олонх шийдчихвэл, намууд нь

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тэгээд зөвшөөрөөд шийдчихвэл бас яагаад болохгүй гэж болохоор л санал байна гэж бодож байна. Зардал чирэгдэл ч хэрэгтэй байгаа байх.

Тэгээд үүний түрүүчийн 2012 онд явсан Сонгуулийн хуулиар тэр нөгөө босго давж чадаагүй намуудад суудлыг хуваарилахдаа хэрэглэж байсан арга бий. Их үлдэгдлийн зарчим гэж нэртэй бай луу, юу билээ тиймээ. Бүр бараг томъёог нь бичиж байгаад заачихсан. Түүний дараа учиргүй тийм том нэг их маргаан гараагүй. Яагаад гэвэл тэр бага санал авсан намуудад очсон санал нь нийт дүнгээрээ сонгуулийн дүнд нөлөөлөхгүй хэмжээнд байгаагүй учраас нэг том асуудал гараагүй. Одоо байгаа бид нарын санал болгож байгаагаар бол ер нь яах вэ тэнцүү хуваагаад өгчихье, түүгээрээ цаана нь хүний санал үлдэхгүй гэдэг агуулгатай логиктой. Тэгэхгүй ээ, жишээ нь тэгээд намуудыг чинь нэг ч гэсэн хүний санал авсан нам байвал тэр Их Хуралд суудалтай байна гэдэг логик бол байж болохгүй л дээ. Түүнтэй адилхан нэг байх уу, хэдэн хувь хүртэл байх вэ гэдэг бол өөрөө өгсөн нэг ч гэсэн санал авсан нам болгон тэнд суудалтай байж болохгүй гэдгийг, боломжгүй гэдгийг харуулсан зарчим гэж бодож байна. Тэгээд тэр үлдэж байгаа суудлаа яаж хуваарилах вэ гэдэг бол бас л тооцооны л асуудал. Тэр их үлдэгдлийн зарчмаар байна уу, эсвэл санал болгосноор тэнцүү өгөөд байх нь уу, ямар ч байсан Улсын Их Хурлын сонгуульд ороод саналаа өгсөн хүн болгоны санал олон санал авсан намууд дээр, дунд зэргийн санал авсан намууд дээр, босгон дээр босго давсан намууд дээр, бүр босго даваагүй нь тодорхой хэмжээгээр аль нэг намууд дээр санал нь очсон нэг хүний санал үлдэхгүй байх талаас нь л бодож хийсэн зарчим байгаа юм. Манай бусад гишүүд нэмж хариулбал хариулаарай.

**Л.Мөнхбаатар:** Раднаасэд гишүүн тодруулж асууя. Раднаасэд гишүүний микрофоныг өгөөрэй.

**Ш.Раднаасэд:** Тэр жагсаалтад нэр дэвшиж байгаа хүмүүс Засгийн газрын гишүүн давхар хийхгүй гэдгийг бас Төрийн байгуулалтын байнгын хороо даргын хувьд ажлын хэсэг байгуулах үеэрээ бас яана биз дээ, намуудтай ярилцана биз гэж би бодож байна. Энэ санал хуваарилалтад одоо 3 хувь гэдэг чинь бол 2 сая сонгогч саналаа өглөө гэхэд 60 мянган хүний л асуудал байна шүү дээ, 3 хувь гэдэг бол. Тэгэхээр энэ 60 мянган хүний саналыг авчхаад, дээрээс нь дахиад өнгөрсөн 12-16 оныхоор бол АН үлдэгдлийн зарчмаар гээд 4 орж ирж байсан юм. Манай намаас лав 2 орж ирж, Шударга ёс эвсэл гээд байгуулагдаад тэндээс бас 2 орж ир лүү, 3 орж ир лүү. Тэгээд энэ дээр чи яг үүнтэй холбоотой өөр хэн нэгэнд өгсөн санал бусад намуудад шилжин хуваарилагдахтай холбоотой, Цэцийн 1 дүгнэлт гарчихсан байдаг юм. Яг тэрийг л зөрчих вий гэж болгоомжлол миний хувьд байгаад байгаа байхгүй юу.

**Л.Мөнхбаатар:** Санал хэллээ. Цэцийн дүгнэлтийг бол дараа нь бас Байнгын хорооныхон аваад үзчихнэ биз ээ. Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Жишээ нь холимог тогтолцоо эд нар бол хийх цаг нь болсон байх. Зүгээр 38, 38-аараа байдаг юм уу, АН-ынхны ярьж байгаа шиг 48, 28-аараа байдаг юм уу, түүнийг нь бол хэлэлцүүлгийн үеэр ярина биз. Надад нэг ийм 2 асуудал байна.

Энэ зардал бууруулахад яг ямар ямар тодорхой заалтууд туссан бэ? Сая Сонгуулийн ерөнхий хорооны Бат-Эрдэнэ дарга захаас нь яриад эхэлчихлээ. Яг түүн шиг ингээд бүр нэг дэс дараатай нэг хэлээд өгөөч. Яг ингээд, ингээд ийм, ийм юмнуудыг ингэж, ингэж хязгаарлаад ингэж зардал хэмнэгдэх гэж байгаа. Өнгөрсөн сонгуультай харьцуулах юм бол төд гарч байсан бол одоо төд болно гэж ойролцоогоор тооцож байна гээд үүнийг



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нэг хэлээд өгөөч. Тэгээд энэ дээр ерөөсөө сонгуулийн энэ улс төрийн намын санхүүжилтийн чинь нэг зовлон нь сонгууль. Сонгуулийн санхүүжилтийн 2 том зовлон бол ухуулагчийн урамшуулал, хэвлэл мэдээллийн зардал 2 байгаа шүү дээ. Тэгээд бид нар олон удаа яриад энэ ухуулагч урамшуулалгүйгээр сайн дураараа ажилладаг тогтолцоо руу шилжиж үзье гээд яриад л байдаг, яриад л байдаг хийж чаддаггүй. Одоо үүнийгээ энэ сонгуулийн хууль дээрээ хийж авахгүй бол зардал буурахгүй ээ. Бүр албан ёсны зардал ч буурахгүй, албан бус зардал ч буурахгүй. Тэгээд энэ дээр хариулаад өгөөч.

Хэвлэл мэдээллийн зардлыг бууруулах дээр юу хийж байна, хэвлэл мэдээллийн зардал чинь сүүлийн сонгуулиудаар бол гол нь энэ юу болсон шүү дээ тиймээ, сошиалын зардал болчихсон шүү дээ. Тэгээд үүнийг бууруулахад яг тодорхой хийж чадах юм байна уу? Бид нар хуульчлаад хийж чадах юм байна уу?

2 дахь асуулт, энэ хуультай уялдуулаад энэ улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох асуудал дээр энэ Сонгуулийн хууль, Улс төрийн намын хууль хоёр хоёулаа яригдаж эхэлж байна. Энэ дээр Төрийн байгуулалтын байнгын хороон дээрээс бодож байгаа, төлөвлөж байгаа, улс төрийн намын санхүүжилтийг ойлгомжтой тодорхой болгох асуудал дээр ямар санал байна. Ийм 2 асуудал байна.

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Нямаагийн Энхболд гишүүн хариулъя. Тэгээд дараа нь ажлын хэсэг нэмж болно.

**Н.Энхболд:** Тэр яг нөгөө хэвлэлээр, зардлаар юу унаагаар, самбараар гээд тэр юмнуудаа дахиад нэг Бат-Эрдэнэ танилцуулчаарай. Ухуулагч нарын асуудал ийм гарсан юмаа. Энэ яг цэвэр улс төрийн бас л тэгээд шийдлийн л

асуудал болчихоод байгаа юм. Бүгдээрээ үүнийг хийж чадах уу, үгүй юү л гэсэн асуудал. Сонгуульд нэр дэвших хүмүүс, одоо гишүүд, сонгуульд оролцъё гэж бодож байгаа хүмүүс зөвшөөрөх үү, үгүй юү гэдэг асуудал. Урьд өмнөхтэй харьцуулаад бидний хувьд шударга бус, тэгш бус нөхцөл байдал үүсгэж байна гэдгээс эхлээд л асуудал гарах юм байна лээ. Ер нь бол сайн дурын үндсэн дээр болгоё гэдэг энэ санаа олон жил яригдаж ирсэн. Энэ хууль дээр ч гэсэн тэгээд биччихсэн байгаа. Ухуулагч бол сайн дураар ажиллана. Тэгэхдээ тэд нарт өгөх урамшуулал, ажлын зардал нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна л гэсэн ийм заалт явж байгаа. Тэгээд хяналт тавих эсэх эд нар нь жич асуудал, тавихын төлөө ажиллах ёстой хууль нэгэнт гарчихвал. Түүнээс илүү өгч мөнгө болохгүй гэж ойлгоод шударгаар ажиллана гэж бодоод л хуулиа хийнэ шүү дээ. Тэгэхээр ийм байгаа энэ дээр гишүүд бас саналаа гаргах боломж байгаа.

Би дэд сайд бас нэмж хариулах болов уу гэж бодож байна. Тэр хянах боломж нь байна уу, үгүй юү гэдгээр. Бидний оруулсан дээр бол сонгууль сурталчилгаанд зарж байгаа зардлын нийт зардлын 15-аас доош хувь нь тийм ээ, цахим сурталчилгаанд зарцуулах гэсэн ийм зохицуулалт явж байгаа.

Бат-Эрдэнэ дарга тэр яг нөгөө юунуудаараа хэвлэлийн хуудас яаж багассан юм, самбарын тоо яасан юм, машин яасан юм тэд нарыгаа 1 хэлчих. Түүрүүн зүгээр хэлсэн Мөнх-Оргил гишүүн байсан уу, үгүй юү? Ингээд зардлыг төрөл төрлөөр нь аваад үзэхэд энэ хуульд туссан байгаа зардал, түрүүчийн хуулийн дагуу явуулсан үеийн зардлаас 30-70 хувь буурахаар тооцоог энэ холимог системээр явуулбал ингээж буурна гэсэн тооцоо Сонгуулийн ерөнхий хороо гаргаж байгаа юм билээ. Энэ нь дунджаар аваад үзвэл нийтдээ их сайхан өөдрөгөөр бодоод үзэхэд яг энэ хуулиа бариад ажиллавал сонгуулийн зардал өмнөх



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сонгуулиас 50 хувиар дунджаар буурна. 48, 49 хувиар буурна гэсэн ийм тооцоолол Сонгуулийн ерөнхий хороон дээр хийсэн юм байна лээ. Энэ талын тооцоог ер нь Сонгуулийн ерөнхий хороо гаргадаг. Дээр нь одоо ингээд энэ хуулиуд батлагдвал дахиад 1 тойрог дээр улсын хэмжээнд ямархуу хэмжээний зардал гарах дээд хязгааруудыг нь бас тооцоолж гаргах ёстой. Тэр нь тэгээд өөрсдийн гэсэн аргачлалууд байдаг юм байна лээ.

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүний асуултад ажлын хэсгээс нэмж хариулъя. Сонгуулийн зардлыг хэрхэн бууруулж байгаа талаарх мэдээллийг Бат-Эрдэнэ дарга өгчихье, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. 85 дугаар микрофоныг өгье. Дараа нь Эрхэмбаатар дэд сайд хариулаарай.

**Д.Бат-Эрдэнэ:** Мөнх-Оргил гишүүний асуултад нэмж хариулъя. 1 дүгээрт, сонгуулийн сурталчилгаанд ажилладаг ухуулагчдын тоог одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бол 200 сонгогч тутамд 1 ухуулагч байсан бол үүнийг өргөн барьсан хуулийн төслөөр нийслэл болон аймгийн төвд 400 сонгогчдод 1 ухуулагч, бусад газарт бол 200 сонгогчид 1 ухуулагч байхаар тооцож багасгасан байж байгаа. Бусад газар гэдэг маань одоо багууд дээр магадгүй 200 хүрэхгүй сонгогчтой газрууд бол их байдаг. Ийм учраас энэ хэсгүүд дээр ухуулагчгүй болчих ийм бас эрсдэлтэй байгаа учраас төвөөс бусад газрууд 200 сонгогч тутамд 1 ухуулагч гэдэг нь бол хэвээр үлдсэн. Түрүүн Энхболд дарга бас хэлж байсан. Энэ ухуулагч ер нь сайн дурын үндсэн дээр ажиллана гэдгийг бол хуулийн төслийн 37.8 дахь хэсэг болгож, 1 заалт нэмж байгаа. Сайн дурын үндсэн дээр ажиллана. Хэрвээ урамшуулал өгөх юм бол энэ урамшууллын хэмжээ бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой шүү гэдэг ийм зохицуулалтыг хийж өгсөн.

Мөн дээрээс нь сонгуулийн сурталчилгааны үндсэн арга хэлбэрүүд болох хэвлэмэл материалын хэмжээ бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар 3 хэвлэлийн хуудас сонин, мөн 3 хэвлэлийн хуудас сэтгүүл байсан бол үүнийг тус бүрд нь 2 хэвлэлийн хуудас болгож бууруулна. Мөн дээрээс нь ухуулах хуудас бол 1 хэсэгт 20-оос илүүгүй байна гэж тогтоож өгсөн байсан бол одоо энэ өргөн барьж байгаа төслөөр 10 болгож 50 хувь бууруулсан байж байгаа.

Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбарыг 60 хувь хүртэл бууруулсан байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар 1 хэсэгт 10 зурагт самбар байрлуулах ийм боломжтой байдаг. Одоо энэ өргөн барьсан төслөөр аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3 самбартай байна гээд ингээд тооцоод үзэх юм бол 60 хувиар буурах ийм тооцоо гарч байгаа. Мөн сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгсэл бол 1 хэсэгт 4 сурталчилгаанд зориулсан тээврийн хэрэгсэл явдаг байсан бол яг 50 хувь бууруулсан, 2 тээврийн хэрэгсэл ашиглаж болно гэсэн ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ дарга гүйцээгээд хариулчихъя.

**Д.Бат-Эрдэнэ:** Ингээд саяын тооцоог үзэх юм бол дундчилаад үзэх юм бол нийтдээ сонгуулийн сурталчилгаанд гарч байгаа зардал бол 50 орчим хувиар буурах ийм боломжтой юм байна гэсэн ийм тооцоо гарч байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгээс нэмж хариулъя. Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Эрхэмбаатар хариулъя. 84 дүгээр микрофоныг өгье.

**Ж.Эрхэмбаатар:** Гишүүний асуултад хариулъя. Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах, сонгуулийн зөрчилтэй контентыг олон нийтийн сүлжээ цахим орчинд

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байршуулахтай холбогдолтой суурь зохицуулалт 2019 оны Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн суурь зохицуулалт бол хэвэндээ үйлчилж байгаа. Энэ дээр нэг орсон нэмэлт зохицуулалт бол цахим орчинд ашиглаж, сонгуулийн сурталчилгаа явуулж бол болно. Явуулахтай холбогдолтой гарах зардлыг нийт зардлын аудитаас тогтоож өгсөн зардлын 15 хувиас хэтрүүлэхгүй байх тухай хориглолтой үүсгэсэн ийм заалтыг бол шинээр санаачилж оруулж ирж байгаа. Энэ заалтыг хэрэгжилттэй холбогдолтой үр дагавар нь яаж гарах вэ гэхээр сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч нар өөрийн цахим хуудсаа бүртгүүлнэ, бүртгүүлэхтэй холбогдолтой түүн дээрээ сурталчилгаа байршуулах эрх нь нээлттэй, гагцхүү зүгээр сурталчилгааг олонд хүргэх зорилготой тодорхой төлбөр төлөөд буюу бүүст хийгээд явуулахад төлбөрийн хэрэгсэл ашиглана. Төлбөрийн хэрэгсэл нь бол дотоодын карт бол ихэвчлэн ашиглагддаг учраас тэр гарч байгаа зардлыг хянах, нягтлах, хожим нөгөө нэр дэвшигчийн, нам, эвслийн гарсан зардлыг аудит хянах үед бол илрэх ийм боломжтой гэж ойлгож байгаа.

Түрүүн Чинзориг гишүүний асуусан олон нийтийн сүлжээнд тэр нэр дэвшигч болон нам, эвслийн эсрэг явуулж байгаа зөрчилтэй агуулга бүхий контент одоо пост сурталчилгаа янз бүрийн сөрөг зүйлийг хориглохтой холбогдолтой суурь зохицуулалт нь бол үндсэндээ хуучин 2019 онд баталсан яг энэ хэвээрээ яваа. Үүн дотор одоо дурдвал зохицуулах хорооны зүгээс бол энэ сүлжээнд сурталчилгаа дууссанаас хойш хаах гэх мэт зохицуулалт нь байгаа. Энэ харилцааг бас зохицуулах зорилгоор олон нийтийн сүлжээнд хүний эрх хамгаалах тухай хуулийн төсөл дээр бол Цахим хөгжил, харилцаа холбооны яам боловсронгуй болгоод намрын чуулганаар өргөн барихаар бэлтгэл ажлыг нь хангахаар ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулахаас өмнө зочид танилцуулаад орхиё.

Шихихутаг хууль зүйн их сургуулийн Бизнесийн эрх зүйн ангийн 3 дугаар дамжааны оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Асуухгүй ээ, дарга аа, зүгээр санал хэлчихье.

**Л.Мөнхбаатар:** Саналаа хэлчихье.

**Ц.Мөнх-Оргил:** Тэр ухуулагч нар сайн дураараа гэгчээд, тэгээд урамшуулал аваад, урамшуулал нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүүгүй байна энэ тэр гээд хоёрдмол юм хийгээд хэрэггүй дээ. Хэрвээ хийх гэж байгаа бол нэг тийш нь л гаргамаар байна. Ерөөсөө сайн дураараа ямар нэгэн төлбөр, урамшуулал авахгүй гэдгээрээ нэг тийшээ болгоод, эсвэл төдөөс илүүгүй авна гээд хууль дээр нь заагаад нэг ойлгомжтой болгомоор байна. Тэгэхгүй ингээд сайн дураараа гэдэг чинь санаа нь бол ямар нэгэн төлбөр авахгүй, зүрх сэтгэлээрээ л явж байна гэсэн үг шүү дээ. 1 дүгээрт, үүнийг нэг тийшээ болгомоор байна.

2 дугаарт, тэр дэд сайд сая яриад байна л даа. Нөгөө суурь зарчмууд хэвээрээ байгаа гээд. Тэр зарчмууд тэр зохицуулалт чинь үйлчлэхгүй байгаа байхгүй юу. Хэцүү байгаа байхгүй юу. Түүнийг нөгөө хэрэгжүүлэх гэж, тэгээд түүнийгээ яаж хэрэгжүүлэхийг нь ажлын хэсэг эд нар дээр сайн тайлбарлаж яриарай. Цаг бага байгаа ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Мөнх-Оргил гишүүн санал хэллээ. Энхтайваны Бат-Амгалан гишүүн асуултаа асууя.

**Э.Бат-Амгалан:** Баярлалаа. Ямар ч байсан орж ирж байгаа энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ер нь зүгээр сонгуулийн тогтолцооны тухайд бол төгс төгөлдөр ийм сонгуулийн тогтолцоо гэж хаана ч байхгүй ээ, дэлхийд ч байхгүй. Тэгээд ингээд түрүүн Батлут гишүүний хэлдэг бас зөв. Ингээд сонгууль дөхөөд ирэхээр тогтолцоогоо өөрчлөөд байдаг юм, өөрчлөөд байх юм уу гээд энэ асуудлыг бас нэг цаашидаа бид нар Монголчуудынхаа энэ хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өөрсдийн энэ Монгол хүмүүсийнхээ энэ нийгэм, эдийн засгийнхаа байдалтай уялдуулж ер нь бас нэлээн алсыг харж хийх нь зөв байх аа гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд холимог системийг бол яах вэ дэмжиж байгаа. Монгол Улсын хөгжлийн асуудал, иргэдийн үндэс, иргэдийн эрх ашиг, үндэсний эрх ашиг гээд л янз бүрийн олон юмнууд бол ярина л даа.

Зүгээр энэ дээр тэр мажоритарар орж ирж байгаа 38 гэдэг тоо бол тоон дээр нэлээдгүй ажлын хэсэг дээрээ бас ярих байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр бол би бас нэг жоохон судалгаа хийж ирсэн. Хүн ам яах вэ, 10-аас доош сая хүн амтай жишээ нь 7.7 сая хүн амтай Серб улс гэхэд чинь 250 гишүүнтэй, 6.4 сая хүн амтай Болгар Улс гэхэд 240 гишүүнтэй, 5.2 сая хүн амтай Финлянд улс гэхэд 200 гишүүнтэй гээд ингээд явж байна. Би үүгээрээ яг юу хэлэх гээд байна вэ гэвэл Монгол Улс чинь 21 аймаг 9 том дүүргүүдтэй. Ингээд ирэхээр ерөөсөө аймаг болгоноос 1 төлөөлөл төлөөлж, энэ Улсын Их Хуралд суух гээд байгаа юм шиг байгаа юм. Ингэхээр бас их харьцангуй ойлголт болж байгаа юм. Энэ сонгууль чинь ер нь энэ төлөөллийн зарчим бол ерөөсөө 1 дүгээрт хүн ам, 2 дугаарт, газар нутгийн хэмжээгээр л барьж явах ёстой гэж ингэж ойлгож байгаа. Гэтэл чинь одоо Говьсүмбэр аймаг ер нь нэг 10 хүрэхгүй мянган сонгогчтой ингээд байж байдаг. Баян-Өлгий, Увс, Хөвсгөл аймгууд гэхэд 100 гараад мянган хүн амтай. Тэгэхээр энэ төлөөллийн зарчим уруудах, төлөөлж чадах, чадах энэ асуудлууд бас

яригдах байх аа гэдгийг эндээс ургаад гараад ирэхээр энэ тооны асуудал хэрвээ хөдлөх юм бол энэ Үндсэн хуульд бас өөрчлөлт орох юм уу, яах юм. Энэ асуудал 1 дүгээр асуудал байна.

2 дугаар асуудал дээр сонгуулийн зардлыг танаж байгаа нь бол зөв өө. 50 хувь, 60 хувь гээд л янз бүрийн үндэслэлүүд гаргаж ирж байна. Хэвлэлийг тэр нөгөө машин техник, тоног төхөөрөмжийг хассан. Гэхдээ энэ ухуулагч нар дээр бол ер нь жоохон амьдралтай бид нар энэ хуульдаа хандаж бодмоор байгаа юм шүү. Яг сонгууль дөхөөд ирдэг сайн дураараа ч байна уу, ямар нэгэн байдлаар нам, улс төр, нэр дэвшигчийг дэмжих ухуулагч нар ажилладаг. Тэгэхээр энэ дээр заавал ингэж хатуу 200 тутамд 1, 400 тутамд 1 гэж хатуу зааж өгөх шаардлага байгаа юм уу. Тэр нэр дэвшиж байгаа нэр дэвшигч өөрөө ямар хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулж чадаж байна вэ энэ чинь сонгууль чинь одоо ялалт байгуулахын тулд л бүгд ажиллаж байгаа шүү дээ. Тэгэхээр ийм хатуу заалтыг ер нь оруулмааргүй байна. Энэ тал дээр бас нэг асуулт байна.

Дараагийн хамгийн сүүлийн 1 асуудал, ойлгохдоо Монгол Улсын иргэд Монгол Улсад амьдарч байгаа иргэд маань 2 хуудас бөглөх гээд байгаа юм шиг байгаа юм. 1 нь нам жагсаалт пропорционалиар, 1 нь тухайн мажоритар дээр, гадаад улсад амьдарч байгаа иргэд нэг саналын хуудас бөглөх үү гэдэг ийм асуултууд байна. Тэгээд тодруулна.

**Л.Мөнхбаатар:** Бат-Амгалан гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Тогтохсүрэн гишүүн хариулъя.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Сонгуулийн тогтолцоо эрх зүйн орчин тогтвортой байх ёстой гэдэгтэй бол санал нэг байгаа юм. Бид чинь нэг сонгуулийн өмнө бүр л сонгуулийнхаа хуулийг өөрчлөөд байгаа юм. Цаашидаа сонгуулийн тогтолцоогоо тогтвортой

байлгая гэвэл бид Үндсэн хуульдаа зааж өгөх ийм шаардлага байгаад байгаа юм.

2 дугаарт нь, энэ Улсын Их Хурлын гишүүдийн тоотой холбоотой асуудлыг бид нар жил гаруй л ярьж байгаа, ярьж байгаа. Цаашидаа бол Улсын Их Хурлын гишүүдийн тоо хүн амаа бүрэн төлөөлж чадаж байна уу, үгүй юү газар нутгаа гэдэг асуудал байгаа юм. 1992 онд 1 тойрогт дунджаар 24-26 мянган иргэн оногдож байсан юм байна лээ. Өнөөдөр 44-46 мянган иргэн ноогдож байгаа юм. Тэгэхээр цаашидаа бол энэ сонгуулийн тогтолцооны асуудал, гишүүдийн тооны асуудал, бид нарын ярьдгаар Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнийг давхар хашихтай холбоотой асуудал эд нар явж явж байгаад л эцсийн цэг дээрээ очихоороо, дээл нь хүрэхгүй байгаа учраас тоон дээрээ л очдог ийм л зүйл.

Ухуулагчдын тооны тухайд бол ухуулагчдын тоог зааж өгөөд явсан уламжлалтай. Хүн амын тоонд тохирсон ухуулагчдын тоог зааж өгөхгүй бол бүгдээрээ ухуулагч болчихдог ийм сөрөг үр дагавар ч бий. Тийм учраас бол ухуулагч нар бол заавал тоотой байх ёстой гэж. Тэгээд харин бид нар зардал бууруулах үүднээс нийслэлд 400 сонгогч тутамд 1 ухуулагч байна гэсэн ийм зардлыг бууруулах хүрээнд нь ухуулагчдын тоог багасгах арга хэмжээ авсан.

Гадаадад байгаа сонгогчдоос зөвхөн пропорциональ дээрээ нэр дэвшиж байгаа нэр дэвшигч, намын асуудлаар л санал хураалт явагдана. Иргэн хүн сонгуулийн санал өгөх өдөр тойргоосоо өөр газар явж байгаа тохиолдолд пропорциональ дээр санал өгөх эрх нээлттэй. Мажоритар дээр бол санал өгөхгүй, өөрийнхөө тойрогт заавал очиж өгөх ийм зохицуулалт хийж байгаа. Энэ нь сонгогчдыг аль болохоор сонгуульд оролцуулах, Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхийг нь эдлүүлэхэд энэ хуулийн 1 зарчим оршиж байгаа гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Бат-Амгалан гишүүн тодруулж асууя.

**Э.Бат-Амгалан:** Яах вэ, тэр нөгөө 200 байж байгаад 400 болгодог бол зардалтай холбоотой танаж байна гэж ойлгож байна шүү дээ, тиймээ. Дараагийн, ойлголоо.

**Л.Мөнхбаатар:** Барилга хот байгуулалтын сайд Цэрэнпиллийн Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Энэ орж ирж байгаа холимог тогтолцоогоор гэдэг Сонгуулийн хууль нөгөө 2012 онд болсон нөгөө хаалгаар өшиглөөд гаргасан чинь тооноор ороод ирлээ гэдэг юм давтагдах гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ 2012 онд хийсэн сонгуулийг дараа нь 2016 онд ялагдсаныхаа дараа бид юу гэсэн гэхээр Үндсэн хууль зөрчсөн юм байна лээ гээд өөрчилсөн юм. Тэгээд ингээд нэг дур нь хүрэхээрээ пропорционалиар явуулаад, дургүй нь хүрэхээрээ мажоритараар явуулаад ингээд л энэ бол бидний байгаа байдал юм л даа. Тэгээд л янз бүрээр тайлбарлана. Ер нь бол Үндсэн хууль дээр тодорхой заагаад өгчихсөн байгаа юм.

Үндсэн хуулийн 3 дээр бол засгийн бүрэн эрх ард түмний гарт байна, шууд сонгосон төлөөллийн байгууллагаараа гээд, 21.2 дээр Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгоно гэж байгаа юм. Дунд нь ямар нэг байгууллага байхгүй гээд. 2016 оны дүгнэлт тийм, дунд нь ямар нэг байгууллага байхгүй юм байна шүү гэж. Мөн 21.3 дээр 25 хүрсэн иргэнийг сонгоно ингээд заагаад өгчихсөн. Тэгээд хэрвээ үүнийг оруулах гэж байгаа бол Үндсэн хуульдаа өөрчлөлт хийх ёстой байхгүй юу. Үндсэн хуулиа зөрчдөг ёс суртахуунтай байна гэдэг бол угаасаа энэ Монгол бол цаашидаа хөгжихгүй, энэ төрт ёс тогтохгүй. Тэгэхээр Үндсэн хуулиа бид нар ингэж зөрчөөд байх юм бол. Тэгэхээр би нэг асуулт асууя.

92 онд, мөн 2019 онд Үндсэн хуулийг өөрчилж байхад холимог



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тогтолцоо дэмжигдээгүй, Тогтохсүрэн гишүүн өөрөө мэдэж байгаа. Үүнийг юу гэж тайлбарлах юм? Одоо энэ чинь шинэ нөхцөл байдал үүссэн гээд 16 оныхоо Цэцийн дүгнэлтийг үүнийг үндэслээд өөрчлөөд хаячихсан шүү дээ. Тэгэхдээ бид нар 92 онд, 19 онд холимог тогтолцоог Үндсэн хууль хэлэлцэхдээ дэмжээгүй юм гэдгийг одоо та бүгд юу гэж үзэж байна вэ гэж.

Одоо ингээд нэг юм яриад байгаа юм. Намын нэр байна, хүний нэр байна гэж. Үгүй ээ одоогийн бид нарын мажоритар чинь тийм л дээ. Хүний нэр байдаг, тэгээд намын нэр ч байдаг. МАН гэсний ард жишээлбэл одоо Мөнхбаатар гишүүн, Даваасүрэн гишүүн, Энх-Амгалан гээд байж л байгаа байхгүй юу, адилхан. Тэгэхээр би ойлгохдоо ингэж ойлголоо. Хүнийг нь дугуйлж болно гэхээр хэн нэг хүнийг дугуйлчихаар тэр намын хүн гэдгээр нь намыг нь тоолох гээд байгаа юм байна шүү дээ, муухан заль хэрэглэх гээд байгаа юм байна, энэ үнэн үү? Тэгэхдээ энэ ер нь санал үлдлээ гээд байх юм. Үгүй одоо 100 хувийн санал авна гэж хаана ч байхгүй шүү дээ. 100 хувийн санал авдаг сонгууль гэж хаана ч байхгүй. Энэ ямар ч боломжгүй зүйл байхгүй юу. Тийм учраас одоо энэ тогтолцоогоор ингээд байгаа юм. Нам сайжирна, төр сайжирна гэж, яаж сайжрах юм. Нөгөө хулгай хийсэн улсууд чинь ард түмэнд нэр нүүргүй болсон гарууд чинь намын нэрийн ард ард түмнээр шүүрдэгдэхгүй үлдчихээд байгаа байхгүй юу. Насан туршидаа үлдэнэ. Намын дарга байсан, намын олон удаа сонгогдсон гээд албан тушаалаараа ингээд үлдээд л байна, үлдээд л байна, намууд нь улам бохирдоод л байна, төрүүд нь улам бохирдоод л байна, ийм л зүйл.

Тийм учраас энэ ард түмний шүүрдэж байгаа, муу улс төрчийг шүүрдэж байгаа энэ сонгуулийн тогтолцоог нь бол устгаж болохгүй ээ. Та нар ард түмнээс сонгогдсон шүү дээ. Гуйж, гувшиж ямар юм явсан бол доо. Одоо бодохоор би инээд хүрээд байх юм.

Өнөөдөр ямар царайтай болчихсон сууж байна. Ард түмнийхээ урдаас нулимаад. Тэр үед тэгвэл та нар хэлэхэд яасан юм, би пропорциональ тогтолцоог авна шүү, та нар надыг сонгоорой гэж хэлэхэд яасан юм. Тэгээд өнөөдөр энэ сонгох эрхийг нь авч үлдэх ганц боломж байгаа нь Улсын Их Хурлын гишүүд та нар. Та нар тэр ард түмний мандатыг авсан улсууд. Тэгээд тангараг өргөхдөө бол Үндсэн хууль зөрчихгүй гэсэн. Би Үндсэн хуулийн зөрчлийг сая хэллээ шүү дээ. Тэгээд тангаргийнхаа эсрэг явж болохгүй гэж би бодож байна. Тийм учраас та бүхэн одоо үүнийг ямар нэг байдлаар Үндсэн хуулийн зөрчлийг арилгаач ээ гэж би хүсэх гээд байгаа юм. Тийм учраас энэ сонгуулийн тогтолцоо бол намуудыг хагална аа.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн гишүүний асуултад хариулахаас өмнө зочид танилцуулаад орхиё.

Улсын Их Хурлын Оюун-Эрдэнэ, Бат-Эрдэнэ, Идэрбат нарын удирдлагаар Хэнтий аймгийн оюутнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа. Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн сурлагад өндөр амжилт хүсье.

Даваасүрэн гишүүний асуултад хэн хариулах вэ? Нямаагийн Энхболд гишүүн хариулъя.

**Н.Энхболд:** Тэгээд энэ цэцийн шийдвэрүүд л янз бүр гараад байсантай холбоотой л үүсээд байдаг асуудал л даа. Ингэсэн юм байна лээ. Үндсэн хуулийн Цэц 16 оны 4 сард гаргасан шийдвэртээ Монгол Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоо руу явуулах талаарх зохицуулсан хувь тэнцүүлсэн хэлбэрт хамаарах заалт нь Үндсэн хуулийн 22.2-т заасан шууд сонгох зарчим болон 3 дахь хэсгийн мөн зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэж. зөрчсөн гэсэн ийм дүгнэлт гаргасан юм байна лээ. Тэгээд дээр нь 12 онд сонгуулийн тухай хувь тэнцүүлсэн тогтолцоонд хамаарал бүхий зохицуулалтын талаарх маргааныг

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэлэлцэхдээ холимог тогтолцоогоор сонгууль явуулах нь зөрчсөн талаар тусгайлан дүгнэлт гаргаагүй юм байна лээ. Өөрөөр хэлбэл 12, 16 онд гаргасан Цэцийн 2 дүгнэлт хоорондоо зөрчилтэй мөртөө нэгэн зэрэг хүчин төгөлдөр байгаад байна гэж үзээд Цэц 22 онд хуралдахдаа энэ 2 тогтоолоо хоёуланг нь хүчингүй болгосон байна. Ингээд энэ 2 тогтоол Цэцийн шийдвэрээр хүчингүй болчихож байгаа юм.

Тэгээд дараа нь одоогийн бид нарын энэ яриад байгаа боломжийг нээсэн дүгнэлт дээрээ юу гэсэн гэхээр Их Хурлын сонгуулийн журмын талаар Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийг хэлэлцсэн Бага Нурлын болон Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүдийг судалж үзэхэд Үндсэн хууль тогтоогч болох Ардын Их Хурал. Их Хурлын сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн журмыг хуулиар тогтоохыг заасан байна, заасныг баталсан байна гэж байгаа юм. Хуулиар гэдэг үгээрээ байж болно гээд.

16 оны 5 дугаар дүгнэлтдээ гарахдаа Цэц тэр Бага Хурлын холбогдох хуралдааны тэмдэглэлийг үндэс болгосон гэж өөрснөө тэмдэглэсэн байдаг юм. Бага Хурал дээр нь болохоор Бага Хурлын тэмдэглэлээс нь үзэхээр Их Хурлыг бүрдүүлэх сонгуулийн тогтолцооны асуудлыг БНМАУ-ын Бага Хурлын энэ хуралдаанаас эцэслэн шийдвэрлэсэн гэж үзэх үндэслэлгүй ээ гэгчихсэн байгаа. Өөрөөр хэлбэл Бага Хурал дээр яригдаж байсан зүйл болохоос биш яг Бага Хурал эцэслэн шийдсэн гэж үзээгүй, 1992 онд. Тийм учраас 1992 онд Их Хурал сонгуулийн журмыг хуулиар тогтооно гээд ингээд гаргачихсан юм байна. Ингээж дүгнэлт хийж байгаад одоо энэ Улсын Их Хурал бол тэр үеийн Ардын Их Хурлын баталсан Үндсэн хуулийн дагуу сонгуулийг яаж явуулах журам, сонгуулийн тогтолцоо яаж байхыг Улсын Их Хурал өөрөө мэдэж хийх шийдэх эрхтэй гэдгийг баталгаажуулсан шийдвэр гарсан гэж үзээд энэ тогтоолоо гаргасан юм байна лээ, ерөөсөө л.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн гишүүний асуултад хуулийн төсөл хамтран санаачлагч Тогмидын Доржханд гишүүн нэмж хариулна. Ингээ, тэгвэл Энхболд гишүүн гүйцээгээд хариулчих. Дараа нь Доржханд гишүүн нэмж хариулъя. Энхболд гишүүн гүйцээгээд хариулчих.

**Н.Энхболд:** 92 оныхыг бол ерөөсөө Ардын Бага Хурал энэ асуудлыг эцэслэж шийдвэрлээгүй ээ. Үгүй ээ, харин тэгэхээр ингэсэн байна л даа. Бага Хурал шийддэггүй юм аа. Тэрийг энэ дээр юу ч алга. Тэр нь бид нарт хамаагүй, Бага Хурлын шийдсэн асуудал шүү дээ. Бага Хурал чинь Үндсэн хууль биш байхгүй юу, Үндсэн хуулийн төсөл ярьж байсан байхгүй юу. Үндсэн хууль Бага Хурал батлаагүй шүү дээ. Ардын Их Хурал баталсан. Ардын Их Хурал батлахдаа Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн журмыг хуулиар тогтоохоор заасан байна гэгчихсэн байгаа юм. Үгүй ээ, тэгэхээр одоо бид нар яриад байгаа шүү дээ. Тогтолцоо гэдэг чинь үүнийгээ л яриад байгаа байхгүй юу. Одоо нөгөө Цэцийн дүгнэлтийг л ярьж байна шүү дээ. Тэгээд ийм л юмны үндсэн дээр бид нар юм хийгээд байгаа юм.

19 онд ингэсэн юм. Тогтолцоо гэдэг үг оруулсан бид нар, холимог гэж ороогүй, биш ээ, би өөрөө мэдэж байгаа. Яг тогтолцоо гээд ганцхан хуулиар гэж үг байсныг тогтолцоо гэж үг оруулья гэж ярьж байгаад тэгээд тогтолцоо нь уначихсан байхгүй юу, тийм. Тогтолцоо гэдэг үг нь унасан юм. Сая бас Даваасүрэн гишүүн асууя. Энэ 12 оны жагсаалт бас хүн сонгох бололцоотой байсан тэр үед байгаагүй, нэрс байсан тэгэхдээ зөвхөн намыг нь дугуйлж байсан байхгүй юу. Одоо бол бид нар юу вэ гэхээр хүсвэл намаа дугуйл, тоолно, үгүй ээ харин тийм, тэгээд хүн дугуйлах дотроос чинь жагсаалтад орсон хүн болгон новших нь байна гэж байхгүй шүү дээ. Жагсаалтад орсон хүн болгоныг дугуйлахгүй, тийм, жагсаалтад орсон хүн болгоныг дугуйлахгүй, тэгээд энэ нээлттэй нь

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

түрүүчийнхээ зарчмын хувьд өөр байхгүй юу. Ийм л байгаа юм, тийм.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн гишүүний асуултад хуулийн төсөл хамтран санаачлагч Тогмидын Доржханд гишүүн нэмж хариулъя.

**Т.Доржханд:** Би энэ дээр бас Даваасүрэн гишүүнд бас тодорхой мэдээлэл өгмөөр байгаа юм. Нөгөө 2012-16 оны тогтолцоо бол муу байсан, яагаад гэвэл хаалттай байсан. Намын даргын эргэн тойрны хүмүүс сонгогддог. Тэгээд нэр нүүргүй улс төрчид сонгогдоно, тухайлбал нөгөө гээд л ингээд л ярьдаг шүү дээ. Энэ удаа бол нээлттэй юмаа. Тэгээд 2 дугаарт, нөгөө бусад улс төрийн намуудынхаа байр суурийг хүндэтгээч ээ гэж хүсэж байгаа юм. Тухайлбал Хүн намын хувьд бол манай листэд хамгийн их санал авахаар хамгийн нэр төртэй, цэвэр тэр улс төрчдийг бид нар оруулна, бид нар бүр оруулна. Яг үүгээрээ бусад улс төрийн намуудыг бас ингэж оруулна гэдэг хүлээлттэй байгаа. Түүнээс ингээд манай нам л ялж байвал хамаагүй, манай намын энэ нөхөд л ингэчихвэл хамаагүй гээд тэр нам чинь бас ард иргэдээс санал авахын тулд хамгийн дэвшилттэй, тэгээд зөв үзэл баримтлалтай, эрүүл саруул улс төрчдөө жагсаж онол авах байлгүй дээ. Авахгүй байх юм бол тэрийг дугуйлахгүй байя аа гэдэг тэр акцыг бид нар хамтдаа хийе гэж бодож байгаа. Үнэхээр хулгай хийчихсэн, тухайлбал нүүрсний хулгайд холбогдохсон, тухайлбал Хөгжлийн банкны хулгайд холбогдсон, мөнгөө ингээд өгдөггүй, тэгээд олон дахин сонгогддог ийм нөхөд хэрвээ листэд орж ирсэн бол иргэддээ тэр мэдээллийг нь өгье гэж бодож байгаа юм. Зөвхөн өөрийн нам гэхгүйгээр.

Ингэж бид нар энэ листийг цэвэрлэх учиртай юм. Тэгээд энэ маань ингээд нэг, хоёр, гурван удаа ингээд хэрэглэгдсэн тохиолдолд хэвшил болоод явчихдаг, соёл болоод явчихдаг. Тэгээд энэ бол иргэдийн сонгох эрх байхгүй юу. Гэтэл иргэдийн өмнөөс ингэчихнэ шүү дээ гэсэн

байдлаар явж байгаа нь ардчилсан ёс бас биш шүү. Тэгээд тийм болохоор бид нар энэ пропорциональ тогтолцоог 12-16 онд хийгээд ухралт гарсан нь юу вэ гэхээр Үндсэн хуулийн Цэцэд захиалга өгч байгаад, 2016 оны сонгуулийн нэг, хоёрхон сарын өмнө өөрчилчихсэн, ямар ч хэлэлцүүлэг болоогүй. Шууд сонголт гэдэг чинь хүнээ сонгодог юм аа гээд тайлбарлаад л явчихсан. Харин энэ Үндсэн хуулийн Цэцийн 01 дүгээр тогтоол бол энэ 30 жилийн болно, болохгүй гэдэг асуудлыг нэг тийш нь болсон. Тэгээд олон улсын ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

**Ц.Даваасүрэн:** Ер нь тэгээд ардчиллын зарчим олонхоороо олонхын санал авсан нь л явна шүү дээ. Түүнээс ч хэрэггүй ээ гээд байгаа, чи чадахгүй ээ гээд байгаа нам заавал би нөгөө санал гээгдлээ гээд байж болохгүй шүү дээ, энэ чинь ардчиллын зарчим бол тэр шүү дээ. Олонхын санал авсан нь л явна гэж. Тэгээд ард түмнээс шүүрдүүлсний буруу ерөөсөө байхгүй. Түүнд гоншигноод байх юм байхгүй. Санал авч чадахгүй байгаа бол хохино шүү дээ. Тэнд бол энэ нам ялчих гээд байна гээд суугаад байж биш ялахын төлөө бай л даа. Тэгээд сайн хатууж, зөв удирд, зөв хүмүүстэйгээ нөхөрлө, намаа зөв авч яв, олонхын итгэлийг ав. Ерөөсөө энэ чинь олонхын итгэлийг л авах асуудал шүү дээ. Тийм учраас энэ бол ардчиллын цэвэр зарчим гэж би ингэж ойлгож байгаа юм. Олонхоороо шүүлгээд явна гэж. Би шүүрдүүлэхгүй, шүүлгэхгүй болно гэдэг бол аюул гэж үзэж байгаа байхгүй юу. Тэгээд намын нэрийн араар шидчихээд л яах вэ танайхан бол юм авахгүй ээ Доржханд аа, манайхан бол авна.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн гишүүн санал хэллээ. Яах юм, нэмж тодруулах юм уу. Тодруулъя. Даваасүрэн гишүүний микрофоныг өгчих.

**Ц.Даваасүрэн:** Ер нь бид нар энэ иргэдийнхээ саналыг намд өгөх гэж

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байгаа гэдгээ л бодох хэрэгтэй байхгүй юу. Муухай шүү дээ. Ард түмнийхээ саналыг авчхаад зөндөө л гоншигнож гүйсэн шүү дээ, надыг гаргаад өгөөч гэж. Тэгэхдээ магадгүй энэ хууль батлагдахгүй ч байж магадгүй шүү. Очно шүү, та нар, ард түмэн дээр, хараарай гарах нь уу үгүй юу. Эцсийн дүндээ бол ард түмэн шүүнэ. Тэгэхдээ ард түмэн тэр энэ хуулийг зүтгүүлж байгаа энэ хуулийг яаж байгаа намуудыг сонгохгүй байх хэрэгтэй. Яагаад гэвэл та нарын саналыг хулгайлж байгаа учраас, та нарын хүнээс сонгох эрхийг булааж авч байгаа учраас, ард түмэн эсрэг санал өгөх хэрэгтэй. Би бол тэгж уриална, тэгэх ёстой. Яагаад гэвэл ард түмнийхээ эсрэг Үндсэн хуулийнхаа эсрэг байгаа учраас. Үндсэн хуульдаа хий л дээ тэгвэл. Үндсэн хуульдаа хийгээд явах юм бол надад ярих юм алга байна шүү дээ. 25 нас хүрсэн иргэнийг сонгоно гэж байна. Дундуур нь ямар нэг нам орж байгаа юм алга байна ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар “Хууль, эрх зүйн боловсролыг дээдлэгч хамт олон” уралдааны аварга “Монгени” цогцолбор сургуулийн 9-ийн Г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсье.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Хууль санаачлагч болоод Сонгуулийн ерөнхий хорооноос ганц хоёр асуулт байгаа. Тэр 38, 38-ын жагсаалтын 38-ыг нам сонгоно аль эсвэл нам сонгохгүйгээр тэнд байгаа намын нэр дэвшигчийг сонгоно гэж ингэж дахин дахин л дуулдаад байна л даа. Энэ яг юу гэсэн үг юм бэ? Намыг нь сонгохгүй бол намын нэр дэвшигчийг сонгочихвол тэр нэр дэвшигчийн саналыг нам дээр тоолно гээд байгаа юм уу. Энэ чинь тухайн хувь нэр дэвшигчийг сонгогчоод үүнийг тухайн

намын санал дээр нэмж тоолно гэдэг агуулга л сүүлийн үед ингээд дуулдаад байхаар түүн дээр нэлээн тийм эргэлзээ олон зүйлүүд, зарчмын асуудлууд байгаа учраас ямар ч байсан эхлээд үүнийг нэг тодруулчихъя.

Хоёрдугаарт нь, сонгуулийн хорооноос та нар тэр түрүүн бас нэг гишүүний асуултад гарч байсан, техникийн хувьд хэрвээ 38 бол, хэрвээ 28 бол, тэгээд 30-аад нам бол янз бүрийн хувилбараар тооцоход саналын хар машин сонгогчийн нөгөө хуудсыг унших бүрэн боломжтой. Магадгүй энэ 500-аас 1000 нэр дэвшигч ч гарах нь байна л даа. Тэгээд энэ дээр нам, мажоритарын нэр дэвшигч гээд дугуйлалтууд гарах юм байна. Дахиад дээрээс нь намаасаа гадна лист доторх нэр дэвшигчийг гэвэл 3-аас доошгүй нэр дэвшигчийг сонгох юм байна. Тэгээд 500-аас 1000-аад хүний асуудал гарах юм байна. Түрүүн би сонссоноор 50 хэдэн инч сантиметр ч гэлүү, инч ч гэлүү ингээд үзэхэд техникийн хувьд аль ч хувилбараар авахад бүрэн боломжтой гэж сонссон үнэн үү? Энэ дээрээ нэг нэмээд тайлбар өгөөч ээ?

Хоёрдугаарт нь, сонгуулийн хорооноос сонгогчийн нэрсийн жагсаалтын нэгдсэн бүртгэл гэдгийг бид нар өргөн барьсан хууль дээрээ оруулж байгаа юм. Энэ сонгогчийн нэрсийн жагсаалтын нэгдсэн бүртгэл ер нь энэ сонгуулийн будилаан гэдэг зүйл ярьдаг. Энэ чинь нэг хэсэг нь хар машинтай холбоотой байна гэдэг, нөгөө хэсэг нь нэрсийн жагсаалт, нэрсийн бүртгэл дээр холбоотой байна гэдэг нэг ийм 2 их томоохон тийм хардлага сэрдлэг, үл ойлголцол яваад байгаа юм. Тэгэхээр энэ нэрсийн жагсаалт дээр нэгдсэн бүртгэл байдаггүйгээс болоод 2500 санал авах байр, 2500 санал тоолох машин дээр тус тусдаа давхацсан нэр очоод байна гэдэг ийм хардлага сэрдлэг одоо иргэдийн дотор тодорхой хэмжээгээр энэ сонгуульд оролцдог, энд нэлээн ойр явдаг хүмүүсийн дотор тийм нэг мэдээлэл байгаад байдаг. Тэгэхээр энэ нэгдсэн



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

жагсаалт гэдэг зүйл дээр Сонгуулийн ерөнхий хороо ямар бодол саналтай байна? Одоо ч гэсэн тийм иргэдийн нэгдсэн бүртгэлээс бид нар улсын бүртгэлээс авдаг гэж бас хэлэх байх. Тэгэхдээ дээр нөгөө дэд хороон дээр Сонгуулийн ерөнхий хорооны даргыг байж байхад бас одоогоор нэгдсэн бүртгэл байдаггүй гэдэг нэг үг гарч байсан. Та тэгэхээр энэ бүгдийг нэгтгээд тэр хар машинаас гадна сонгогчийн жагсаалттай холбоотой ийм үл ойлголцол байдагт та нэг хариулт өгөөч. Тэгээд үүнээс сэргийлсэн нэгдсэн бүртгэл гэдэг зүйлийг хэрхэн яаж бий болгож болох вэ? Үүн дээр та нэг хариулт өгөөч ээ.

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад Нямаагийн Энхболд гишүүн хариулъя. Дараа нь нэмээд ажлын хэсэг хариулъя.

**Н.Энхболд:** Өргөн барьсан Сонгуулийн хуулийн төслийн заалтаар бол иргэн хүн 2 санал өгнө. Нэгдүгээрт, тойрогт нэр дэвшиж байгаа хүнийхээ төлөө санал өгнө тийм ээ. Тойрог дээрх саналаа өгнө. Хоёрдугаарт, 2 дахь санал нь 2 варианттай байхгүй юу. Эсвэл намын төлөө өгнө. Жишээлбэл, би хүн нь ч яах вэ дээ, ер нь нам бүхэлдээ юу чадах юм, ямар мөрийн хөтөлбөр дэвшүүлж байгаа юм, ямар түүхтэй, уламжлалтай явж ирсэн юм, энэ талаас нь бодоод ер нь би бодлого талд нь намаа өгнө гээд хүн харалгүйгээр намуудын мөрийн хөтөлбөрүүдийг харьцуулж байгаад санал өгдөг тийм юм бий шүү дээ. Ер нь бид нар цаашидаа энэ рүү нь илүү их хандуулах ёстой юм болов уу гэж би боддог. Тэр тохиолдолд намын төлөө саналаа өгчих. Тэгээд л гүйцээ, тэр хүний 2 санал гүйцээ. Тойрогт өгчихсөн, намд өгчихсөн.

Эсвэл тойрогт өгчөөд одоо манай зарим гишүүдийн яриад байгаа шиг хүнээ таньж байж өгнө, би хүнд л өгнө. Түүнээс тэр нам, мөрийн хөтөлбөр нь надад хамаагүй гэж бодвол нөгөө нэр дэвшүүлсэн хүнээ судалж байгаад 1 хүний

төлөө саналаа өгчихнө, 1 хүний төлөө. Өөрөөр хэлбэл, тэр хүн цаад утгаараа бол тэр намаас нэр дэвшсэн хүний төлөө өгч байгаа бол тэр намын төлөө л өгч байна гэсэн үг шүү дээ, тиймээ. Ингээд 2 л санал тэр хүний саналд тоологдоно, 1 хүнээс 2 санал тоологдоно. Тойрогт хэний төлөө өгөө вэ, нам юм уу намаас дэвшүүлсэн хэний төлөө саналаа өгөө вэ гэдэг ийм 2 санал тоологдоно. Тэгээд намд өгсөн санал хүнд өгсөн одоо жагсаалтад байгаа хүнд өгсөн санал 2-ын тоо нийлээд яг сонгогчдын тоотой нийлж байх ёстой ийм л зарчмаар явж байгаа. Давхардахгүй, бас манайхан буруу ойлгоод байх шиг байна. Эхлээд намд өгчөөд, тэгээд хүнд өгчихнө. Тэгэхээр нь тэр хүнд өгсөн саналыг нь дахиад нам дээр нь явчихна гэж. Тэгвэл энэ их утгагүй юм болох байх.

Тэгэхээр ерөөсөө 1 хүн бол тойргийн төлөө 1 санал өгнө, эсвэл дараагийнх нь намын юм уу, тэр намаас дэвшсэн хүний төлөө, тэгнэ шүү дээ, тэгнэ шүү дээ. Жишээ нь ингэж болно шүү дээ. 1 хүн Цогтгэрэл гишүүн ээ, мөрийн хөтөлбөрийг нь харж байгаад Ардын намын төлөө саналаа өгчхөж болъё гэж бодъё тиймээ. Хүнийг нь харж байгаад хүн дотроос нь бол би харин АН-ын энэ хүнд өгнө гээд өгчхөж болно шүү дээ. Тэгэхдээ эцсийн дүндээ тэр чинь 1 л санал өгч байгаа гэсэн үг шүү дээ. Ардын намын төлөө өгөөгүй юм чинь АН-ын хүний төлөө өгчихлөө, эд нар нь бүгдээрээ нийлж байгаад л нийт сонгогчдын тоо болно. Тэгэхээр наана чинь асуудал байхгүй, энэ талаас нь бас их хүмүүст зөв ярьж ойлгуулах ёстой юм байна лээ. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг хариулъя, ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Сонгуулийн ерөнхий хорооны дарга хариулъя.

**П.Дэлгэрнаран:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нар энэ хуулийн төсөл дээр заагдсан нэр дэвшихтэй холбоотой бүх

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үзүүлэлтүүд дүүрэн байхаар тооцож, бид нар бол хаширлаж, тэгээд энэ саналын хуудсыг макет хийж үзсэн. Үүнийг өмнө нь бол бүртгэл хяналтын дэд хороон дээр бид нар бас яг макет хэлбэрээр нь үзүүлсэн. Техникийн ажилтнууд, инженер техникийн ажилтнуудтайгаа зөвлөлдсөн. Үүнийг яг одоо ийм болсон нөхцөлд хэрэглэж болох эсэхээр, тэгээд техник манай одоо хэрэглэж байгаа техникийн үзүүлэлт бол энэ саналын хуудсыг унших хүчин чадалтай. Тэгээд үүнийг ийм нөхцөлөөр хийгдсэн байхад саналын хуудсыг техник хэрэгсэл маань хүлээж авч уншина гэж ингэж үзэж байгаа. Тэгэхдээ яах вэ, бид нар бол хамгийн дээд хязгаараар хийсэн учраас яг бодит байдал дээр саналын хуудас маань харьцангуй богино болох байх аа гэж бид нар бодож байгаа.

Нэрсийн жагсаалттай холбоотой асуудал дээр таны юутай манай Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ хариулна.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье. Нэмж хариулъя.

**Д.Бат-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүний асуултад нэмж хариулъя. Ер нь бид сонгогчдын нэрийн жагсаалт 1 баазтай байх, сонгогч хаана ч явж байсан зөвхөн тэр нэгдсэн баазаас нь санал өгсөн, өгөөгүй нь гардаг байх энэ чиглэл рүү бол бид нар ер нь цаашидаа явах ёстой. Энэ бол мэдээж техникийн үндсэн суурь дэд бүтэцтэй бол шууд хамааралтай. Улсын бүртгэлийн ерөнхий газартай бид нар хуулийн төслийг боловсруулах явцад яг энэ асуудлаар бас уулзаж зохион байгуулсан. Ингэхэд бол сум, хорооны түвшинд бол одоогийн байдлаар бол энэ дэд бүтэц бол бүрэн бүрдчихээд байгаа. Гэтэл хэсгийн хороод маань багууд дээгүүр гардаг учраас бол түүн дээр бас яг бүрэн дүүрэн одоо энэ нэгдсэн нэг ийм нэрийн жагсаалттай байна гэхээр бас техникийн хувьд, дэд бүтцийн хувьд бас бүрэн шийдэгдэх боломжгүй байгаа.

Ер нь энэ сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдлыг хангах, хяналттай байлгах тал дээр өргөн барьсан хуулийн төсөл дээр хэд хэдэн зохицуулалтууд тусгагдсан байгаа. Тухайлах юм бол, сонгогч энэ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Их Хурлын сонгуулийн тухай хуулиар бол зөвхөн өөрийнхөө мэдээлэлтэй танилцах л эрхтэй байсан бол энэ өргөн барьж байгаа төслөөр өөрийнхөө болон өөрийн хаяг дээр байгаа бусад хүмүүсийн нэртэй танилцах ийм боломжийг бүрдүүлж байгаа. Энэ маань өөрөөр хэлэх юм бол манай хаяг дээр танихгүй хүн байна гэдэг энэ маргааныг эрт шийдвэрлэх ийм боломжийг нэг талаараа олгож байгаа.

Нөгөө талаасаа сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх энэ үйл ажиллагаа дээр сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчид мөн сонгуулийн үйл ажиллагаанд хяналт хөндлөнгийн мониторинг хийдэг төрийн бус байгууллагууд бол хяналт тавих ёстой гэдэг дээр өнгөрсөн хугацаанд явагдсан хэлэлцүүлгүүд дээр саналууд гаргаж байсан. Тэгэхээр яг энэ санал дээр үндэслээд энэ сонгуульд оролцогч бүх талууд бол нэрийн жагсаалтын энэ үйл ажиллагаа дээр холбогдох журмын дагуу танилцаад, хяналтаа тавих эрхтэй байх ийм зохицуулалтыг бол нэмж тусгасан байгаа.

Мөн дээрээс нь Сонгуулийн ерөнхий хороон дээр нэрийн жагсаалттай холбоотой гомдлууд ирэхэд бол яг Сонгуулийн ерөнхий хороо шийдвэрлэх боломжгүй болчихоод байдаг. Тэгэхээр энэ асуудлыг бол шийдвэрлэх нэг зохицуулалт тусгачихсан. Тэр нь юу вэ гэхээр зэрэг сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг шаардлагатай гэж үзэх юм бол Сонгуулийн ерөнхий хорооноос Улсын бүртгэлийн ерөнхий газраас шаардлагатай мэдээлэл баримтуудаа гаргаж аваад, зөрчлийг арилгах асуудлаар бол холбогдох байгууллагууд нь хугацаатай үүрэг даалгавар өгөх ийм

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

эрхтэй байх ийм нэмж ийм зохицуулалтууд тусгагдсан байгаа.

Энэ сонгогчдын нэрийн жагсаалт болон санал тоолох төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, нөхөн бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар бол Сонгогчийн бүртгэл хяналтын дэд хороон дээр яг энэ хуулийн төсөл өргөн баригдсантай холбоотойгоор зэрэг энэ бэлтгэл ажлууд бол хийгдэж явж байгаа. Сонгуулийн ерөнхий хорооны хувьд энэ бүртгэл хяналтын дэд хороон дээр энэ техникийн нөхөн бүрдүүлэлтийн асуудлыг танилцуулгаа хийгээд ингээд явж байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм уу? Нямаагийн Энхболд гишүүн нэмж хариулъя.

**Н.Энхболд:** Түрүүн би хэлэхдээ тойрог дээр бол нэг л санал гээд хэлчихсэн. Тэгэхдээ бас хүмүүст буруу мэдээлэл очиж магадгүй. Магадгүй зарим тойрог дээр 2 юм уу, 3 хүний мандаттай байж болно шүү дээ, тийм ээ. Мандатынхаа тоогоор л саналаа өгчихнө. Нөгөө 2 нь миний түрүүн тайлбарласан маягаар явах юм.

**Л.Мөнхбаатар:** Та нэмж асуух гэж байна уу? Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Сонгуулийн хорооноос тэр 1 баазтай байх асуудлыг шийдэх хэрэгтэй гэж байна л даа. Үүнд ер нь ямар хэмжээний нөөц бололцоо шаардагдах юм? Цаг хугацаа, софтвэйр, олон зүйл. Яг үүний цаана чинь л 1 хүн олон удаа санал өгөөд байна, нэгдсэн бүртгэлтэй биш байна, давхар давхар бичигдээд байна гэдэг нэг ийм хардлага сэрдлэг л яваад байгаа шүү дээ. Үнэн эсэхийг мэдэхгүй, ийм маш том хэмжээний ийм хардлага сэрдлэг яваад байгаа. Тэгэхээр энэ дээр ямар хэмжээний хүн хүч, нөөц бололцоо, хөрөнгө мөнгө юу хэрэгтэй юм? Софтвэйр хардвэйр юу хэрэгтэй юм? Түүн дээр нэг юм хэлээч.

2 дугаарт нь, тэр Энхболд даргаас та тэр тойргийг нь орхичихъё, жагсаалт хэсэг гэдэг чинь ерөнхийдөө энэ намын нэгдсэн бодлого авч явах гэж байгаа хэсэг. Гэтэл та түүн дээр жагсаалт хэсэг буюу пропорциональ хэсэгт хүн дугуйлчхаад тэрийг намын санал тоолно гээд байх юм. Энэ чинь яг жинхэнэ зарчмаараа энэ ямарваа нэгэн энэ пропорционалийн тухай яриа биш. Энэ чинь улс даяар бараг нэг тойргийн тухай томсгосон ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хариултаасаа өмнө зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн, Энх-Амгалан, Мөнхбаатар нарын урилгаар Хөвсгөл аймгийн ахмадын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Цогтгэрэл гишүүний тодруулгад хэн хариулах вэ? Энхболд гишүүн хариулъя. Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Намуудын төлөө өгөх санал нь ойлгомжтой тиймээ, хөтөлбөртөө өгч байна гэж үзнэ. Жагсаалтад байгаа хүмүүс дотроос аль нэг намын хэн нэгийг дугуйлна гэдэг бол ерөнхийдөө таны хэлсэнтэй би бол санал нэг байна. Энэ бол улсын хэмжээнд том тойргоос сонгогдож байгаа л гэсэн үг байхгүй юу. Үгүй ээ, танай намын хүнд өгсөн, үгүй ээ тэр өөр. Тэр тойрог чинь өөр, үгүй ээ үгүй. Тэр өөр биш ээ. Яах вэ түүнийг та нар өөрсдийнхөөрөө ойлгоод яв. Ер нь мөрийн хөтөлбөрт өгч байна, хүнд өгч байна, том мажоритартад өгч байгаа, тийм. Тэгэхдээ үгүй ээ биш намын жагсаалт гаргаж байгаа юм чинь намын жагсаалтад өгч байна. Намын мөрийн хөтөлбөрт өгч байна гэдэг чинь пропорциональ руу өгч байгаа юу байхгүй юу. Тэгээд бид нар олж авсан арга нь энэ юм. Тэгэхгүй болохоор түрүүчийн удаагийн сонгуулийн ... /минут дуусав/

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Л.Мөнхбаатар:** Энхболд гишүүн гүйцээгээд хариулчих.

**Н.Энхболд:** Түрүүчийн сонгуулийн 2012 оны сонгуулийг нөгөө холимгоор явуулсныг дагаж гарч байгаа гол шүүмжлэл чинь наадах чинь байхгүй юу. Үгүй ээ, тэртээ тэргүй хүн бүгдийг нь юу яана. Тэгээд ингэж ярьж байна шүү дээ. Жагсаалт дотроо хүмүүс янз бүрийн юм хийчихнэ ээ намууд, үгүй ээ тэгээд л түүн дотроос нь сайныг нь шилээд сонгог л дээ. Тэгээд нэгэнт танай намаас дэвшсэн нэр дэвшигч юм бол АН-даа 1 оноо авчирч, 1 санал авчирч байна гэсэн үг шүү дээ. Намын чинь мөрийн хөтөлбөрт өгчихлөө, эсвэл бол танай намаас дэвшсэн хүнийг хүнээ харж байгаад сонгох сонирхолтой хүн дэмжчихлээ гэж бодоход тэр АН дээр л тооцогдохоос биш тэр хүнийг Ардын нам дээр тооцохгүй шүү дээ.

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад нэмж хариулъя. Хуулийн төсөл хамтран санаачлагч Доржханд гишүүн хариулъя. Доржханд гишүүний микрофоныг өгөөрэй, асуултад хариулъя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр энэ ингээд бид нарын парламент дээрээ бас нэг талдаа гаргах ёстой зүйл мөн үү гэвэл мөн. Ер нь бол 2012-16 оны тогтолцоо бол параллель тогтолцоо, холимгог биш параллель тогтолцоо гэж ойлгох хэрэгтэй. Тэгээд тэр бол хаалттай жагсаал буюу намд нь өгдөг, намын бодлогод нь өгдөг энэ тогтолцоо бол олон улсын жишиг юм. Гэтэл нөгөө шүүмжлэл зарим 1 гишүүдийн шүүмжлэл болохоороо нам биш хүнээ дугуйлдаг баймаар байна гэсэн энэ шүүмжлэлээс болоод тэгвэл дараачийн асуудал нь жагсаалтаа нэе гээд тэгээд нээгээд явж байгаа. Уг нь бол зарчим бол эхнийх нь зөв юм. Тэгж байж улс төрийн нам тогтворждог, төлөвшдөг, институц бий болдог бодлогоор өрсөлддөг. Уг нь энэ бол олон улсын жишиг. Ингэж байж эмэгтэйчүүдийн төлөөлөл нөгөө бүлгүүдийн төлөөллүүд орж ирж байдаг,

тийм. Үүнийгээ бол харин нөгөө ажлын хэсэг дээрээ зүгээр яриад явах нь бол зүйтэй.

Тэгээд холимог тогтолцоо гэдэг бол хоорондоо ингээд уусдаг тогтолцоо шүү дээ. Үүнийг бол уг нь бид нар санал болгосон гэхдээ ажлын хэсэг дээрээ ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Дараа нь нэгтгээд хариулуулчихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж ирж байна. Ер нь хэдүүлээ нэг сайн нухацтайнхан үзэх хэрэгтэй байх. Энэ өнгөрсөн оны 10, 11, 12 сард гадаа жагсаал болсон, бүгд мэдэж байгаа. Дээрээс нь нүүрс, Хөгжлийн банктэй холбоотой хэлэлцүүлгүүд болсон. Ер нь ард иргэд нэлээн бухимдалтай байсан, одоо ч бухимдалтай байгаа. Тэгээд энэ саарал байшин дотор нэг болох бүтэхгүй хэдэн 76 нөхөд суугаад байгаа юм шиг л ийм л ойлголт байгаад байгаа шүү дээ. Маш олон, энэ жагсаал бол ер нь яг бодит болсон жагсаал гэж би бас бодоод яваад байгаа. Хэд хэдэн хүмүүстэй уулзсан. Жагсагчидтай уулзсан, олон сайхан залуучууд, мэдлэгтэй боловсролтой хүмүүстэй уулзсан. Тэгээд ярьж байхад та нар хэрвээ ингээд үнэхээр энэ 76 гишүүн болохгүй, бүтэхгүй нөхөд гээд байгаа юм бол өөрсдөө орж ирээд ингээд засалцаад явахад яадаг юм гэсэн. Тэгэхээр сонгуулийн зардлаа бид нар гаргаж чадахгүй, наад сонгуульд чинь орж чадахгүй шүү дээ л гэж байгаа байхгүй юу. Энэ маш том асуудал.

Тэгэхээр түрүүнээс хойш сонгуультай холбоотой, юу зардалтай холбоотой асуудлууд яригдаад байна, нэг л одоо бид нар шийдлүүд хийж чадахгүй л байх шиг байх юм. 1 асуулт байгаад байна. Ажлын хэсэг яг сонгуульд 1 гишүүнээс дунджаар хэдэн төгрөг гарч байна гэсэн ийм тооцоо гарсан уу? Үүнийг



барагцаагаар хэлж өгөөч боломж байна уу? 1 дүгээрт.

2 дугаарт, бид энэ зардал маань их байх тусмаа ер нь санал худалдаж авах тал руугаа орж байна гэсэн ойлголт байгаад байгаа шүү дээ. Монгол Улсын 1 иргэн статистик тоогоор сая 500 төгрөгийн орлоготой цалинтай гэж байгаа юм. Статистик тоо шүү дээ. Ингээд 12 сард нь үржүүлээд 4 жилд нь үржүүлэхэд 72 сая төгрөгийн орлоготой гэж байгаа юм. Монгол Улсын 1 иргэн 72 сая төгрөгийн орлоготой гэж үзсэн. Сонгуульд та бүхэн хэл дээ, яг хэдэн төгрөг ер нь дунджаар зарж орж ирж байна? Тэгэхээр үүний зөрүү ямар хэмжээтэй байгаа вэ? Үүнээс ингээд харахаар хэн мөнгөтэй, бололцоотой, боломжтой, сонгуульд ордог, цаана нь өчнөөн олон мэдлэгтэй, боловсролтой, чадалтай, туршилагатай судлаач, эрдэмтэн, эдийн засагчид сонгуульд орох ийм боломж бололцоогүйгээр ард талд нь үлдэх ийм нөхцөл байдал бий болгочоод байна шүү дээ. Үүнээс чинь хамаг юм бий болоод байна шүү дээ. Тэгэхээр эндээс ер нь сонгуулийн зардлыг нэг хамаагүй ингээд хаячхаж бас болмооргүй байгаад байгаа юм.

2 дугаарт, тэр ухуулагчтай холбоотой асуудлууд байна. Сайн дурын гэсэн бол одоо сайн дураараа явчихмаар байна. Өөрсдийгөө удирдах, өөрсдийнхөө төлөөлөл болж байгаа удирдах гэх юм уу, юу гэх юм одоо өмнөөс нь бол хууль батлалцах, амьдралынх нь хуулийн суурь хуулийг баталж өгөх ийм хүмүүсээ томилж байгаа бол, ийм хүмүүсээ сонгож байгаа бол, яагаад сайн дураараа үйлчилж бас болохгүй гэж.

Тэгээд 2 дугаарт, энэ сонгогчдоо бид нар ер нь жилээс жилд л улам одоо буруу юм руу л, жишиг рүү л оруулаад байгаа шүү дээ. Яг тоотой хэсэг яг амьдрал дээр хэдүүлээ үнэнээ ярьж л даа. Энэ чинь, амьдралдаа юун дээр тоотой яг бодит хуульд заасан хүмүүст нь бас тодорхой хэмжээгээр хөлсөө зараад

ингээд явуулдаг, бусдыг нь бас ил далд янз, янзын тийм сурталчилгаа ухуулагч нар томилоод явуулдаг гээд ингээд л явж байгаа юм. Тэгээд бид нар яг үүнийгээ засаж байж нөгөө нэг цэвэр нийгмийг бий болгох, цэвэр энэ дотор боломж бололцоотой хүмүүс нь орж ирэх, тэгээд хууль жинхэнэ батлалцдаг судлаачид нь орж ирэх, бүх зүйл чинь үүний чинь суурь нь ерөөсөө энэ зардалтай холбоотой асуудал болчихоод байна шүү дээ. Тэгээд энэ дээр нэг хариулт аваад, тэгээд дахиад тодруулъя.

**Л.Мөнхбаатар:** Хуулийн төсөл санаачлагч Нямаагийн Энхболд гишүүн хариулъя, нэмж ажлын хэсэг хариулж болно.

**Н.Энхболд:** Түрүүн яг ийм асуулт гарсан, тэгээд би хэлсэн л дээ ажлын хэсэг дээр Мөнх-Оргил гишүүн ч бас энэ асуудлыг хөндсөн. Ер нь угаасаа яг л Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаагаар үнэхээр өөрсдийнхөө ирээдүй, өөрсдийнхөө үр хүүхдийн ирээдүй, улс орны ирээдүйн төлөө чин сэтгэлээсээ зүтгэе гэж байгаа бол хүн болгон өөр өөрийнхөө байран дээр тэгвэл энэ сурталчилгаа энэ юмнуудыг үнэ төлбөргүй, сайн дурынхаа үндсэн дээр хийж өгч байвал яасан юм бэ гэдэг асуудлыг ярьсан. Одоо чухам яг өнөөдрийн бид нарын сонгууль явж ирсэн туршилагаас харахад хамгийн наад захын сурталчилгааны материалыг хүнд тарааж өгөхөөс эхлээд, айлуудад хүргэхээс эхлээд л ажил гардаг л даа. Тэгээд одоо яг тэгж хүмүүс явах нь уу, үгүй юү? Би бол сонгуульд ажиллаж байсан, ажиллах гэж бодож байгаа хүмүүсийн өмнөөс тэд нар бүгдээрээ ямар ч урамшуулал, цалингүйгээр тэгээд яваад өгөхөд бэлэн байна гэж хэлж мэдэхгүй л байна. Яах вэ, хэлэлцүүлгийн явцад хэдүүлээ санал гаргаад олонхоороо шийдэж болно. Ерөөсөө ухуулагч байна, бидний нэр дэвшиж байгаа хүмүүсийн төлөө ажиллах ёстой, үнэ хөлсгүй ажиллах ёстой, сайн дурынхаа үндсэн дээр ажиллах ёстой гэж олонх үзвэл

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тэгээд л гарчихна. Үгүй ээ, бас тодорхой хэмжээний зардал яах аргагүй гардаг даа, түүнд нь ядаж одоо бид нарын санал болгосон шиг үгүй ээ дор хаяж нэг 10 хэд хоногийн л ажил шүү дээ, тийм ээ. Ядаж нэг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний юмыг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шүү дээ. Ингээж байж бас тэр ажиллуулахгүй бол болохгүй дээ гэж болохгүй байх л гэж бодож бид нар саналаа оруулж байгаа. Тэгээд зарчмын зөрүүтэй санал оруулж болно, ухуулагч нараа та нар ямар ч урамиуулал, нөхөн төлбөргүйгээр бид нэр дэвшиж байгаа хүмүүсийн өмнөөс яваад, ялангуяа хөдөө энэ тэр бол, багуудаар хүргээд унаа малынхаа зардлыг гаргаад яв гэхэд бас яг өнөөдөр яаж хүлээж авах бол доо гэж бодож л ийм санал оруулсан юм. Хэлэлцүүлгийн явцад бол ямар ч байдлаар шийдэж болно л доо уг нь, тийм. Бусдыг нь өөр ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**П.Дэлгэрнаран:** Бат-Эрдэнэ гишүүний тэр асуусан тооцоолол дээр хариулахад бол ийм байгаа. Яг одоогийн байдлаар бол хууль батлагдаагүй байхад тэдэн төгрөг гарна аа гэх нарийн тооцоолол хийх боломжгүй байна. Ер нь энэ тооцооллыг бол хууль батлагдсаны дараагаар төрийн аудитын байгууллага гаргаж тогтоодог, ингээд өгдөг. Зүгээр яах вэ, энд сонирхуулаад гэх юм уу, 20 онтой харьцуулаад хэлэх юм бол 20 онд бол нэг тойрогт дунджаар ер нь тойргуудын зардал бол харилцан адилгүй байдаг. Хот хөдөө гэдэг юм уу, үүнээсээ болоод ер нь 390 орчмоос 600-гийн хооронд 20 оны зардал бол 600 сая орчим төгрөгийн хооронд ингээд нэг дунджаар 400-аад сая төгрөгийн ийм зардалтайгаар 20 оны сонгууль болж өнгөрсөн. Тэгэхээр одоо бид нарын энэ өргөн барьсан, манай гишүүдийн өргөн барьсан энэ хуулийн төслөөр зардлыг 50 хувь хямдруулна аа гэвэл яах вэ 1 барагцаагаар ийм тооцоолол харагдах юм

аа гэсэн урьдчилаад зүгээр барагцаалж хэлбэл иймэрхүү тооцоолол харагдах юм аа л гэж хэлэх байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ажлын хэсэг маань бас амьдрал руу орж хариулахыг хүсэж байна. Хэрвээ нэгэнт л хууль хийж байгаа доторх бас судалгаа юмнуудаа хийчихсэн л байх ёстой шүү дээ, энэ чинь. Тэгээд би сая хэллээ шүү дээ. Нэг Монгол Улсын нэг иргэн статистикийн дундаж үнэлгээгээр 72 сая төгрөгийн орлого олж байгаа шүү. 72 сая төгрөгийн орлого олж байгаа. Таны саяын хэлж байгаагаар 600 сая төгрөг дунджаар зарах гээд байна. Асар их зөрүү байгаа биз. Юуны төлөө ийшээ зүтгэж байгаа юм гэдэг асуултыг асууж байгаа шүү дээ, энэ чинь ,бодит байдал шүү дээ энэ чинь, хариулж чадахгүй л байгаа шүү дээ. Тэгээд үүнийгээ шийдэж байж хэдүүлээ явах хэрэгтэй шүү дээ энэ чинь одоо. Үнэхээр одоо цэвэршье, нийгмээ сайжруулъя одоо үнэхээр бодит хувьсгал хийе, шинэчлэл хийе л гэж байгаа бол бид нар ингээд энэ өөрчлөлтүүдийг хуульдаа оруулах хэрэгтэй шүү дээ.

Дээрээс нь 30 сая төгрөг гэж байх шиг байна 1 компани, 2 компани 60 ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ гишүүн гүйцээгээд асуучихъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгээд нэг бол энэ чинь хандиваар мэдлэгтэй, боловсролтой хүмүүс нь тэгээд хандив авч байгаад сонгуульд орох, мөнгөтэй хүмүүс, бизнестэй хүмүүс нь бол мөнгөө зарж сонгуульд орох нэг хоёрхон л зам болчихоод байна шүү дээ. Тэгээд үүнийхээ ар дээр 30 сая төгрөгөөр нэг компаниас хандив авсан хүн цаашаагаа нөгөө компанитайгаа яах вэ, угаасаа баярлалаа гэж хэлээд үлдэх үү? Баярлалаа гэж хэлээд дуусах уу? Мөрөн дээрээ алгадаад ингээд асуудал ингээд шийдэгдээд дуусчих

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

уу? Үүнийгээ бодолцох хэрэгтэй байна шүү дээ. 30 сая гэж би сая харлаа, 30 сая төгрөгт нэг компани өгнө гэж байна. 2 компани 60 сая, 10 компани 300 сая, тэгээд нөгөө нэг компаниудын ивээлд ордог, компанийн төлөөлөл болдог гэдэг юм чинь энэ чинь ингээд л бид нар өөрсдөө хуульд нь албан ёсоор суутгаад байгаа юм биш үү.

Ухуулагчтай холбоотой асуудал дээр бол ер нь би түрүүн хэллээ шүү дээ. Үнэхээр улс орныхоо төлөө өөрсдийнхөө энэ итгэл үнэмшилээр одоо төлөөлөл болж байгаа гэж явж байгаа бол энэ хүмүүс бид тодорхой хэмжээнд ажиллах ийм боломж бололцоог нь олгох, тэртээ тэргүй хүн өөрсдийнхөө ирээдүйн төлөө зөв хүнээ сонгоё гэж байгаа түүнийхээ төлөө нэг гүйж очоод нэг хэдэн материалыг нь тараагаад өгчхөлгүй ч яах вэ дээ, уг нь. Хамгийн гол нь бид нар шинэчлэлээ хийж чадаж байгаа юу? Энэ нийгмээ цэвэршүүлж чадаж байгаа юу, ирээдүйн бидний зорилго чинь юу билээ, ардчилсан нийгмийг бий болгох, дундаж давхаргыг бий болгох, ингээд том хувьсгал хийх том шинэчлэл хийх ёстой гэж л бид нар энэ рүү зориод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ талынхаа зүйлүүдийг.

2 дугаарт, тэр царцаатай холбоотой асуудал дээр нэг хариулт хэлж өгөөч. Жил болгон баахан царцаа давхиж очдог шүү дээ. Царцаа, яг үүнтэй мөн ижил зөндөө олон хүмүүсийг дайчлаад тийшээ аваачаад л хэвтүүлчихдэг, мянга мянгаар нь царцаа аваачаад явуулчихдаг. Бас мөнгөтэй хүмүүсийн энэ нэг асуудлууд байна. Ер нь бол жишээ нь манай тойрог дээр Бат-Эрдэнэ гэдэг нэг хүн нэр дэвшсэн. Ямар ч одоо сурталчилгаа юу ч хийхгүй зүгээр л дэмий тэнэсээр байгаад л дууссан. Үгүй ээ, очиж очиж Бат-Эрдэнэ гэдэг хүн давхцаж очоод тэгээд тэр хүн үнэхээр сонгогдъё гэсэн бол бас нэг явна даа, хүнтэй уулзана даа. Машин тэрэг тэр ухуулагч хөлсөлсөн яах вэ тэгээд л явсаар байгаад л дууссан шүү дээ. Үгүй ээ, инээдтэй байгаа биз дээ, энэ чинь. Хэн нэг нь бас л мөнгө төгрөг

өгөөд л явуулж л байна шүү дээ, энэ чинь. Амьдрал дээр байгаа шүү дээ. Энэ чинь том ухуулагч, үгүй ээ тэгээд иймэрхүү зүйлүүдээ энэ царцаатай холбоотой асуудал гээд ерөөсөө бид нарт амьдрал шийдэх асуудлууд зөндөө л байгаад байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Байр сууриа илэрхийлээд үг хэлчихлээ гэж ойлголоо.

Хавдисламын Баделхан гишүүн асуултаа асууя.

**Х.Баделхан:** Баярлалаа. Манай Үндсэн хуульд бол Улсын Их Хурлын гишүүдийг шууд сонгоно гэж заасан байгаа. Их Хурлын гишүүд иргэдийн төлөөлөл, ард түмний төлөөлөл, нөгөө талаараа орон нутгийн төлөөлөл, манай өргөн уудам нутагтай Монгол орны хувьд аймаг, сум болгоноос, аймаг болгоноос ингээд сонгогдоод Их Хуралд суудаг. Их Хурал бол манай төрийн эрх барих дээд байгууллага. Нэг ёсондоо төрийн төлөөллөө сонгож байгаа хэлбэр л дээ. Тийм учраас нутгийн иргэдийн төлөөлөл заавал байх ёстой гэж ингэж үзэж байгаа.

Манай аймгийн хувьд ер нь улсын хэмжээний хамгийн олон хүн амтай аймгийн тоонд ордог, эхний 3 аймагт ордог, 3 аймгийн тоонд ордог. Ер нь сонгууль болгон дээр 3 хүний төлөөлөл бол байнга сонгогдоод ирсэн юм байна лээ. 3 хүнээ төлөөлөл болгоод парламентад суулгаж ирсэн юм байна. Бүр анх 1924 онд анхны Үндсэн хуулиа батлахад бас 3 хүний төлөөлөл оролцож байсан түүхтэй юм байна лээ. Гэтэл 12 онд бол холимог тогтолцоотой болоод 2 хүн сонгогдсон. 12 онд холимог тогтолцоо бөгөөд 48, 28-аар сонгууль явагдсан. Тэгээд хүний тоо 1-ээр буураад 2 хүн болсон. Одоо энэ удаа 50, 50-аар ингээд сонгууль явагдах юм байна. Тэгэхээр бүр 1 хүн болчих болов уу гэсэн тийм бодолтой байгаа, орон нутгийн иргэд. Тэгэхээр энэ иргэдийн төлөөллийг яаж хангах юм бэ? Ер нь түүний 3 хүний төлөөлөлтэй л байлгах

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

талаар арга хэмжээ авч өгөөч гэсэн ийм орон нутгийн иргэдийн хүсэлт байгаа.

2 дахь нь бол ирц. Ер нь орон нутагтаа нэр дэвшсэн хүмүүс ирцийг бүрдүүлэх талаар бол маш их идэвхтэй ажилладаг. Ингээд ирц хангагддаг. Гэхдээ 92 оноос хойших 8 удаагийн сонгуулийн ирцийг харахад жил болгон буурч ирсэн юм байна. Гэтэл энэ удаа энэ хосолсон 38, 38-аар явагдахад ер нь ирц хэр бүрдэх юм бэ? Энэ тал дээр бас судалгаа хийсэн юм байна уу? Нэг ёсонд өмнөх сонгууль дээр тэр тойрогтоо нэр дэвшсэн гишүүд маш идэвхтэй сайн ажиллаад ирцийг бол бүрдүүлчхээж байгаа. Ирц ямар байх юм бол? Ер нь ирц бол 51 хувь уу, ер нь зүгээр иргэдийн нэрсээр авах юм уу. Энэ талаар нэг тайлбар авмаар байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын “Хөгжил” цогцолбор сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд сурлагын өндөр амжилт хүсье.

Баделхан гишүүний асуултад Тогтохсүрэн гишүүн хариулъя.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Баделхан гишүүний асуултад хариулъя. Одоо 38, 38 яг өнөөдөр мөрдөж байгаа Үндсэн хуулийнхаа хүрээнд авч үзэх юм бол 38, 38 гэдгээр явбал мэдээж аймгуудын тойрогт нэр дэвшигчдийн тоо тодорхой хүрээнд багасах нь тодорхой болоод байгаа юм.

Ирцийг нэмэгдүүлэх хэд хэдэн арга байгаа. 1 дүгээрт, урьдчилсан санал өгөлтийг хийсэн. Нөгөө 5 хоногийн хугацаанд, санал хураалт явахаас 5 өдрийн өмнө урьдчилсан санал хураалтууд явагдаж байгаа. Тийм учраас 1 дүгээрт энэ ирцэд нөлөөлөх болов уу гэж бодож байгаа.

2 дугаарт, пропорциональ элементийн санал хураалтыг тэр өдөр нь ч, мөн гадаадад байгаа сонгогчдоосоо авна, гадаадад байгаа сонгогчдоосоо авна. Хэрэв тэр өдөр нь одоо өөр орон нутагт юм уу, өөр тойрогт явж байх үед пропорционалийн саналаа өгөх бүрэн эрхтэй, бүрэн эрхтэй. Тийм учраас энэ энэ байдлуудаасаа хараад бид нар ирцийг тодорхой хүрээнд нэмэгдэх болов уу гэж бодож байна. Ирцийн тухайд бол энэ нэмэлт, өөрчлөлтөөр хөндөгдөөгүй, өнөөдрийн мөрдөж байгаа Сонгуулийн хуулиар 50 хувь дээр сонгогчдын 50 хувь дээр нэмэх нь 1 нь орсон тохиолдолд саналыг хүчинтэйд тооцно гэсэн хуультай. Энэ хуулиараа явж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл орж ирж байна. Мэдээж энэ хэлэлцүүлгийн явцад олон талаас нь тал бүрээс нь нэлээн сайн ярилцаж, шийдэлд хүрэх байх гэж би ингээж ойлгож байна. Тийм учраас ажлын хэсгээ нэлээн сайн байгуулж байж, нэлээн сайн ажиллах ёстой болов уу гэсэн ийм зүйл байна гэж.

Намын жагсаалтаар тодорхой тооны нэр дэвшигчид дэвшинэ гээд байгаа. Тэгээд хэрвээ хэдүүлээ ингэж ярьж байгаа бол намын жагсаалтаар нэр дэвшигчийн жагсаалт ил байх тухай асуудлыг л ярих болохоос биш тэр жагсаалтад байгаа улсын төлөө санал өгдөг юм гэж байж таарахгүй шүү. Ингэх юм бол 38 хүн ахиу санал авахын төлөөх өрсөлдөөн болж хувирна шүү. Ерөөсөө бид нар энэ пропорциональ системийн давуу тал, нам хариуцлагаа үүрдэг, нам шүүгддэг, нам нэгдсэн бодлогоор хөгжлийнхөө асуудлыг ярьдаг үйл явцаа л гэж харж л хийж байгаа үйл явц шүү дээ. Тийм учраас харин тэр сонгогчдыг саналаа илэрхийлэх бололцоог нь хангаж, ийм нэр дэвшигчид байгаа юм



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

аа гэдгийг нь харуулж чадаад, саналаа өгөхдөө бол зөвхөн намын төлөө санал өгдөг энэ асуудлаар хууль, эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгөхгүй бол энэ ёстой эрх зүйн гажиг үүснэ шүү. Юун тэр парламентын ардчиллыг хөгжүүлэх, тийм асуудал байхгүй ээ. Тийм учраас үүнийг би төсөл өргөн баригчид онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой гэж ингэж ойлгож байна.

Бид сүүлийн хэдэн жил улс төрийн намууд нь хатуу гишүүнчлэлгүй улс орнуудын сонгуулийн хуулийг авч хэрэглээд болж өгөхгүй байгаа юм. Бид бол улс төрийн нам нь хатуу гишүүнчлэлтэй улс орон байхгүй юу. Тийм учраас ухуулга сурталчилгааны үйл явц, намынхаа сонгууль эрхэлсэн байгууллага дээр тулгуурлаж явагдах ёстой. Түүнээс нэр дэвшигчийн баг энэ тэр байж таарамгүй байгаад байгаа юм. Одоо та нарын оруулж ирчхээд байгаа энэ хуулийн концепцоор бол холимог систем гэж оруулж ирж байна. Тийм учраас ёстой одоо харин наад хатуу гишүүнчлэлтэй улс орнуудынхаа сонгуулийн үзэл баримтлалтай нь нийцүүлж, намынхаа сонгууль эрхэлсэн байгууллага дээр ухуулга сурталчилгааных нь ажил явдаг энэ арга хэлбэрийг нь шийдэж өгөх ёстой. Тэгээд түүндээ харин нэр дэвшигчид нь тойрогт нэр дэвшигчид нь тодорхой санхүүжилтэд дэм оруулахаар эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгч чадах юм бол сая энэ нам хийгээд нэр дэвшигчдийн ухуулга сурталчилгааны бодлогын үйл ажиллагаанууд нэгдсэн байдлаар явах, зардал мөнгө хэмнэх ийм бололцоо боломж бүх юм нь бүрдэнэ ээ.

Дээр нь тэр мэтгэлцээний зарчим яриад байгаа бол нэр дэвшигчид мэтгэлцэнэ гэхээсээ илүүтэйгээр тэр орон нутгууд дээрээ, тойрог бүр дээрээ улс төрийн байгууллагууд нь мэтгэлцээнээ хийх ёстой. Түүнд нь нэр дэвшигч хамтдаа оролцож, өөрийнхөө намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр, тухайн орон нутгийнхаа чиглэлээр тусаж орсон

асуудлуудаараа илүүтэй байр сууриа илэрхийлдэг ийм л үйл явц явах ёстой гэж ингэж ойлгож байна. Тэгэхгүй бол бас наад хууль дотор чинь нэр дэвшигч өөрийн бие даасан хөтөлбөргүй орно. Тэгэхээр мэтгэлцээнд орохоор тэр нэр дэвшигч юу ярих юм. Намынхаа сонгуулийн мөрийн хөтөлбөрийг ярина шүү дээ, ойлгомжтой. Тэгэхээр зэрэг үүний ерөөсөө ухуулга сурталчилгааны нэгдсэн бодлого, эргээд хариуцлага хүлээх хамтын зарчмыг нь бодож энэ сонгуулийн ухуулга сурталчилгааны ажлыг намын сонгууль эрхэлсэн байгууллагынх нь бүтэц дээр явуулах талаар л бодмоор байна. Энэ дээр ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Батжаргал гишүүн ерөнхийдөө хуулийн төсөлд санал хэлчихлээ. Хариулт авах юм уу, та. Хуулийн төсөл санаачлагч Тогтохсүрэн гишүүн асуултад хариулья.

**Д.Тогтохсүрэн:** Батжаргал гишүүн бол үндсэндээ санал хэлсэн юмаа, 3 чиглэлээр. Батжаргал гишүүний хэлдэг тэр үнэн. Тэр намын жагсаалтаар л хэрэв сонгогдох гэж байгаа бол нэргүй байх ёстой гэдэг бол энэ олон улсын зарчим. Тэгэхдээ манайх 12 онд энэ пропорциональ тогтолцооны элементийг авч хэрэгжүүлсэн. Ингэхэд 2 асуудал дээр иргэдийн зүгээс асар их шүүмжлэлтэй байдаг 2 асуудал байгаа юм.

1 дүгээрт нь, гулсах тухай асуудал байдаг. Тэгээд энэ хуульд бол бид нар намын нэрсийн жагсаалтаар нэр дэвшиж байгаа хүн эсвэл тойрогт нэр дэвшиж байгаа хүн давхар нэр дэвшихийг хориглочихсон байгаа. Тийм учраас гулсах тухай ойлголт бол байхгүй ээ гэж байгаа юм.

2 дугаар асуулт нь нөгөө намын нэрийн ард хүн нуугдах гээд байна гээд байгаа. Янз бүрийн одоо нэр муутай хүмүүс нуугдах гээд байна гэдэг ийм шүүмжлэл байдаг учраас намын нэрсийн жагсаалтыг гаргаж байгаа юм. Тийм, учраас намд хэрвээ санал өгөхгүй гэвэл

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нэрсийн жагсаалтаас санал нэрсийн жагсаалтад байгаа нэр дэвшигчдээс сонгох нь нээлттэй байгаа юм. Ийм хэлбэрээр зохицуулалтыг хийж өгсөн.

Батжаргал гишүүний энэ саналуудыг ажлын хэсэг дараа нь авч үзээд боловсронгуй болгоод, яриад явах бол ийм боломжтой саналууд байна гэж ингэж үзэж байна.

**Л.Мөнхбаатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Пүрэвдорж оо, чимээгүй байж байгаарай, би асуултаа асуучихъя. Би энэ сонгуулийн хуулийн хэлэлцүүлэгт өчигдөр би Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бас саналаа илэрхийлж байсан. Ингээд би энэ ажлын хэсгийн гишүүн, МАН-ын бүлгийн дарга Тогтохсүрэнгээс 2, 3 асуулт асууя. Энэ Сонгуулийн тухай хуулийг өргөн барьж өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцэж байна. Тэгээд Сонгуулийн тухай хууль Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн байх ёстой. Энд зориуд би нэг юмыг хатуу анхааруулж хэлье, өчигдөр ч би хэлсэн. Энэ аливаа Үндсэн хуулийн өөрчлөлт, энэ Сонгуулийн хуулийн тогтолцооны асуудал ярихдаа Үндсэн хуулийн Цэцийн нэрийг, Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийг ярихыг бүр Танаас одоо дахиж ийм асуудал ярихгүй байхыг би хатуу шаардаж байна. Яагаад гэхээр өнөөдөр Үндсэн хуулийн Цэц гэдэг бол Монгол Улсын Үндсэн хуулиар баталсан хууль Үндсэн хууль зөрчиж үү гэдэг асуудлыг л ярьдаг. Гэтэл өнөөдөр Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд үүрэг чиглэл өгсөн мэтээр тэр Цэцийн тогтоол, шийдвэрүүд дотор ийм агуулгатай зүйл байгаа мэтээр, ингэж хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулийн Цэцэд өгсөн мэтээр ийм ойлголтыг нийгэмд тараахыг хэн ч хэрхэвч зөвшөөрөхгүй ээ гэдгийг бас цаашидаа анхаараарай гэж хэлье.

Тэгээд энэ Үндсэн хуулийн тэр шууд сонгоно гэдэг түрүүн Чинзориг

гишүүн асуугаад байсан, энэ зарчим чинь энэ сонгуулийн хуульд хэр багтсан бэ?

Дээр нь тэр намын санхүүжилт, зардлын асуудал гэж байгаа юм. Өчигдөр Улсын Их Хурлын дарга зардлыг бууруулна гэдэг юм ярьж байснаа энэ сонгуулийн сүүлийн үеийн сонгуулиуд дандаа мөнгө авлига болдог. Авлигын сонгууль хийдэг, сонгогчдыг мөнгө төгрөгөөр сонгууль хийдэг ийм юм ярьж байна лээ. Үүнийгээ бас ингээд Баянхонгорт хэдэн төгрөгийн мөнгө төгрөг тараагаад өөрөө энд гарч ирсэн хүн байгаа. Үүнийг бас энэ Монголчуудад Улсын Их Хурлын даргын хувьд үүнийгээ тайлбарлах байх аа гэж би бодож байгаа юм. Тэгэхээр энэ сонгуулийн зардлыг бууруулахад ямар шийдэл гаргасан бэ гэдэг талаар нэг хариулт авъя.

Тэгээд дээр нь өнөөдөр энэ Сонгуулийн хууль батлагдахтай холбогдуулаад улс төрийн намуудын тухай хууль хатуу гишүүнчлэлгүй гэдэг асуудал ярьж байгаа. Гэтэл сонгуульд нэр дэвшиж байгаа энэ бүх нэр дэвшигч тэгш боломжоор хангана. Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгох, сонгогдох эрхийг эрхэмлэнэ ээ гэж бүр ингэж та нар өнөөдөр яриад байгаа. Гэтэл өнөөдөр намынхаа даргад таалагддаггүй, намынхаа бодлого энэ тэрийг бас тодорхой зарчмаар шүүмжилдэг ийм хүмүүс нэр дэвшүүлэхгүй байвал тэр хүмүүсийн эрх яаж хангагдах юм. Энэ талаар нэг тайлбар авъя. Энэ бол өнөөдөр өөр намын гишүүнийг заавал тэр намаасаа нэр дэви, бусад газраас нэр дэвшиж болохгүй, нэг бол бие дааж нэр дэви гэдэг ийм шаардлагыг тавьсаар ирсэн. Гэтэл тэр тухайн намын гишүүний, тухайн иргэний эрхийн асуудал энд яаж тусгагдах юм бэ, үүнийг хангах талаар ямар бодлогыг барьж байгаа вэ гэдэг талаар хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Адьяа гишүүний асуултад хуулийн төсөл санаачлагч Тогтохсүрэн гишүүн хариулъя.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Д.Тогтохсүрэн:** Улсын Их Хурлын гишүүн бидний өргөн барьсан Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бид Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж байгаа гэж үзэж энэ хуулийн төслийг өргөн барьсан. Хууль санаачлах, хууль тогтоох эрх мэдэл бол зөвхөн Улсын Их Хуралд байгаа. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг битгий дурдаач ээ гээд байна. Зүгээр яах вэ, бид нар энэ нөгөө пропорциональ тогтолцоотой холбоотой асуудал ярихаар Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг дурдахаас өөр аргагүй учраас л би дурдаж ярьсан. Өөрөөр хэлбэл хууль тогтоогчид маань эсвэл хуулийн төсөл санаачлагчид маань Үндсэн хуулийн хүрээнд, бусад хуулийн хүрээнд бид хуулийнхаа төслийг өргөн барих ёстой. Энэ хүрээндээ л бид дурдаж яваа.

Юуны шууд сонгох тухайд бол энэ хуульд бол тойргоос нэр дэвшсэн ч, намын жагсаалтаар нэр дэвшсэн ч хүн сонгох учраас шууд сонгох гэдэг Үндсэн хуулийн заалт бид хангагдаж байгаа гэж ингэж үзэж байгаа. Сонгуулийн зардлыг манай Сонгуулийн ерөнхий хороо тооцсон байгаа. Ухуулагчийн зардлаас эхлээд сурталчилгааны самбар, сурталчилгаанд явдаг автомашины зардал гээд бүгдээрээ буурсан. Нийт бол 1 тойрогт зарцуулж байгаа сурталчилгааны зардал өмнөхөөсөө 48 хувиар буурах боломжтой байна гэж Сонгуулийн ерөнхий хороо тооцоо гаргасан байгаа.

Өнөөдөр мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль Монгол Улс бол хатуу намын гишүүнчлэлтэй явж байгаа. Харин энэ сонгуулийн хуулиар өөрийнхөө одоо гишүүнчлэлтэй байгаа намаасаа нэр дэвшиж чадахгүй бол тэндээсээ гараад өөр намаас нэр дэвших, бие даан нэр дэвших нь бол бүгд нээлттэй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Адьшаа гишүүн тодруулж асууя.

**Ш.Адьяа:** Тэр Үндсэн хуулийн Цэцийн нэрийг барьж байгаа гэдэг чинь ерөөсөө үнэн шүү. Үндсэн хуулийн Цэц гэдэг бол түрүүн би бүр хэлсэн. Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль Үндсэн хуульд нийцэж байна уу, нийцэхгүй байна уу гэдгийг л ярьдаг. Гэтэл тэр Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт дээр энэ сонгуулийг ийм журмаар явуул, пропорционалиар явуул, нэг бол өөр хэлбэрээр явуул гэж заасан мэтээр та нар яриад байгаа байхгүй юу. Үүнийг дурдах ямар ч шаардлага байхгүй. Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй гэдэг дүгнэлтийг тэр Цэц гаргаад л тавьсан. Гэтэл тэр Цэцийн чинь дүгнэлт дээр сонгуулийн системийг ийм системээр явуул аа, олон болго оо, тоо нэм ээ гэдэг юм ерөөсөө байхгүй шүү дээ. Тийм асуудлыг өнөөдөр хариуцлагагүй та ингэж ийм том намын бүлгийн даргын хувьд ингэж цаашид яривал энэ ард түмнийг доромжилсон ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хариулах юм уу. Хуулийн төсөл санаачлагч Тогтохсүрэн гишүүн хариулъя.

**Д.Тогтохсүрэн:** Би тоо нэм гэж Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр гарсан гэж огт хэлээгүй шүү, хариуцлагатай хэлье. Пропорциональ тогтолцоог өмнө нь хаачихсан байсан, тэрийг нээж байж болох юм гэдэг шийдвэрийг Үндсэн хуулийн Цэц 2022 оны 6 сарын 22-нд гаргасан гэдгийг л дурдсан. Би өөр юм дурдаагүй. Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийг бол бид нар дурдаж л явна уу гэхээс бид заавал одоо үүгээр явна гэж Үндсэн хуульд заасан гэж би огт хэлээгүй. Үндсэн хуулийн Цэц өмнө нь пропорциональ тогтолцоог хорьчихсон байсан юм. Тэрийгээ өнгөрсөн онд нээсэн юм. Пропорционалиар ч явж болно, мажоритараар ч явж болно, холимгоороо ч явж болно, үүнийг Цэц нээгээд өгчихсөн учраас бид холимог тогтолцоог өргөн барьж байгаа юм аа л гэж ярьж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Асуулт асууж, хариулт авч дууссан.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин асуултаа асууя.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байна. Ер нь сонгуулийнх нь хуульд бас өөрчлөлт хийгээд цаашидаа ингээд сонгуулийнхаа хуулийг тогтвортой аваад явах нь бол зөв байх. Холимог тогтолцоогоор хийхэд ер нь цаашидаа ямар үр дүнд гарах юм бэ? Энэ үр дүнгийн талаар 1, 2, 3 гээд одоо ингээд нэг сайхан тайлбарлаад явчихвал их зүгээр байна.

Санхүүгийн хувьд, төсөв санхүүгийн хувьд бол хэмнэгдэх юм байна. Орон нутгийн бодлого, улсын том бодлого бол нэгтгэгдээд асуудал бас яриад явах ийм ач холбогдолтой юм байна. Өөр ямар ямар үр дүн гарах юм бэ гэдэг дээр бас нэг тодорхой 1, 2 гээд нэрлээд яваач ээ гэдгийг хэлмээр байна.

2 дахь асуудал бол энэ ирцийн асуудал байж байгаа. Орон нутгийн сонгууль бол ирцгүй болсон. Энэ Улсын Их Хурлын сонгуулийн ирцийн асуудал 50 дээр нэмэх нь 50, хэвээрээ байгаа юм шиг байна. Заавал одоо энэ дээр ирц тавих тийм шаардлага байна уу? Ингээд сонгууль болоод одоо юу гэдэг юм 7-8 цагийн алдад бол эрт янз янзын л юм гардаг юм шүү дээ. Нөгөө хол байгаа хүмүүсээ зөөдөг, олон хүнд бүлгээрээ очиж сонгууль өгдөг, тэгээд мөнгө төгрөг тараадаг ч гэдэг юм уу ийм асуудлууд зөндөө гардаг. Тэгэхээр энэ ирцийн асуудал дээр ер нь бас яаж явбал зүгээр юм бэ? Үүнийг заавал ирц тавьж заавал ингэж босго тавих шаардлага байгаа юм уу гэж асууж байна.

3 дахь асуудал дээр бол энэ тойрогт нэр дэвшээд жагсаалтад бас ороод явчих ийм бололцоо боломж байхгүй ээ гээд Тогтохсүрэн дарга бас хэлчих шиг болсон. Тэгээд мэдээж намууд чинь юу гэдэг юм, олон хүний санал авч ялалт байгуулахыг л бодож байгаа шүү

дээ. Тойрогтоо ч нэр дэвшдэг, жагсаалтад ч гэсэн ороод явдаг ийм бололцоо боломжийг нээж өгч бас болоогүй юм уу гэсэн ийм 3 асуултыг тавьж байна.

**Л.Мөнхбаатар:** Энхтүвшин гишүүний эхний асуултад нь Доржханд гишүүн хариулъя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Энхтүвшин гишүүний асуулт 1, 3 дугаар асуултад хариулъя. Тэгээд манай ажлын хэсгээс хариулах байх аа, 2-т нь бол.

1 дүгээр асуулт нь юу байна гээд тэгэхээр яг ямар, ямар үр дүнгүүд гарах юм бэ гээд тодорхой асууж байна. Би маш тодорхой хэлье. Маш том үр дүн гарна. 1 дүгээрт, пропорциональ элемент 50 хувьд нь орсон тохиолдолд энэ парламентын 50 хувь маань нийт эдийн засгийн бүтээн байгуулалт, бодлого ярьдаг, бодлогыг санхүүжүүлдэг, бодлогын төлөө кноп дардаг ийм парламент бүрдэх юм. Өөрөөр хэлэх юм бол парламент бол улс төрийн намуудын бодлогын мэтгэлцээний талбар байдаг. Яг энэ агуулгаараа бид нар бодлогоороо өрсөлддөг болно. Тэгээд өнөөдрийн байдал бүгд мэдэж байгаа шүү дээ. Бид нар 5, 10 жилийн бодлого хэрэгжүүлж чадахаа больчихсон. Нэг жилийнхээ төлөвлөгөөг хүртэл, төсвийг хүртэл 1, 2 удаа тодотгодог, өөрчилдөг болчихсон. Энэ өөрөө бид нар бодлогогүй болчихсон байхгүй юу. Яагаад вэ гэхээр энэ парламент маань өөрөө бодлого ярьдаг ийм парламент байж чадахгүй байгаа юм. Энэ яаж бий болох вэ гэхээр олон улсад бол пропорциональ систем орж байж л бий болдог. 100 хувь пропорциональ орох юм бол 100 хувь бодлого ярьдаг, 50 хувь бол ядаж 50 хувьд нь бодлого барьдаг байя аа гэж байгаа юм.

2 дугаарт, Монгол Улсын эдийн засагт маш том өөрчлөлт гарна шүү, Энхтүвшин гишүүн ээ. Тухайлбал өнөөдөр 30 жилийн хугацаанд Монгол Улсын нийт



өр 30 тэрбум доллар, Засгийн газрын өр 30 их наяд төгрөг байгаа юм аа. Тэгээд төсөв маань жилийн жилд алдагдалтай баталдаг, яагаад вэ гээд тэгэхээр нөгөө тойрог орон нутгаа мөн сонгуулийн өмнөх хөтөлбөрүүд гээд гоё нэртэй хөтөлбөрүүдийг санхүүжүүлж явсаар байгаад, тэрийгээ дандаа зээлээр санхүүжүүлж явсаар байгаад өртэй болчихсон. Харин бид нар энэ пропорциональ орж ирсэн тохиолдолд бол Монгол Улсын өрийн асуудал шийдэгдэнэ. Төсөв алдагдалгүй батлагдах боломж бас бүрдэнэ. Үр дүнд нь Монгол Улсын мөнгөний бодлого орон зайтай болно. Зээлжих зэрэглэл өснө, тэгээд хувийн бизнесийг дэмжих орон зай гарч ирнэ ээ. Энэ бол олон улсад хийгдчихсэн зүйл. Монголд бас энэ хийгдэх юм аа.

Тэгээд дараагийн нэг зүйл нь нөгөө төлөөлөх чадварын асуудал байгаа. Нөгөө нэг эмэгтэйчүүдийн төлөөлөл байна уу, ядаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл байна уу гэхээр энэ мажоритар тогтолцоогоор бол боломжгүй, яагаад гэвэл мөнгөтэй нь гарч ирдэг, сүлжээтэй нь гарч ирдэг, бүгд мэдэж байгаа. Харин пропорционалиар бол бүлгүүдийн төлөөлөл байна, мэргэжилтнүүдийн төлөөлөл байна, багш, эмч нарын төлөөлөл орж ирнэ, залуучуудын төлөөлөл орж ирнэ ийм болохоороо олон төлөөллүүд гарч ирэхээр иргэдээ төлөөлөх чадвар нь бий болно гэж үзэж байгаа.

Тэгээд эцэст нь хэлэхэд ийм тогтолцооны томоохон өөрчлөлт хийснээр манай парламентын чадавх бэхэжнэ ээ. Өөрөөр хэлэх юм бол ардчилал маань бэхэжнэ. Иргэд маань төрдөө итгэх бодлогодоо оролцох тэр оролцоо нь бол өөрөө бий болно, чадавхажна. Үр дүнд нь бол манай ардчиллын дархлаа бий болно. Ялангуяа энэ үүсээд байгаа гадаад орчны нөхцөл байдал ялангуяа 2 улсын хөршийн нөхцөл байдалтай холбоотойгоор парламент бол чадавхажна, үр дүнд нь бол ардчилал ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Ер нь Монголын ард түмний, хүмүүсийн хүсээж байгаа зүйл бол мөнгөний сонгууль биш харин одоо Монголоо хөгжүүлэх бодлогын сонгууль байдаг тэр л тогтолцоог бүрдүүлээсэй гэсэн хүсэл байгаа. Тийм ч учраас энэ сонгуулийн тухай хуулийг маш сайн хийчхээд, тэгээд дахин дахин ингээд сонгууль болгоны өмнө өөрчлөөд л байдаггүй, харин энэ нь өөрөө тогтвортой байдаг. Тэр тоглоомын дүрэм нь хүн бүхэн мэддэг ийм байх нь өөрөө чухал байна л даа. Одоо ингээд л харахад эрх барьж байгаа нам болгон яг сонгуулийн өмнө эсвэл нэмэлт, өөрчлөлт эсвэл ингээд л шинэчилсэн найруулга ч гэдэг юм уу өөрчлөөд л яваад байдаг. Зөвхөн энэ хувь хүмүүс юм уу эсвэл одоо тухайн улс төрийн нам бодсон шийдвэрүүд энэ тэр гаргана. Энэ нь өөрөө эргээд улс орны хөгжилд асар их сөрөг нөлөө үзүүлж байгааг 30 жилийн өнөөгийн Монгол Улсын байж байгаа байдал, хөгжил, иргэдийн амьжиргааны түвшин бүгд харуулж байгаа шүү дээ. Тийм учраас одоо энэ Сонгуулийн тухай хуулийг ер нь цаашидаа тогтвортой байх тал дээр бол маш их сайн анхаармаар байна. Ялангуяа манай Сонгуулийн ерөнхий хорооныхон. Улсын Их Хурал ч гэсэн өөрөө одоо ингээд л 2, 3, 4, 5-уулаа хууль санаачлаад л, тэгээд л ингээд янз янзын хувилбарууд оруулж ирээд л энэ нь өөрөө тэгээд амьдралын бодит байдалтай нийцэхгүй байх явдал байгаад байгаа шүү гэдгийг хэлчихье.

Энэ удаагийн яах вэ, нэмэлт, өөрчлөлт дээр орж ирж байгаа маш том 1 давуу тал бол төлөөллийн балансыг тэнцвэрийг барих асуудлыг бас онцгойлон аль аль нам анхаараад, Засгийн газар ч гэсэн хуулийн төсөлдөө үүнийг тусгаад байж байгаад бол би маш талархаж байгаа. Яагаад гэвэл, энэ жендерийн баланс барих төлөөллийн жендерийг, балансыг барьснаар энэ нь өөрөө улс орны хөгжилд бол маш их чухал ач

холбогдолтой байдаг гэдгийг бусад өндөр хөгжсөн ёстой нөгөө аз жаргалын индексээрээ эхний 3, 4-д орж байгаа улс орнуудын бодит байдал харуулж байгаа учраас энэ баланс барих гэдэг асуудал чухал байгаа. Харин энэ жендерийн баланс барих төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангахдаа намын жагсаалтын ард бичигдэх тэр хүмүүс өөрөө төлөөлж чадах хүчтэй сайн кандидатууд байх нь л өөрөө чухал байгаа гэдгийг хэлье. Үүнийг бол маш олон хүмүүс хэлж байгаа юм. Зарим нь пропорциональ гэж хэлчхээд намын нэрийн ард есөн шидийн юм бүрдчихсэн хүмүүс орчихдог гэдэг. Эсвэл нөгөө талаасаа огт хэний ч мэдэхгүй, энд ирээд нөгөө нэг төлөөлөх чадвартай, хүчтэй улс орны хөгжлийн төлөө дуу хоолойгоо гаргадаг, үр дүнд хүргэж чаддаг, бодлого гаргадаг, хууль санаачилдаг тийм хүмүүс биш. Шинэ гэдэг юм уу эсвэл зүгээр нэг даргын дохиогоор хөдөлдөг хүмүүс ч гэсэн жагсаад ороод ирэх вий гэсэн болгоомжлолыг бас их хэлж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ улс төрийн намын тухай хууль дээр ч, сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр ч юм уу энэ жагсаалтын эрэмбэ дараалал, тойрог дээр ч гэсэн үүнийг сонгохдоо яг тэр олон түмнийг хүлээн зөвшөөрөгдсөн байх тэр үзүүлэлтүүдийг маш сайн тусгаж өгөх асуудал бол өөрөө чухал байгаа гэдгийг хэлье.

Асуултын тухайд сая сонгуулийн сурталчилгаанд зарцуулах зардлыг 48-50 хувиар буулгах бололцоотой гээд байгаа юм. Тэгэхээр зүгээр бололцоотой гэж үзээд одоо л тооцоо судалгаа хийж байна уу эсвэл Сонгуулийн тухай энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ 50 орчим хувийн сонгуулийн зардлыг бууруулах бүрэн бололцоотой гэдэг тооцоог нь хийчхээд заалт болгоод оруулж ирж байгаа юу. Одоо энэ дээр л хоёрхон зүйл яриад байгаа шүү дээ. Ухуулагчийн зардал, хэвлэлийн зардал гээд. Тэгэхээр энэ дээр яг ямар заалт орж байж, та бүхний хэлээд байгаа тэр 48-50 хувиар бууруулна гэж үнэхээр тооцоо судалгаа гарсан бол энэ

өөрөө сайн бас гэж гайгүй зүйл, 50 хувиар буурчихвал, тиймээ. Тэгэхгүй бол энэ чинь дахиад л мөнгөний сонгууль болно. Тойрог дээр ч тэгнэ, намын жагсаалын ард ч гэсэн намд санхүүжилт өгсөн хүмүүс нь жагсаад жагсаад л ороод ирдэг, энэ худлаа биш, үнэн шүү дээ. Тэгээд л нөгөө том том төлөөллүүдийн хүмүүс нь орж ирчхээд, тэгээд ард түмэнд зориулсан нөгөө чухал хууль биш тухайн бизнесийн ашигтаа зориулсан хууль дүрэм гаргаад өнөөдөр Хөгжлийн банк үүнийг гэрчлээд л өглөө шүү дээ. Тэгэхээр иймэрхүү зүйлийг гаргахгүйн тулд ямар чагт хийх нь зөв байгаа вэ гэдэг дээр би хариулт авъя гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ 85 дугаар микрофон өгье.

**Д.Бат-Эрдэнэ:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь сонгуулийн зардлыг Үндэсний аудитын газраас бол тогтоодог. Сонгуулийн сурталчилгааны төрөл хэлбэр, тоо хэмжээнд нийцүүлж байгаад тогтоодог байж байгаа. Өнгөрсөн сонгуулиас тэр тогтоосон тоог ерөнхийдөө харах юм бол 2012 онд бол жишээ нь 9.6 тэрбум төгрөгийг намаас зарцуулж болно гэж тогтоож байсан. 2016 онд бараг 3 дахин бууруулаад 3 аравны тэрбум төгрөгөөр тогтоож байсан бол хамгийн сүүлд болсон 2020 оны Улсын Их Хурлын сонгуулиар намаас бол 5.9 тэрбум төгрөгийг зарцуулах юм байна гэдэг тооцоог бол Үндэсний аудитын газраас хийж байсан байдаг. Түүрүүн Дэлгэрнаран дарга бас хариулж байсан. Тойрог болгон харилцан адилгүй зардал бол тогтоогддог. Дундажлаад үзэх юм бол 400 сая төгрөгийг нэг нэр дэвшигчээс гарна гэдэг ийм дээд хэмжээг бол тогтоож өгдөг. Аудитын байгууллага дээр ирсэн зардлын тайлангуудыг хараад үзэх юм бол гүйцэтгэл нь бол яг энэ 400 саядаа бол хүрэхгүй 70-80 орчим хувьтай

байдаг гэсэн ийм тайлангууд бол ирдэг юм байна лээ.

Энэ өргөн барьсан хуулийн төсөл дээр байгаа зохицуулалтууд бол сонгуулийн зардлыг 50 хувь бууруулах боломжтой биш, ерөөсөө шууд буурах энэ нөхцөлийг бол бүрдүүлж эрх зүйн орчин нь бүрдэж байгаа л гэж үзнэ. Яагаад гэх юм ерөөсөө тодорхой тоо хэмжээнүүдийг 50 хувь, 70 хувь, 30 хувь, 60 хувь бууруулж байгаа тохиолдолд зардлын дээд хэмжээг тогтоохдоо яг үүнийхээ дагуу тоо хэмжээгээр нь тооцоолж байж гарах учраас яг энэ хэмжээн дээр шууд 50 хувь буурч зардал бол тогтоогдоно л гэсэн үг. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Яах юм, тодруулах юм уу? Зардалтай холбоотой асуудлыг чинь өнөөдөр их олон удаа хариуллаа, гишүүдийн асуултад. Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Квоттой холбоотой асуудал дээр сая Төрийн байгуулалтын байнгын хороо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, бусад улс төрийн намуудтай хамтраад хийсэн уулзалтын үеэр гаднын том мэргэжилтнүүд ирсэн шүү дээ. Тэгэхээр ХБНГУ жишигээр квотоо бариагүй улс төрийн нам бариагүй тохиолдолд дахин сонгууль явуулна гэсэн заалтыг тусгаж өгсөн нь өөрөө өнөөдөр үр дүнгээ өгсөн гээд ярьж байсан л даа. Тэгэхээр иймийг ингэж яг тусгаж өгөх квотын тоогоо 70, 30 ч гэдэг юм уу эсвэл ингээд барилаа. Гэхдээ үүнийгээ яг тусгаагүй, биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага, ямар заалт байгаа вэ?

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг хариулъя, 85 дугаар микрофоныг өгье. Бат-Эрдэнэ дарга хариулчих.

**Д.Бат-Эрдэнэ:** Нам, эвслээс нэр дэвшигчид тавигдах шаардлага, нэр дэвшигчдийг бүртгэхгүй байх үндэслэлүүдийг хуульчилсан. Яг энэ нэмэлт, өөрчлөлт энэ квоттой

холбоотойгоор мөн дээрээс нь жагсаалт дотор нэг нэг байх гэдэг харьцаагаа барьсан уу, үгүй юу гээд. Хэрвээ энэ харьцааг бариагүй 30 хувьдаа аль нэг хүйсийнх нь төлөөлөл хүрээгүй байх юм бол тухайн намаас нийт нэр дэвшигчийг бүртгэхгүй байх үндэслэл болохоор бол хуулийн төсөл дээр орж ирж байгаа. Гэхдээ энэ зөрчлөө арилгаад дахиж орж ирэх боломж нь бол бас хуулиар нээлттэй байгаа.

**Л.Мөнхбаатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Ямар ч байсан МАН, АН-аас 2 янзаар Сонгуулийн хуулийг төслийг хэлэлцүүлж байна. Ямар ч байсан одоо ингээд яах вэ нэгтгээд юм уу ингээд хэлэлцээд явах нь зүйтэй байх. Би бол 2024 оны сонгууль бол Монгол Улсад улс төр, эдийн засгийн томоохон шинэчлэл хийж болох ийм баг томилогдсон, баг сонгогдсон ийм сонгуулийн хууль батлагдаж, сонгууль болоосой гэж хүсэж байгаа юм. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монголын ард түмэн бол саналаа өгсөн. Зүгээр сонгосон ард түмэнд буруу өгөх арга алга. Яагаад өнөөдөр эдийн засаг, улс төр нь тогтворгүй эдийн засаг нь ийм байдалтай болж ирсэн бэ гэвэл хүмүүстэй л холбоотой, хүмүүстэй холбоотой. Ялангуяа энэ Улсын Их Хуралд томилогдож байгаа энэ 76 гишүүн бүгд одоо энд бас их буруутай биш байх л даа. Тодорхой эрх мэдэл одоо хүмүүсийн ажлын арга барил тийм янз бүрийн холбоотой л доо. Гишүүд очоод тойрог тойрогтоо очоод ажиллаад энд нэг суудал аваад ирдэг. Тэгээд одоо засаг нь байгуулагдахдаа тодорхой хүмүүст эрх мэдэл нь шилждэг. Нөгөө үг байдаг шүү дээ, нөгөө ухаантнууд нь сэдэж, зоригтнууд нь хийж, тэгээд бас нэг хүмүүс нь үр шимийг нь хүртдэг гэж нэг иймэрхүү л байдалтай яваад байгаа. Тэгээд эцэст нь юу гэхээр ерөөсөө энэ чинь хүндээ л байгаа. Монгол улсын хөгжлийн хоцрогдол бол хүндээ л байгаа. Тийм учраас 2024 онд мэдлэгтэй

чадвартай ийм хүмүүс сонгогдоосой, хууль бол ямар ч шийдвэртэй байж болох байх аа гэдгийг ингэж бодож байгаа юм.

Ард түмний сонголт мэргэн байж, төрийн нуруу тэгш оршдог. Тэгээд энэ ард түмний сонголт мэргэн байх ийм хууль бол болоосой, элдэв бусыг нь янз бүрийн юм битгий ороосой. Тэгээд энд хэд хэдэн асуулт байна.

1 дүгээрт нь, энэ сонголт хийх чадвар гэдэг юм байгаа юм. Манай Сонгуулийн ерөнхий хороо энэ сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлд юу хийж ажилладаг юм бэ? Сонгуулийг бол явуулчхаж байна. Сонгуулийн бус цагаар сонгогчдын боловсролыг дээшлүүлэх асуудал мэдээж одоо Сонгуулийн ерөнхий хорооны бас нэг ажил байдаг байх гэж бодож байгаа. Энд юу хийж байгаа вэ гэж.

2 дугаарт нь, энэ сонгуулийн зардал асар их өндөр, ил, далд маш их хэмжээгээр авдаг шүү дээ. Энэ зардлыг бууруулах ил тод болгох чиглэлд энэ хуульд юу харагдаж байна гэж.

Дараагийн асуудал энэ 2024 оны сонгуульд ямар эрсдэлүүд байна. Эрсдэлүүдийг тооцсон уу? Тухайлбал энэ сошиал ертөнц, хуурамч хаяг гээд янз бүрийн юмнууд байна шүү дээ. Үүнийг одоо хууль санаачлагч хариулах юм уу, яах юм.

Өнөөдөр улс төрийн 40 нам байгаа. Нийт сонгогчдын бараг 50 орчим хувь нь улс төрийн намын гишүүн болчихсон байгаа шүү дээ. Тэгэхээр энэ улс төрийн намын хууль маань хаана явна. Үүнтэйгээ сонгуулийн хуультайгаа холбогдож барьж энэ асуудал яригдах уу, үгүй юү. Ийм нэг асуулт байж байгаа юм.

Энэ улс төрийн намуудын төлөвшил юу байна. Энэ 30 жилийн хугацаанд чинь Ардын нам, АН 2 хэд хэдэн удаа хамтарч засаг барих гээд дампуурсан шүү дээ. Яагаад гэхээр

болохгүй. Яагаад гэхээр энэ чинь одоо 2 өөр үзэл баримтлалтай намууд шүү дээ. Барууны, зүүний. Тэгэхээр одоо тэр барууны чиглэлийн намууд нь энэ 40-өөд нам чинь хэд байх юм, зүүний чиглэлийн намууд нь ямар юм байх юм. Тэр Европт их мундаг гоё хамтраад барьчихдаг юм гоё гээд л манай энэ улсууд л яриад байгаа юм л даа, тэнд чинь энэ парламентаасаа эдийн засаг нь хамаарал ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Нямаагийн Энхболд гишүүн хариулах уу? Тэгээд Сонгуулийн ерөнхий хороонд хаяглаж асуусан асуултад 86 дугаар микрофон ажлын хэсгийн микрофоныг өгье. Энхболд гишүүн хариулаад дараа нь ажлын хэсэг хариулъя.

**Н.Энхболд:** Улс төрийн намуудаас ихээхэн юм шалтгаалж байгаа, энэ үнэн. Түүн дотроо дахиад хувь хүмүүсээс ялангуяа шийдвэр гаргах түвшний хүмүүсээс нэлээд их зүйлүүд хамаарч байгаа нь их үнэн. Тэгээд үүнийг ерөөсөө ийм нөхцөл байдлыг шийдэх хамгийн зөв арга нь л аль болохоор хувь хүнээс хамааралтай шийдвэр гаргадаг ийм механизм бүрдүүлэх, ийм механизмыг бүрдүүлэх тэгээд их идэвхтэй, санаачилгатай, мэдлэгтэй, мэдээлэлтэй оролцдог одоо юу гэдэг юм, иргэд сонгогчид, ард түмэн, төрийн зүтгэлтнүүд, улс төрийн албан хаагчид энэ бүх юм цогцоороо яригдаж байж л төгс төгөлдөр нийгэм рүү дөхөцгөөнө л дөө. 1 дүгээрт нэг ийм юм хэлмээр байна.

Би бол Баттөмөр гишүүнтэй тэр хувь хүнээс их олон юм хамаараад байгаа. Үүнийг засах тал дээр юу хэрэгтэй вэ гэдэг ажил хэрэгтэй байна гэдгийг бол санал нэг байна. Үүний нэг зам нь дараагийн тэр асуудал, намуудын төлөвшилтэй холбоотой. Ер нь улс төрийн намууд ямар үүрэгтэй байх ёстой юм, тэр нь хуулиар ямар зохицуулалттай байх ёстой юм гэдэг зохион байгуулалт нь ямар байх ёстой юм гэдэг энэ асуудал гарцаагүй мөн.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Монгол Улсын Ерөнхийлөгч улс төрийн намуудын тухай хууль санаачлаад нэлээд урт хугацаанд боловсруулаад мөн надад байгаа мэдээллээр бол энэ 7 хоногт өргөн барих гэж байгаа юм байна лээ. Тэгээд энэ сонгуулийн хуультай зэрэгцээд бараг Төрийн байгуулалтын байнгын хороогоор эхлээд хэлэлцээд ингээд зэрэгцээд явах байх. Одоогоор гишүүдийн гар дээр ирээгүй байна. Яг ямар концепцтой, ямар агуулгатай, юунд юу руу илүү чиглэсэн тийм хууль болж вэ гэдгийг нь гишүүд гар дээрээ авангуутаа судалж үзээд ер нь дараагийн 7 хоногоос хэлэлцээд эхлэх байх, 2 хуулийн хэлэлцүүлэг зэрэг явах байх.

Тэгээд Сонгуулийн хуулийн хажуугаар биш ээ, Улс төрийн намын тухай хуульд сонгуулийн чиглэлээр, сонгуульд оролцох чиглэлээр ямархуу зүйл заалтууд зохицуулалтууд орж ирэх нь үү тэр бас тодорхой хэмжээгээр Сонгуулийн хуулийг хэлэлцэх явцад ийм уялдах шаардлага гарна. Одоо яг хараагүй байгаа болохоор тэр намын хуулийн тийм заалтад Сонгуулийн хуульд ингэж тусгах ёстой гэсэн юмыг хэлж мэдэхгүй байна. Ямар ч байсан энэ чуулганы хугацаанд Улсын Их Хурлаас тавьж байгаа нэг том зорилтын нэг бол Сонгуулийн хууль, Улс төрийн намын хууль, Улс төрийн санхүүжилтийн хууль шаардлагатай гэж, шаардлага гарвал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлууд ингээд бүгдээрээ цогцоороо явж байж энэ Монголын төрийг байгуулах төрийн байгууллын тогтолцооны асуудалд нэлээд урт хугацаанд тогтвортой үйлчлэх ийм эрх зүйн орчин зохицуулалт бүрдэх байх аа гэж ингээж ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нямаагийн Энхболд гишүүн нэмж хариулъя 1 минут.

**Н.Энхболд:** Тэгээд энэ асуудлууд цогцоороо явж шийдэгдэнэ ээ, тэгээд одоо энэ Сонгуулийн хууль, Намын тухай хууль гэх мэтчилэн хуулиуд урьд нь ч олон удаа саналууд гарч байсан, олон санал авч байсан зориуд, одоо хэлэлцүүлэх явцад ч

гэсэн бас хэдийгээр цаг хугацааны хувьд хуулиар заагдсан хязгаарууд байгаа ч гэсэн бид нар аль болохоор бас нэлээд санал онолыг нь авах хэлэлцүүлэг явуулах ийм ажлуудыг энэ хуулиудыг хэлэлцэх нь зүйтэй гээд Их Хурлаас дэмжчихвэл, дараагийн шатанд хэлэлцүүлгийн явцад тэгээд өргөн хэлэлцүүлгүүд явуулж байж санал онолуудыг бас үүсээд байгаа нөхцөл байдлуудтай уялдаж тусгах ийм ажлууд хийгдэх байх аа гэж харж байна.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүний асуултад нэмж хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Баяндүүрэн 88 дугаар микрофон өгье, 86 дугаар микрофон.

Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Баяндүүрэн Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны үндсэн чиг үүргийн нэг бол сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг байгаа. Энэ ажлын хүрээнд бол Сонгуулийн ерөнхий хороонд бол үндсэн одоо нийт сонгогчдод боловсрол олгох чиглэлээр сонгогчийн сургалт судалгааны төвийг үндсэн нэгжийг бол байгуулаад ажиллаж байгаа. Уг төв маань олон улсын байгууллага болон дотоодын төрийн бус байгууллагуудтай хамтраад олон төрлийн сургалт сурталчилгааг сонгогчдодоо чиглүүлж ажиллаж байгаа.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтраад “хариуцлагатай сонгогч” гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт бол тус бүрд нь өнгөрсөн жил 2, 2 сургагч багшийг бэлтгээд тухайн тойрог аймаг, дүүргүүддээ залуу сонгогчдыг хариуцлагатай сонгогчийг бэлтгэх энэ сургалтыг зохион байгуулж явуулсан. Энэ жилийн хувьд бас энэ сургалтын хөтөлбөр маань үргэлжлээд ингээд явж байгаа.

Мөн дээрээс нь бол 20 оны сонгуулиас эхлээд Сонгуулийн ерөнхий

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хорооноос сонгогчдод боловсрол олгох чиглэлээр “сонгогчийн ном” гэдэг ийм номын одоо эрх зүйн бичиг баримтыг номыг бүтээж, сонгогчдодоо хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн өнгөрсөн оноос эхлээд Сонгуулийн ерөнхий хороо бол “сонгогчийн боловсрол” гэдэг ийм сэтгүүлийг бий болгоод үндсэндээ 3, 4 дугаар ингээд гаргаад явж байна. Энэ ажил маань цаашидаа үргэлжлээд ингээд зохион байгуулагдаад явагдана.

Үндсэндээ төсвийн хөрөнгөөр энэ ажлыг зохион байгуулж явуулахад хангалттай хүртээмж муутай байгаа учраас бид нар цаашидаа олон улсын байгууллагууд, сонгуулийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Солонгосын сонгуулийн төв байгууллагатай хамтраад Койка-ийн дэмжлэгтэйгээр бол 24 оноос эхлээд бас энэ сонгогчдын боловсролын чиглэлд бас сургалт сурталчилгаа явуулах энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажлаа хөөцөлдөөд явж байгаа гэх мэтчилний ийм олон зүйлийн ажлыг хийж байгаа. Мөн дээрээс нь ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** 1 минутад багтаагаад нэмээд хариулчих, ажлын хэсгийн 86 дугаар микрофон өгье.

**Д.Баяндүүрэн:** Мөн өнгөрсөн 20 оны сонгууль, 21 оны Улсын Их Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгуулиудаар бол зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг бол зохион байгуулж явуулсан байгаа. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санал өгөх чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, мөн сонгуулийн санал авах байруудад орох орц гарцыг нээх, мөн дээрээс нь санал өгөх боломжоор хангах брайл үсэгтэй хавтсаар хангах, мөн зурагтаар явж байгаа телевиз, радиогоор явж байгаа сургалт сурталчилгааны контентуудыг бол тодорхой дохионы хэллэгээр орчуулах энэ чиглэлийн ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлж ажилласан байгаа.

**Л.Мөнхбаатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн нэмж асууя.

**Б.Баттөмөр:** Миний ойлгож байгаагаар 2024 оны сонгуульд эрсдэлүүд маш их бий. Энэ эрсдэлийг бол тооцох ёстой. Бас хууль санаачилж байгаа улсууд, Сонгуулийн ерөнхий хороо тэгээд оонийгээ тооцно биз. Энэ дээр бол их олон зүйлүүд бий шүү. Үүнийг хэлэх гээд байгаа юм. Сая одоо манай улсууд ч бас ярьж байна. Энэ сонгогчдын санал худалдаж авдаг, үүнийг бууруулах чиглэлээр юм тараадаг барьдаг юмнууд зөндөө байгаа шүү дээ. Үүнийг хаах хэрэгтэй. Сая манай зарим гишүүдийн ярьсан тэр жагсаалтад орсон хүмүүс Засгийн газарт орохгүй байх. Ухуулах сурталчилгааг дандаа мэтгэлцээний хэлбэрээр, бие биеийнхээ араар тойрч явах биш мэтгэлцээний хэлбэрээр хамт явдаг хэлбэрүүд, би бол дэмжиж байна. Энэ бас ил шүү, өөрийнхөө зорилтот хөтөлбөр, мөрийн хөтөлбөрөө танилцуулаад явах нь бол ил тод ийм болох сайн талтай гэж ингэж үзэж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр гишүүн үг хэллээ. Санал хэлчихлээ. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ өргөн барьсан төслийг бол зарчмын хувьд дэмжиж байна. Энэ Монгол Улсын хөгжилд өнгөрсөн 30 жилд нэр дэвшигч төвтэй буюу хувь хүний үүрэг нөлөөтэй байдаг, тойргоор хуваагдсан мажоритар систем бол ихээхэн хөгжлийн болон эдийн засгийн төсвийн одоо тарамдмал байдлыг үүсгэж ирсэн сөрөг үр дагавартай. Тэгвэл энэ холимог систем бол үүнийг даван гарах нэг гарц учраас бол дэмжиж байна. Тэгээд холимог системийг нэвтрүүлсэн тэр дотор намын жагсаалтыг оруулж ирсэн нь намуудыг бодлогоор өрсөлддөг гэсэн, бодлогын нам бий болгох, иргэд бодлогын төлөө саналаа өгдөг болох, түүнээс биш хувь хүн нэр дэвшигч гэдэг юм уу, тухайн олны танил хүмүүсийн хувь хүнийх нь мөн чанарт

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

саналаа өгдөггүй ийм байдлыг бий болгож байгаа учраас энэ бол дэвшилттэй.

Тэгэхдээ яг энэ холимог системийн хувьд намын жагсаалтыг хэрхэн хийх вэ, намыг жагсаалтад ямар байдлаар сонгогчийн саналыг авах вэ гэдэг дээр бодолцох шаардлагатай байгаа юм. Тухайлбал хэрвээ намын жагсаалтад сонгогч хүн нэр дэвшигчийг сонгоно гэж байвал энэ маань одоо пропорциональ төлөөлөл болж чадахгүй. Бүхэлдээ улс орны хэмжээний нэг том тойрог томсгосон тойрог тэгээд нам бүрээс 38 нэр дэвшигч дэвшсэн бараг одоо хэдэн зуун нэр дэвшигч бүхий томсгосон тойрог болчих учраас бид нар энэ намын жагсаалтад сонгогчийн санал өгөх байдлыг маш сайн бодолцох шаардлагатай. Ер нь бол одоо Герман, Япон, Солонгос зэрэг улсуудын сонгогч бүр 2 саналаа өгдөг, 1 саналаа тойрогт нэр дэвшигч, 2 дахь саналаа бол нам юм уу эвсэлд өгдөг энэ хувилбараар явах нь зүйтэй байгаа. Ингэж байж нөгөө сонгуулийн санал өгөлт маань сонгогчидтой хялбар ойлгомжтой болох ёстой.

Тэгээд нэг ийм асуулт байна. Ер нь энэ сонгуулийн энэ төсөл дээр яах вэ зардлыг бууруулна аа гээд тодорхой дэвшилттэй заалтууд бол байна. Тэгэхдээ яг бидний хүсэн хүлээж байгаа энэ сонгуулийн зардлыг үлэмж хэмжээгээр бууруулах, сонгуульдаа хөрөнгө мөнгөний нөлөөг багасгах ийм дэвшилд хүрэх үү, үгүй юү гэдгийг нь хуулийн төсөл санаачлагчаас асуумаар байна. Ер нь бол энэ яг ухуулагчийн зардлыг, самбаруудыг, дээр нь бусад тээврийн хэрэгсэл зэргийг бууруулсан болов чиг энэ маань ерөнхийдөө томоохон үндэслэл болж чадах юм уу үгүй юү? Ер нь Герман Европын улсын жишигээр ерөөсөө ухуулагч бол ямар нэг цалин хөлсгүй, сайн дураар ажилладаг. Нам нэр дэвшигч нарын сонгуулийн сурталчилгааны материалыг нь нэгдсэн журмаар тараадаг. Монгол шуудан компани ч юм уу, иймэрхүү байдлаар аль болох энэ

зардлыг бууруулах дэвшилттэй алхмуудыг хиймээр санагдаад байна, үүнийг асууя.

2 дугаарт нь, ер нь бүхэлдээ энэ 38 тойрог мажоритар, 38 намын жагсаалт гэхээр Монгол Улсыг төлөөлөх энэ парламент бүрдэж чадах уу. Өнөөдөр байгаа 76 гишүүн маань ер нь Монгол Улсын иргэдийг төлөөлж чадаж байгаа юм уу, үгүй юү гэдэг асуудал үүсэж байна. Холимог системээр явах нь зөв. Тэгэхдээ бид нар улс орны хэмжээний нийгмийн бүтцийг парламентад төлөөлөх ёстой.

Дээр нь жижиг улсын хувьд бид нар газар нутгийн төлөөллийг бас хангамаар байна. Хязгаар нутаг, бүс нутгуудын хөгжлийг бодолцох ёстой. Тийм учраас мажоритар системтэй, дээр нь намын жагсаалт бүхий ийм пропорциональ байх ёстой. Тэгэхдээ өнөөдөр байгаа энэ 76 гишүүнтэй парламент бол Монгол Улсын иргэдийн төлөөлөл болж чадахгүй байгаа. Тийм учраас хэрвээ манай Улсын Их Хурал энэ асуудлыг хэлэлцэж байгаа бол давхар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ярих зайлиггүй шаардлага байна. Олон улсын хэмжээнд, бүс нутгийн хэмжээнд тодорхой бас геополитикийн асуудлууд байна. Ер нь одоо гадаад улсуудын эрх зүйн болон бусад нөхцөл байдлыг үзэхэд бид нар бол цаашидаа энэ Монгол Улсын парламентыг бэхжүүлэх, тэр дотроо энэ парламент маань иргэдээ бүрэн хэмжээгээр төлөөлөх, нийгмийн бүлэг бүрийн төлөөллийг хангах шаардлагатай. Залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг. Эдгээрийн төлөөллийг хангахын тулд бид нар намын жагсаалттай мөн одоо парламентынхаа тоог эргэж харах шаардлагатай. Энэ дээр одоо манай хууль санаачлагч юу гэж үзсэн юм бол.

3 дугаарт нь, нэг ийм хязгаарлалтын шинжтэй асуулт орчихсон байна л даа. Төслийн 67-ын 19 дээр сонгогчийг саналаа өгсний дараа өгсөн саналынх нь талаар асуухыг

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хориглоно гэж. Гэтэл дэлхийн улс орнуудад саналаа өгсөн сонгогчоос асууж, судалгаа авдаг нь бол олон улсын чиг хандлага, энэ бол экзит полл гээд маш чухал үр дүн байдаг. Өөрөөр хэлбэл сонгуулийг будилаан, луйвраас хамгаалах, сонгуулийн үр дүнд нөлөөлөхгүй байх нэг судалгааны үндэслэл бол ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Доржханд гишүүн хариулах уу? Тэгье. Хуулийн төсөл хамтран өргөн барьсан гишүүн, Доржханд гишүүн хариулъя, асуултад.

**Т.Доржханд:** Мөнхцэцэг гишүүнтэй бол 100 хувь санал нэг байна. Тэр саналууд бол яг таны хэлсэн агуулгаар бол бид нар энэ тогтолцооны өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Ялангуяа том бодлогыг ярьдаг, бодлого дээрээ хэлэлцүүлэг хийдэг, ийм бодлогын улс төрчдийг яг энэ пропорциональ тогтолцоогоор оруулж ирэх нь зүйтэй гэсэн ийм агуулгаар бол 50 хувьд нь гэж оруулж ирж байгаа. Үр дүнд нь бол яах аргагүй бас эдийн засгийн хувьд бол маш том бүтээн байгуулалтууд хийгдэх боломж бүрдэнэ. Мөн түрүүчийн хэлдгээр бас өрийн асуудлыг ишидэх боломж бас бүрдэнэ ээ. Цаашаагаа хувийн секторыг дэмжих боломж бүрдэнэ. Зах зээлийн эдийн засгийг дэмжих боломж бүрдэнэ. Ардчилаа хамгаалах бас боломж бүрдэнэ ээ гэж.

Харин асуултын хувьд нөгөө 1 дүгээр асуултын хувьд яг нөгөө үнэмлэхүй хэмжээгээр зардлыг бууруулж чадаж байгаа юу гээд. Тэгээд манай бас ажлын хэсгээс түрүүн нэлээн олон тайлбар өгсөн. Яг бидний тооцоогоор маш ойлгомжтойгоор 50 хувиар бол буурах юм байна лээ. Дунджаар 2020 оны сонгуулийн дундаж зардал бол 600 сая төгрөг байсан юм байна лээ. Одоо бол 300 сая гэж. Тэгээд энэ бол нэг доллароор илэрхийлэх юм бол 90 мянган доллар юм билээ. Тэгээд цаашаа бас буулгах боломж байгаа юу гэхээр, боломж байгаа, та саналаа өгөөрэй. Тэгээд ажлын хэсэг гарсны дараа бол ажлын хэсэг дээр яриад бас энэ

чиглэлээр ажиллах ёстой юм билээ. Тухайлбал, ухуулагчид сайн дурынх байх ёстой юу гэвэл маш олон гишүүд бас энэ асуудлыг тавьж байна. Сайн дурынх байх ёстой.

Дээрээс нь нэг самбар дээр нийт нэр дэвшигчдийн зургийг нь нийтлээд яг Япон, Германы жишигээр явах ёстой юу гэдэг дээр бас санал нэгтэй байгаа. Үүнийгээ бол бид нар бас зохион байгуулах ёстой. Энэ ажлуудаа ажлын хэсэг дээр нарийлж ярих боломжтой.

2 дугаарт, энэ Улсын Их Хурлын гишүүдийн тооны асуудал ярьж байна. Тэгээд өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр мөн Засгийн газарт өгсөн Улсын Их Хурлын тов тодорхой чиглэл байгаа. Энэ бол Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол. 54 дүгээр тогтоолоор Улсын Их Хурал дахь парламентын төлөөлөх чадварыг дээшлүүлэх, 2 дугаарт, сонгуулийн тогтолцоог тодорхой болгох буюу пропорциональ элементийг оруулах гэсэн энэ чиглэлээр тогтоол гарсан. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруул аа гэдэг үүргийг Засгийн газарт өгсөн. Тэгээд Засгийн газар дээрх ажлын хэсгийн ахлагч нь бол яг энэ асуудал бэлэн байгаа. Тэгээд яамдаас бол санал аваад ирэх 7 хоногоос Засгийн газраар хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн барина аа гэдгээ бол албан ёсоор мэдэгдсэн байгаа.

Тэгэхээр үүнийг бол бид нар хамтад нь ярих ёстой. Тэгээд хамтад нь энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал, нэмэх нь энэ сонгуулийн хуулийн нэмэлт өөрчлөлт, нэмэх нь бас улс төрийн намын тухайн хуулийн асуудлыг цогцоор нь ингээд ярьж байж бид нар энэ цогц реформоо бол хийнэ ээ гэж ойлгож байгаа.

Тэгээд мөн дараагийн асуудал нь болохоор тэр экзит поллын асуудал ярьж байх шиг байна лээ. Яг түүн дээр бол яг нарийн деталийг манай ажлын хэсэг хариулах байх. Баярлалаа.



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг нэмж хариулья, 85 дугаар микрофон өгье. Бат-Эрдэнэ дарга хариулья.

**Д.Бат-Эрдэнэ:** Мөнхцэцэг гишүүний асуултад нэмж хариулья. 1 дүгээрт, ухуулагчийг сайн дурын үндсэн дээр ажиллуулах ёстой гээд ер нь бол 2016 онд явсан Их Хурлын сонгуулийг бол ерөөсөө үнэгүй ажиллана гээд хуульчилчихсан байсан. Тэгээд эндээс давуу талтай. Нөгөө талдаа ямар сөрөг тал гарсан бэ гэхээр зэрэг нөгөө ухуулагчид зайлшгүй ингээд зардал өгөх үйл ажиллагааны зардал гэдэг юм уу, урамшуулал гэдэг юм уу өгөх ийм шаардлага үүсдэг. Ажлын хэлс ч гэдэг юм уу. Гэтэл үүнийг нөгөө өгөхөөр зэрэг хууль зөрчсөн арга хэлбэр лүү орчих гээд байсан учраас ерөөсөө үнэ төлбөргүй гэж шүүд ингэж заах нь боломжгүй юм байна. Үнэ төлбөргүй ажиллуулах уу, төлбөртэй ажиллуулах уу гэдгийг нэр дэвшигч болон ухуулагчаар ажиллах гэж байгаа хүмүүсийн хоорондоо тохиролцох ийм асуудал юм байна, үндсэн зарчмыг нь заагаад өгье гэж энэ нэмэлт, өөрчлөлтөөр бол сайн дурын үндсэн дээр ажиллана. Өгч байгаа урамшууллын чинь хэмжээ нь бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна шүү гэдэг үндсэн зарчмыг л тогтоож өгсөн байгаа.

2 дугаарт, эксит поллтой холбоотойгоор 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеэр эксит поллыг бол бид нар, бид нар яах вэ төрийн бус байгууллагуудаас Америкт явуулж байсан ийм турилага бий. Ер нь энэ эксит полл мөн опенион полл гэж явдаг. Энэ яг цэвэр сонгуулийн ийм соёлтой холбоотой асуудал. Бид нар бол цаашидаа үүнийг бас зөвшөөрдөг энэ хэлбэр лүүгээ л явах ёстой. Одоо ер нь яагаад болохгүй байгаад байгаа юм бэ гэхээр зэрэг 2 эксит пол болон опенион полыг хоёуланг нь хориглохгоод байгаа юм. Хуулийн төслийн 14-ийн 11-ээр Мөнхцэцэг гишүүний хэлдгээр Сонгуулийн ерөнхий хороо албан ёсны дүн гаргаагүй байхад нэр дэвшигч нар өөрсдөө уралдаад мэдэгдэл гаргадаг.

Би энд ялж явж байна, энд ялж явж байна гээд. Гэтэл санал хураалтын дүн албан ёсоор гараад ирэхээр зэрэг магадгүй тэр мэдэгдлээс нь зөрөх юм бол сонгууль луйвардлаа, булхайдлаа гэсэн ийм хэл ам гардаг учраас үүнийг хаах зорилготой. Ер нь үндсэндээ бол энэ 2008 оны 07 сарын 01-тэй холбоотой ийм асуудлууд яваад байдаг юм байна лээ.

Мөн дээрээс нь тэр чансаа тогтоохыг бол бас одоо хориглочихсон л байгаа. Ер нь бид нар цаашидаа яг энэ сонгуулийн соёлыг зөв хэвшүүлэхийн тулд эксит полл, опенион полуудыг бас цаашид хүлээн зөвшөөрөх юм бол хандлага ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Холимог тогтолцоогоор Сонгуулийн хуулийн төсөл орж ирж байгаад бас талархалтай байна. Яагаад гэвэл үнэхээр мажоритарт тогтолцоогоор сонгогдсон энэ парламентад тойргийн буюу өөрийн зөвхөн сонгогдсон тойргийнхоо эрх ашгийн үүднээс ажиллах гэдэг юм уу, зүгээр л жишээ болгоход төсөв батлагдахад зөвхөн тойргийнхтойгоо төсвийг ярьдаг нэг ийм сөрөг тал байдаг. Тэгвэл ийнхүү холимог тогтолцоогоор явснаар зөвхөн 1 тойргийн бус 1 улс гэсэн энэ бодлого бас хэрэгжих бүрэн боломж бас нээгдэх байх аа гэж харж байна.

Яг өнөөдрийн бид нарын хэлэлцэж байгаа Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан энэ хуулийн төсөл дээр хүйсийн харьцаа 30 хувь байх гэсэн квот оруулж ирсэн. Мөн жагсаал дээр орж ирэх 38 нэрс дээр 1, 1 гэсэн харьцаагаар эрэгтэй, эмэгтэй хүйсийг бас сольж жагсаах гэсэн ийм заалтууд орж ирсэн байгаа. Энэ бол зөвхөн ганц эмэгтэйчүүдийн асуудал биш юм аа. Хүйсийн тэгш байдлыг хангах энэ боломжийг бас нээж өгч байгаа. Харин энэ хууль батлагдсаны дараагаар энэ хуулийг бас батлах байх гэж би бодож

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

байна. Энэ хууль батлагдсаны дараагаар ямарваа нэгэн нам үл харгалзан эмэгтэйчүүд маань хуулиа сонгогч түмэндээ танилцуулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх тал дээр бас хамтран ажиллана гэдэгт бас итгэлтэй байгаагаа хэлье.

Ингээд асуулт руугаа оръё. Ер нь яагаад намын нэрийн өмнөөс 38 гэсэн жагсаалтыг оруулж ирсэн юм бол оо. Яагаад 38 гэсэн тоог зааж өгч байгаа юм бол оо гэдгийг бас тайлбарлаж өгөөч ээ гэдэг нэг ийм хүсэлт байна. Ер нь Монгол Улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй. Гэтэл энэ хуулийн зарим нэг зүйл заалт дээр сонгогчдын бас сонгох эрхэд бас тодорхой хэмжээний хязгаарлалт буюу сонгогчдын эрхийг сонгох саналыг хязгаарлах ийм заалт байна уу гэж харж байна. Өөрөөр хэлэх юм бол 74.3.2 энэ хуулийн 74.2-т заасан шаардлага хангаагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг мөн хуулийн 74.2-т заасан шаардлага хангасан нам, эвсэлд тэнцүү хэмжээгээр хуваан, тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно гэсэн нэг ийм заалт байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол би одоо жишээ нь Энхболд гишүүний намыг сонгогчоод, саналаа өгчихсөн байхад, Энхболд гишүүний нам 3 хувьдаа хүрч чадаагүй бол миний санал Сэргэлэн гишүүний нам руу шилжих нь ээ, нэг ийм ойлголт байгаад байна. Тэгэхээр миний өгсөн санал хүчгүй болоод өөрөөр хэлэх юм бол гулсаад орчхож байгаа байхгүй юу, өөр нам руу гэж ойлгогдоод байна л даа. Энэ 74.2-ын 3.2-ыг бас тайлбарлаж өгөөч ээ? Тэгвэл миний нөгөө сонгосон санал маань хүчингүй болчихно. Ингээж өөр тийш нь шилжүүлж байхаас илүүтэйгээр зүгээр хүчингүйд тооцож болдоггүй юм уу? Энэ асуултад хариулт авчхаад дараагийнхаа асуултыг асууя.

**Л.Мөнхбаатар:** Жаргалмаа гишүүн нэлээн тодорхой асуулт асуугаад байна. Доржханд гишүүн хариулчихъя, асуултад хариулъя.

**Т.Доржханд:** Жаргалмаа гишүүний асуултад хариулахад яагаад 38, 38 гэсэн юм бэ гэдэг тоо асууж байх шиг байна. Тэгээд энэ маш их агуулгатай тоо байгаа. Өөрөөр хэлэх юм бол парламентын гишүүдийн 50 хувь нь бол пропорциональ элемент буюу тухайн намын бодлогоор сонгогдож гарч ирсэн ийм парламентын гишүүд байя аа. Энэ нь болохоор улс орныхоо бодлогын асуудлуудыг ярьдаг байя. Маш энгийн жишээ гэхэд 20 жил цахилгаан станц баригдаагүй. Яагаад вэ гэхээр цахилгаан станцын хөрөнгө оруулалтын төслийг кноптож чадаагүй байхгүй юу. Маш энгийнээр хэлэхэд бид нар нөгөө дунд, урт хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрөө хэрэгжүүлж чаддаггүй, бодлого ярьдаггүй. Яагаад вэ гэхээр тэр тойргоос хамааралтай 30 жил ингээж явж ирсэн юм аа. Тэгээд ийм болохоороо дор хаяж парламентын 50 хувь нь болохоор бодлого ярьдаг, бодлогын улс төрчид байя аа, улс орныхоо 3.4 сая иргэдийг төлөөлдөг байя гэж байгаа юм.

Харин үлдсэн 50 хувь нь болохоороо орон нутаг, газар нутгаа төлөөлдөг байя аа. Ингээж нөгөө балансыг нь барьж явъя аа гэж байгаа юм. Цаашаа бол яг парламентын хөгжилтэй улсуудын хувьд жишиг нь бол 100 хувь пропорциональ байдаг. Ингээж байж бүх төлөөллүүд орж ирдэг. Өнөөдрийн төлөөлөлд байж чадахгүй байгаа асуудал нь юу байна гэхээр эмэгтэйчүүдийн төлөөлөл байгаа, та сайн мэдэж байгаа. Нийт 151 эмэгтэйчүүд 2020 онд сонгуульд өрсөлдсөн боловч ердөө 13 нь буюу нийт парламентын 17 хувь нь төлөөлж байдаг. Гэтэл нийт хүн амын 51 хувь байна аа, энэ бол төлөөлж чадахгүй байна аа, залуучуудыг төлөөлж чадахгүй байна, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна уу гээд. Тэгэхээр энэ төлөөллийг бий болгодог арга хэрэгсэл нь юу байна аа гээд тэгэхээр энэ пропорциональ элемент олон улсад ингээж явдаг, үүгээрээ л явах ёстой гэж.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2 дугаар асуудал болохоор тэр санал гээгдээд байна аа гээд. Тэгэхээр парламент гэдэг бол улс төрийн намуудын бодлогын мэтгэлцээний талбар. Улс төрийн нам гэдэг бол өөрсдийн үзэл санаан дээр нэгдсэн, бодлогоороо өрсөлддөг ийм институц юм. Гэтэл та ч мэдэж байгаа, би ч мэдэж байгаа. Монголд 40-өөд нам бол байна. Зарим нь бол 1 хүний нам гэж ярьдаг. Сонгуульд ороод байхгүй болчихдог. Тэгээд намаа татан буулгая гэхэд нөгөө хүмүүс нь цуглаж чадахгүй байна гэж байна шүү дээ, бид нар нөгөө хууль эрх зүйн орчин тийм. Тэгэхээр босго тавьж өгөөд тэр улс төрийн намуудыг илүү сахилгажуулъя, үүрэгжүүлъя. Улс төрийн институц рүү нь оруулъя. Тийм болохоороо үнэхээр 3 хувийнхаа босгыг давж гарч ирэх юм бол парламентдаа суудалтай бол, үлдсэн тохиолдолд бол үүнийгээ бусад парламентын босго давсан намууд руу хуваарилдаг олон улсын жишиг юм. Парламентын ардчилалтай бүх улсуудын хувьд яг энэ жишигээр явдаг. Тэгээд энэ жишигээрээ бол бусад руу нь харин хуваарилснаараа тэр хүмүүсийн сонголт бол хадгалагдаж үлддэг энэ олон улсын жишиг байгаа юм аа. Тэгээд үүний дагуу бид нар экспертүүдтэй сайн ярилцаж байгаад энэ зохицуулалтыг оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу. Бадарчийн Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалмаа:** Бид нар Үндсэн хуулиараа бас сонгогдох, сонгох эрхтэй. Ямарваа нэгэн байдлаар энэ хуулийн төслийн саяын миний дурдсан заалтаар миний сонгосон санал ямарваа нэгэн байдлаар шилжих аваас энэ эрх зөрчигдөж байна гэдэг ийм асуудал бас гарах болов уу гэсэн ийм бодлогын үүднээс бас саяын асуултыг асуулаа. Яг энэ парламентад бас МАН болон АН аль аль нь бас сонгуулийн төсөл өргөн барьсан байгаа. Тэгээд парламентад суудалтай намууд маань бас эмэгтэйчүүдийн квотыг бас тодорхой хэмжээнд

нэмэгдүүлж, жагсаалтаар орж ирэх пропорциональ тогтолцоо дээрээ ч гэсэн 1:1, 2:1 гэсэн ийм боломжийг бас эмэгтэйчүүдэд олгож байгааг бас талархан бас дэмжиж байгаагаа бас илэрхийлэхийг хүсэж байна. Би түрүүн хэлсэн. Ер нь сонгогчдын боловсролд бол бид онцгойлон анхаарч, энэ хуулийн зорилтуудаа бас танилцуулах зайлшгүй шаардлага үүснэ гэж бодож байна. Тийм учраас нам үл харгалзан эмэгтэйчүүд маань бас хамтран энэ хуулиа олон нийтэд танилцуулах, сурталчлах яагаад нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоо чухал юм бэ? ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Санал хэллээ. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя. Одонтуяа гишүүний микрофоныг өгөөрэй. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

**С.Одонтуяа:** Жоохон яриулах дургүй байгаа юм байх даа. Тэгэхээр ер нь энэ улс оронд, улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн бүх асуудалд бид нар тогтолцооны шинэчлэл хийх ингээд зорилт тавьсан. Яг энэ улс төрийн намын тухай хууль, сонгуулийн хуулиа бид нар энэ реформыг нь яг бодит утгаар нь хийхгүй бол энэ тогтолцооны шинэчлэл угаасаа нийгэмд хийгдэнэ гэж горьдоод ч хэрэггүй юм байна лээ. Гол 2 хууль чинь энд байгаа. Олон улсын байгууллагууд трансперенси интернэйшнл байгууллагаас Монгол Улсад байгаа авлигын гол голомт чинь энэ улс төрийн намын, улс төрийн нам болон сонгуулийн зардлаар чинь дамжиж гарч байна аа, бий болж байна аа гэж үздэг. Тийм учраас бид нар энэ хуулиа үнэхээр яг реформ авчирч чадах тийм л хууль болгох ёстой юм. Түүнээс зүгээр 1, 2 заалт засаад бол явахгүй.

Тэгэхээр би Сонгуулийн ерөнхий хорооныхноос асуумаар байна л даа. Зардал зөвхөн тэр нэг хэдэн хуулагчдын тоог нэмж, хассанаар их сүртэй зардал буурахгүй шүү дээ. Цаана нь маш их зардал бууруулж болж байна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Жишээлэхэд Европын Холбооны орнуудын ингээд бид нар эмэгтэй парламентчидтай уулзахад 1000, 2000 евро л зарсан байдаг байхгүй юу, сонгуульдаа. Гэтэл Монголд өнөөдөр Сонгуулийн ерөнхий хороо нь 600 сая доод талын зардал нь, 1 тэрбум гээд ингээд сууж байгаа чинь Монголчууд бид үнэхээр тэнэг байдалтай л байна гэсэн үг. Тэгэхээр энэ зардлыг яаж бууруулж болох вэ? Иргэд бол хэд хэдэн хувилбар хэлдэг шүү дээ. Үгүй ээ, нэгдсэн самбар тавьчхаач ээ эсвэл материалаа нэгдсэн тараачхаач ээ гээд. Тэгэхээр энэ дээр яг аргачлал хэрэгтэй байна. Яг аргачлал хэрэгтэй. Жишээлэхэд Японд болоод, Солонгост болоод, Монголд яагаад болохгүй юм?

Хэрвээ тэр тараах материал жишээлэхэд төсвөөс гарахаар зардал үнэ бүр төсвийн зардал дийлэхгүй байгаа бол нэр дэвшигчид зардлаа хуваах маягаар бас тойрог бүрдээ шийдэх энэ боломжийг нь олгож болно. Жишээлэхэд 1 дүүрэг яриад та нар одоо нэр дэвшигчид нийлээд самбарынхаа зардлыг гаргаад, нэгдсэн ингээд тавих юм уу гэдэг ч юм уу ингээд зардлыг нь тодорхой хэмжээгээр бас нэр дэвшигчдээс гаргавал хамаагүй хямдарна шүү дээ гэх мэтчилэн энэ зардал хэмнэх дээр ямар зүйл байна?

2-т, Доржханд гишүүнээс бас санаачлагчаас 1 зүйлийг асууя. Та бид хоёр 2021 онд тэр цагаан сараар одоо ерөөсөө гишүүд энэ боов тараадгаа больё гээд хэлсэн. Тэгэхээр энэ хуульд энэ заалтууд чинь яг яаж тусах гээд байна вэ? Тэр ер нь ингээд зөвхөн сонгуулийн жил тараах гээд орчихсон байдаг шүү дээ, одоогийн хуульд. Тэгэхээр ер нь бол хүн сонгогдсоноосоо хойш л тараахыг бүр хориглочих. Яагаад гэхээр хууль тогтоогчид шүү дээ, бид нар чинь. Тэгэхээр хууль тогтоогчид нийт улс орныхоо хэмжээний хууль тогтоомж дээр л ажиллах ёстой болохоос биш тэгж нэг юм тараадаг.

Дээрээс нь горилогчдыг бас хориглох хэрэгтэй. Нөгөө сонгогдчихсон гишүүн нь тараахгүй байж байтал 1 хүн тараагаад л байдаг, тараагаад л байдаг, тэгээд нэр дэвшээд дараагийн сонгуульд гараад ирвэл яах юм. Санал авсан. Тэгэхээр үүнийг Доржханд гишүүнээс асуумаар байна. Тэгээд ер нь энэ одоо бид нар чинь цахимжсан орон боллоо л гэдэг энэ цахим хууль, энэ цахимжсан байдлаа энэ зардал бууруулах дээр яг яаж оруулаад байгаа юм бэ гэдгийг тодорхой асууя.

**Л.Мөнхбаатар:** Одонтуяа гишүүний эхний асуултад ажлын хэсэг хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга хариулъя, 83 дугаар микрофон өгье. 2 дахь асуултад нь Доржханд гишүүн хариулаарай.

**П.Дэлгэрнаран:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Одонтуяа гишүүн өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр бас бид нарт үүнийг сануулж анхааруулсан. Тэгээд бид нар судалж үзсэн. Тэгэхээр энэ самбарыг нэгдсэн байдлаар зохион байгуулах боломж алга уу? Тэгвэл одоо тэнд тухайн тойрог дээр нэр дэвшигчид болон оролцож байгаа намууд нийлээд сурталчилгааныхаа самбарыг нэгдмэл байдлаар хийгээд явбал зардал бол маш огцом буурах ийм боломж байна шүү дээ гэдэг ийм юуг өгсөн. Бид нар бол судалж үзсэн. Нэг хэсэг дээр нэг ийм 2 самбар байрлуулаад, тэгээд яах вэ, энэ хуулийн төслөөр бол 1 дэвшигчийнх хэвлэлийн хуудсаар хэмжигдэж байгаа. Ингээд яах вэ хэмжээг нь бол нэг стандарт тогтоогоод, загварыг нь баталж өгөөд, тэгээд одоо цаг хугацааны хувьд ч гэсэн уг нь боломж бол байгаа юм, энэ. Яагаад вэ гэвэл үүнийг шийдэх 2 арга байгаа юм.

1 дүгээрт нь, улсын төсвөөр тухайн аймаг, орон нутаг буюу сум, дүүргийн төсөвт урьдчилж суулгаад тэгээд сонгуулийн жил тэрийгээ ашиглаад явна. Тэгээд энэ нэгэнт ингээд бүтээчихсэн самбар чинь цаашдаа олон



дахин ашиглагдах бас ач холбогдолтой байхгүй юу.

2 дахь нь, Одонтуяа гишүүний хэлж байгаа тухайн тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүс бол дундаасаа зардлаа гаргаад, ингээд самбараа нэгдсэн байдлаар ашиглаад сурталчилгааны материалуудаа нэгдсэн байдлаар байрлуулаад ингээд явах юм бол энэ бас их үр дүнтэй, сайн арга байж болох юм. Тэгэх юм бол энэ бид нар хуулийн төслийн 42 дугаар зүйлд бүхэлд нь өөрчлөлт оруулаад ингээд явах уг нь боломж байна гэж үзэж байна. Тэгээд энэ зардал ингээж хямдрах юм бол энэ самбар бий болчих юм бол цаашидаа зөвхөн сонгуулийн төдийгүй, сонгуулийн бус үед ч гэсэн орон нутгийн засаг захиргаа үүнийг ашиглаад яваад байх ийм боломж үүсэж байгаа юм.

Тэгээд өчигдөр мөн Нямбаатар гишүүн хэлсэн. E-монголиа систем дотор тэр и-мэйл гээд аппликэйшн бий болсон, үүнийг иргэн болгон ашиглах боломжтой гэж үзэж байгаа. Тэгээд үүнийг хэрвээ ашиглахыг нээж, хуульчилж өгье гэвэл бас энэ хуулийн төслийн 47 дугаар зүйл дээр нэмэлт бас оруулаад явбал ийм байж болох юмаа гэж үзэж байна.

Цахим хөгжлийн яамныхантай зөвлөлдөхөөр энэ бол хэрэглэх боломж нь бүрэн бүрдсэн, гэхдээ хэрэглээний түвшин бол их бага байгаа гэдэг ийм тайлбарыг өгч байгаа. Тэгэхээр энэ бол хэр зэрэг үр дүн гаргах вэ гэдгийг бас бодолцох хэрэгтэй гэсэн ийм зөвлөмжийг өгч байгаа юмаа. Баярлалаа. Тэгээд бас нэр дэвшигч дээр ч бас хийж болох л юм.

**Л.Мөнхбаатар:** Тогмидын Доржханд гишүүн асуултад хариулъя.

**Т.Доржханд:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Одонтуяа гишүүн бидний зүгээс бол энэ бэлэг тараалтыг хориглох ийм хуулийн төслийг санаачилж байсан. Тэгээд яг энэ агуулга маань Сонгуулийн тухай хуульд орсон уу гэж асууж байна. Тэгэхээр энэ агуулга

маань энэ Улс төрийн намын тухай хууль дээр орсон байгаа. Ажлын хэсэгтэй нь уулзаж саналаа өгсөн, туссан байгаа. Харин Сонгуулийн тухай хууль дээр бол яг одоо уг үсгээрээ ороогүй байгаа. Гэхдээ оруулах шаардлага байгаа гэж үзэж байгаа. Яг тантай санал нэг байгаа. Тухайлбал улс төрийн нам болон эвслийг бол хориглож болдог. Улсын Их Хурлын гишүүнийг хориглож болдог. Гэтэл бие даагчдын асуудал гарч ирж байгаа, бие даагчид маань мөн бэлэг сэлт өгөөд тэгээд сонгогдох ийм нөхцөлийг үүсгэсэн тохиолдолд тэр нь Улс төрийн намын тухай хуулиар бол ямар нэгэн хязгаарлалт байхгүй байгаа юм. Ийм болохоор бид нар ажлын хэсэг дээрээ ярилцаад энэ асуудлыг тусгах боломжтой, тусгаад явна аа гэсэн ийм бодолтой байна. Ер нь бол сонгогдсон албан тушаалтан, мөн сонгогдох гэж горилж байгаа аливаа нэр дэвшигчид ямар нэгэн байдлаар санал худалдан авах зорилгоор бэлэг сэлт тараахыг хязгаарлах ёстой. Тэгээд үүнийг бид нар оруулаад явна аа гэсэн ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

**Ц.Туваан:** Энэ дээр энэ холимог тогтолцоог бол дэмжиж байгаа. Тэгээд энэ намууд тусдаа хуулиудаа өргөн барьсан байгаа. Тоо нь бол ингээд гараад ирэх байх. АН-ын хувьд бол энэ холимог тогтолцоонд яагаад ард түмэн дургүй байдаг вэ гэхээр энэ хулгайч, авлигачин, муу нэртэй янз бүрийн юманд холбогдсон хүмүүсийг энэ листэд бичиж оруулж ирэх гээд байна аа гэдэг ийм л асуудал ярьдаг шүү дээ. Тэгэхээр АН-ын хувьд бол ийм листийг хийхгүй ээ. Дээрээс нь энэ ард түмний дунд энгийн хэллэгээр бол хаалгаар гаргаад хаячихаар тооноор ороод ирэх юм гээд, АН-ын хувьд бол тооноороо оруулахгүй, тооноо торлоно. Тийм. Тэгэхээр ингээж бодож байгаа тийм. Энэ ингэхгүй бол нөгөө энэ юу пропорциональ тогтолцоо оруулж ирж байгаа юмыг чинь юу яагаад байгаа, ард

түмний дунд нэр нь муудаад байгаа, ийм асуудал байгаа.

Энэ лист дотор орж ирж байгаа улсууд чинь энэ мэргэжлийн улсууд, тодорхой секторын төлөөллүүдийг оруулж ирнэ ээ. АН-ын бодлого бол ийм, АН-ын дарга Лувсаннъямын Гантөмөр ч гэсэн бас хэлж байгаа үгнүүддээ хэлж байгаа. Малчдын төлөөлөл, тариаланчдын төлөөлөл, багш, эмч нарын төлөөлөл, бүр мэргэжлийн хуульч нарыг оруулж ирнэ. Бид нар саяхан энэ нийтийн сүлжээнд Хүний эрх хамгаалах тухай хууль гэдэг дээр парламент онигоонд орсон. Хөдөө орон нутагт ярьж байна лээ. Энэ төрийн бодлого гэдэг юм чинь ийм туйлбаргүй болчихсон юм уу гээд. Нэг гараараа болохоор үүнийгээ зөв зөв гэж, ээ гэгээн минь гэж баталчхаад, 1 хүн хориг тавихаар буцаагаад буруу гээд хүлээлгээд авчхаж байна. Энэ хууль чинь устай муу хуулиуд батлаад байна аа гэсэн ийм шүүмжлэл хэлж байна. Тэгэхээр энэ мэргэжлийн, мөнгөгүй хүмүүс орж ирж чадахгүй байгаатай нь холбоотой шүү дээ. Мөнгө бол тодорхой шалгуурт болчихсон, сонгуульд нэр дэвшиж байгаа улсуудын хувьд бол.

Тэгэхээр энэ сонгуулийн зардал бууруулах дээр бодитой заалтуудаа тусгасан уу, тусгаач ээ. Хэвлэл мэдээллийнхэн гэхэд хэдэн жилд олох мөнгөө 1 сарын хугацаанд энэ тэр олдог шүү дээ. Энэ бол бид нар сонгууль мэдэхгүй биш үнэн шүү дээ. Тэгэхээр энэ тэр дээр тодорхой заалтыг оруулмаар байна аа.

Дараагийнх нь энэ Сонгуулийн ерөнхий хороо одоо энэ үнэхээр Сонгуулийн ерөнхий хороо юм бол энэ эрх мэдлээ хуулиараа аваад, ажлаа хийгээч. Улсын бүртгэлийн ерөнхий газар гээд нэг даам гарчихсан байгууллага. Тэд нар нэг юу нэрсийн жагсаалт гаргаад л өгч байдаг, түүгээр нь явж л байдаг. Тэгээд ер нь энэ сонгуулийн асуудлыг хариуцна гэж ингээд бүхэл бүтэн тусгай эрхтэй төлөөллүүдээ сонгогддог энэ Сонгуулийн

ерөнхий хороо байвал одоо энэ ажлаа өөрсдөө авч хий. Тэр бүртгэлийнхэн бэлдэж өгөх юмнуудыг нь бэлдээд л өгдөг юм байгаа биз. Түүгээр нь тэрийг нь аваад өөрсдөө хариуцлагаа хүлээгээд энэ сонгуулиа бас хиймээр байгаа юм. Энэ зүйлийг бас хэлчихмээр байна.

Нэрсийн жагсаалтыг гээд тэгж байна. Хэсгийн хорооны нэг 2000 нэр гаргаж өгөөд, нөгөөдхийг нь хүмүүс баахан газар давхарлаж өгөөд царцаа явуулж байна гэдэг шүүмжлэл байгаа шүү дээ. Одоо аль ч банкны картаар АТМ-аас мөнгө авахад давхарддаггүй шиг ийм нэг цахим Монгол, Е-Монголиа болчихсон биз дээ. Тэгэхээр энэ асуудал дээрээ бас анхаармаар байна.

Тодорхой асуулт нь болохоор энэ санхүү бууруулах ялангуяа энэ хэвлэл мэдээллийн зардал бууруулах дээр ямар заалт орж ирсэн бэ? Сонгуулийн хуудас чинь одоо түрүүн Сонгуулийн ерөнхий хорооны дарга хэлээд байна лээ, бүр ингээд манайх боломжтой л гээд байна. Энэ Төрийн байгуулалтын байнгын хороон дээр тоо нэмэгдэх юм ярьж байна. Энэ нэмэгдсэн үед бол энэ чинь бүр паник юм болно. Тэгэхээр, одоо та энэ хуудсаа нэг иргэн хөдөөгийн нэг иргэн уншиж дуусах хугацааг тооцож үзсэн үү? ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг хариулах нь зохимжтой юм шиг байна. Хэн хариулах вэ? Зардалтай холбоотой юман дээр Бат-Эрдэнэ хариулах уу? 85 дугаар микрофон өгье.

**Д.Бат-Эрдэнэ:** Сонгуулийн зардал сонгуулийн сурталчилгааны арга хэлбэрийн нэг болох энэ радио телевиз ашиглаад сонгуулийн сурталчилгаа явуулах дээр энэ хосолсон тогтолцоог хэрэглэж байгаа энэ онцлогийг нь харгалзаж бас шинэ зохицуулалт хийж өгсөн. Тэр маань юу вэ гэхээр зэрэг Үндэсний олон нийтийн радио телевиз бол эфирийнхээ цагийг нэр дэвшигч нарт тэгш хуваарилаад үнэ төлбөргүй

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэг явуулдаг. Үүнийх нь тал нь яг сонгуулийн нам, эвсэлд зориулсан цаг байх ёстой гэдэг ийм шинэчилсэн зохицуулалтыг бол оруулж өгсөн. Энэ ямар учиртай вэ гэхээрээ цэвэр энэ цаг дээр бол намууд мөрийн хөтөлбөрөөрөө бодлогын мэтгэлцээн хийх ийм зохицуулалттай, энэ бол үнэ төлбөргүй явах шинэ ийм зохицуулалтыг оруулж өгсөн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Яах юм, нэмж хариулах юм уу, болчихсон уу хариулт. Сонгуулийн ерөнхий хорооны дарга хариулъя, 83 дугаар микрофон өгье.

**П.Дэлгэрнаран:** Туваан гишүүний асуултад хариулъя. Урьд нь бол урд талын сонгуулиуд дээр бол бид нар саналын хуудас нэг талдаа, тэгээд 14 инчийн ийм хэмжээтэй урттай ийм саналын хуудаснуудыг хэрэглэж байсан. Энэ саналын хуудсыг бол манай төхөөрөмж уншихдаа 3 секунд орчимд уншдаг. Тэгээд одоо бид нарын би дээр бүртгэл хяналтын дэд хороон дээр харуулсан тэр макет бол 56 сантиметр буюу 22 инч, тэгээд үүний 2 тусдаа саналын хуудас болохоор 6-8 секунд унших хэмжээний ийм тооцоололтой болно. Тэгэхдээ ерөнхийдөө манай хэсгүүдэд төхөөрөмжүүдийг байрлуулахдаа 1500 сонгогчтой хэсэг дээр 2 төхөөрөмж байрлуулдаг. 1500-аас доошоо хэсгийн хороод дээр 1 төхөөрөмж, бүр хөдөө орон нутгуудад 200, 200 бараг хүрэхгүй сонгогчтой ийм хэсгүүд байгаа. Эд нар дээр зүгээр уншилтын хугацаа ачаалал дээр тооцох юм бол тэр нормативаар бодвол энэ боломжтой гэж л үзэж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Техникийн хувьд бол боломжтой гэж хариулж байна. Яах юм, тодруулж асуух юм уу та? Туваан гишүүн тодруулж асууя.

**Ц.Туваан:** Нэг сонгогч надад 50 хэдэн сантитай юу юу гэхэв, наадхыг чинь дуустал нь уншихад хэдий хугацаа зарцуулах вэ гэж би асууж байгаа юм.

Одоо бүх нэрээ хүн уншина шүү дээ. Нөгөө араар бичигдсэнийг нь уншихгүй гэж тооцож болохгүй. Тэгээд би хэлж байна. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр яригдсан, энэ юуны тоо нэмэгдвэл гишүүдийн тоо энэ тэр нэмэх асуудал энэ тэр дараа нь бас мэр сэр яригдана гээд байх шиг байна. Тэгээд ирэх юм бол наад хуудас чинь уртасна. Тэгэхээр ямар хугацаанд 1 сонгогч наад хуудсыг чинь уншиж дуусах вэ?

2 дугаарт, тэр нэгдсэн бүртгэлээс шүүх гэдэг дээр та хэд ер нь ямар байр суурьтай байгаа юм? Дэмжиж байна уу? Эсрэг байна уу? Нэг хэсгийн хороон дээр гаргаж өгчихсөн нэрийг нь тэр оффлайн горимоор гаргаж өгчихсөн нэрийг нь баримтлах гээд байна уу? Энэ байр суурь чинь сонсьё.

**Л.Мөнхбаатар:** Туваан гишүүний тодруулгад хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон өгье.

**П.Дэлгэрнаран:** Тухайн санал өгч байгаа сонгогч бас саналын хуудастайгаа танилцах, санал дээр саналын хуудсан дээрээ тэмдэглэгээ хийхэд мэдээж арай цаг хугацааны хувьд хуучинтай харьцуулбал урт болно. Тэгээд ч одоо сая хуулийн төсөлд явж байгаа намыг дугуйлна, бас нэр дэвшигчийг бас дугуйлж болно тухайн намаас нэр дэвшигчийг дугуйлж болно гээд ийм бас юу орж байгаа учраас энэ бол бас сонгогчдод нэлээн маш сайн тайлбарлаж, таниулах ийм ажил шаардагдах байгаа. Тэгэхээр энэ дээр одоо тухайн хууль батлагдах юм бол энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэлээн сайн сурталчилгааны ажил, таниулах ажил эрчимтэй сайн явуулах ийм шаардлага үүснэ ээ гэж ингэж үзэж байгаа. Тэгээд 1 сонгогч тухайн саналын хуудастайгаа танилцаад тэмдэглэх хугацаа бас харьцангуй уртасна. Тэгэхдээ ерөнхийдөө ачааллаа үзэх юм бол үүнийг энэ дээр одоо багтахгүй хэмжээнд бол хүрэх ... /минут дуусав/

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Л.Мөнхбаатар:** Амгалангийн Адьяасүрэн гишүүн асуултаа асууя.

**А.Адьяасүрэн:** Энэ сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг маш дэлгэрэнгүй ярилцсан учраас би үүнийг давхардуулахгүйгээр тодорхой үндсэн 4 ойлгомжгүй байгаа асуудал дээр тайлбар авъя гэж бодож байна.

1 дүгээрт нь, энэ Сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 буюу сонгуульд оролцох нам өөрийн хүсэлтээ хавсаргасан байх баримт бичиг буюу 26.3.9 гэсэн заалтыг бол нэмсэн байна. Энэ нэмэлтээр намын дарга Улсын дээд шүүхийн лавлагаа, тамга тэмдгийн улсын бүртгэлийн лавлагааг хавсаргах ёстой болж байгаа юм л даа. Энэ заалтыг ингээж ийм дэлгэрэнгүй байдлаар ийнхүү ингээд онцгойлон авч үзэж, мөн 26.2 гэсэн заалттай давхардсан агуулга бүхий заалтыг нэмж, ингээж бичиг цаас болгох ямар шаардлага шалтгаан байгаа юм бол оо? Энэ дээр тодорхой тайлбар, тодруулга авмаар байна. Энэ үнэхээр ийм чухал зохицуулалт бүхий заалт мөн юм уу бас гайхаж байна л даа.

5 дугаарт нь, энэ хуулийн төсөл дээр 59.4 гэсэн шинэ заалтыг нэмж саналын хуудсанд тойрогт нэр дэвшигчийн болон нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн саналыг тэмдэглэх эсэхтэй байна гэж бол заасан байх юм. Тэгэхээр сонгогчид маань намын нэрийг дугуйлаад бас намын жагсаалтад орсон хүмүүсийг мөн дугуйлах болж байна уу. Энэ дээр бас тайлбар авмаар байна.

АН-ын бүлгийн өргөж байгаа төслөөр бол зөвхөн нам, эвслийг дугуйлах тэмдэглэгээний хэсэгтэй байхаар заасан байгаа л даа.

Мөн 3 дугаарт нь, Улсын Их Хурал нь намаас нэр дэвшигчийн жагсаалтыг хөгжлийн урт хугацааны бодлогод нийцүүлэн хувааж болно гэсэн 11.4 дэх нэлээд бүрхэг заалтын талаар бас

тодруулга авмаар байна. Манай бүлгийн өргөн барьж байгаа энэ хуулийн төсөл дээр бол жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улс нутаг дэвсгэрийн сонгуулийн 1 тойрог байна гэж тов тодорхой бас тусгасан байгаа.

Мөн хамгийн сүүлд нь мөн дээр дурдсан 59.4 дэх заалт, мөн төслийн 66.2-оор нэмж байгаа заалттай хэрхэн уялдаж байгаа нь бол ойлгомж муутай байна. Энэ дээр бас ингээд тодруулга авах гэсэн юм.

**Л.Мөнхбаатар:** Адьяасүрэн гишүүний энэ 3 асуултад хэн хариулах вэ? Эхлээд Бат-Эрдэнэ хариулах уу? Ажлын хэсэг хариулах уу? 85 дугаар микрофоныг өгье. Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ.

**Д.Бат-Эрдэнэ:** Адьяасүрэн гишүүний эхний асуултад хариулъя. Намаас сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ бүрдүүлдэг хэд хэдэн баримтууд байдаг. Энд 26.3.9, 26.2 гээд энэ 2 давхардсан заалт бол биш, 1 нь 26.2 бол нам сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ бүрдүүлэхэд бүрдүүлэх баримт байгаа. 26.3.9 бол эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлж байгаа яг адилхан үүнийг бүрдүүлнэ ээ гэсэн ийм л заалт. Ер нь бол нам сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ бүрдүүлдэг хэд хэдэн баримтуудаас заримыг нь бол хассан. Жишээлэх юм бол аудитын дүгнэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд давхардуулж ирүүлдэг байсан. Үндэсний аудитын газраас албан ёсоор Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлдэг. Гэтэл намаас бас зайлшгүй үүнийг ирүүлэх ийм шаардлага үүсдэг байсан бол зарим шаардлагагүй гэдэг юм уу давхардаж ирдэг энэ бүрдүүлэх баримтуудыг хасаад харин оронд нь энэ нам, эвслийн даргын болон тэр тамга тэмдгийн улсын бүртгэлийн лавлагаа гэдгийг бол нэмсэн. Үүнийг өмнөх сонгуулиудаар гарч байсан маргаан бүхий асуудлуудаас үүдэж энэ бүрдүүлэх баримтыг нэмж оруулсан байгаа юм. Баярлалаа.



**Л.Мөнхбаатар:** Хуулийн төсөл санаачлагч Нямаагийн Энхболд гишүүн нэмж хариулъя.

**Н.Энхболд:** Үгүй ээ, би нэмж биш ээ, тэр 2 дахь асуултад хариулах гэж байгаа юм. Яагаад энэ 2 тэмдэглэгээ байна вэ гэж. Бид нарын оруулсан хувилбараар эсвэл намд нь, эсвэл хүнд нь өгч болно гэсэн ийм 2 л юу байж байгаа юм. Тэгээд энэ 2-ын дүн нийлээд тухайн намд өгсөн нийт санал гарах юм. Ийм тайлбартай.

АН-ын өргөн мэдүүлсэн юун дээр бол зөвхөн намаараа байна гэж байгаа. Өөрөөр хэлбэл нээлттэй жагсаал байхгүй, нэрс байж болно, зөвхөн намын төлөө өгнө гэсэн.

Бид яагаад нэртэй оруулсан юм гэхээр энэ үнэхээр 1 дүгээрт, 12 онд болсон сонгуулийн дараа өмнө нь ч гарч байсан, дараа нь ч гарсан, одоо ч гарч байгаа. Өнөөдөр ч гишүүд хурал дээр ярьж байна. Нэр байхгүй зүгээр нам гэдэг нэрийн ард нуугдаад буруу, зөв иргэдийн хүсээж хүлээж байсан хүн орчихдог оо. Энэ бол энэ шиг муухай юм байхгүй гээд зөндөө олон хүн ярьж байна шүү дээ, өнөөдөр ч гэсэн. Үүнээс л бид нар зайлсхийж аль аль нь сонголттой, хүнээ ч болно, эсвэл намаа сонго, эсвэл хүнээ сонго. Энэ 2-ын нийлсэн дүн нь нийлээд 50 хувьд ноогдож байгаа, 38 суудлын хэдэн хувийг нь авах вэ гэдэг ийм л тооцоо гарах юм байгаа юм. Хэрэв юу яавал бүр жишээ гаргаж байгаад хэдүүлээ хэлэлцүүлгийн явцад босоо нөгөө багануудыг нь зурж байгаад, сонгогчдынхоо тоог тавиад тиймээ, ингээд явж болно, тэгээд яах вэ энэ хэлэлцүүлгийн явцад ямархуу байдлаар байх нь вэ. Энэ бол бид бол өөрсдийнхөө оруулж байгаа саналын ийм үр дүн гарах юм, ингэж тооцох юм гэдэг юмыг нь бол бас энэ дээр зурж байлтай биш зураад харуулж болно, тийм боломж байгаа.

Тэр түрүүн бас Цогтгэрэл гишүүн асууж байсан. Энэ чинь тэгээд үндсэндээ яг нэрээр байгаа жагсаалтад байгаа

нэрсийг ингээд дугуйлаад явна гэдэг чинь улс үндсэндээ 1 тойрог болсон, мажоритар системтэй адилхан юм биш үү гэж. Нэг талаараа бас ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу, нэрсээ өгөөрэй. Дэмжсэн 3 хүртэл, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Яасан олон хүн болчихов. Үг хэлэхдээ дэмжиж байгаа эсэх, дэмжээгүй эсэхээ заавал урьд нь хэлнэ шүү. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Их Хурлын гишүүд танхимдаа орж ирээрэй.

Ганбат гишүүн үг хэлье.

**Д.Ганбат:** Ер нь бол МАН-ыг би бас овоо доо л гэж бодож байгаа юм л даа. Яагаад вэ гэхээр бас улс төрийн ууган хүчин, Ази дахь анхны нам энэ тэр гээд л өөрсдийгөө ярьдаг л даа. Тийм, тэгээд энэ удаа ёстой үнэхээр тийм байж чадлаа гэж бодож байгаа юм, би. Бас нэг улс төрийн зориг гаргаад, энэ хуулийг Нямаагийн Энхболд Тогтохсүрэн гишүүнтэй энэ дарга нар өргөн бариад ингээд явж байна. Тийм, улс төрийн зориг гаргаж байна. Ер нь бол бид 1991, 92 оноос хойш 8 удаа сонгууль явуулсан, Улсын Их Хурлын сонгууль. Монголын ард түмэн бол өөрсдийнхөө төрийг байгуулаад төр нь Засгийн газрыг байгуулж, ард түмнийхээ төлөө ингэж ажиллах ёстой хэд хэдэн онцлог бий, Монгол Улсад бол. Далайд гарцгүй, 2 том гүрний дунд байдаг гэх мэтчилний ийм онцлогтой. Гэхдээ энэ 30 жилийн хугацаанд бид нар ардчиллаасаа ухрахгүй. Парламентын засаглал, чөлөөт зах зээл гээд ингээд явж байна аа.

Сүүлийн 8 жил та бүхний засаг барьж байгаа энэ үед бол ард түмний амьдрал үнэхээр дээшилсэнгүй ээ. 65, 62 суудалтай, харамгүй сандал суудлыг чинь өглөө л дөө. Тэгээд энэ хугацаанд Монголын ард түмний хүлээлт, та бүхний амлалт 2 бол ёстой нэг тэнгэр газар шиг байлаа. Удахгүй та хэд маань ингээд очоод өөрсдийнхөө дүнг тавиулна. Ер нь

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ямар дүн тавих нь бол ойлгомжтой байна л даа. Энэ 7 жил ингээд явчихсан улс энэ 1 жилд юу л амжив гэж дээ. Тэгээд одоо энэ сонгууль чинь өдрөөс өдөрт, жилээс жилд ингээд явахад бол нөгөө ирц нь багасаж байна. Ард түмний идэвх муудаж байна, итгэл алдарч байна. Анх бол 90 хувьтай сонгуульд ордог байсан бол сүүлийн нөхөн сонгууль гэхэд бол сонгогчдын 50 хувьд хүрэхгүй тийм сонгууль явагдлаа шүү дээ. Тэгээд манай энэ Улсын Их Хурлын байж байгаа царай, бүгдээрээ л ямар нэгэн юманд холбогдчихсон, цөөхөн хүн нэр цэвэр байна даа. Бүгд мэдлэгтэй, мэдээлэлтэй, түүнийгээ ашиглаад ЖДҮ, нөгөө Хөгжлийн банк, нөгөө нүүрсний хулгай, энэ бүх юманд холбогдож байна. Нэр цэвэрхэн хүн над мэтийн нэг цөөхөн л хэдэн хүн байна даа, тийм. Сонгогч дээрээ очоод, ингээд ярихад.

Ингээд сонгуулиа цаашидаа бид нар маргаангүй аятайхан явуулах хэрэгтэй. Ямар нэгэн юмны гадна, дотнын олз болж болохгүй ээ. Тэр мэдлэг мэдээлэлтэй, хамгийн их мэдлэг мэдээлэлтэй байгаа хүмүүс нь бид нар. Гэтэл тэр мэдлэг мэдээллээ бол ганцхан хувийнхаа эрх ашигт зарцуулдаг, ард түмэндээ тайлбарладаггүй, таниулдаггүй, тэр орон зайг нь юу нөхөж байна вэ гэхээр энэ троллууд нөхөж байна. Тэгэхээр энэ улс оронд хэрэгтэй хуулийг бид бүхэн батлаад явуулаад, зөв зүйтэй хийгээд, сонгогчдынхоо санал бодлыг тусгаад ингэж явах ёстой. Үүнээс гадна бол тэр хар машин, луйвар тэр мөнгө тараадаг тэр янз бүрийн юманд холбогдоод та нар больсон нь дээр байх шүү. Цаашидаа явцгүй боллоо. Янз бүрийн юманд холбогдсон улсуудаа энэ нам, эвслүүд нь дэвшүүлэхгүй байсан нь дээр. Эд нараасаа салъя. Тэгэхгүй бол энэ Улсын Их Хурлын нэр хүнд энэ тэр чинь бол уначихсан байна шүү дээ.

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүн дэмжиж үг хэлж байгаа юм уу, дэмжээгүйгээ хэлж байгаа юм уу? Дэмжиж үг хэлсэн гэж ойлголоо шүү. Ер

нь гишүүд маань дэмжиж байгаа эсэхээ үгийнхээ юунд хэлчхээрэй. Тэгэхгүй бол энэ өөрөө бас дэг зөрчигдөнө. Дэмжээгүй 3, дэмжиж байгаа 3 гэсэн ийм л гишүүд үг хэлэх боломжтой шүү дээ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** 2024 оны босгон дээр Монголын эдийн засаг доройтсон, ард иргэдийн амьдрал ядуурсан, дээрээс нь энэ төрийн эрх барьж байгаа олон түшээд, сайд, дарга нар янз бүрийн хулгай зэлгийд холбогдсон ийм нөхцөл байдалтай ард түмний шүүлт дээр очно л доо. Энэ шүүлтээс дан юу байдаг юм хуучин мажоритар тогтолцоогоор очсоноос илүүтэйгээр жагсаалтын ард нуугдаад очвол илүү дээр гэж үзэж байгаа юм. Тийм учраас өнөөдрийн Их Хурлын гишүүд асуудалд холбогдсон гишүүд дахин яаж сонгогдох вэ гэдэг арга замаа л хайж байгаа юм.

Тэгээд энэ дээр нь 38, 38 гэсэн тойргоос жагсаалтаас гэсэн сонгуулийн хувилбар оруулаад ирэхээр өнөөдрийн энэ Их Хуралд сууж байгаа гишүүдийн 28-хан л дэвших эрхээ дөнгөж авна. Үлдсэн Ардын намын 32 гишүүн тойроггүй үлдэнэ. Өөрөөр хэлбэл 28 Их Хурлын гишүүн өөрсдөө тойрогтоо дэвших эрх юм уу жагсаалтад орох эрх авчхаад үлдсэн 48-ыг нь намын дарга өөрөө шийдэх тийм нөхцөл байдал руу орж ирж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг дэмжихгүй байх магадлал МАН-ын гишүүдэд маш их бий. Тэгээд үүгээрээ юу юу руу чиглүүлж байна вэ гэхээр Үндсэн хуулийн өөрчлөлт рүү Ардын намын удирдлагууд чиглүүлж байна. Өөрөөр хэлбэл та нар сонгогдох гэж байгаа юм бол гишүүдийн тоог 152 болго гэдэг. Тэгвэл та нарын 60 гишүүнээс 47, 48 нь дахин дэвших боломжоо өөртөө авна гэж ийм байдалтай. Гэтэл одоо гадна ард түмэн бол энэ 100 ямаанд 60 ухна гэгчээр 152 гишүүнтэй болохыг эсэргүүцээд

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ингээд байж байдаг. Тэгээд эцсийн хувилбартаа энэ Үндсэн хуулийн өөрчлөлт явахгүй бол 2020 оны сонгуулийн хувилбар буюу томсгосон мажоритар луу ирэх л ийм нөхцөл байдалд орж байгаа.

Тийм учраас өнөөдрийн энэ асуудлаар Их Хурлын гишүүд санал өгөхдөө өөрсдийнхөө эсрэг дахин сонгогдохгүй байх ийм юм руу санал өгөх юм бол буруу гэж үзэж байгаа. Би бол энэ Ардын намын гишүүд өнгөрсөн 8 жилийн хугацаанд энэ Монголын эдийн засгийг дордуулсныхаа төлөө, энэ ард түмнийг ядууруулсныхаа төлөө, дээрээс нь янз янзын хулгай зэлгийг холбогдсоныхоо төлөө ард түмэн дээр нүцгэнээрээ очиж шүүлгэх ёстой л гэж би үзэж байгаа. Тийм учраас хэдийгээр би энэ холимог тогтолцоог дэмждэг боловч 1 удаа ухраад өнөөдрийн энэ хүнд нөхцөл байдлыг бий болгосон энэ Ардын намын гишүүд дангаараа нэг нэгээрээ тэр ард түмэн дээр очиж шүүлгэх ёстой л гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгээд бас нэг асуудал бол өнөөдрийн энэ намыг дугуйлна, жагсаалтыг дугуйлна гэж ийм 2 жагсаалтад байгаа хүнийг дугуйлна гэсэн ийм 2 үзүүртэй зүйл оруулж ирж байгаа. Өнөөдрийн МАН бол 70 жил коммунист нам явсан, коммунист үзэл суртлаар бол нам бол Ленин юм, Ленин бол нам юм гэж явдаг. Тэгэхээр өнөөдөр энэ Оюун-Эрдэнэ даргыгаа энэ авлигатай тэмцэж байгаа 5 Ш гээд олон янзын юм явуулж байгаа нэр хүндийг нь өсгөж байгаад, Оюун-Эрдэнэ бол нам юм, нам бол Оюун-Эрдэнэ юм гэж дугуйлах гэж байна шүү дээ. Тэгээд баахан тэр жагсаалтынхаа ард баахан нөхдийг бас оруулж ирэх ийм юм зүйлийг хийгээд байна. Тийм учраас энэ хуулийг дэмжихгүй байгаа гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн дэмжихгүй байр сууриас үг хэллээ. Цэдэвийн Сэргэлэн гишүүн үг хэлье.

**Ц.Сэргэлэн:** Баярлалаа, би уг нь асуулт асуух гэж байсан тэгээд амжсангүй энэ үг хэлэх юун дээр санал авлаа. Би дэмжиж байгаа, дэмжиж хэлж байгаа юм. Энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа ажлын хэсгээс олон намын төлөөлөл орж ирэх боломжтой гэж дүгнэж байгаатай 1 дүгээрт, санал нэг байна. Олон намын төлөөллөөс гадна би нэг маш чухал энэ нийгмийн бүхий л салбарын төлөөллүүдээс орж ирэх боломж нээгдэж байна уу гэж хараад үүнийг би дэмжиж байгаа юм. Яагаад гэвэл одоогийн Сонгуулийн тухай хууль дээр төрийн албан хаагчид хэрвээ сонгуульд оролцох юм бол сонгуулийн тухайн жилийн 01 сарын 01-нээс өмнө ажлаа өгсөн байх ёстой гэдэг нэг заалт байгаа. Энэ заалт шилдэг эмч нарын төлөөлөл, хуульчдын төлөөлөл, багш нарын төлөөлөл бусад одоо энэ нийгмийн бүхий л салбаруудын шилдэг онолын болон практик мэдлэг бүхий төлөөллийг оруулж ирэхийг хаачихсан заалт. Тэгэхээр энэ заалт хасагдах ёстой, хасах ёстой гэж би хэлэх гээд байгаа юм. Магадгүй сайн судалж үзвэл энэ Үндсэн хууль зөрчсөн, энэ төрийн албан хаагчдыг, төрийн үйлчилгээний албаны дарга нарыг, захирлуудыг нь сонгогдох эрхийг нь зөрчсөн байж болзошгүй ийм заалт одоогийн Сонгуулийн тухай хууль дээр байгаа. Хэрвээ сонгуульд оролцоод унавал тэр хүн ажил ч үгүй, амьдрал ч үгүй болно. Тийм учраас энэ 6 сарын өмнө ажлаасаа өгдөг энэ заалтаас болоод энэ миний саяын хэлсэн эмч, багш нар, инженерүүд, хуульчдын төлөөлөл орж ирэхгүй байна.

2 дугаарт, энэ чинь мөнгө ихээхэн хэмжээгээр шаарддаг сонгуулийн систем байгаа учраас энэ төрийн албанд ажилласан хүмүүс үүнээс нь болоод бас орох боломж хомс байна аа. Тийм учраас энэ заалтыг авч хаях ёстой гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Тэгж байж энэ Улсын Их Хурлын танхимд Монгол Улсын нийгмийн бүхий л салбаруудын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, хуульчдын, инженерүүдийн төлөөлөл орж ирж суух

ийм боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Үүнийг ажлын хэсэг анхааралдаа авна биз дээ.

2 дугаарт, жагсаалтын нөгөө талд энэ нэр дэвшигчид шууд тойргоор өрсөлдөх ийм тогтолцоо байгаа. Тэгвэл энэ тойргийг одоо бол 1 аймаг 1 тойрог, 2 мандаттай ч байдаг юм уу үүнийг өшөө томсгомоор байгаа юм. Хэд хэдэн аймаг нийлээд 1 тойрог, хотын хэд хэдэн дүүрэг нийлээд 1 тойрог. Тэгвэл жинхэнэ утгаараа харин энэ бодлогын том өрсөлдөөний сонгууль болж энэ Улсын Их Хурлын танхимд хэн мөнгөтэй нь, хэн мөнгө цацсан нь, хэн попорсон нь орж ирдэг энэ явдал таслан зогсоогдож, бодлогын өрсөлдөөн явагдана гэж би харж байна.

3 дугаарт, энэ улсын хил дээр үүрэг гүйцэтгэж байдаг хилийн заставын хилчдийн сонгох эрх зөрчигддөг асуудал бий шүү. Яагаад гэвэл санал авах өдөр улсын хил дээр үүрэг гүйцэтгэж байгаа хилчид саналаа өгөх боломж байдаггүй. Тийм учраас хилийн заставуудыг хайрцагар санал өгдөг байсныг нь одоогийн хуулиар болиулчихсан юм. Тийм учраас одоогийн энэ нэмэлт, өөрчлөлтөөр хилийн заставт албан үүрэг гүйцэтгэж байгаа хилчдийг саналаа өгөх боломжийг нь хангаж, хайрцагар авдаг болгож өгөөч гэж хүсэх байна. Одоо хамгийн захын застав гэхэд төв суурин газраас 360 километр хүртэл алслагдсан байна. Зарим хилийн застав нисдэг тэргээр очихоос өөр аргагүй заставууд байж байна. Тэгээд энэ чинь хүн шүү дээ, Монгол Улсын иргэн шүү дээ, энэ хүмүүс сонгох эрхээ эдлэх ёстой. Төр өөрийнхөө хуулиар алба хаалгаж байна. Төр сонгох эрхийг нь хангаж өгөх ёстой, энэ саналуудыг хэлэх ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн үг хэлье.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр холимог системээр явагдах энэ шинэ сонгуулийн хуулийн төслүүдийг дэмжиж байна.

Тэгэхдээ бид нар энэ хуулийн төсөл дээр бас зарчмын нэлээд хэдэн шинэчлэлийг давхар хийх ёстой. Та бүхэн бүгд санаж байгаа байх, 2008 оны сонгуулийг дуустал нэр дэвшигч намуудын сурталчилгааны зардлын хамгийн бас том хэсэг энэ урлаг, уран сайхны тоглолт байсан. Тэгвэл 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн хуулиар энэ урлагийн тоглолтыг сонгуулийн сурталчилгаанаас хассан. Энэ бол асар том дэвшил байсан. Одоо яг үүнтэй адилаар бас томоохон дэвшил, бүтцийн том үр дүн гаргамаар байна. Жишээлбэл, сонгуулийн сурталчилгааны үеэр телевизүүдээр нэр дэвшигч нарын шторк нэвтрүүлэг гээд дандаа ийм төлбөртэй мэдээллүүд их гардаг. Бодлогын өрсөлдөөн тэнд ерөөсөө харагддаггүй. Тийм учраас телевизийн сурталчилгаанд зөвхөн бодлогын мэтгэлцээнүүд явах байдлаар бид нар хуульчилж өгмөөр байна. Намуудын бодлогыг, хөгжлийн бодлогыг уралдуулдаг, хөрөнгө мөнгөөр биш бодлогын өрсөлдөөн болгодог ийм дэвшилийг бид нар энэ Сонгуулийн хууль, Улс төрийн намын тухай хуулиар хийх юм бол бид нар энэ алдсан хэдэн жилүүдийнхээ өнгөрсөн 30 жилийн алдааг засах боломжтой болно. Тэгэхээр үүнийг энэ ажлын хэсэг дээр анхаарч Их Хурал дээр бид нар ажиллахаар ер нь зориг шулуудаж байна.

Тэгээд дараагийн асуудал нь энэ сонгогчдын боловсролыг дэмжих чиглэлээрх энэ сонгуулийн төв байгууллагын үүрэг функцийг нэлээд сайжруулмаар байна. Ялангуяа залуу сонгогчдыг сонгуульд татах, сонгогчдод улс төрийн мэдээлэл олгох, яагаад Монгол Улсын иргэн сонгуульд оролцох ёстой вэ гэдгийг бид нар сайн сайн ойлгуулж өгсөн. Тэд нарын хүлээж авах суваг бүхий жишээлбэл сошиал сүлжээний тодорхой сувгуудаар сонгогчид руугаа мэдээлэл түгээх хэрэгтэй байна. Яах вэ, жилийн жилд манай Сонгуулийн ерөнхий хороо бол сонгуулийг зохион байгуулдаг. Түүнээс биш сонгогчдын боловсролд анхаарах чиглэлээр үйл ажиллагаа явуулах ийм одоо хүний нөөцийн болон бусад юу бол



хязгаарлалттай байсан. Одоо үүнийг дорвитой нэмж өгөх шаардлагатай байна.

Дээр нь мөн сонгуулийн төв байгууллагын хараат бус байдлыг нэмэгдүүлэх энэ асуудлыг бас дагалдах хуулиар бид нар өргөн барих шаардлагатай. Энэ бол бас Улс төрийн намын тухай хуулийн төсөлд явсан байгаа.

**Л.Мөнхбаатар:** Мөнхцэцэг гишүүн дэмжсэн байр сууринаас үг хэллээ. Ингээд 3 гишүүн дэмжсэн байр сууринаас үг хэллээ. Одоо дэмжээгүй байр суурьтай гишүүн байвал үг хэлж болно. Ганибал гишүүн үг хэлье.

**Н.Ганибал:** Миний хувьд болохоор энэ пропорциональ систем холимог системийг дэмжиж байгаа. Гэхдээ энэ МАН-ын бүлгийн нэр бүхий гишүүдийн өргөн барьсан энэ хувилбарыг дэмжихгүй байгаа юм. Яагаад гэж. Ер нь манай МАН-ынхан маань ер нь нэг юм болгон дээр АН гэдэг энэ нэр томъёоллыг үгүй хийсэн, буруутгасан энэ улс төрөөр бараг 8 жил явлаа. Хөгжлийн банк гэнгүүт зөвхөн АН-ын асуудлуудын гишүүдийн оролцоотой асуудлуудыг нь салгаж авч хэлэлцүүлэгтээ оролцуулдаг.

Нүүрсний хулгай гээд хамгийн том асуудлыг өнөөдөр сонсгол хийх байсан. Харамсалтай нь МАН-ын удирдлагын зүгээс болиулсан уу, яасан хойшлууллаа. Ийм асуудлууд өнөөдөр ингээд зөвхөн намын нэр хүндийн асуудлууд дээр ингээд гарч ирээд байгаа юм. Тэгээд цаашид энэ хууль батлагдахаар мэдээж намуудын нэр хүндийн асуудал бол цаашид зайлшгүй яригдаад явна л даа. Яах вэ энэ 38, 38-ыг дэмжихгүй байгаа юм аа.

Манай бас бүлгийн гишүүдийн өргөн барьсан хувилбараа бол дэмжиж байгаа. 48, 28. Шалтгаанаа бас тайлбарлая. Энэ дээр намын санал авах намуудын босгыг 3 хувь гээд 38, 38, 48, 28 хоёрын хооронд бас ялгаатай байгаа юм.

2, 3 хувь. Энэ 38, 38 дээр бол 1 намын авах тэр листэд ч байна уу, намынх нь нэрийг дугуйлаад ч байна уу нийлээд авах тоо 40 мянга орчим байгаа юм. 2020 оны сонгуулийн санал өгсөн сонгогчийн тоотой харьцуулахад. Энэ бол бас Монгол төрийн босгыг бас бүхэл бүтэн нам 38 хүн листэд нэр дэвшүүлээд авах энэ босго дэндүү бага байгаа юм. Бас төрийн босгыг бас бага болгож байгаа юм. 28 дээр бол мэдээж энэ 54 мянга болоод жосоохон өсөх юм. Ер нь тэгээд цаашид гишүүдийн тоог нэмнэ гээд бас манай энэ Ардын намын гишүүд маань яриад л байх юм. Хэрвээ энэ 3 хувь гишүүдийн тоог нэмэх юм бол эргээд 15 мянга болох ийм магадлалтай болж байгаа байхгүй юу. Тэгээд Монгол төрийн босго чинь ийм Монгол Улс даяар авсан санал нь 15 мянган хүн болоод, тэнд гишүүн болж орж ирэх ийм асуудлуудыг сөхөж гаргаж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ болгон, энэ дээр бид нар бас зарчмын зөрүүтэй байгаа юм.

Тэгэхээр энэ босго бол гишүүдийн тоо хэд байхаас хамаараад энэ намуудын авах босгыг бас ярилцах ёстой, хэлэлцэх ёстой. Энэ дээр Ардын нам, АН-аас өргөн барьсан хуулиудын бас ялгаа нь энэ байгаа юм. Тэгээд ер нь зүгээр манай энэ 76 дотор ч гэсэн 50 мянгаас дээш санал аваад орж ирсэн гишүүд зөндөө байгаа шүү дээ, 4, 5 хүн байгаа. Тэгэхээр үүнийг бас бид бүхэн дараа дараагийн одоо 2 хууль хооронд нь нийлүүлээд ярилцах асуудлууд дээр бол хэд хэдэн зарчмын зөрүүтэй асуудлууд байгаа. Тийм учраас АН-ын 2 гишүүнийхээ өргөн барьсан хуулийг дэмжиж байгаа. Энэ хуулийг дэмжихгүй байгаа гэдгээ хэлье.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд танхимдаа орж ирье. 1 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Одоо Сайнбуянгийн Амарсайхан гишүүн үг хэлье.

**С.Амарсайхан:** Дэмжинэ ээ, үүнийг. Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль цаашид

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Үндсэн хуулийн асуудал цогцоороо яригдаад явах байх гэж ойлгож байгаа. Энэ бол 1 намын эсвэл улс төрийн аль нэг хүмүүсийн нэр дэвших тухай асуудал биш ээ. Энэ хуулиуд энэ тогтолцооны өөрчлөлтүүд бол Монгол Улсын засаг төр, улс орны дотоод үйл ажиллагаа төдийгүй гадаад бодлогын маш чухал орон зай. Бас том үндэс суурь нь, 1 дүгээрт.

2 дугаарт, энэ хуулиудыг хэлэлцэхдээ бид нар 2, 3 асуулт дээр анхаармаар байгаа юм. Цаашидаа тойрог яригдаад явна. 1 дүгээрт, тойргийг томсгох ёстой гэж. Жишээ нь Улаанбаатар 1 тойрог болох ёстой. Зарим аймгууд бүсчилсэн тойрог болох ёстой. Ингээж байж жижиг сажиг, жалга довны, нутаг усны, нөгөө аж ахуй асуудалтай холбоотой туйлиралууд байхгүй болно. Ингээж байж өргөн хүрээнд том агуулгаар нь улс орны бодлогыг тогтвортой явуулах, улс төр төлөвших, төр төвшин байх, түмэн олон амгалан байх ийм боломж бүрдэнэ.

2 дугаарт нь, нэр дэвшилт бий. Одоо бид нар жагсаалт тойрог яриад байна. Гэтэл хэн дэвшиж болох вэ гэдэг асуудлаа эргэж харах хэрэгтэй. Хэн сайн гудамжинд орилж чадсан эсвэл хэсэг бүлэг улс төрчид нэг бол улс төрийн алба хашиж байгаа хүмүүс дэвших боломжтой. Гэтэл нөгөө талдаа эрдэм шинжилгээ, шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, инженер техник, тэгээд бусад нарийн мэргэжлийн боловсон хүчнүүд, мэргэжилтнүүд, доктор, профессорууд энд өрсөлдөх боломж нь хязгаарлагдмал байгаа. Өнөөдөр зөвхөн төрийн захиргааны болон төрийн өмчит орон нутгийн газрууд, түүний дарга болон дэд дарга нар тухайн сонгуулийн жилийн 01 сарын 01 буюу 6 сарын өмнө ажлаа өгсөн байх ёстой гэдэг ийм шаардлагатай байгаа. Тэгэхээр ингээж ажлаа өгчхөөд гарах, гарахгүй нь тодорхой зүйл дээр ажил амьдрал хувь заяагаараа хохирдог тийм ухаантан, сэхээтэн байхгүй. Тэгэхээр энэ хүмүүсийг орж ирэх

боломжийг нээж өгөх хэрэгтэй. Ингээж байж Улсын Их Хурал, Засгийн газар төр засгийн бодлого шийдвэр, эрүүл эдийн засаг ч, шинжлэх ухаан ч эргээд харах эдийн засаг нийгмийн үр дагаврыг нь нарийн тооцсон ул суурьтай гардаг болно. Тэгэхгүй бол өнөөдөр батлагдсан хууль маргааш өөрчлөгддөг, маргааш баталсан нь нөгөөдөр нь шинэчлэгддэг ийм байдлаар бид 30 жил явж ирлээ. Иймэрхүү асуудлуудаа бид цогцоор нь шийдэхгүйгээр жагсаалт, тойргийн асуудал, хэн тойрогт дэвших вэ, хэн жагсаалтаар орох вэ гэдэг асуудал бол өнгөцхөн асуудал шүү. Би үүнийг хэлэх гэсэн юм. Энэ бол мэдээж Их Хурлын сонгуулийн тухай хууль, энэ дээр бас анхаарах ёстой юм тэр 3, 5, 7 хувь гэсэн улс төрийн нам, эвлүүдийн оролцох эсэх тухай заалтууд бий. Энэ дээр нэлээн нухацтай хандахгүй бол хэт доогуур бол хэн орж ирэх нь тодорхой, хэт дээгүүр орж ирэх ёстой хүмүүс нь орж ирэх боломж бүрдэхгүй ээ. Тэгэхээр үүнийг бол нарийн эргэж хэлэлцүүлгийн явцад гишүүд маань бас сайн судалж, тооцож явах ёстой гэж бодож байгаа шүү.

**Л.Мөнхбаатар:** 18 цаг болсон байна. Ажлын цаг дууссан.

Гэхдээ өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаагүй байгаа тул чуулганы нэгдсэн хуралдааны цагийг сунгаж байна аа.

Гишүүд танхимдаа орёе, байраа эзэлье. Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураана аа. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хуралдаанд оролцсон гишүүдийн 74.4 хувь нь дэмжсэн байна.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

18.09 цаг

Дараагийнхаа асуудал оръё.

**Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын Цогтгэрэл, Ганбат нар 2023 оны 04 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энэ хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн нэр бүхий гишүүдийн зүгээс Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг бэлтгэн өргөн барьж байна.

Бидний боловсруулсан хуулийн төслийн ерөнхий агуулга, ач холбогдлыг дараах байдлаар тоймлон илэрхийлье.

1 дүгээрт, Монгол Улсын нэгдсэн бодлого гаргах хөгжлийн бодлого төлөвлөлт нэгдсэн байх үндэс суурь бүрдэнэ.

2 дугаарт нь, сонгуулийн санал хамгийн багаар гээгдэх пропорционал элементийг оруулж өгсөн.

3 дугаарт нь, жендерийн тэгш байдлыг чухалчлан хүйсийн квотыг үлэмж нэмэгдүүлсэн.

4 дүгээрт нь, олон нам парламентад орох үүд хаалга нээгдэнэ.

5 дугаарт нь, шударга сонгууль явагдах нөхцөл бүрдэнэ.

6-д нь, гадаадад буй Монголчууд саналаа өгөх эрхийг баталгаажуулна.

7 дугаарт нь, сонгуульд хийх нэр дэвшин өрсөлдөх зардлыг бууруулах эмэгтэйчүүд, залуучууд Их Хуралд сонгогдох боломж бүрдэнэ.

8-д нь, парламентын ардчиллын тогтолцооны чухал үндсэн хэсэг болсон нь улс төрийн намуудын төлөвшилд чухал түлхэц өгнө гэж үзсэн.

Өнгөрсөн 8 удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн дийлэнх олонх нь мажоритар системээр явагдсан. 2000 оны ээлжит сонгуулиар нийт сонгогчдын 51.5 хувийн саналыг авсан тухайн үеийн МАХН Улсын Их Хурлын 76 суудлын 72-ыг авч байж 95 хувийг. Тэгэхэд тухайн үед сонгогчдын 24 хувийн саналыг авч байсан АН 1 хувийн 1 суудал авч байсан сонгогчдын 24 хувийн санал авчхаад Улсын Их Хуралд 1 суудал авч байсан, 2000 онд. 2016 онд нийт сонгогчдын 46.5 хувийн саналыг авсан МАН Улсын Их Хуралд 65 суудал буюу нийт сонгогчдын 85 хувийг, харин 34 хувийн саналыг авсан АН 9 хувийн саналыг авч байж 9 суудал авч байж. Энэ парламент бүрдсэн 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд сонгогчдын 45 хувийн санал авсан МАН нийт суудлын 82 хувийг авсан бол нийт сонгогчдын 24 хувь авсан нь АН 11 суудал буюу 14 хувийг авч байж. Энэ мэтээр сонгуулийн үр дүн савлаж, иргэд сонгогчдын санал гээгддэг муу жишиг мажоритар тогтолцоонд ихээр агуулагдаж байна. Ийм учраас АН-ын бүлэг сонгуулийн тогтолцоонд пропорциональ элементийг оруулах шаардлагатай гэж үзэж уг нэмэлт, өөрчлөлтийг бас дэмжсэн.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ард иргэдийн дунд очих нүүргүй, эрх, эрхгүй улс төрчид намын жагсаалтад нуугдаж үүдээр гаргасныг нь тооноор оруулж ирэх гэж байна гэдэг хардлага эргэлзээ бий тул жагсаалтаар сонгогдох гишүүдийг 28 байхаар тооцож, тэдгээрийг нам хаалттай хүрээнд жагсаах бус иргэдийн саналаар нээлттэй эрэмбэлж өгөхөөр заасан. Ийнхүү 2012 оны Улсын Их Хурлын сонгууль явагдсан жишигээр томсгосон тойргоос 48 гишүүн, намын жагсаалтаар ард иргэдээс эрэмбэлэгдсэн 28 гишүүн байхаар хуулийн төсөлд өргөн барьж байна.

Дан мажоритар тогтолцооны нэг сул тал нь сонгогдоход санал гээгдэх явдал байдаг бол сонгогдсоны дараа тойргийнхоо асуудлыг шийдэх эрэлт хэрэгцээний үүднээс улсын хөгжлийн нэгдсэн бодлого гаргах мөрдүүлэхэд тодорхой хэмжээгээр саад тотгор бий болох явдлыг юугаар бас тодорхой хэмжээнд сааруулахад намын жагсаалт нөлөө үзүүлнэ ээ гэж бас харж байгаа.

Жендерийн тэгш байдал бол зөвхөн аль нэг хүйс хэн нэг хүмүүсийн тухай асуудал биш ээ. Нийгмийн асуудал, хөгжлийн шалгуур үзүүлэлт, ардчиллыг тодорхойлох хамгийн чухал үнэлэмжүүдийн нэг болсон. Ийм учраас төлөөлөл нь хангагдахгүй байгаа бүлгийн эрхийг хангах төлөөллийг нэмэгдүүлэх нь тогтвортой хөгжилд хүрэх боломж гэж дэлхий нийтээрээ үзэж байна.

Олон улсын парламентын холбооны нэгдсэн мэдээллээс үзэхэд 2021 оны байдлаар нийт улс орнуудын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь дунджаар 25.8 хувь байгаа бол Монгол Улсад 17 хувь. Энэ нь Азийн бүс нутгийн дунджаас ч доогуур үзүүлэлттэй. АН-ын бүлгийн зүгээс хүйсийн квотыг зөвхөн эмэгтэйчүүдийг албан тушаалд дэмжих асуудал гэж үзэлгүйгээр асуудлыг том зургаар нь харах цаг нь болсон гэж үзэж эмэгтэй квот 40 хувь байх тэр тусмаа намын жагсаалтад 1, 1 гэсэн саналыг бас оруулах нь зүйтэй гэж дэмжсэн.

Өнгөрсөн 30 гаруй жилд 8 удаагийн сонгууль болж 30 гаруй нам, эвсэл сонгуульд орж байсан ч Улсын Их Хуралд суудал авсан намын тоо 5-аас хэтрэхгүй байна. Ийм учраас суудал хуваарилах босгыг намын хувьд ч 3 хувь, эвслийн хувьд 5 хувь байх саналыг хуулийн төсөлд оруулсан. Үүний үр нөлөөгөөр олон олон намуудын парламентын босго алхан, өөрсдийн дуу хоолойгоо хүргэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Сонгуулийн тогтолцоог зөв сонгохоос дутуугүй ач холбогдолтой нэгэн зүйл бол сонгуулийг шударгаар явуулах нөхцөлийг бүрдүүлэх юм. Ийм учраас сонгуулийн үеийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлж, Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэл, хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгээс томилох гэх зэргийг бас хуулийн төсөлд тусгасан.

Жил бүр өсөн нэмэгдэж буй гадаадад сурч, суурьшин буй иргэдээ Монгол төрийн сонгуульд оролцох боломжийг бүрдүүлэн тухайн улсынхаа ЭСЯ-нд очин намын жагсаалтаар дэвшсэн нэр дэвшигч болон намд саналаа өгөх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр олон намын төлөөлөл Улсын Их Хуралд дэвших сонгох боломж бодитоор бүрдэнэ. Энэ нь сонгуулийн зардлын өндөр босгыг буулган олон бүлгийн төлөөлөл Улсын Их Хуралд бодитоор сонгогдох замыг нээж өгч байна гэж бид үзэж байна.

Улс орны эрх ашгийг эрэмбэлэн үзэж олон улсын жишгийн дагуу пропорциональ элементийг тусган өгсөн парламентын гаднах намуудад боломж олгосон жендерийн тэгш байдлыг чухалчлан тусгасан бидний өргөн барьсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүнд баярлалаа. Төслийн талаарх



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна

**А.Адьяасүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч сонгуулийн мажоритар тогтолцооны сонгогчдын санал гээгддэг гажуудлыг засахын тулд сонгуулийн холимог тогтолцоог хуульчилж, төрийн эрх мэдлийг ард түмэн, төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд сонгуулийн тогтолцоог холимог байхаар тусгаж, тойргоос 48, жагсаалтаас 28 хүн сонгохоор жагсаалт хуваарилахад улс нэг зарчим баримтлах. Тойрогт хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялах ба нийт сонгогчдын 28 хувиас доош хувийн санал авсан тохиолдолд дахин санал хураалт явуулах, тойрог болон жагсаалтад зэрэг нэр дэвшихийг хориглох. Нам эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчдийн 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх, жагсаалт нээлттэй байх, санал өгсөн иргэн бэхэн тэмдэглэгээ заавал хийлгэх зэрэг нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хуулийн төсөлд тусгасан тойргоос 48, жагсаалтаас 28 хүн сонгох зохицуулалт хэр оновчтой байх талаар, одоо хүчин

төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийн явцад гарсан зарим зөрчлийг арилгах зохицуулалтыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын сонгуульд тойргоос сонгогдох гишүүдийн тоо, намын жагсаалтаар сонгогдох гишүүдийн тооноос өндөр байгаа үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нийт сонгогчдын 28 хувиас доош хувийн санал авсан тохиолдолд дахин санал хураалт явуулах босго, тойрогт ноогдох нийт мандатын 50 буюу түүнээс дээш хувьд нэр дэвшүүлэх суудал авсан байх хуулийн шаардлагын талаар төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан бүх шатны сонгуулийн өмнөх жилийн төсвийг батлахдаа оюутан суралцагчид тэтгэлэг өгөх, тусламж өгөх, цалин, тэтгэвэр тэтгэмж нэмэх, нийгмийн халамж, хамгааллын төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэхийг хориглох зохицуулалт нь Улсын Их Хурлын улсын төсвийг хэлэлцэн батлах онцгой бүрэн эрхэд халдаж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа нам тухайн нэр дэвшигчийг нэр дэвшүүлээгүй тохиолдолд бусад намаас Улсын Их Хуралд нэр дэвших асуудлыг хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж улс төрийн намд 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх босго тавьсан үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хуулийн төслийн зарим зүйл заалт хоорондоо зөрчилтэй эсэх, улс төрийн намд 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан байх босгын ач холбогдлын талаар асуулт асууж, хариулт авсан болно. Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан нийгмийн төлөөлөл бүрийг тэгш хангах зарим нэр дэвшигч тухайн сонгуулийн жил эхлэхэд төрийн албанаас чөлөөлөгдөх зохицуулалтыг эргэн харах, тэгш оролцох, сонгох, сонгогдох эрхийг хангах,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сонгуулийн тойргийг томсгох талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 57.1 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Адьясүрэн гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Пүрэвээгийн Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүд байна уу? Идэрбат гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн. Батжаргал гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуултаа асууя.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Сонгуулийн хууль дээр улс төрийн намууд улс орныхоо эрх ашгийг бодож энэ пропорциональ гэдэг энэ системийг оруулж ирэх тал дээр Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан хууль дээр орж

ирж байна. Одоо Цогтгэрэл нарын гишүүдийн хууль дээр ч бас ийм зүйл орж ирж байна. Энэ бол юу гэдэг юм, эрх баригч намд зориулсан ийм зохицуулалт биш улс орны эрх ашгийг бодсон юм аа. Энэ дээр бас Ардын намд баярлалаа гэж манай энэ Ганбат гишүүн бол бас улс төрийн туршилагатай хүн хэлж байна. Би бол энэ пропорциональ систем бол үнэхээр цаашидаа улс орны эрх ашигт бол нийцсэн ийм системийг улс төрийн намууд оруулж ирж байна аа гэж ингэж бас бодож байна.

Тэгэхдээ яах вэ, сая бол Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан хууль дээр энэ пропорционалийн ард нуугдах тэр бололцоо, нуугдуулахгүй байх ямар зохицуулалтууд байгаа вэ гэдэг тал дээр бас гишүүд олон талаас нь ярилаа. Одоо энэ Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн барьсан энэ юун дээр ард иргэд пропорционалийг зөвшөөрөхөд цаана нь нөгөө тооноор орж ирнэ гээд байдаг энэ зохицуулалтыг яаж хааж байгаа вэ гэсэн 1 дүгээр асуулт.

2 дугаарт, сонгуулийн зардлыг бууруулах тал дээр Энхболд нарын гишүүдийн өргөн барьсан дээр бол 48-50 хувь бууруулна аа гэж байна. Яг та бүхний өргөн барьсан энэ хуулийн төсөл дээр энэ сонгуулийн зардлыг бууруулах тал дээр ямар хувь тодорхой хэлэх вэ? Ер нь цаашидаа манай Монгол Улсын энэ 8 удаагийн парламентын сонгууль явсан үүх түүхийг харахад ер нь сонгуулийн жилийн өмнөх жил л энэ сонгуулийн хууль өөрчлөгдөөд явдаг юм байна лээ. Тэгэхээр магадгүй энэ хууль 2027 онд өөрчлөгдөх байх, хэрвээ энүүгээрээ явбал. Тэгэхээр 2027 он хүртэлх энэ сонгуулийн хуулийн өөрчлөлт үүгээр явахаар энэ нэг иргэд олон нийтэд юм тараадаг, маш их хэмжээний мөнгө цаас тэрэндээ зарцуулдаг, тэр нь ирээдүйн сонгогчдыг худалдаж авах нэг том хэрэгсэл болдог. Хэдийгээр 3 жилийн өмнөх тарааж байгаа ч гэсэн би ер нь 3 жилийн дараа ирнэ шүү, та намайг таниарай гэсэн байдлаар л хандаж байгаа юм шиг

харагддаг. Одоо бол сонгогчид тэрийг чинь элэг доог болж хүлээж авдаг болж байгаа.

Тийм учраас бид одоо энэ сонгуулийн хууль дээр сонгуулийн өмнөх жил тухайн жилд биш, энэ Их Хурлын гишүүн хүн одоо энэ сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор эсэн бусын юм тараадаггүй ийм зүйлийг энэ ер нь Сонгуулийн хуулиуд дээр ер нь оруулбал яасан юм бэ. Энэ чинь цаашилаад аймгийн Иргэдийн хурал, сумын иргэдийн хурал гээд бүр ингээд дамжаад явчихлаа л даа. Тийм учраас ер нь үүнийг ер нь бид нар эргээд нэг харахгүй бол болохгүй. Яг энэ асуудлаар ер нь энэ хуулийн зохицуулалт энэ дээр тусгагдсан зүйл байгаа юу гэж.

3 дахь асуулт бол энэ цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэхгүй ээ гэсэн ийм зүйл орж ирж байна. Ер нь бол би түрүүнд хэлсэн, Сонгуулийн хууль бол бараг л 1 удаагийн үйлчлэлтэй ийм хууль байгаа. Энэ практикаас харахад. Гэтэл өнөөдрийн энэ таны өргөн барьсан хууль дээр энэ асуудал ороод ирэх юм бол нөгөө ард иргэдийн хүлээгээд байгаа энэ нөгөө цалингийн асуудал, нийгмийн даатгалын энэ багц хуулийн шинэчлэлийн асуудал явахгүй зогсох юм уу. 2024 оны 7, 8 сар магадгүй 2025 он хүртэл тэтгэвэр нэмэхгүй байх бололцоо үүгээр гараад ирэх юм биш биз ээ. Энэ дээр ер нь ямар байр суурьтай байгаа юм бэ гэсэн ийм үндсэн 3 асуултыг хууль санаачлагчаас асууя гэж ингэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Идэрбат гишүүн 3 асуулт асуулаа. Хуулийн төсөл санаачлагч Цогтгэрэл гишүүн асуултад хариулъя.

**О.Цогтгэрэл:** 1 дүгээрт нь, жагсаалтыг хэрхэн яаж нээлттэй байгаа юм бэ нөгөө хаалгаар тооноор гэдэг шиг хүсээгүй улс төрчид орж ирэх нөхцөл ямар вэ гэж байна. Бидний өргөн барьсан төслөөр бүрэн дүүрэн нээлттэй ийм төсөл өргөн барьж байгаа. Яг сонгогч 1 мандаттай жишээ нь аймагт

гэхэд 1 мандатынхаа тойргийн нэр дэвшигчийг дугуйлна. Пропорциональ талдаа болохоор намын нэрийг дугуйлна, нэмээд намаас нэр дэвшигчдийг бас эрэмбэлнэ. Тэгэхээр 3 үндсэндээ нэр дэвшигчийн нэрсийн хавтгай дээрээс 3 дугуйлалт хийх бүрэн дүүрэн намыг ч дугуйлна, намын дотоод эрэмбийг ч хийж өгнө гэдэг ийм чиглэлтэй. Харин зарчмын хувьд нэг жаахан зөрүүтэй зүйл байгаа нь Энхболд дарга нарын өргөн барьсан дээр бас үүнийг том тойрог шиг зарим нэр дэвшиж байгааг нэр дэвшигчид өгсөн саналыг нам тоолох гэдэг нэг ийм зарчмын зөрүүтэй саналууд байгаа. Дараа нь ажлын хэсэг дээр бас ярилцаад явах боломжтой байх.

Дараа нь тэр сонгуулийн зардалтай холбоотой зүйлийг яригдаж байна. Ер нь өнгөрсөн 2020 оны сонгуулийн дундаж зардлаар угаасаа хуульд бас зардлууд байдаг. Мэдээж бас янз бүрийн зардлууд л гарч байдаг. Ер нь тэр шинжилгээгээр янз бүрийн ажлын хэсгүүд дээр гарснаар дунджаар 600-гаад сая төгрөгийн зардал өнгөрсөн тойрогт нэр дэвшигчдэд гарч байжээ гэдэг ийм дундаж статистик гарч байгаа. Тэгэхээр энэ бас нэлээн тийм үлэмж хэмжээгээр буурна, зарим судалгаагаар 50 орчим хувиар буурна аа гэдэг дүнгүүд гарна лээ. Энэ дээр эргээд бас зардал нэмэгдэх зүйл бас гарна. Нэмэгдэх гэдэг нь гадаад улс оронд байгаа өмнө нь сонгууль өгдөггүй байсан иргэд Их Хурлын сонгуульд сонгууль өгдөггүй байсан иргэд буцаж сонгууль өгч байгаа болохоор өмнө нь гардаггүй байсан зардал буцаж нэмэгдэж байгаа. Энэ дээр Сонгуулийн ерөнхий хороо бол тодорхой бас тооцооллууд хийсэн байна лээ.

Дараа нь тэр цалин, тэтгэвэр тэтгэврийг нэмж болохгүй юм уу гэдэг асуулт. Яг энэ өөрөө бас бид нар дагалдуулан Төсвийн тухай хууль өргөн барьсан, энэ дээр бас ийм зарчмын зөрүүтэй зүйлс байгаа юм. Ер нь сонгуулийн өмнө янз бүрийн амлалтууд их авдаг, янз бүрийн нөгөө мөрийн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хөтөлбөрт тусаагүй зүйлүүдээр үндсэндээ сонгогчдыг бүхэл бүтэн ингээж намаараа эрх баригчид тухайн үед эрх барьж байсан хүчин авлигадах, халамж тараах энэ тэр энэ гэх нам байхгүй 16 онд ч гэсэн бас ийм зүйл явж л байсан. Энэ өөрөө аливаа зүйл явагдаж болно. Тэгэхдээ энэ өөрөө тухайн улс төрийн нам, хүчний мөрийн хөтөлбөрт туссан зүйл энэ дээр байх нь зүйтэй. Мөрийн хөтөлбөрт ямар ч тусаагүй зүйлийг гэнэт шинээр бодож гаргаж ирдэг.

Тэгэхээр 1 дүгээрт нь, мөрийн хөтөлбөрт туссан, 2 дугаарт нь, төсөвт тусчихсан зүйл бас төсвийн хуулийн дагуу төсөвт туссан зүйл мэдээж зөвшөөрөгдөнө. Төсвийн тодотгол хийх замаар мөрийн хөтөлбөрт тусаагүй зүйлсийг энэ бүгд чинь өөрөө бүхий л цаана нь төсвийн болоод тогтвортой байдлын хууль, олон зүйлсийг харьцаа, олон зүйлүүдийг алдагдуулж энэ яг соёлтой хуулийн хүрээнд сонгуулийн тэгш бус байдлыг улс төрийн намуудад тэгш бус байдал авч ирж байгаа ийм зүйл үүний цаана агуулагдана аа, агуулагддаг учраас үүнийг бас тодорхой хэмжээгээр хаах нь зүйтэй гэж. Гэх мэтээр ер нь энэ гарч байгаа хууль бол нэмэлт, өөрчлөлтийг дагалдуулаад 3 хуульд бас өөрчлөлт орохоор өргөн барьж байгаа Эрүүгийн хуульд ч байгаа, Улсын Их Хурлын тухай хуульд, саяын яригддаг Төсвийн хуульд гээд ийм 3 хуульд бас нэмэлт, өөрчлөлтийн зарим зүйлс өргөн баригдсан байгаа. Нэмж хариулах бол хамтран өргөн барьсан Ганбат гишүүн бас нэмэх байх аа.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулах юм уу? Хуулийн төсөл санаачлагч Ганбат гишүүн нэмж хариулъя.

**Д.Ганбат:** Манай Идэрбат гишүүн бас орон нутгаас сонгогдсон ийм залуу хүн болохоор их зөв зүйтэй юмыг олж харж байна аа. Бас ийм зөв зүйтэй, ийм сайхан гишүүд Ардын намд олон болоосой л гэж бодож байна, тийм.

Ялангуяа одоо 48 байх орон нутгаас үүнийг бол та дэмжих байх аа.

Нөгөө талаар бол энэ хөрөнгө мөнгө яах вэ гэж асууж байх шиг байна. Та хэмнэгдэх вэ гээд. Энэ дээр бол одоо эмэгтэйчүүдийн квотыг бид нар бол Ардын нам 30 гээд байгаа. Бид нар бол 40 гэж байна. Тэгээд эмэгтэйчүүдийн оролцсон энэ сонгууль бол ямагт зардал хэмнэгдчихсэн ийм сонгууль болдог. Би нөгөө мөнгө төгрөгтөө нарийн гэж хэлээгүй шүү, бас тийм ээ, яах вэ ер нь бол зөв зүйтэй шударга өрсөлддөг болохоор гэж хэлж байгаа юм.

Нөгөө талаар бол бас юу шүү. Танай нутгийн Чойням гуайн шүлэг байдаг шүү дээ. Манай нутгийн гавьяат Со ах энэ тэр унидаг л даа. Энэ ээжийгээ ийм болгочихсон хүн нь би байна аа гээд тийм ээ, одоо ингээд хөгшин, ядуурсан, туйлдсан, хамаг сайн сайхан юмыг өөртөө зориулаад ийм болгочихсон хүн нь хүү нь болсон би байна аа гэдэг шиг л өнөөдөр Монголын ард түмнийг ийм болгочихсон нь бараг 60, 70 хувь нь, 80 хувь нь МАН-ынхан, 20, 30 хувь нь бид нар байгаа юм аа. Тэгэхээр энэ одоо зөв зүйтэй сонгуулийг энэ тогтолцоог бол ингээд дэмжих нь зүйтэй гэдгийг та их маш зүйтэй анзаарсан байна. Нөгөө орон нутгийн амьдралыг мэддэг бас улс орны онцлогийг зөв харж байгаа ийм юм байна. Тэгэхээр хэмнэлтийн талаар ярихад тийм байна.

Нөгөө талаар бол тэр 38, 38 гэдэг Ардын намынх арай буруу гэдгийг нь ойлгоод байх шиг байна, та. 48, 28 гэдэг бол яг л зөв тогтолцоо гэдгийг нь олж харжээ. Эмэгтэйчүүдийн квотыг 40 хувь болгох нь бол бас цагаа олсон асуудал байх аа. Бид бүхэн Азидаа одоо дэлхий дээр бол эмэгтэйчүүддээ хамгийн түрүүнд л сонгогдох квотыг нь өгч байсан ийм улс орон шүү дээ. МАН анх удаа сонгуулийн хууль санаачлаад тэр МАХН гэж байхдаа тэр 1945, 1950 онд чинь бараг л дэлхийн эмэгтэйчүүдээс өмнө тэр эрхээ эдэлж байсан улсууд. Тэгэхээр энэ тал дээр бид нар бас манлайлан ажиллах ёстой байх



аа, энэ 2 нам. Тэгж ойлгож байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Идэрбат гишүүн тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Ингээд улс төрийн намууд пропорциональ систем дээр тогтоод магадгүй энэ 2 хуулийн төсөл нэгтгээд явах байх. Энэ үеэр ард иргэд пропорциональ гэдэг энэ системийн гол алдаа бол тэр тооноор орж ирж байгаа, ард түмний өмнө санал авч чадахгүй хүмүүс энэ жагсаалтын ард нуугдана аа гэдэг энэ зүйлийг маш сайн хамгаалж байх нь зүйтэй байх аа гэсэн ийм санал байгаа юм.

Дараагийн нэг зүйл бол тэр сонгуулийн жил гэдэг ганцхан хязгаарлалт байсан. Тэр юм хум тараадаг, эд өлгий тараадаг, мөн дэвшихийг бодож байгаа, горилж байгаа хүмүүс тараадаг энэ системийг ер нь улс төрийг хөрөнгө мөнгөнөөс хамаарал багатай болгоход бол энэ туйлын чухал заалт болно. Магадгүй үүнийгээ дийлэх гэж, үүнийгээ хийх гэж хууль бус юм руу халтирдаг байхыг ч үгүйсгэхгүй юм байгаа юм. Тийм учраас энэ улс төрийн намын хууль дээр, сонгуулийн хууль дээр тэр юм хум тараадаг юмыг бүгдийг нь болиулаад, энэ хуралдаа суудаг, үгээ хэлдэг, ажлын хэсэг дээрээ ажилладаг, тойрогтоо очдог ийм одоо улс төрийн соёл ... /минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Идэрбат гишүүн санал хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** 2, 3 асуулт нь давхцаж байна. Тийм учраас цаг идээд хэрэггүй биз. Хамтатгаад хэлэлцэх үйл явц руугаа орох байлгүй дээ. Би бодвол тэгж бодож байна. Та хэд эндээс өргөн барьсан нь ч тэр, тэндээс өргөн барьсан нь ч тэр, намаар нэг санал өгөөд, намын жагсаалтад байгаа улсуудаар санал өгүүлэх тухай л юм яриад байгаа юм. Наадхыг чинь даадаг техник ажиллагаа

гэж байхгүй ээ. Тэр улсуудын санал өгдөг үйл явц, цаг хугацаа, тэр тоног төхөөрөмж энэ тэр 1 дүгээрт байхгүй.

2 дугаарт, энэ орон нутгийн намын байгууллагуудыг задлах үйл явц болно шүү. Наад 38 гэдэг юм уу, 28 хүн чинь бүгдээрээ орон нутагт сүлжээ хийх гэж оролдоно, арай ахиу санал авах гэж оролдоно. Ингээд бөөн тачигнасан юм болно. Дээр нь ямар юмных нь сонгуулийн зардал хэмнэх байдаг юм бэ. Ил гардаггүй баахан сонгуулийн зардал үүсгэх гэж байгаа байхгүй юу. Үнэхээрийн тэр парламентынхаа ардчилал руу явъя, парламентын засаглалаа хөгжүүлъя гэж байгаа бол энэ пропорциональ системийнхээ хэлбэрийг оруулж ирж л байгаа юм бол ард түмэн итгээж өгөхгүй байгаа бол тэр нэрээ ил болго. Саналаа өгөхдөө зөвхөн намын төлөө өгдгөөр л зохицуулах ёстой. Муу хүмүүс нэр дэвшүүлчихсэн бол тэр намд санал өгөхөө л байчихна шүү дээ, улсууд угаасаа л ойлгомжтой. Тийм учраас ийм хэлбэр энэ тэрээ бодсон дээр ээ, худлаа үнэн ард түмэнд таалагдах гэж техник ажиллагаатай, сонгуулийн үрэлгэн зардалтай, тэгээд баахан намын байгууллагуудыг эвдрэлцүүлсэн, системийн гажиг хийх гэж оролдоод хэрэггүй шүү. Үүнийг хэлэлцүүлгийнхээ түвшинд анхаараарай.

**Л.Мөнхбаатар:** Хариулах юм уу? Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултад хариулъя.

**О.Цогтгэрэл:** Батжаргал гишүүний санал дотор гарч байгаа зүйлд бас нэг хариулт хэлчихье. Тэгээд техник ажиллагааны хувьд магадгүй нэлээн олон хүний нэр гарна, 30-аад нам байгаа, дангаараа орвол яах юм, эвсвэл яах юм 28-30 хүний жагсаалт орно гэж байгаа. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс судалгаа хийж үзээд бэлэн тест хийж үзээд, Сонгуулийн ерөнхий хороо техник ажиллагааны хувьд болоод одоо байгаа хар машины хувьд унших бүрэн дүүрэн боломжтой. Энд яг энд өнөөгийн

энэ хууль 2-ын хууль 38, 38 дээр ч, 48, 28 дээр ч алин дээр нь ч техник ажиллагааны хувьд боломжтой гэдэг зүйлийг Сонгуулийн ерөнхий хороо өмнө нь бас хэлж байгаа.

2 дугаарт нь, тэр Батжаргал гишүүний хэлж байгаа тэр пропорциональд орсон гишүүдийг эрэмбэлэхээр улс даяар бас нэг баахан нэр дэвшигчид гарч ирж бас баахан нам хагалсан, улс даяар уралдсан асуудал болно оо гэж байна. Гэхдээ үүний цаана энэ хүмүүсийн чинь цаана зангидаж байгаа нэг эрх ашиг нь нам нь өөрөө өндөр хувь процент л авах ёстой, нам өөрөө энэ өндөр авч байж л энэ хүмүүс орох зөвхөн хувь хүмүүс өндөр байх биш, нам өндөр байх гэдэг шаардлага тавигдаж байгаа болохоор нэгдмэл зорилго, нэгдмэл эрх ашиг, нэгдмэл бодлого, улс даяар нэгдсэн сурталчилгаа олон зүйл рүүгээ тэр нэгдмэл зүйл рүү олон зүйл анхаарагдах учраас сонгуулийн зардал тодорхой хэмжээгээр буюу нэлээн тийм эрс хэмжээгээр буурна аа гэдэг ийм зүйлийг бас үүнийг агуулж бас цаана нь хэлээд байгаа юм. Тэгэхээр тодотгоод хэлбэл тийм зүйл байна. Техникийн хувьд боломжтой эсэх дээр шаардлагатай бол сонгуулийн хороо нэмж тодруулж хэлэх байх аа.

**Л.Мөнхбаатар:** Хуулийн төсөл хамтран санаачлагч Ганбат гишүүн нэмж хариулья.

**Д.Ганбат:** Батжаргал гишүүний зовнилыг бол ойлгож байна аа. Ер нь яах вэ, нам тэгээд нэрсээ жагсаачихна шүү дээ, тийм ээ. Тэгээд ард түмэн эрэмбэлээд өгөхөөр тэр нам ард түмэн, мэдээж хэрэг нам бол өөрөө бас нэг багцаатай эрэмбэлэх байх аа. Тэр ард түмэн, нам хоёрын зөрүү нь ямар байна гэдэг нь ч харагдах байх. Техникийн хувьд асуудал биш гэдгийг манай Сонгуулийн ерөнхий хороо, Цогтгэрэл дарга 2 ярьчих шиг боллоо.

Түүрүүн манай Идэрбат гишүүн хөндсөн, тэр сонгуулийн 1 жилийн өмнө та нарын тэр яриад байгаа хууль дотор цалинг нь нэмж болохгүй, энэ тэр гэсэн ийм юм орж байна аа гээд. Энэ бол бас нэг юу шүү. Энэ 8 жил болоход цалингаа нэмж чадаагүй байж байж, яг сонгууль болохын өмнө 1 жилийн өмнө нэмдэг ээ, тэгээд чадан ядан тэрийг нь 225 мянган төгийн албан хаагчдадаа өгчихдөг, тэр зардал чирэгдлийн сонгуулийн дараа нөгөө төр засаг маань дааж чаддаггүй, нөгөө ханины уналт, мөнгөний уналт, юмны үнийн өсөлт бол үргэлжлээд явчихдаг. Тэгээд ард түмэн нийтээрээ хохирдог. Ийм учраас энэ заалтыг оруулж өгсөн шүү. Зөвхөн саналын хойноос хөөцөлдөх биш бас улс орноо бодох ёстой л гэсэн ийм бодолтой байгаа. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Гишүүд суудлаа эзлээрэй. Та юугаа дарсангүй шүү дээ. Санал хураалт явуулья. Гишүүд суудлаа эзлээрэй. Пүрэвдорж гишүүн. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 56.1 хувь нь дэмжсэн байна.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

*бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын  
байнгын хороонд шилжүүлж байна.*

*Ажлын хэсэгт баярлалаа.*

*Өнөөдрийн чуулганы нэгдсэн  
хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан  
тул өнөөдрийн хуралдааныг өндөрлүүлж  
байна.*

*Дууны бичлэгээс буулгасан:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ*

*18.39 цаг*

*П.ОЮУНГЭРЭЛ*

*Гишүүдэд баярлалаа.*